



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Шударга ёс, хөгжил дэвшилд

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ЭМХЭТГЭЛ

2020-2021 он

IV БОТЬ

ННА 72
ДАА 001.4
У-314

Хянасан: Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасанням

Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албаны дарга, эрхэлсэн комиссар Ц.Шинэбаяр

Боловсруулсан: Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албаны ахлах ажилтан, ахлах комиссар Ц.Бадам

Цаасны хэмжээ: А4

Хэвлэсэн тоо: 300ш

“УРАНГАР ПРЕСС” ХХК-д хэвлэв

ISBN 978-9919-22-714-2

Өмнөх үг

Авлигатай тэмцэх газраас 2020-2021 онд зохион байгуулсан судалгааны тайлангуудыг эмхэтгэн Та бүхэнд толилуулж байна.

Эдгээр судалгааны ажлыг эмпирик ба загварчлалын судалгааны тоон болон чанарын аргаар зохион байгуулж, үр дүнг нь тооцоолсон бөгөөд зорилго нь авлигын нөхцөл байдлыг тодорхойлох, хэмжих, авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс үр дүнтэй урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, түүнийг хэрэгжүүлэх шинэ арга замыг тогтоох, гарсан үр дүн, дүгнэлт, шийдлийг үйл ажиллагаандаа ашиглахад оршиж байгаа юм.

Энэхүү эмхэтгэл нь тус газраас зохион байгуулсан давтамжит болон цаг үеийн шинжтэй судалгааны үр дүнгийн тайлангуудаас бүрдэж, өмнөх 3 ботийн үргэлжлэл болгон эмхэтгэлээ. Судалгааны ажлын үр дүнгүүд нь авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөр үйл ажиллагааг боловсруулах, төлөвлөх, үнэлж дүгнэхэд шаардлагатай тоон мэдээ, мэдээлэл, санал дүгнэлтийг агуулахын зэрэгцээ олон нийтэд мэдээллийн багц эх сурвалж болох ач холбогдолтой.

Авлигатай тэмцэхэд тулгарч буй асуудлуудыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлан шийдвэрлэх, судалгааны мэдээллийг бүрэн хэмжээгээр ашиглах, судалгаагаар тогтоогдсон дүгнэлт, баримтад дүн шинжилгээ хийж, бодлогын баримт бичиг, стратегийн төлөвлөлтийг уялдуулан боловсруулах нь туйлын чухал гэдгийг гадаад улс орны туршлага, эрдэмтэн судлаачдын санал, зөвлөмж харуулдаг. Бид ч үүнтэй санал нэгдэж Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг шинээр боловсруулахдаа энэхүү судалгааны ажлын үр дүнд тулгуурлаж, үндсэн шалгуур үзүүлэлтийн нэг болгосон.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт туссан үр дүн, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тооцохдоо тус үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулагдсан судалгаа шинжилгээний ажлын үзүүлэлт, үр дүнг харгалзан үнэлэлт, дүгнэлт хийх боломжтой. Цаашид практикт тулгамдаж буй аливаа асуудлын мөн чанар, холбоо хамаарал, учир шалтгааныг тогтоохын тулд шинжлэх ухаанч байр сууринаас хандан судлах нь чухал юм.

Судалгааны ажлуудыг зохион байгуулахад хамтран ажиллаж үнэтэй санал, дэмжлэг, тусалцаа үзүүлсэн, судалгаанд хамтран оролцсон бүх хүмүүст талархлаа илэрхийлье.

Шударга ёс, хөгжил дэвшилд

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР З.ДАШДАВАА

ГАРЧИГ

УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА-2020	5-43
ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА-2020	45-62
ХАСХОМ МЭДҮҮЛЭГЧДЭЭС АВСАН СУДАЛГАА-2020	63-79
ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА-2020	81-110
ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ-2021	111-165
УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА-2021	167-188
ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА-2021	189-222
ГАДААД УЛС ОРНУУДЫН АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГТ ОНОГДУУЛЖ БУЙ ЯЛ ШИЙТГЭЛИЙН ТӨРӨЛ, ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА-2021	223-232
ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА-2021	233-250
НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 12-Р СУРГУУЛИЙН СУРАГЧИД, ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН СУДАЛГАА-2021	251-263



УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ
АВЛИГЫН ТАЛААРХ
ТӨСӨӨЛЛИЙН 2020 ОНЫ
СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Удиртгал

Судалгааны үндэслэл:

Улсын Их Хурлын 2005 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтыг Улсын Их Хурлын 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 13 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, хөгжлийн зорилтуудын үзүүлэлт, арга зүйг боловсронгуй болгох, хэрэгжилтийг үзүүлэлт бүрээр дүгнэх, хяналт тавих, төрөлжсөн болон тусгайлсан санг холбогдох мэдээллээр бүрдүүлж ажиллахыг Засгийн газар болон холбогдох бусад байгууллага, үүний дотор Авлигатай тэмцэх газарт үүрэг болгосон.

Авлигатай тэмцэх газар 2008 оноос хойш жил тутам “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийгн судалгаа”-г зохион байгуулж, судалгааны үр дүнг Мянганы хөгжлийн 9 дэх зорилтын “Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгох, хэвшүүлэх” 24-р зорилтын хэрэгжилтийг үнэлж дүгнэх нэг шалгуур болгож ирсэн.

Мянганы хөгжлийн зорилт тус бүрийн шалгуур үзүүлэлтийг тогтоолд тусгасны дотор 24 дэх зорилтын шалгуур үзүүлэлтийг дараахь байдлаар тогтоосон:

1. Авлигын индекс;
2. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөлөл;
3. Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын хүрээн дэх авлигын талаарх иргэдийн төсөөлөл.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн “МХЗ-9.Хүний эрх, ардчилсан засаглалыг бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгээс дээр дурдсан 2 дахь шалгуур үзүүлэлт болох “Улс төрийн байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөлөл”-ийн үнэлгээ хийх арга зүйг боловсруулж, анхны судалгааг зохион байгуулсан. Энэхүү арга зүйн дагуу 2009 оноос эхлэн Авлигатай тэмцэх газраас судалгааг жил бүр зохион байгуулан үр дүнг нийтэд мэдээлж ирлээ.

Судалгаа нь авлигын хандлага, авлигад өртөмтгий ажил, албан тушаал, авлигад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Мөн улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэхэд мэдээллийн чухал эх сурвалж болох учиртай.

2017 он хүртэл улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөлийг нэг судалгааны хүрээнд судалж, нэгтгэсэн тайланг гаргаж байсан бол 2018, 2019 оноос эхлэн тус хоёр хүрээг тусд нь авч үзэж авлигын талаарх төсөөллийн судалгаа” болон “Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г хийдэг болсон юм. Уг хоёр судалгааг “Хүлүгү санаачлага” НҮТББ энэ жилээс хийж гүйцэтгэв.

Судалгааны зорилго зорилт:

Судалгааны хүрээнд дараах зорилтыг тавьж зохион байгуулав.

- Авлигын талаарх төсөөлөл, хандлага, шалтгааныг тодруулах;
- “Дээд (өндөр) түвшний” хүрээн дэх авлигад автагдсан байдал, цар хүрээ, авлигын хэлбэрийг авч үзэх;
- “Дээд (өндөр) түвшний” авлигын шалтгаан, нөхцөл түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах;
- “Дээд (өндөр) түвшний” авлигын хэмжээ, түүний хор уршиг, үр дагаврыг гаргах;

- “Дээд (өндөр) түвшний” хүрээн дэх авлигатай тэмцэх үйл ажиллагааг
- үнэлүүлэх, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах зэрэг болно.


Судалгааны арга зүй:

“Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г нийгмийн эмпирик судалгааны тоон болон чанарын судалгааны аргаар хийж явуулсан. Улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллага, бодлогын судалгаа, олон нийтийн санал бодлын судалгаа, бизнесийн салбар, иргэдийн төлөөлөөс оролцуулан нийт 62 шинжээчийг хамруулсан.

Тоон судалгааны мэдээллийг цуглуулахдаа нүүр тулсан яриулагын асуулгын аргыг ашигласан ба шинжээчдээр асуулт бүрийг “1-ээс 5” гэсэн баллаар үнэлүүлэн тооцоолсон. Баллын үнэлгээ буурах тусам эерэг утгыг илэрхийлж байгаа бол баллын үнэлгээ өсөх тусам сөрөг утгыг илэрхийлдэг.

Өмнө нь дан тоон судалгааны аргыг ашигладаг байсан бол 2018 оноос эхлэн чанарын судалгааны аргыг нэмэлтээр нэвтрүүлж эхэлсэн. Судалгааны мэдээлэлд шинжилгээ хийхдээ “Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн 2018 болон 2019 оны судалгаа”-ны тоо баримттай харьцуулан 2020 оны өгөгдлийг шинжилж, гарсан өөрчлөлт, үр дүнг тогтоосон болно.


Зураг 1. Улс төрийн хүрээн дэх авлигын үнэлгээ, үзүүлэлтийн схем.



НЭГ. 2020 ОНЫ АВЛИГЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВ


Энэ бүлгийн хүрээнд улс төрийн авлигын үндсэн үнэлгээнээс гаднах бусад үзүүлэлтүүдийн байдлаар буюу авлигын ерөнхий төлөв, ойлголт төсөөллийг дэлгэрүүлэн үзүүлнэ. “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх Авлигын талаарх төсөөлөл” судалгааны хүрээнд улс төрийн хүрээгээр хязгаарлалгүй Монголын нийгэм дэх авлигын ерөнхий төлөв түгээмэл байдлыг шинжээчдээр үнэлүүлэн өмнөх жилийн судалгааны дүнтэй харьцуулан жишсэн болно.

Зураг 2. Монгол Улсад дэлгэрсэн авлигын түгээмэл байдал. хувиар



Судалгаанд хамрагдсан шинжээчдийн 53.2 хувь их байна гэж энгийн ойлголтоор харуулсан байна. Маш их байгаа гэж үзсэн оролиогчид 24.2%, дунд зэрэг гэж илэрхийлсэн оролиогчид мөн л 24.2 хувьтай байгаагаас үзэхэд Монгол Улс авлигад их автсан байгаа нь дээрх дүнгээр илэрсэнийг нотлон харуулж байна. Монгол Улсын иргэдийн дийлэнх нь авлига нь бүх нийтээрээ тархсан нийгэмд ердийн хэвийн үзэгдэл гэсэн ойлголттой байна. Улс төрийн тогтолоог өөрчилж, ардчилсан нийгмийг байгуулсан хэдий ч хээл хахууль авлигатай тэмцэх тогтолоог бий болгон суурьшуулж чадахгүй байгаа нь бодит байдал юм.

Зураг 3. Монгол Улсад дэлгэрсэн авлигын түгээмэл байдлын харьцуулалт. хувиар




Монгол Улсад дэлгэрсэн авлигын түгээмэл байдлыг 2019 оны дүнтэй харьцуулсан зурагт шинжээчид ерөнхий энгийн ойлголтоор их байна гэж 53.2 хувь нь харуулсан. 2019 онд 25.8 хувь нь их байна гэсэн харуулт өгөгдсөн. 2020 онд 2019 оныхоос 27.4 хувийн өссөн өөрчлөлт гарсан нь Монгол улсад авлига нилээд түгээмэл байгаагийн илрэл юм. Харин 2020 онд маш их гэсэн байр суурьнаас хандсан шинжээчид 24.2 хувь байгаа нь өнгөрсөн оныхоос -6.1 хувийн өөрчлөлт гарч буурсан нь сайн үзүүлэлт хэдий ч цаашид авлигын түвшин хэлбэлзэх магадлалтайг энэ оны дүн харуулж байна.

УЛС ТӨРИЙН НАМУУДЫН АВЛИГАД АВТСАН БАЙДАЛ

Улс төрийн нам, улс төрийн сонгууль, төрийн албыг авлигаас ангид байлгах эрх зүйн орчныг боловсронгуй болгохын төлөө зорилго бий болгон нэгдэн ажиллахаар тохиролцсон байдаг боловч энэ нь төдийлөн хөрсөн дээр буудаггүй бөгөөд ямар нэг байдлаар авлигад автсан байдаг. Энэ талаар уг судалгаанд доорх байдлаар бэлтгэн үзүүлээ.

Зураг 4. Монгол Улс дахь улс төрийн намуудын авлигад автсан байдал. хувиар



Монгол Улсад хамгийн их авлигад автсан байж болох талаар тодруулга хийхэд 42.3 хувиар эрх барьж буй МАН гэсэн байна. МАН хамгийн их авлигад автагдсанаар тооцогдсон. 40.1 хувь нь АН, 13.1 хувь нь МАХН эрх мэдэл нь буурч байгаа гэсэн төсөөллөөр харцуулт өгчээ. АН 40.1 хувь нь, 13.1 хувь нь МАХН эрх мэдэл нь буурч байгаа гэсэн төсөөллөөр харцуулт өгчээ. Харин бусад жижиг намыг нэрлэсэн нь 4.4 % байна.

АВЛИГЫН ХҮРЭЭНИЙ ТҮГЭЭМЭЛ БАЙДАЛ

Монгол Улсад ялангуяа төр, нийгмийн халамж үйлчилгээ, улс төрийн сонгууль, улс төрч, бизнес эрхлэгчдийн хоорондын харилцаанд авлигын талаар ихээр яригддаг байна. Улс төрийн нам 4.38, засгийн газар яам, агегтлагад 4.18, Орон нутгийн төрийн захиргааны удирдлагад 4.17, төрийн байгууллага, УИХ-д 4.02, прокурор 3.88, шүүх 3.84, хэрвлэл мэдээллийн хэрэгсэл 3.72 баллаар үнэлэгдсэн нь эдгээр салбаруудад авлига илэрэхэн илэрдэг байна. Үүнээс гадна гааль, татвар, шүүх, цагдаа, боловсрол болон эрүүл мэндийн байгууллага гэх зэрэг газруудыг авлигад ихээр автдаг гэх ойлголт түгээмэл байдаг байна.

Зураг 5. Авлигыг салбар хүрээгээр тоймлон авч үзвэл (дунджаар)



Хэрэв индексжүүлж өмнөх оны үзүүлэлттэй харьцуулбал дараах дүр зураг харагдана.

Хүснэгт 1. Сүүлийн нэг жилийн хугацаан дахь авлигын нөхцөл байдал (индекс).

№		2018 он	2019 он	2020 он	Өөрчлөлт
1	Улсын Их Хурал	4.02	4.02	4.02	0.1
2	Засгийн газар (яам, агентлаг)	4.27	4.32	4.18	0.05
3	Шүүх	4.09	4.18	3.84	0.1
4	Прокурор	4	4.25	3.88	0.25
5	Орон нутгийн төрийн захиргааны удирдлага	3.84	4.05	4.17	0.21
6	Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	3.57	3.72	3.8	0.15
7	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж	3.83	4.36	4.10	0.53
8	Төрийн бус байгууллага	2.27	2.08	2.59	-0.19
9	Улс төрийн нам	4.28	4.18	4.38	-0.1
10	Хувийн хэвшил	2.75	2.5	2.84	-0.25
11	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	3.91	3.58	3.72	-0.33
12	Боловсролын систем	0	0	2.67	

Сүүлийн нэг жилийн хугацаан дахь авлигын нөхцөл байдлыг индексээр бодож гаргав. Авлигад Улс төрийн нам, Засгийн газар (яам, агентлаг), Улсын Их Хурал, Орон нутгийн төрийн захиргааны удирдлага гэх мэтчилэн салбаруудад түгээмэл байна. Хэдийгээр өмнөх оныхоос зарим салбарын үзүүлэлт буурсан ч төрийн өндөр албан тушаалтан, улс төрчдийн дундах авлигын асуудалд харууллага хүлээлгэхгүй, хэвийн байдаг зүйл мэтээр даамжруулж болохгүй юм.

АВЛИГЫН ТҮВШИНД НӨЛӨӨЛСӨН ГОЛ ХҮЧИН ЗҮЙЛС

Нийгэмд авлига нь ямар нөлөөллөөс үүсэн гарч байгаа, хэр их хэмжээнд тархсан, түүний шалтгаант нөхцөл нь юу байгааг судалгаагаар нийтэд нь шалгаж, тогтоох шаардлагатай байна. Монгол Улсын авлигын түвшинд нөлөөлсөн гол шалтгааныг уг судалгаанд ийн тайлбарлаж байна. Улс төр хууль хяналтын байгууллагын хүрэн

дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа нь Монгол Улс дахь авлигын түвшинд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар шинжээчдээс нээлттэй асуулгын хэлбэрээр асуухад нийт 25 төрлийн давхацсан санал, бодлоор хариулсан. Давхардсан саналыг адил утгаар нь кодлосон болно.

Хүснэгт 2. Монгол Улсын авлигын ерөнхий түвшинд нөлөөлсөн гол хүчин зүйлс, нөхцөл байдал (хувиар)

Код		Давтамж	Хувь
1	Төрийн байгууллагын хүнд суртал	15	11.2
2	Мэдээллээ ил тод бус байдал	19	14.2
3	Төрийн албан хаагчид мөнгө төлж ажилд ордог	19	14.2
4	Сонгууль хууль бусаар явагддаг байдал	13	9.7
5	Иргэдийн сэтгэлгээ, ёс зүйн хандлагыг сул	17	12.7
6	Хүн амын тоо бага	2	1.5
7	Төрийн оролцоот газруудыг хувьчлахгүй байгаа нь нөлөөлсөн	1	0.7
8	Нийгэм эдийн засгийн хангалтгүй байдал	9	6.7
9	АТГ нь өөрөө авлигалд өртсөн байдаг	1	0.7
10	Улс төрийн хариуцлагагүй байдал	5	3.7
11	Хэт их улс төржиж байна	3	2.2
12	Төрийн хяналт хангалтгүй байна	6	4.5
13	Төрийн байгууллагын эрх мэдэл их байгаатай	2	1.5
14	Хууль боловсруулах батлах явц нь авлига боловсронгуй болох явцаас хоцорч байна	2	1.5
15	Төгрөгийн ханш суларч байна	1	0.7
16	Зах зээл тогтоогүй, ЖДҮ-ийн зээл нөлөөлсөн	2	1.5
17	Шударга өрсөлдөөний хууль үйлчилдэггүй	3	2.2
18	Авлигыг үл тэвчих хандлага тогтоогүй	1	0.7
19	Улс төрийн санхүүжилт зохицуулалт муутай	1	0.7
20	Шүүх, прокурорын үйл ажиллагаанд тохироо их байна	2	1.5
21	Иргэдийн хууль эрх зүйн мэдээлэл бага	3	2.2
22	Цахим хэлбэрт шилжихгүй байгаа учир	1	0.7
23	Үе солигдож байна	1	0.7
24	Засаглалын тогтворгүй байдал	1	0.7
25	Хүлээлгэх арга хэмжээ, шийтгэл муу	2	1.5
99	Хариулж мэдэхгүй	2	1.5
НИЙТ		134	100.0


Авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд хүн ба нийгэм хоорондын харилцаа холбоог сайтар ойлгох хэрэгтэй юм. Түүнээс гадна төрийн албан хаагчдын дээрээс томилдог томилгоо 14.2 балл, нээлттэй бус мэдээлэл 14.2 балл, Иргэдийн сэтгэлгээ, ёс зүйн хандлага сул 12.7 балл, сонгууль хууль бусаар явагддаг 9.7 балл, Нийгэм эдийн засгийн хангалтгүй байдал 6.7 балл, төрийн хяналтын байгууллагын сул ажиллагаа 4.5 балл байна. Иймд авлигыг буруулахад чиглэсэн үр дүнтэй ажил зохион байгуулах ёс журмыг сахиулахад анхаарч боломжит сургалтыг явуулж, захиргааны хэм хэмжээг товч тодорхой болгох, төрөөс хэрэгжүүлж байгаа үйлчилгээний талаар дэлгэрэнгүй ойлгомжтой иргэдэд сурталчлах, иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч түргэн шуурхай шийдвэрлэх, үр ашигтай арга замыг хэрэгжүүлэх.

ХОЁР. 2020 ОНЫ УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТҮВШИН

Авлигын түвшин нийгэм эдийн засгийн чадавхаас шууд хамаардаг. Авлигын түвшний өнгөрсөн болон ирээдүйн үнэлгээ аль аль нь олон нийтийн ойлголт төсөөлөл дээр тулгуурладаг. Авлигын тархалтыг илрүүлэхийн тул “Авлига түгээмэл үзэгдэл

болсон” гэдэг үзүүлэлтийг үндэс болгон ашигласан. Авлигын төсөөллийн индексэд ашигласан шатлалд ойртуулахын тулд дунджийг тооцож ашигласан.

Зураг 6. Улс төрийн авлигын түвшин, 2008-2020 онд хувиар



Судалгааны үр дүнд 2020 онд улс төрийн авлигын төсөөллийн индекс 3.98 гарлаа. Өмнөх оныхоос -0.10 баллын өөрчлөлттэй байгаа нь авлига нь аажмаар буурах хэтийн төлөвийг харуулж байна. 2019 онд улс төрийн хүрээн дэх авлигын төсөөллийн индексийн дундаж 4.08 гарсан. 2018-2019 оны үзүүлэлттэй харьцуулахад 0.15 баллаар өсжээ. Тус судалгаа хийгдэж ирсэн өнгөрсөн 12 жилийн үзүүлэлтийг харьцуулан харахад 3.89 байгаа нь авлигын түвшин тогтвортой хэлбэлзэх хандлагатай байна.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 1. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ЦАР ХҮРЭЭ

Улс төрийн авлигын түвшинг тогтооходоо дараах үндсэн дөрвөн шалгуур үзүүлэлтийг ашигладаг цар хүрээ, хэлбэр, шалтгаан нөхцөл, хор уршиг, үр дагавар болно. Үндсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн хувьд ч энэ оны судалгаагаар бага зэргийн өсөлт тогтоогдсоныг өнгөрсөн жилийн өөрчлөлттэй харьцуулан жишин үзье.


Зураг 7. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ, 2018-2020 оны индекс.



Авлигын шалгуур үзүүлэлтийг тогтооход 2020 онд авлигын цар хүрээ 4.10 буюу -0.03 функтээр өөрчлөгдөж өмнөх 2019 оныхоос буурсан дүн гарлаа. Авлигын хэлбэр нь 3.89 гарч -0.15 функтийн өөрчлөлттэйгөөр буурсан. Авлигын шалтгаан, нөхцөлийн хувьд 4.13 буюу -0.08 функтээр буурчээ.

Авлигын хор уршиг, үр дагавар нь 3.93 функт буюу -0.05-аар тус тус буурсан нь эерэг дүн боловч өмнөх 2018-2019 он хүртэл өссөөр байсан. Харин үүнийг шинжээчид эксперт ярилцлагын аргаар тодруулахад 2019 оны ковид-19 гарсантай холбогдуулан иргэд ААНБ-ууд хөл хорионд орж ажил хэрэг амжуулах нь буурсан нь нөлөөлсөн гэх байр суурьнаас хандсан.

Зураг 8. Улс төрийн авлигын цар хүрээний үнэлгээ (индекс)



Улс төрийн авлигын цар хүрээний үнэлгээ 2020 онд 4.08 гарч, өмнөх оны дүнгээс 0.05 пунктээр илүү гарлаа. Улс төрийн авлигын цар хүрээг нийт 5 дэд үзүүлэлтийн хүрээнд тодорхойлсон бөгөөд тус бүрт дараах өөрчлөлт гарсан байна. Үүнд:


1. Улс төрийн авлигын түгээмэл байдал 2020 онд (-0.04); 2018-2019 онд (-0.02)

- Улс төрийн авлигын түвшний өөрчлөлт 2020 онд (+0.06); 2018-2019 онд (+0.13) байсан.
- Салбар хүрээн дэх улс төрийн авлигын тархалтын цар хүрээ 2020 онд (+0.09); 2018-2019 онд(-0.01) байсан.
- Төрийн байгууллагын тодорхой үйл ажиллагаан дахь авлигын түвшин 2020 онд (-0.03); 2018-2019 онд (+0.20)
- Тодорхой салбар болон үйл ажиллагаанд улс төрийн авлига чиглэгдсэн байдал, салбар үйл ажиллагаатай улс төрийн авлига хэр холбогдсон болох нь 2020 онд (-0.11); 2018-2019 онд (+0.15) ул байна.

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 1. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТҮГЭЭМЭЛ БАЙДАЛ


Монгол Улсад авлига нь маш өргөн цар хүрээтэйгээр салбар бүрт илэрч байгаа. Үүнийг иргэд, албан хаагчид, бизнесменүүд, улс төрийн зүтгэлтнүүд нийгэмд энгийн байдаг л зүйл мэтээр хүлээн авах нь ихэссэн харагдана. Ялангуяа улс төрийн байгууллагын хүрээн дэх авлигыг шинжээчид дараах байдлаар илэрхийллээ.

Зураг 9. Монгол Улсын улс төрийн байгууллагын хүрээн дэх авлига, хувиар



Монгол Улсын улс төрийн байгууллагын хүрээн дэх авлигын нөхцөл байдлыг шинжиллээ. Улс төрийн байгууллагын хүрээн дэх авлига монголын нийгэмд нилээд газар авсан байна. Их байгаа гэж харуулсан респондентууд 43.5 хувь, маш их гэж 40.3, дундзэрэг гэж үнэлсэн нь 12.9 байна. Монголд авлига огт байхгүй, бага зэрэг гэж хариулсан респондентууд байгаагүй болох нь дээрх зураг харуулж байна.

Зураг 10. Монгол Улсын улс төрийн байгууллагын хүрээн дэх авлигын харьцуулалт, хувиар




Улс төрийн авлигын түгээмэл байдлын үнэлгээ 4.32 гарч өмнөх оныхоос 0.02 пунктээр (2018 онд 4.32) буурсан буюу бараг өөрчлөлтгүй байна. Дээрх харьцуулалтаас харахад улс төрийн байгууллагын хүрээн дэх авлига их гэж үнэлсэн нь 2018 оныхоос 5.6, 2019 оныхоос 14.7 хувиар өссөн нь аажмаар тогтвортой нэмэгдэх төлөвтэй байна. Харин маш их гэж үнэлсэн респондентуудын 2018 оны судалгааны харцуулттай харьцуулвал -5.29% 2019 оны үзүүлэлтээс -14.2 %-иар буурсан нь улс төрийн байгууллагын хүрээн дэх авлига харьцангуй багассан бүхий дүн гарлаа.

дэд үзүүлэлт 2. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТҮВШНИЙ ӨӨРЧЛӨЛТ


Шинжээчдийн өгсөн авлигын цар хүрээний үнэлгээг улс төрийн хүрээний байгууллага, албан тушаалтны үйлдэл, үйл ажиллагаа, шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнийхэн болон албан тушаалтны үйлдэл, үйл ажиллагаа тус бүрээр гаргаж, тэдгээрийн дунджаар тооцно. “Цар хүрээ” гэдэгт авлигын тархалтын хэмжээ, давтамжийг тодорхойлон гаргана.

Зураг 11. Улс төрийн байгууллагын хүрээн дэх авлига өмнөх жилийн түвшнээс өөрчлөгдсөн байдал, хувиар



Монгол улсын Улс төрийн байгууллагын хүрээн дэх авлига өмнөх жилийн түвшнээс хэр өөрчлөгдсөн талаар олон нийтийн санал бодлыг авлигад автах магадлалтай салбар байгууллагуудын албан тушаалтнаас тодруулга болгон шинжлэв. 38.7 хувь нь нэмэгдсэн хандлагатай гэж харцуулсан бол 33.9 хувь нь өөрчлөгдөөгүй хэвэндээ байгаа гэжээ. 19.4 хувь нь маш их нэмэгдэж байгаа гэсэн бол 4.8 хувь нь багассан, 3.2 хувь нь хэрхэн өөрчлөгдсөнийг мэдэхгүй байна гэж санал бодлоо тусгажээ.

Зураг 12. Улс төрийн хүрээн дэх авлигын түвшний өөрчлөлт, индекс



Улс төрийн хүрээнд дэх авлигын түвшин өөрчлөгдсөн байдалд өгсөн үнэлгээ 3.69 гарч өмнөх оноос 0.13 пунктээр 2018 онд 3.56 өссөн бага зэргийн өөрчлөлттэй гарсан байна. Ингэхдээ шинжээчдийн 56.1% нь улс төрийн хүрээнд авлига өмнөх оны байдалтай харьцуулахад “нэмэгдсэн” болон “маш их нэмэгдсэн” гэж үнэлсэн. Харьцуулалтаас харахад 2018 оны тус хоёр үзүүлэлтийн нийлбэр 48.5% байв. Харин 2020 онд өөрчлөгдөөгүй гэж 33,9% хувь нь харцуулсан нь өмнөх оны дүнгээс 2.1 %-ийн өөрчлөлт оржээ. Шинжээчдийн 38.7 хувь нь өмнөх оноос 2.3 %-ийн өөрчлөлттэйгөөр авлига нэмэгдсэн байна.

дэд үзүүлэлт 3. ТӨРИЙН ИНСТИТУЦИ ДЭХ УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТАРХАЛТЫН ЦАР ХҮРЭЭ

Монгол Улсад сүүлийн нэг жилийн хугацаанд дараах салбар, хүрээнд авлига тархсан цар хүрээг шинжээчид тодорхойллоо. Үүнд: Засгийн газар /яам, агентлаг 48.4%, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, ЗДТГ 41.9%, Нутгийн өөрөө удирдах байгууллага 40.3%, Ерөнхийлөгчийн засаглалын хүрээ 35.5%, Монгол Улсын Их Хурал 32.3 % байгаа нь Монгол улсын төрд авлига нилээдгүй тархсан байна.

Хүснэгт 3. Сүүлийн нэг жилийн хугацаанд дараах салбар, хүрээнд авлига тархсан цар хүрээ

Салбар хүрээ	Огт үгүй (1)	Бага зэрэг (2)	Дунд зэрэг (3)	Их (4)	Маш их (5)	Мэдэхгүй (9)	Дундаж (1-5)
Монгол Улсын Их Хурал	1.6	3.2	22.6	32.3	32.3	8.1	3.98
Ерөнхийлөгчийн засаглалын хүрээ	4.8	3.2	22.6	35.5	21.0	12.9	3.74
Засгийн газар /яам, агентлаг/	0	0	16.1	48.4	33.9	1.6	4.18
Нутгийн өөрөө удирдах байгууллага /аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ/	0	9.7	16.1	40.3	30.6	3.2	3.95
Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, ЗДТГ	0	1.6	19.4	41.9	37.1	0	4.15

Тайлбар: Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал, 5-маш сайн, 4-сайн, 3-дунд, 2-тааруу, 1-маш муу

Төрийн институци дэх улс төрийн авлигын тархалтын үзүүлэлт 3.33 дундажтай өмнөх онохоос +0.58 пунктийн өөрчлөлттэй гарлаа. (2019 оны индекс 3.92).

Хүснэгт 4. Салбар хүрээнд (төрийн институци) дэх авлига тархсан байдал.

№		2018	2019	2020	Өөрчлөлт
1	Монгол Улсын Их Хурал	3.87	4.04	3.98	-0.06
2	Ерөнхийлөгчийн засаглалын хүрээ	3.57	3.75	3.74	-0.01
3	Засгийн газар /яам, агентлаг/	4.23	4.22	4.18	-0.04
4	Нутгийн өөрөө удирдах байгууллага /аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ/	3.75	3.56	3.95	+0.39
5	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, ЗДТГ	3.97	3.85	4.15	+0.3
6	Улс төрийн намууд	4.21	4.08	0	0

Ингэхдээ ерөнхийлөгчийн засаглалын хүрээ болон Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, яам агентлаг, үзүүлэлт бага зэрэг өссөн (- 0.01; -0.04; -0.06) бол аймаг/нийслэл, сум/дүүргийн засаг дарга/ЗДТГ болон Нутгийн өөрөө удирдах байгууллагын үзүүлэлт

+ 0.3; +0.39 баллын хооронд нэмэгдэж өнгөрсөн оныхоос эсрэг үзүүлэлттэй байна. Ингэхдээ засгийн газар, түүний харъяа байгууллага болон Монгол улсын их хурал, улс төрийн намууд, Нутгийн өөрөө удирдах байгууллага /аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ/ урьдын адил авлига хамгийн түгээмэл институцээр тооцогдсон хэвээр байна.

дэд үзүүлэлт 4. ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТАРХАЛТЫН ЦАР ХҮРЭЭ


Хүснэгт 5. Нийтийн алба/төрийн байгууллагын үйл ажиллагаан дахь авлигын тархалтын цар хүрээ.

№	Үйл ажиллагаа	Бага зэрэг (2)	Дунд зэрэг (3)	Их (4)	Маш их (5)	Мэдэхгүй (9)	Дундаж (1-5)
1	Төсвийн зарцуулалт	6.5	16.1	38.7	35.5	3.2	4.06
2	Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах	-	11.3	35.5	48.4	4.8	4.39
3	Худалдан авах ажиллагаа, тендер шалгаруулалт	-	4.8	35.5	58.1	1.6	4.54
4	Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	3.2	14.5	37.1	43.5	1.6	4.23
5	Тусгай сангийн үйл ажиллагаа	3.2	9.7	30.6	48.4	8.1	4.35
6	Албан тушаалын томилгоо	-	8.1	35.5	54.8	1.6	4.48

Тайлбар: Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал, 5-маш сайн, 4-сайн, 3-дунд, 2-тааруу, 1-маш муу

Төсвийн хөрөнгө ихээр эргэлддэг газар буюу төрийн үйлчилгээ явагддаг талбарт авлигын хэмжээ өссөн байна. Ялангуяа төрд тендер, худалдан авах ажиллагаа, зөвшөөрөл, газар эзэмших эрх авахад авлига нь ноцтой илэрдэг хүрээ бөгөөд мөн төрийн дунд шатны байгууллагуудын дунд ч авлига нь өргөн хүрээтэйгээр илрэн гарч байна.

Зураг 13. Төрийн байгууллагын үйл ажиллагаан дахь авлигын тархалтын цар хүрээ.



Төрийн байгууллагын үйл ажиллагаан дахь авлигын тархалтын цар хүрээг тодорхой зургаан чиглэлээр авч үнэлүүлсэн. Нэгдсэн дүнгийн үзүүлэлтээр 4.34 гарч, өмнөх оны дүнтэй харьцуулахад -0.03 пунктээр буурсан өөрчлөлттэй байна.

дэд үзүүлэлт 5. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН НӨЛӨӨЛӨЛ, ЧИГЛЭЛ

Улс төрийн хүрээний авлига салбар болон үйл ажиллагаанд хэр зэрэг чиглэгдсэн болох талаар тодруулга хийх үүднээс салбар, үйл ажиллагааны чиглэлээр нөлөөлж болохуйц үзүүлэлтүүдийг доорх хүснэгтээр үзүүлж байна.

Хүснэгт 6. Улс төрийн хүрээний авлигын чиглэл

№	Салбар, үйл ажиллагаа	Огт үгүй (1)	Бага зэрэг (2)	Дунд зэрэг (3)	Их (4)	Маш их (5)	Мэдэхгүй (9)	Дундаж (1-5)
1	Уул уурхай, ашигт малтмал	-	1.6	4.8	29.0	61.3	3.2	4.55
2	Гадаадын хөрөнгө оруулалт	-	8.1	21.0	30.6	30.6	9.7	3.93
3	Аж үйлдвэр	-	3.2	22.6	25.8	19.4	29.0	3.86
4	Дэд бүтэц	-	-	21.0	35.5	38.7	4.8	4.19
5	Барилга		6.5	19.4	27.4	46.8	-	4.15
6	Шүүх	1.6	6.5	16.1	25.8	43.5	6.5	4.10
7	Хууль сахиулах	-	8.1	9.7	35.5	33.9	12.9	4.09
8	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	3.2	8.1	25.8	21.0	29.0	12.9	3.74
9	Хууль тогтоох, шийдвэр гаргах үйл ажиллагаа	-	4.8	22.6	33.9	30.6	8.1	3.98
10	Бизнес, хувийн хэвшил	6.5	17.7	27.4	21.0	16.1	11.3	3.26
11	Төрийн алба	-	-	22.6	33.9	38.7	4.8	4.17
12	Олон улсын төрийн бус байгууллага	-	-	-	100	-	-	4.00

Тайлбар: Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал, 5-маш сайн, 4-сайн, 3-дунд, 2-мааруу, 1-маш муу

Нийтийн алба /төрийн байгууллага/-ны дараах үйл ажиллагаанд хэр зэрэг чиглэгдсэн болохыг шинжээчид салбараар тодорхойлсоныг эрэмбэлэн үзүүлье. Улс төрийн хүрээний авлига салбар болон үйл ажиллагаанд хамгийн их чиглэгдсэн салбарууд:

1. Уул уурхай, ашигт малтмалын салбар
2. Дэд бүтэц
3. Барилга
4. Төрийн алба
5. Шүүх
6. Хууль сахиулах байгууллага

Дундаж хэмжээнд чиглэгдсэн салбарууд

1. Хууль тогтоох, шийдвэр гаргах үйл ажиллагаа
2. Гадаадын хөрөнгө оруулалт
3. Аж үйлдвэр

Бага хэмжээнд чиглэгдсэн салбарууд:

1. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
2. Бизнес, хувийн хэвшил
3. Олон улсын төрийн бус байгууллагуудыг эрэмбэлж байна.

Хүснэгт 7. Улс төрийн хүрээний авлигын чиглэл, индексээр.


№		2018 он	2019 он	2020 он	Өөрчлөлт
1	Уул уурхай, ашигт малтмал	4.57	4.61	4.55	-0.06
2	Гадаадын хөрөнгө оруулалт	3.96	4.08	3.93	-0.15
3	Аж үйлдвэр	4.11	3.72	3.86	+0.14
4	Дэд бүтэц	4.1	4.43	4.19	-0.24
5	Барилга	4.02	4.19	4.15	-0.04
6	Шүүх	3.97	4.38	4.1	-0.28
7	Хууль сахиулах	3.84	4.11	4.09	-0.02
8	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	3.81	4.03	3.74	-0.29
9	Хууль тогтоох, шийдвэр гаргах ажиллагаа	3.81	4.12	3.98	-0.14
10	Бизнес, хувийн хэвшил	3.38	3.2	3.26	+0.06
11	Төрийн алба	4.14	4.32	4.17	-0.15
12	ОУБ	0	0	4	4

Улс төрийн авлига бусад салбар хүрээний үйл ажиллагаа руу хэр чиглэж байгаа буюу нөлөөллийн авлигын чиглэл буюу аль салбар, үйл ажиллагаатай хэр холбогдсон байдал үнэлгээний үзүүлэлт 4.00 гарч өмнөх оны үнэлгээнээс 2.83 пунктээр өссөн байна. Иймд Улс төрийн хүрээний авлигад салбар болон үйл ажиллагаанд хамгийн их чиглэгдсэн зургаан салбаруудад ач холбогдол өгч бууруулах арга зүйг нэвтрүүлэх хэрэгтэй.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 2. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХЭЛБЭР

Авлигад оролиогчид голдуу далд хэлбэрээр хуйвалдан үйлддэг. Монгол улсын хуульд Авлига авсан, өгсөн, зуучилсан этгээдүүдэд эрүүгийн харууллага хүлээлгэхээр хуульчилсан байдаг. Улс төрийн хүрээнд авлигын тархсан байдлыг судлан шинжээчдийн төсөөллөөр үнэлэн гаргав.

Зураг 14. Улс төрийн авлигын хэлбэрийн үнэлгээ, индексээр.



Улс төрийн хүрээн дэх авлигын хэлбэрийн үнэлгээ 3.88 гарч өмнөх оны үнэлгээнээс -0.16 пунктээр буурсан байна. (2019 оны үзүүлэлт 4.04, 2018 оны үзүүлэлт 3.81). Улс төрийн авлигын хэлбэрийг нийт 5 дэд үзүүлэлтийн хүрээнд тодорхойлох бөгөөд энэ удаа бүх дүн буурсан. Ийм үр дүн гарсан нь улс төрийн хүрээн дэх авлигын хэлбэрүүд харьцангуй багасч байгаа эерэг тайлтай.

1. Хээл хахуулийн хэлбэр -0.16;
2. Хээл хахууль өгөх, авах аргууд -0.09;
3. Бүлэглэлүүдийн нөхцөл байдал -0.15;
4. Авлигын хэлбэр -0.23;
5. Хууль бус нөлөөллийн хэлбэр - 0.04.

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 1. ХЭЭЛ ХАХУУЛИЙН ХЭЛБЭР

Хээл хахууль нь нийгэм, эдийн засгийг хүндрэлд оруулахаас гадна, хувь хүний ёс зүйд нөлөө үзүүлж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд саад учруулж байна. Иймд төр ба хувь хүний оролцоо маш чухал байдаг. Улс төрийн хүрээнд албан тушаалтнаар өөрт ашигтай, давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахад түгээмэл ашигладаг хэлбэрүүд нь дараах шинжтэй байна.

Хүснэгт 8.Хээл хахуулийн хэлбэрийн дундаж

№	Хээл хахуулийн хэлбэр	Орт үгүй (1)	Бага зэрэг (2)	Дунд зэрэг (3)	Их (4)	Маш их (5)	Мэдэхгүй (9)	Дундаж (1-5)
1	Бэлэн мөнгө өгөх	-	6.5	12.9	30.6	41.9	8.1	4.18
2	Хувьцаа өгөх	-	21.0	17.7	29.0	11.3	21.0	3.39
3	Гадаадын банкинд данс нээж өгөх	3.2	12.9	16.1	19.4	19.4	29.0	3.55
4	Ашиг, орлогоо хуваалцах	-	9.7	16.1	48.4	22.6	3.2	3.87
5	Аялал жуулчлалын зардал төлөх	4.8	17.7	21.0	22.6	24.2	9.7	3.48
6	Гадаад арга хэмжээний зардал төлөх	1.6	16.1	25.8	22.6	22.6	11.3	3.55
7	Үнэтэй бэлэг өгөх	1.6	9.7	29.0	32.3	21.0	6.5	3.66
8	Ажил, албан тушаалд томилох, оруулах	-	-	12.9	30.6	53.2	3.2	4.42
9	Эмчилгээ, сувилгааны зардал төлөх	1.6	25.8	17.7	32.3	11.3	11.3	3.29
10	Сургалтын зардлыг төлөх	1.6	19.4	24.2	33.9	12.9	8.1	3.40
11	Ажил, үйлчилгээний төлбөрийн хөнгөлөлт эдлүүлэх	-	17.7	24.2	30.6	17.7	9.7	3.54
12	Өрийг нь төлөх	1.6	14.5	22.6	22.6	16.1	22.6	3.48
13	Шагнал, цол, тэмдгээр шагнах	-	12.9	17.7	33.9	29.0	6.5	3.85


Тайлбар: Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал, 5-маш сайн, 4-сайн, 3-дунд, 2-тааруу, 1-маш муу

Улс төрийн хүрээнд албан тушаалтнаар өөрт ашигтай, давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахад түгээмэл ашигладаг хэлбэрүүдийг шинжээчдээр 1-5 баллаар үнэлүүлсэн үнэлгээг хувиар тооцохын зэрэгцээ дундаж үзүүлэлтийг тооцон гаргасан болно. Улс төрийн авлигын хэлбэр олон янзаар илэр гарч ирдэг ба энэ нь улам бүр далд хэлбэртээ шилждэг байна. Ялангуяа хамгийн өргөнөөр ашиглагддаг хэлбэрийг эрэмбэлвэл дараах шинжтэй байна.

1. Ажил, албан тушаалд томилох, оруулах (4.42);
2. Бэлэн мөнгө өгөх, авах (4.18);
3. Ашиг, орлогоо хуваалцах (3.87);
4. Шагнал, цол, тэмдгээр шагнах (3.85);
5. Үнэтэй бэлэг сэлт өгөх /байр, машин гэх мэт/ (3.66);
6. Гадаадын банкинд данс нээж өгөх (3.55);
7. Гадаад арга хэмжээний зардал төлөх (3.55)
8. Ажил, үйлчилгээний төлбөрийн хөнгөлөлт эдлүүлэх (3.54);
9. Аялал жуулчлалын зардал төлөх (3.48);

10. Өрийг нь төлөх (3.48);
11. Сургалтын зардлыг төлөх (3.40);
12. Хувьцаа өгөх (3.39);
13. Эмчилгээ, сувилгааны зардал төлөх (3.29);

Зураг 15. Хээл хахуулийн хэлбэрийн үнэлгээ.



Улс төрийн хүрээн дэх хээл хахуулийн хэлбэрийн үнэлгээ 3.67 гарч өмнөх оноос -0.16 пунктээр багассан үзүүлэлттэй байна (2019 оны үзүүлэлт 3.84; 2018 оны үзүүлэлт 3.59). Улс төрийн авлигын хүрээн дэх хээл хахуулийн 13 хэлбэрээс өмнөх оныхоос бэлэн мөнгө өгөх 0.09, Ажил, албан тушаалд томилох, оруулах 0.10, Өрийг нь төлөх 0.05 пунктээр эдгээр гурван хэлбэр нь мэдэгдэхүйц өссөн байна. Бусад хээл хахуулийн хэлбэрийн хувьд (+/- 0.01-0.33) пунктээр буурчээ. Дараах хэлбэрүүдийн хувьд үзүүлэлт мэдэгдэхүйц өссөн байна:

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 2. ХУУЛЬ БУС НӨЛӨӨЛЛИЙН ХЭЛБЭР

Улс төрчид, өндөр албан тушаалтнууд хувийн зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөхийн тулд хэрэглэдэг арга хэлбэрүүдэд шинжээчдийн өгсөн харцулманд үндэслэн дараах дүнгийн хүснэгтийг боловсруулав.

Хүснэгт 9. Улс төрчид, өндөр албан тушаалтнууд хувийн зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөхийн тулд хэрэглэдэг арга хэлбэрүүд,


№	Нөлөөллийн хэлбэр	Огт үгүй (1)	Багазэрэг (2)	Дундзэрэг (3)	Их (4)	Маш их (5)	Мэдэхгүй (9)	Дундаж (1-5)
1	Дарамт шахалт үзүүлэх	-	3.2	9.7	43.5	37.1	6.5	4.22
2	Садан төрлийн хэлхээ холбоог ашиглах	-	6.5	12.9	43.5	32.3	4.8	4.07
3	Найз, танил талын хэлхээ холбоог ашиглах	-	8.1	8.1	38.7	45.2	-	4.21
4	Нутаг орны хэлхээ холбоог ашиглах	-	8.1	19.4	32.3	33.9	6.5	3.98
5	Намын хэлхээ холбоог ашиглах	-	1.6	9.7	30.6	56.5	1.6	4.44
6	Айлган сүрдүүлэх, заналхийлэх	1.6	14.5	21.0	22.6	29.0	11.3	3.71
7	Алдаах	1.6	14.5	16.1	33.9	22.6	11.3	3.69

8	Амлалт өгөх	-	11.3	12.9	40.3	30.6	4.8	3.95
9	Хүсэлт тавих	3.2	6.5	21.0	27.4	33.9	8.1	3.89
10	Улс төрчийн нөлөө	-	9.1	-	27.3	18.2	45.5	4.00

Тайлбар: Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал, 5-маш сайн, 4-сайн, 3-дунд, 2-тааруу, 1-маш муу

Үүнд: Улс төрийн намын хэлхээ холбоог ашиглаж нөлөөлдөг, дарамт шахалт үзүүлэх, Найз, танил талын хэлхээ холбоог ашиглах, Улс төрчийн нөлөөллийн арга хэрэглэж дадсаар иржээ. Түүнчлэн амлалт өгөх хүсэлт тавих, албадах зэргээс танил талын нөлөөллүүд үүсдэг байна.

Зураг 16. Хууль бус нөлөөллийн үнэлгээ.



Улс төрчид, өндөр албан тушаалтнууд хувийн зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ нь 36.16 гарч өмнөх оноос -0.10 пунктээр буурсан байна (2019 онд 4.12; 2018 онд 3.96).

Хууль бус нөлөөллийг тогтоох 9 дэд үзүүлэлтээс бараг бүгд бууралттай гарсан. Харин Айлган сүрдүүлэх, заналхийлэх 0.08, Албадах 0.02 пунктээр бага зэрэг нэмэгдсэн байна. Өмнөх онуудад буурч байсан нөлөөллийн хэлбэр өсөж, нэмэгдэж байсан нөлөөллийн хэлбэр буурсаныг дээрх хүснэгт харуулж байна.

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 3. УЛС ТӨРИЙН НАМ, БҮЛЭГЛЭЛ, УЛС ТӨР, БИЗНЕС, ГЭМТ ХЭРГИЙН БҮЛЭГЛЭЛҮҮДИЙН ХАРИЛЦАА ХАМААРАЛ

Сүүлийн нэг жилийн хугацаанд үүссэн нөхцөл байдал байгаа (бий болсон) гэдэгт шинжээчид ийнхүү санал бодлоо илэрхийлсэнийг дундаж үзүүлэлтээр дүгнэн тайлбарлана. Улс төрчдийн халаасны ТББ-д төсвийн хөрөнгийг зарцуулах 4.67, Улс төрийн авлига нь илүү далд хэлбэрт шилжсэн 4.45, Улс төр, бизнесийн бүлэглэл нэгдсэн 4.21, Бизнесийн бүлэглэл улс төрчдийг эрхшээлдээ оруулсан 4.12, Улс төрчид шүүгч болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн 4.05, Улс төрчид бизнесийн бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан 4.00 гэсэн байдлаар илэрхийлсэн.

Хүснэгт 10. Сүүлийн нэг жилийн хугацаанд үүссэн нөхцөл байдал байгаа (бий болсон) гэдэгтэй шинжээчдийн нийлж буй эсэх.

№	Нөхцөл байдал	Үгүй (1)	Бага зэрэг (2)	Дунд зэрэг (3)	Их (4)	Маш их (5)	Мэдэхгүй (9)	Дундаж (1-5)
1	Улс төрчид бизнесийн бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан	4.8	4.8	11.3	37.1	35.5	6.5	4.00
2	Бизнесийн бүлэглэл улс төрчдийг эрхшээлдээ оруулсан	1.6	4.8	16.1	30.6	41.9	4.8	4.12
3	Улс төр, бизнесийн бүлэглэл нэгдсэн	-	6.5	11.3	33.9	45.2	3.2	4.21
4	Улс төрийн нам /бүлэглэл/ гэмт бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан	8.1	17.7	11.3	22.6	21.0	19.4	3.38
5	Гэмт бүлэглэл улс төрийн нам /бүлэглэл/-ыг эрхшээлдээ оруулсан	8.1	8.1	22.6	24.2	12.9	24.2	3.34
6	Гадны улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-ыг эрхшээлдээ оруулсан	4.8	11.3	19.4	29.0	12.9	22.6	3.44
7	Гадны бизнесийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-ыг эрхшээлдээ оруулсан	3.2	11.3	17.7	35.5	16.1	16.1	3.59
8	Гадны улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-тай нэгдсэн	11.3	8.1	19.4	17.7	14.5	29.0	3.23
9	Гадны бизнесийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-тай нэгдсэн	4.8	4.8	24.2	27.4	16.1	22.6	3.58
10	Улс төрийн авлига нь илүү далд хэлбэрт шилжсэн	-	3.2	8.1	29.0	59.7	-	4.45
11	Улс төрчид шүүгч болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн	1.6	3.2	22.6	27.4	38.7	6.5	4.05
12	Улс төрчдийн халаасны ТББ-д төсвийн хөрөнгийг зарцуулах	-	-	-	8.3	16.7	75.0	4.67

Тайлбар: Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал, 5-маш сайн, 4-сайн, 3-дунд, 2-мааруу, 1-маш муу

Иймд уг нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж анхаарах нь тэргүүнд тавигдах ажил юм.

Төрийн өндөр албан тушаалтнууд, улс төрчид болон улс төрийн нам, бүлэглэл, гадаад дотоод бизнесийн бүлэглэл, гэмт бүлэглэлийн харилцаа хамаарлын үнэлгээ 3.84 гарч өнгөрсөн оноос -0.12 пунктээр буурсан байна. (2019 оны үзүүлэлт 3.96).

Хүснэгт 11. Бүлэглэлүүдийн харилцаа хамаарал, нөхцөл байдлын үнэлгээ.индексээр.

№	Нөхцөл байдал	2018	2019	2020	Өөрчлөлт
1	Улс төрчид бизнесийн бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан	3.8	4.21	4	-0.21
2	Бизнесийн бүлэглэл улс төрчдийг эрхшээлдээ оруулсан	4.2	4.21	4.12	-0.09
3	Улс төр, бизнесийн бүлэглэл нэгдсэн	4.35	4.46	4.21	-0.25
4	Улс төрийн нам /бүлэглэл/ гэмт бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан	3.36	3.7	3.38	-0.32
5	Гэмт бүлэглэл улс төрийн нам /бүлэглэл/-ыг эрхшээлдээ оруулсан	3.29	3.72	3.34	-0.38
6	Гадны улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-ыг эрхшээлдээ оруулсан	3.42	3.63	3.44	-0.19

7	Гадны бизнесийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-ыг эрхшээлдээ оруулсан	3.75	3.66	3.59	-0.07
8	Гадны улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-тай нэгдсэн	3.27	3.4	3.23	-0.17
9	Гадны бизнесийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-тай нэгдсэн	3.4	3.44	3.58	+0.14
10	Улс төрийн авлига нь илүү далд хэлбэрт шилжсэн	4.19	4.28	4.45	+0.17
11	Улс төрчид шүүгч, хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн	4.15	4.3	4.05	-0.25
12	Улс төрчдийн халаасны ТББ-д төсвийн хөрөнгийг зарцуулах	0	0	4.67	+4.67

Нийт 12 нөхцөл байдлын үзүүлэлтээс 4 үзүүлэлтийн үнэлгээ нэмэгдэж бусад нь бүгд буурсан буюу өмнөх жилийхээс урвуу дүн гарсан. Нэмэгдсэн 4 үзүүлэлтийн үнэлгээ нь: Улс төрчид шүүгч, хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн +0.25; Улс төрийн авлига нь илүү далд хэлбэрт шилжсэн +0.17; Гадны бизнесийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-тай нэгдсэн +0.14; Улс төрчдийн халаасны ТББ-д төсвийн хөрөнгийг зарцуулах +4.67 тус сүүлийн үнэлгээ нь асуулгын бусад гэсэн мөрөнд нэмэлтээр хариулсан шинжээчийн хариулт болно.

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 4. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХЭЛБЭР

Монгол Улсад авлигын хэлбэр олон төрлөөр илэрч гардаг бөгөөд жил ирэх тусам авлигын арга хэлбэр нь нарийсаж далд хэлбэртээ шилждэг байна. Авлига нь салбар бүрт ихээхэн тохиолддог боловч улс төрийн хүрээнд илүү нарийсалтай байх нь элбэг. Судалгаанд хамрагдсан шинжээчдийн тайлбарыг боловсруулсан хүснэгтээс толилуулъя.

Хүснэгт 12. Сүүлийн нэг жилийн хугацаанд улс төрийн хүрээнд авлигын хэлбэрүүд тархсан байдал


№	Авлигын хэлбэр	Үгүй (1)	Бага зэрэг (2)	Дунд зэрэг (3)	Их (4)	Маш их (5)	Мэдэлгүй (9)	Дундаж (1-5)
1	Төрийн өмчийг хувьдаа завших	1.6	3.2	25.8	29.0	37.1	3.2	4.00
2	Аж ахуйн нэгжид давуу байдал бий болгох	-	4.8	11.3	37.1	45.2	1.6	4.25
3	Ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулах	-	-	16.1	29.0	54.8	-	4.39
4	Төсвийг хувийн ашиг сонирхлын дагуу хуваарилах	-	3.2	14.5	43.5	35.5	3.2	4.15
5	Бизнесийн бүлэглэлийн захиалгаар хууль тогтоомж санаачлан батлуулах, дэмжих	4.8	3.2	17.7	41.9	27.4	4.8	3.88
6	Сонгогчдын саналыг худалдан авах	-	4.8	8.1	24.2	59.7	3.2	4.43
7	Улс төрийн зорилгоор хандив өгөх, авах	-	4.8	8.1	35.5	50.0	1.6	4.33
8	Албан тушаалын байдлаа урвуулан ашиглах	-	4.8	9.7	38.7	45.2	1.6	4.26
9	Албан тушаал, эрх мэдлээ хэтрүүлэх	-	1.6	24.2	27.4	45.2	1.6	4.18
10	Хээл хахууль авах, өгөх, зуучлах	-	-	17.7	35.5	43.5	3.2	4.27
11	Шан харамж авах, өгөх	-	6.5	14.5	38.7	40.3	-	4.13

12	Төсвийн хөрөнгийг зориулалтын бус зарцуулах	1.6	3.2	14.5	43.5	33.9	3.2	4.08
13	Мөнгө угаах	1.6	4.8	17.7	22.6	32.3	21.0	4.00
14	Хууль бусаар дампууруулах	1.6	9.7	19.4	27.4	17.7	24.2	3.66
15	Төрийн өмчийг хууль бус арга замаар хувьчлах	4.8	11.3	22.6	27.4	21.0	12.9	3.56
16	Бизнес үнэ төлбөргүй хөрөнгө оруулах	-	-	-	-	100	-	5.00

Тайлбар: Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал, 5-маш сайн, 4-сайн, 3-дунд, 2-мааруу, 1-маш муу

Сүүлийн нэг жилийн хугацаанд улс төрийн хүрээнд авлигын хэлбэрүүд хэрхэн тархсан талаар шинжээчдийн төсөөллөөр гаргав. Эндээс дүгнэн үзэхэд бизнест үнэ төлбөргүй хөрөнгө оруулах, сонгууль болох үеэр сонгогчдын саналыг худалдан авах, ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулах, аж ахуйн нэгжид давуу байдал бий болгох, төсвийг хувийн ашиг сонирхлын дагуу хуваарилах, хээл хахууль авах, өгөх, зуучлах, шан харамж авах, өгөх, мөнгө угаах зэрэг үйлдлүүд нь авлигыг өөхшүүлэх байдлаар авлигын хэлбэрүүд улам тодорсоор иржээ.

Зураг 17. Улс төрийн хүрээнд дэх авлигын хэлбэр.



Улс төрлийн авлигын хэлбэрийн үнэлгээ 4.16 гарч өнгөрсөн оноос 0.17 пунктээр мэдэгдэхүйц буурсан үзүүлэлттэй байна (2019 онд 4.35; 2018 онд 4.06).

Нийт 15 дэд үзүүлэлтийн бүгдэд нь тодорхой хэмжээний (-0.4-0.35) пунктийн хооронд бууралт гарснаас авлигын хоёр хэлбэрийн хувьд мэдэгдэхүйц өссөн байна. Үүнд:

- Хээл хахууль авах, өгөх, зуучлах + 0.05,
- Бизнес үнэ төлбөргүй хөрөнгө оруулах +5.0 /энэ нь асуулгын бусад гэсэн мөрөнд нэмэлтээр харуулсан шинжээчдийн харуулт болно./

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 5. УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДАХ ХЭЭЛ ХАХУУЛЬ ӨГӨХ, АВАХ АРГА

Улс төрийн хүрээн дэх хээл хахууль өгөх, авах аргууд манай нийгэмд улс төрийн хүрээнд дэх хүндрэлтэй асуудал нь авилга хээл хахууль. Материаллаг сонирхолтой холбоотой эрх мэдэл болон бизнесийн үйл ажиллагаа түүнтэй холбогдох томоохон өмчлөл төрд хэдий чинээ их байна, төдий чинээ авилга хээл хахуульд төр идэгддэг. Тэгэхээр улс төрийн хүрээнд хээл хахууль өгөх, авах аргуудын үнэлгээг 1-5 баллаар үнэлэн хувиар тооцов.

Хүснэгт 13. Улс төрийн хүрээнд хээл хахууль өгөх, авах аргуудын үнэлгээ

№	Хээл хахууль өгөх, авах хэлбэр	Үгүй (1)	Бага зэрэг (2)	Дунд зэрэг (3)	Их (4)	Маш их (5)	Мэдэхгүй (9)	Дундаж (1-5)
1	Биечлэн уулзаж өгч, авах	4.8	21.0	14.5	30.6	16.1	12.9	3.37
2	Зуучлагчаар дамжуулах	-	4.8	19.4	29.0	38.7	8.1	4.11
3	Ойр дотны хүмүүсээр дамжуулах	-	6.5	12.9	41.9	30.6	8.1	4.05
4	Хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх	-	14.5	19.4	35.5	17.7	12.9	3.65
5	Ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдний компанид давуу байдал олгох	-	4.8	11.3	41.9	37.1	4.8	4.17
6	Эд зүйлсийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах	1.6	12.9	21.0	30.6	22.6	11.3	3.67
7	Эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах	1.6	9.7	19.4	27.4	35.5	6.5	3.91
8	Мөрийтэй тоглож санаатай алдах	6.5	11.3	16.1	12.9	16.1	37.1	3.33
9	Мөнгө зээлдүүлээд мартаx	1.6	17.7	12.9	16.1	19.4	32.3	3.50
10	Үйл ажиллагааны зардал болгож өгөх	3.2	6.5	21.0	32.3	29.0	8.1	3.84
11	Өмгөөлөгчөөр дамжуулах	6.5	14.5	16.1	19.4	12.9	30.6	3.26

Тайлбар: Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал, 5-маш сайн, 4-сайн, 3-дунд, 2-тааруу, 1-маш муу

Улс төрийн хүрээнд хээл, хахууль өгөх, авах аргуудыг хэр хэрэглэсэн болох талаарх шинжээчдын таамаглалыг хувь болон дунджаар үзүүллээ. Хээл хахууль өгөх, авах хэлбэрийг хамгийн түгээмэл байдлаар ашигладаг аргууд нь:

Ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдний компанид давуу байдал олгох
 Ойр дотны хүмүүсээр дамжуулах
 Зуучлагчаар дамжуулах
 Эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах
 Үйл ажиллагааны зардал болгож өгөх
 Эд зүйлсийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах
 Хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх
 Мөнгө зээлдүүлээд мартаx
 Биечлэн уулзаж өгч, авах
 Мөрийтэй тоглож санаатай алдах
 Өмгөөлөгчөөр дамжуулах

Хээл хахуулийн хамгийн өргөн хэрэглэгддэг аргууд нь ойр дотны гэр бүл, найз нөхдийн тусламж авах буюу итгэл даах хэн нэгнийг зуучлагч болгон ашиглахын зэрэгцээ ямар нэг эд зүйлсийн оролцуулах, үйл ажиллагааны зардал төлөх гэх мэт

байна. Дундаж байдлаар хэрэглэдэг аргууд нь 6-9 дугаарт байгаа бол төдийлөн ашигладаггүй хэлбэрүүд нь 10-12 дугаарт эрэмбэлэгдсэн байна.

Зураг 18. Улс төрийн хүрээнд хээл хахууль өгөх, авах аргуудын үнэлгээ, индексээр



Улс төрийн хүрээний хээл хахууль өгөх, авах аргуудыг хэрэглэсэн байдлын үнэлгээ 3.71 гарч өмнөх оноос -1.08 пунктээр буурсан байна. (2019 онд 3.79; 2018 онд 3.71). Нийт 11 түгээмэл үзүүлэлтийн 7 үзүүлэлтийн үнэлгээ өмнөх онуудаас бага зэрэг буурсан бол бусад 4 үзүүлэлт өссөн байна. Дараах үзүүлэлтийн үнэлгээ мэдэгдэхүйц өссөн.

Зуучлагчаар дамжуулах +0.19
 Биечлэн уулзаж өгч, авах +0.10
 Ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдний компанид давуу байдал олгох +0.06
 Эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах +0.06


Харин дараах долоон үзүүлэлтийн үнэлгээ буурсан.

- Өмгөөлөгчөөр дамжуулах -0.38
- Мөрийтэй тоглож санаатай алдах -0.37
- Мөнгө зээлдүүлээд мартаx -0.30
- Эд зүйлсийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах -0.19
- Үйл ажиллагааны зардал болгож өгөх -0.16
- Ойр дотны хүмүүсээр дамжуулах -0.06
- Хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх -0.03

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 3. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

Улс төрийн авлигын шалтгаан, нөхилийг 1. Улс төрийн авлигад нөлөөлсөн хүчин зүйлс, 2. Улс төрийн авлигын түвшинд нөлөөлсөн дутагдал доголдол, 3. Хүрээлэл,б үлэглэлүүдийн нөхцөл байдал гэсэн гурван дэд үзүүлэлтэд тодорхойлон авч үзнэ.

Зураг 19. Авлигын шалтгаан, нөхцөл.



Шалтгаан, нөхилийн үзүүлэлтийн өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулах зорилгоор 3 дэд үзүүлэлтийн хүрээнд шинжилгээ хийв. Улс төрийн авлигын шалтгаан нөхилийн үзүүлэлт 2020 онд 4.10 гарч өнгөрсөн оноос -0.11 пунктээр мэдэгдэхүйц буурсан байна. (2019 онд 4.21, 2018 онд 4.09).

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 1. УЛС ТӨРИЙН АВЛИГАД НӨЛӨӨЛСӨН ХҮЧИН ЗҮЙЛС

Улс төрийн авлига нь дээд түвшний авлигад тооцогддог тул нөлөөлөх хүчин зүйлс олонтой. Нөлөөллийн хүчин зүйлсийг 1-5 баллын оноог хувиар илэрхийлсэн бөгөөд дундаж үзүүлэлтийг мөн тооцон гаргав.

Хүснэгт 14. Улс төрийн авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн үнэлгээ

№	Хүчин зүйлс	Үгүй (1)	Бага зэрэг (2)	Дунд зэрэг (3)	Их (4)	Маш их (5)	Мэдэхгүй (9)	Дундаж (1-5)
1	Сонгуулийн өнөөгийн тогтолцоо	-	1.6	9.7	25.8	58.1	4.8	4.48
2	Сонгуулийн санхүүжилтийн механизм	-	8.1	6.5	25.8	58.1	1.6	4.36
3	Намын санхүүжилтийн механизм	-	1.6	9.7	19.4	66.1	3.2	4.55
4	Албан тушаалын томилгоо (нам дотор болон төрийн албанд)	-	-	4.8	22.6	71.0	1.6	4.67
5	УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	1.6	6.5	12.9	35.5	38.7	4.8	4.09
6	Засгийн газрын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	-	1.6	22.6	29.0	40.3	6.5	4.16

7	ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	-	3.2	16.1	41.9	29.0	9.7	4.07
8	Улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил	-	1.6	12.9	25.8	50.0	9.7	4.38
9	Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	-	8.1	16.1	32.3	38.7	4.8	4.07
10	Хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл явц	-	3.2	19.4	35.5	37.1	4.8	4.12
11	Төрийн байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалт	-	1.6	29.0	25.8	35.5	8.1	4.03

Тайлбар: Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал, 5-маш сайн, 4-сайн, 3-дунд, 2-мааруу, 1-маш муу

Сүүлийн нэг жилийн хугацаанд дараах авлигад дээрх арван нэгэн хүчин зүйлс хэр зэрэг нөлөөлсөн талаар шинжээчдийн өгсөн харуулт дээр үндэслэлээ. Өмнөх жилүүдээс үл мэдэгдэх хэлбэлзсэн үзүүлэлтүүд гарсан. Улс төрийн авлигад нөлөөлсөн хүчин зүйлс жил бүр нийгэм эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж хувьсан өөрчлөгдөх дүр төрх харагдаж байна.

Хүснэгт 15. Улс төрийн авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн үнэлгээ.

№	Хүчин зүйл	2018	2019	2020	Өөрчлөлт
1	Сонгуулийн өнөөгийн тогтолцоо	4.25	4.22	4.48	-0.03
2	Сонгуулийн санхүүжилтийн механизм	4.43	4.48	4.36	0.06
3	Намын санхүүжилтийн механизм	4.58	4.63	4.55	0.06
4	Албан тушаалын томилгоо (нам дотор, төрийн албанд)	4.74	4.59	4.67	-0.15
5	УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	4.19	4.19	4.09	0
6	ЗГ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	4.05	4.35	4.16	0.3
7	ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.9	4.05	4.07	0.15
8	Улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил	4.52	4.29	4.38	-0.23
9	Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	4.05	4.35	4.07	0.3
10	Хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл явц	3.81	4.19	4.12	0.38
11	Төрийн байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалт	4.02	4.17	4.03	0.16

Улс төрийн авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн үнэлгээ 4.27 гарч өнгөрсөн оноос -0.06 пунктээр бага зэрэг буурсан байна (2019 онд 4.33; 2018 онд 4.24). Улс төрийн авлигын нөлөөллийг 11 дэд хүчин зүйлсээр хэмжсэн. Үүнээс онгой анхаарч үзэх нөлөөллийн хүчин зүйлсийг дор дурдсан болно. Үүнд:

1. Сонгуулийн өнөөгийн тогтолоо +0.26;
2. Улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил +0.09;
3. Албан тушаалын томилгоо (нам дотор, төрийн албанд) +0.08;
4. ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил +0.02

пунктийн өөрчлөлт гарч өмнөх оныхоос мэдэгдэхүйц дүнгээр өссөн нь улс төрийн авлигын нөлөөллийн эдгээр 4 хүчин зүйлсийн хүрээнд нэмэгдэх сөрөг хандлагатай байна гэсэн үг юм.

дэд үзүүлэлт 2. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТҮВШИНД НӨЛӨӨЛЖ БҮЙ ТӨРИЙН АЛБАН ДАХЬ ДУТАГДАЛ, ДОГОЛДОЛ

Улс төрийн авлигад төрийн үйл ажиллагааны нөлөөлөл төрийн албанд хүчтэй сөрөг нөлөө үзүүлдэг. Үүнээс улбаатай алдаатай ажиллагаа гарч төрийн олон салбарт алдаа эндэгдэл болон нөлөөлөх уршигтай. Үүнийг дан гани төрөөр хязгаарлалгүй бизнесийн салбарт ч мөн гардаг тул алдаа догголдлоо олж гарах үр дагаврыг өмнөхөөсөө сайжруулж ажиллах нь эерэг үр дүнг авчирдаг. Доорх авлигын түвшний нөлөөллийн хүснэгтэд төрийн байгууллагад гардаг алдаа дутагдлыг тодорхойлсон болно.

Хүснэгт 16. Нийтийн алба /төрийн байгууллагын үйл ажиллагаанд оршиж буй дутагдал, доголдол нь авлигын түвшинд нөлөөлж буй нөлөөлөл

№	Авлигын төвшин	Үгүй (1)	Бага зэрэг (2)	Дунд зээг (3)	Их (4)	Маш их (5)	Мэдэхгүй (9)	Дундаж (1-5)
1	Хүнд суртал	-	-	21.0	40.3	35.5	3.2	4.15
2	Олон шат дамжлага, давхардал, хийдэл	-	-	24.2	33.9	38.7	3.2	4.15
3	Төрийн үйлчилгээний хүртээмж муу	1.6	8.1	32.3	32.3	22.6	3.2	3.68
4	Мэдээлэл нээлттэй, ил тод бус	-	3.2	19.4	35.5	40.3	1.6	4.15
5	Шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдал дутмаг	-	1.6	14.5	32.3	48.4	3.2	4.32
6	Албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж	-	1.6	16.1	40.3	38.7	3.2	4.20
7	Хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал	-	1.6	14.5	32.3	50.0	1.6	4.33
8	Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул	-	1.6	4.8	45.2	46.8	1.6	4.39
9	Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналт сул	1.6	3.2	11.3	33.9	48.4	1.6	4.26
10	Албан хаагчийн цалин, орон сууц, нийгмийн баталгаа хангалтгүй	1.6	9.7	21.0	27.4	35.5	4.8	3.89
11	Төрийн албан хаагчийн ёс зүйн доголдол	-	6.5	9.7	33.9	46.8	3.2	4.25
12	ТАХ-ийн ур чадвар дутмаг	3.2	3.2	21.0	19.4	35.5	17.7	3.98
13	Хуулийн хариуцлагын санкцууд хэрэгждэггүй	-	-	-	-	100	-	5.00

Тайлбар: Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал, 5-маш сайн, 4-сайн, 3- дунд, 2-тааруу, 1-маш муу

Нийтийн алба /төрийн байгууллагын үйл ажиллагаанд оршиж буй дутагдал, доголдол нь авлигын түвшинд нөлөөлж буй нөлөөлөл нь доорх байдлаар илэрсэн. 1. Шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдал дутмаг, 2. Төрийн албан хаагчийн ёс зүйн доголдол, 3. ТАХ-ийн ур чадвар дутмаг, 4. Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналт сул, 5. Хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал, 6. Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул, 7. Мэдээлэл нээлттэй, ил тод бус, 8. Олон шат дамжлага, давхардал, хийдэл, 9. Хүнд суртал гэх мэт төрийн үйлчилгээтэй холбоотой асуудлууд хөндөгдсөн байна.

Хүснэгт 17. Улс төрийн авлигын түвшинд нөлөөлж буй төрийн албан дахь дутагдал, доголдол (индексээр)

№	Авлигын төвшин	2018	2019	2020	Өөрчлөлт
1	Хүнд суртал	4.08	4.35	4.15	-0.2
2	Олон шат дамжлага, давхардал, хийдэл	4.21	4.31	4.15	-0.16
3	Төрийн үйлчилгээний хүртээмж муу	3.68	4.02	3.68	-0.34
4	Мэдээлэл нээлттэй, ил тод бус	4.11	4.23	4.15	-0.08
5	Шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдал дутмаг	4.19	4.41	4.32	-0.09
6	Албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж	4.24	4.48	4.20	-0.28
7	Хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал	4.26	4.32	4.33	+0.01
8	Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул	4.27	4.22	4.39	+0.17
9	Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналт сул	4.21	4.25	4.26	+0.01
10	Албан хаагчийн цалин, орон сууц, нийгмийн баталгаа хангалтгүй	3.97	4.11	3.89	-0.22
11	Төрийн албан хаагчийн ёс зүйн доголдол	4.17	4.27	4.25	-0.02
12	ТАХ-ийн ур чадвар дутмаг	4.19	4.4	3.98	-0.42
13	Хуулийн хариуцлагын санкцууд хэрэгждэггүй	0	0	5	+5

Улс төрийн авлигад нөлөөлөх төрийн үйл ажиллагааны дутагдал, доголлын нөлөөллийн үнэлгээ 2020 онд 4.21 гарч өнгөрсөн оноос -0.07 пунктээр багассан байна (2019 онд үзүүлэлт 4.28, 2018 онд үзүүлэлт 4.13).

Төрийн үйл ажиллагааны дутагдал, доголлыг 13 дэд үзүүлэлтэд хамааруулж хэмжсэн бөгөөд үүний 10 дэд үзүүлэлтийн (+0.02-0.42) хооронд үнэлгээ нь уналттай буюу эерэг гарчээ. Ингэхдээ “Хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал” (+ 0.01), “Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналт сул” (+ 0.1), “Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул” (+ 0.17), бага зэргийн өсөлттэй байна. Өмнөх оныхоос харьцангуй буурсан хэдий ч ирэх жилүүдэд өсөх хандлагыг үгүйсгэхгүй.

дэд үзүүлэлт 3. УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ ХҮРЭЭЛЛҮҮДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Улс төрийн хүрээн дэх тодорхой ашиг сонирхолд хөтлөгдсөн хүрээллийн нөхцөл байдал буюу ямар төрлийн хүрээлүүд түгээмэл байгаа талаар доорх хүснэгтэд үзүүлэх болно.

Хүснэгт 18. Улс төрийн хүрээн дэх хүрээлүүдийн нөхцөл байдал


№	Хүрээлэл, бүлэглэлийн хэлбэр	Үгүй (1)	Бага зэрэг (2)	Дунд зэрэг (3)	Их (4)	Маш их (5)	Мэдэхгүй (9)	Дундаж (1-5)
1	Хувийн эрх ашгийг илүүд үзсэн, нэг хүнийг тойрсон хүрээлэл	-	6.5	21.0	38.7	32.3	1.6	3.98
2	Хувийн эрх ашгийг илүүд үзсэн, нам тойрсон хүрээлэл	-	-	3.2	35.5	59.7	1.6	4.57
3	Хувийн эрх ашгийг илүүд үзсэн, бизнесийн хүрээлэл	-	4.8	16.1	41.9	35.5	1.6	4.09

4	Хувийн эрх ашгийг илүүд үзсэн, нам дамнасан хүрээлэл /намуудын нэгдэл/	-	3.2	12.9	22.6	54.8	6.5	4.38
5	Хувийн эрх ашгийг илүүд үзсэн, нэг нутаг / аймаг/ тойрсон хүрээлэл	-	11.3	21.0	33.9	30.6	3.2	3.87
6	Хувийн эрх ашгийг илүүд үзсэн, найз нөхдийн хүрээлэл	-	11.3	22.6	37.1	27.4	1.6	3.82
7	Нийтийн эрх ашгийн төлөө бий болсон хүрээлэл	21.0	35.5	22.6	8.1	6.5	6.5	2.39

Тайлбар: Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал, 5-маш сайн, 4-сайн, 3- дунд, 2-мааруу, 1-маш муу

Сүүлийн нэг жилийн хугацаанд Монгол Улсад хүрээлэл, бүлэглэлүүдийн нөхцөл байдлын талаар шинжээчид ийнхүү байр сууриа илэрхийлсэн. 4.57 дундажтай байгаа нь сүүлийн жилүүдэд хувийн эрх ашгийг илүүд үзсэн, нам тойрсон хүрээлэл болон бизнесийнхэн ихэссэн байна. Мөн нэг нутаг, аймаг, нам дагасан эрх ашгийг илүүд үзэх болсон нь нийгэмд дундаж байна. Харин нийтийн эрх ашгийг төлөө бий болсон хүрээлэл нь хамгийн бага буюу 2.39 дундаж үзүүлэлттэй гарлаа. Дээрхээс дүгнэхэд хувийн эрх ашгийн сонирхолдоо хөтлөгдсөн болон аймаг, нэг нутаг усны эрх ашиг улс төрийн хүрээлэлд илүү орших шинж үзэгдэж ард иргэдийн төлөө бий болсон хүрээлэл багасаж байгаа нь сөрөг хандлагыг нэмэгдүүлэх талтай. Зураг 20-д өмнөх онуудтай харьцуулсан дүнг харуулъя.

Зураг 20. Улс төрийн хүрээн дэх хүрээллүүдийн нөхцөл байдал.



Улс төрийн хүрээн дэх тодорхой ашиг сонирхолд хөтлөгдсөн хүрээллийн нөхцөл байдал буюу ямар төрлийн хүрээллүүд түгээмэл байгаа талаарх үнэлгээ 3.93 гарч өнгөрсөн оноос -0.06 пунктээр өссөн буюу бараг өөрчлөлтгүй байна (2019 оны үзүүлэлт 3.93; 2018 оны үзүүлэлт 3.89). Нийт 7 дэд үзүүлэлтээс 4 дэд үзүүлэлтийн үнэлгээ буурсан, 3 үзүүлэлтийн үнэлгээ мэдэгдэхүйц өссөн.


Үзүүлэлтийг өөрчлөлт тус бүрээр харуулвал.

- Нийтийн эрх ашгийн төлөө бий болсон хүрээлэл -0.24
- Хувийн эрх ашгийг илүүд үзсэн, нэг нутаг /аймаг/ тойрсон хүрээлэл -0.18
- Хувийн эрх ашгийг илүүд үзсэн, нэг хүнийг тойрсон хүрээлэл -0.18
- Хувийн эрх ашгийг илүүд үзсэн, бизнесийн хүрээлэл -0.12
- Хувийн эрх ашгийг илүүд үзсэн, найз нөхдийн хүрээлэл +0.24
- Хувийн эрх ашгийг илүүд үзсэн, нам дамнасан хүрээлэл /намуудын нэгдэл/ +0.05
- Хувийн эрх ашгийг илүүд үзсэн, нам тойрсон хүрээлэл +0.19

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 4. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХОР УРШИГ, ҮР ДАГАВАР

Сүүлийн жилүүдэд улс орнууд, олон улсын байгууллагууд авлигын эсрэг идэвхтэй тэмцэл өрнүүлэх болсон. Үүнд монгол улс ч идэвхтэй ажиллаж байгаа. Аливаа шийдвэрийг нийгэмд үр ашигтай бус өөрт ашигтай байхаар гаргавал хур хуршигтай байх талаар дор дурдлаа.

Зураг 21. Улс төрийн авлигын хор уршиг, үр дагавар.индекс.



Хор уршиг, үр дагаврын үзүүлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлийг хоёр дэд үзүүлэлтийн хүрээнд тодорхойлов. Улс төрийн авлигын түвшний шалгуураас авлигын хор уршиг, үр дагаврын үзүүлэлт 2020 онд 3.85 гарч өнгөрсөн оноос -0.14 пунктээр буурсан байна (2018 онд 3.98; 2019 онд 3.81). Өмнөх 2018-2019 онуудад улс төрийн авлигын хор уршиг, үр дагаврын үзүүлэлт 0.07 пунктээр буурч, харин авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын үзүүлэлт 0.29 пунктээр нэмэгдсэн юм.

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 1. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХОР УРШИГ

Авлига нь улс орны хөгжилд саад тотгор болж, эдийн засаг, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн үр ашгийг бууруулан ардчилал, шинэчлэлийн явцыг сааруулах хүчин зүйл болж байна.


Хүснэгт 19. Улс төрийн хүрээний авлига буюу төрийн өндөр албан тушаалтнуудын авлигын улмаас учирсан хор уршиг, сөрөг үр дагаврын түвшин

№	Хор уршиг, үр дагавар	Үгүй (1)	Бага зэрэг (2)	Дунд зэрэг (3)	Их (4)	Маш их (5)	Мэдэхгүй (9)	Дундаж (1-5)
1	Монгол Улсын нэр хүнд олон улсын түвшинд унасан	1.6	1.6	16.1	30.6	43.5	6.5	4.21
2	Улс орны эдийн засгийн хүч чадал суларсан	1.6	1.6	9.7	24.2	59.7	3.2	4.43
3	Төрийн албаны чадавх суларсан	1.6	-	11.3	30.6	53.2	3.2	4.38
4	Гадаадын хөрөнгө оруулалт буурсан	3.2	1.6	14.5	24.2	46.8	9.7	4.21
5	Шударга ёс алдагдсан	1.6	1.6	6.5	35.5	53.2	1.6	4.39
6	Нийгмийн дэг журам алдагдсан	1.6	4.8	21.0	33.9	35.5	3.2	4.00
7	Ёс суртахууны үнэт зүйлс алдагдсан	4.8	-	11.3	29.0	51.6	3.2	4.27
8	Өмч хөрөнгийн тэгш бус байдал нэмэгдсэн	-	-	12.9	27.4	56.5	3.2	4.45
9	Ядуурал нэмэгдсэн	1.6	3.2	14.5	25.8	53.2	1.6	4.28
10	Инфляци нэмэгдсэн	1.6	4.8	17.7	32.3	40.3	3.2	4.08
11	Гэмт хэрэг нэмэгдсэн	3.2	3.2	27.4	29.0	32.3	4.8	3.88
12	Ажилгүйдэл нэмэгдсэн	1.6	1.6	14.5	41.9	33.9	6.5	4.12
13	Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдсэн	1.6	1.6	24.2	21.0	45.2	6.5	4.14
14	Хуулийн хэрэгжилт суларсан	1.6	4.8	8.1	33.9	48.4	3.2	4.27
15	Гадаадын зээл тусламжийн үр ашиг буурсан	3.2	4.8	16.1	24.2	41.9	9.7	4.07
16	Хүний эрхийн зөрчил нэмэгдсэн	1.6	6.5	11.3	27.4	50.0	3.2	4.22
17	Нийгмийн итгэлцэл буурч нийгмийн хандлага сөрөг, харгис болсон	-	-	-	-	100	-	5.00

Тайлбар: Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал, 5-маш сайн, 4-сайн, 3-дунд, 2-тааруу, 1-маш муу

Улс төрийн хүрээний авлига буюу төрийн өндөр албан тушаалтнуудын авлигын улмаас учирсан хор уршиг, сөрөг үр дагаврын түвшинг 1-5 баллаар үнэлэн хувилж, дунджийг гарган тооцов. Авлигын хор уршиг, үр дагавар нь 1. Өмч хөрөнгийн тэгш бус байдал нэмэгдсэн, 2. Улс орны эдийн засгийн хүч чадал суларсан, 3. Шударга ёс алдагдсан, 4. Төрийн албаны чадавх суларсан, 5. Нийгмийн итгэлцэл буурсан байна. Энэ нь иргэдийн дунд яригддаг нийгмийн асуудлууд байв. Эдгээр асуудлууд буурахгүй нэмэгдсэнээр улс төрийн хүрээнд авлигыг бий болгоход нөлөөлж авлигын хор уршиг, үр дагавар болон хувирч нийгэмд байдаг асуудал мэт болох сөрөг нөлөөг үзүүлэх аюултай.

Зураг 22. Улс төрийн хүрээний авлигын улмаас учирсан хор уршиг, сөрөг үр дагаврын түвшин.



Улс төрийн авлигын хор уршгийн үзүүлэлтийн үнэлгээ 4.26 болж өнгөрсөн оноос +0.20 пунктээр өссөн байна (2019 оны үзүүлэлт 4.06; 2018 оны үзүүлэлт 4.09). Нийт 16 дэд үзүүлэлтээс 10 үзүүлэлтийн үнэлгээ өссөн байна.

Хамгийн их өссөн таван үзүүлэлтүүд:

- Ажилгүйдэл нэмэгдсэн +0.26
- Гадаадын хөрөнгө оруулалт буурсан + 0.24,
- Нийгмийн дэг журам алдагдсан + 0.16,
- Хүний эрхийн зөрчил нэмэгдсэн + 0.14,
- Нийгмийн итгэлцэл буурч нийгмийн хандлага сөрөг, харгис болсон +5.00/ энэ

нь асуулгын бусад гэсэн мөрөнд нэмэлтээр хариулсан шинжээчдийн хариулт болно. Дунд зэрэг өссөн гурван үзүүлэлтүүд:

- Гэмт хэрэг нэмэгдсэн + 0.12,
- Өмч хөрөнгийн тэгш бус байдал нэмэгдсэн +0.08
- Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдсэн +0.04

Бага зэрэг өссөн гурван үзүүлэлтүүд:

- Улс орны эдийн засгийн хүч чадал суларсан +0.03
- Төрийн албаны чадавх суларсан +0.01
- Инфляци нэмэгдсэн +0.01

Харин дараах зургаан үзүүлэлтийн үнэлгээ буурсан:

➤ Гадаадын зээл тусламжийн үр ашиг буурсан- 0.33,
➤ Ёс суртахууны үнэт зүйлс алдагдсан- 0.17,
➤ Шударга ёс алдагдсан- 0.02,
➤ Хуулийн хэрэгжилт суларсан- 0.01,
➤ Ядуурал нэмэгдсэн- 0.01,
➤ Монгол Улсын нэр хүнд олон улсын түвшинд унасан -0.01

Гадаадын хөрөнгө оруулалт буурсан, ажилгүйдэл нэмэгдсэн, өмч хөрөнгийн тэгш бус байдал нэмэгдсэн гэсэн үзүүлэлтүүд бараг өөрчлөлтгүй байв. Өөрчлөлтийн дүн (+/-0.1—ээс 0.2) байна.

дэд үзүүлэлт 2. АВЛИГААР ОЛСОН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Улс төрчид, төрийн өндөр байгууллагын албан тушаалтнууд авлигын замаар олсон хөрөнгөө хэрхэн зарцуулсан байдаг талаар доорх хүснэгтэд тайлбарлан үзүүлнэ. Ингэхдээ 1-5 баллын үнэлгээг хувиар илэрхийлэхийн зэрэгцээ дундаж үзүүлэлтийг тооцон гаргасан.

Хүснэгт 20. Авлигын замаар олсон хөрөнгөө зарцуулсан байдал

№	Хөрөнгө зарцуулалт	Үгүй (1)	Бага зэрэг (2)	Дунд зэрэг (3)	Их (4)	Маш их (5)	Мэдэхгүй (9)	Дундаж (1-5)
1	Өдөр тутмынхаа хэрэгцээнд зарцуулах	9.7	17.7	25.8	17.7	17.7	11.3	3.18
2	Дотоодын банкинд хадгалах	8.1	29.0	27.4	9.7	9.7	16.1	2.81
3	Гадаадын банкинд хадгалах	8.1	3.2	14.5	27.4	35.5	11.3	3.89
4	Гадаадын оффшор банк, санхүүгийн байгууллагад хадгалах	4.8	4.8	8.1	35.5	33.9	12.9	4.02
5	Гадаадын оффшор бүсэд компани байгуулах	4.8	9.7	16.1	30.6	25.8	12.9	3.72
6	Бэлэн мөнгө хэлбэрээр хадгалах	3.2	11.3	11.3	27.4	32.3	14.5	3.87
7	Хувьцаа худалдан авах	3.2	8.1	24.2	33.9	21.0	9.7	3.68
8	Автомашин, тээврийн хэрэгсэл худалдан авах	1.6	16.1	29.0	27.4	14.5	11.3	3.42
9	Дотоодод орон сууц, үл хөдлөх хөрөнгө худалдан авах	1.6	9.7	16.1	24.2	41.9	6.5	4.02
10	Дотоодод орон сууц, барилга байгууламж бариулах	-	9.7	11.3	24.2	46.8	8.1	4.18
11	Гадаадад орон сууц, үл хөдлөх хөрөнгө худалдаж авах	1.6	3.2	25.8	21.0	33.9	14.5	3.96
12	Урлагийн бүтээл худалдан авах	-	12.9	16.1	24.2	22.6	24.2	3.75
13	Хурдан морь худалдан авах	-	12.9	12.9	25.8	33.9	14.5	3.94
14	Гэр бүлийн өмчлөлийн компанид хувь оруулах	1.6	6.5	21.0	25.8	40.3	4.8	4.02
15	Зугаа цэнгэл, мөрийтэй тоглоомд зарцуулах	-	6.5	24.2	24.2	32.3	12.9	3.94
16	Гэр бүлийн гишүүний сургалтын төлбөрт зарцуулах	1.6	17.7	19.4	29.0	19.4	12.9	3.54
17	Эмчилгээнд зарцуулах	1.6	17.7	30.6	19.4	14.5	16.1	3.33
18	Хандив, тусламж өгөх	21.0	21.0	16.1	12.9	8.1	21.0	2.57
19	Хөшөө дурсгал, суварга босгох	11.9	13.6	27.1	16.9	13.6	16.9	3.08

Хамгийн түгээмэл буюу 1-р төрлийн зарцуулалтийг 6 хэлбэрээр авч үзвэл:

- Дотоодод орон сууц, барилга байгууламж баруулах,
- Дотоодод орон сууц, үл хөдлөх хөрөнгө худалдан авах,
- Гадаадын оффшор банк, санхүүгийн байгууллагад хадгалах,
- Гэр бүлийн өмчлөлийн компанид хувь оруулах, Гадаадын оффшор банк, санхүүгийн байгууллагад хадгалах
- Зугаа цэнгэл, мөрийтэй тоглоомд зарцуулах, Хурдан морь худалдан авах,
- Урлагийн бүтээл худалдан авах гэх мэт байдаг байна.

2-р төрлийн зарцуулалт:

- Бэлэн мөнгө хэлбэрээр хадгалах
- Гадаадын оффшор бүсэд компани байгуулах
- Хувьцаа худалдан авах
- Гэр бүлийн гишүүний сургалтын төлбөрт зарцуулах
- Автомашин, тээврийн хэрэгсэл худалдан авах
- Эмчилгээ, сувилгаанд зарцуулах

3-р төрлийн зарцуулалт

- Өдөр тутмынхаа хэрэгцээнд зарцуулах
- Хөшөө дурсгал, суварга босгох
- Дотоодын банкинд хадгалах
- Хандив, тусламж өгөх гэх мэт байгаагаас харахад бэлэн мөнгө хэлбэрээр

хадгалах, өдөр тутмынхаа хэрэгцээнд зарцуулах, дотоодын банкинд хадгалах нь 1-рт орно гэсэн судлаачийн таамаглалаас эсрэгээр 2,3 р төрлийн зарцуулалтанд бичигдсэн байна. Энэ нь авлигын замаар олсон хөрөнгийг цаашдаа өөрсдийн ашгийн төлөөх хэтийн төлөвлөгөөндөө зарцуулах хөрөнгө оруулалт болгох хүсэл сонирхолыг нь илэрхийлж байна.

Зураг 23. Улс төрийн (түүнчлэн шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээний) авлигаар олсон хөрөнгийн зарцуулалт. (индекс)



Авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын үнэлгээ 3.63 гарсан нь өнгөрсөн оноос -0.18 пунктээр буурсан байна (2019 оны үзүүлэлт 3.81; 2018 оны үзүүлэлт 3.52). Авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын талаар улс төрийн болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд нэгтгэсэн нэг асуултаар үнэлүүлсэн.

Уг үзүүлэлт хамаарах 19 дэд үзүүлэлтээс 16 үзүүлэлтийн үнэлгээ нь (-0.04)-өөс (-0.33) хүртэл буурсан дүн гарав. 3 үзүүлэлтийн дүн бага зэрэг өсчээ. Өссөн үзүүлэлтийг өөрчлөлтөөр нь дурвал өдөр тутмынхаа хэрэгцээнд зарцуулах +0.09, бэлэн мөнгө хэлбэрээр хадгалах +0.04, хувьцаа худалдан авах +0.04 байна.

ХОЁР. БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ЗАРЦУУЛЖ БУЙ АВЛИГЫН ХЭМЖЭЭ

Шинжээчдээс бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны явцад зарцуулж буй авлигын хэмжээг хувиар илэрхийлүүлэн гаргасан болно. Ингэхдээ шинжээчийн таамаглал буюу төсөөллөөр асуулга авсан.

Хүснэгт 21. Бизнес эрхлэгчдийн авлигад зарцуулсан мөнгөний хэмжээ (%)

	<5%	6-10%	11-15%	16-20%	21%<	Хэлж мэдэхгүй
Төсөл, хөтөлбөрт хамрагдахад	8.1	29	12.9	19.4	12.9	17.7
Тендерт шалгаруулалтад ялахад	0	17.7	30.6	19.4	21	11.3
Зээл авахад	17.7	17.7	21	12.9	9.7	21
Өр төлбөр барагдуулах, иргэний нэхэмжлэл шийдвэрлүүлэхэд	11.3	25.8	17.7	3.2	17.7	24.2
Татвараас чөлөөлүүлэх, бууруулахад	4.8	24.2	16.1	8.1	24.2	22.6
Хяналт шалгалтаар зөрчил дутагдалгүй гарахад	4.8	17.7	25.8	9.7	16.1	25.8
Тусгай зөвшөөрөл авахад	4.8	12.9	24.2	21	19.4	17.7
Бараа, ажил, үйлчилгээ хүлээлгэн өгөхөд	9.7	24.2	22.6	12.9	9.7	21
Гадаадаас ажиллах хүч авахад	4.8	12.9	16.1	9.7	21	35.5

Бизнес эрхлэгчид үйл ажиллагааныхаа явцад өгч буй авлигын үнэлгээг дундаж үзүүлэлт болон хариултын хувиар тооцсон. Бизнес эрхлэгчдээс авлигад зарцуулсан мөнгөний хэмжээ голчлон 11-15 хувийг зарцуулдаг байна.

ХЭЭЛ ХАХУУЛЬД ЗАРЦУУЛСАН МӨНГӨНИЙ ХЭМЖЭЭ

Энэ хэсэгт бизнес эрхлэгчид үйл ажиллагааныхаа явцад хэзээ хахуульд хичнээн төгрөг зарцуулдаг болохыг сая, төгрөгөөр тооцон харуулсан болно. Ингэхдээ шинжээчийн таамаглал буюу төсөөллөөр асуулга авсан.

Хүснэгт 22. Бизнес эрхлэгчдээс авлигад зарцуулсан мөнгөний хэмжээ /зорилгоор/, сая төгрөгөөр. хувиар

	1 сая хүртэл	1-5 сая	5 - 10 сая	10 - 20 сая	20 - 50 сая	50 < сая	Мэдэхгүй
Ажил, албан тушаалд ороход	6.5	12.9	19.4	24.2	6.5	19.4	11.3
Тусгай зөвшөөрөл авахад	1.6	11.3	19.4	17.7	16.1	22.6	11.3
Ашиг сонирхолдоо нийцсэн хууль тогтоомж, шийдвэр гаргуулахад	0	1.6	9.7	4.8	14.5	43.5	25.8
Шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход	0	0	1.6	16.1	19.4	33.9	29
Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хэргийг хэрэгсэхгүй болгоход	1.6	3.2	9.7	14.5	21	24.2	25.8
Эрүүгийн хэрэг үүсгэхэд	3.2	1.6	11.3	19.4	9.7	17.7	37.1
Гэмт хэрэг, зөрчлийг нуун дарагдуулахад	1.6	3.2	9.7	9.7	19.4	25.8	30.6
Хуурамч бичиг баримт үйлдэхэд	3.2	11.3	14.5	16.1	12.9	4.8	37.1

Хээл хахуульд өгч буй мөнгөн дүнг дундаж үзүүлэлт болон хариултын хувиар тооцож үзсэн бөгөөд ашиг сонирхолдоо нийцүүлсэн хууль тогтоомж, шийдвэр гаргуулахад,

шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход, гэмт хэрэг, зөрчлийг нуун дарагдуулахад зэрэгт хамгийн их өгдөг гэж шинжээчид хариулжээ.

ДЭЭД ТҮВШНИЙ АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дээд түвшний авлигад төр засгийн албан тушаалтан, томоохон бизнесменүүдийн эрхэлдэг үйл ажиллагаа үүнд хамаарагдах төдийгүй мэдээллийн ил тод байдлыг тэр бүр хангаад байдаггүй хууль хяналтын байгууллага ч хүчинд нь автагдаж, нийтийн эрх ашгийг ханган ажиллах хүч сул байх магадлалтай тул энд авч үзэж байгаа болно.

Зураг 24. Авлигыг бууруулахад шаардлагатай арга хэмжээ.




Улс төрийн (дээд түвшний) авлигатай тэмцэх үйл ажиллагааны сэдэвтэй холбогдуулан шинжээчдээс хаалттай хэлбэрээр нийт 22 арга хэмжээний ач холбогдлын талаар асууж үнэлүүлсэн юм. Авлигыг бууруулахад шаардлагатай арга хэмжээ нь улс төр, нам, төрийн шийдвэр гаргах болон түүнд тавих хяналт тавих бага, ашиг сонирхлын зөрчилдөөнийг сармагжуулж улмаар арилгах нь чухал.

Дээд түвшний авлига Монголд оршиж байгаа шалтгаан нь бизнес, улс төрийн нийлсэн ашиг сонирхлыг арилгах нь хамгийн зөв шийдэл болоод байна.


ГУРАВ. ШИНЖЭЭЧДИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Зураг 25. Шинжээчдийн хүйс.



■ Эрэгтэй ■ Эмэгтэй


Зураг 26. Шинжээчдийн нас.



Зураг. 25-д Судалгаанд хамрагдсан шинжээчдийн хүйсийг үзүүлж байна. Шинжээчдийн 66.1 хувь нь эрэгтэй, 33.9 хувь нь эрэгтэйчүүд байна.

Зураг 27-д Шинжээчдийн насны бүтцийг авч үзсэн. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаанд гол төлөв 35.5 хувь нь 41-50, 27.4 хувь нь 40 хүртэлх, 21 хувь нь 51-60, 16.1 хувь нь 61-ээс дээш насныхан тус тус хамрагдсан байна.

Зураг 28. Шинжээчдийн салбарын хаярьялал.



Судалгаанд хамрагдсан шинжээчдийг ажлын газрын салбараар нь төлөөлүүлсэн билээ. Ингэхэд 42.6 хувь нь төрийн байгууллагад, 24.6 хувь нь хувийн хэвшилд, 13.1 хувь нь төрийн бус байгууллага, 6.6 хувь нь олон улсын байгууллага, 13.1 хувь нь судалгааны компанид харъяалалтай байв.




2020 оны улс төрийн хүрээн дэх авлигын төсөөллийн индекс 3.98 байна. Энэ нь өмнөх оны үзүүлэлтээс -0.10 пунктээр буурсан үзүүлэлт. Ингэхдээ индексийг бүрэлдүүлэх үндсэн 4 шалгуур тус бүр -0.03-0.15 хүртэлх пунктээр буурсан бүхий үр дүн гарсан. Үндсэн шалгууруудыг бүрдүүлэгч дэд үзүүлэлтүүдийн түвшинд ч буурсан нь харьяангуй жигд буурах хандлагатай байгаа нь эерэг хэдий ч цаашдын жилүүдэд анхаарал хандуулан ажиллах нь зүйтэй.

Авлигын цар хүрээний хувьд дундаж индекс 4.10 гарсан. Өмнөх жилийн дүнгээс -0.03-аар мэдэгдэхүйц буурлаа. Авлигын цар хүрээ багасах тусам салбар дундын авлига буурах тул энэ нь эерэг үр дүн хэдий ч мэдэгдэхүйц тоон үзүүлэлт гэдэгт анхаарал тавих хэрэгтэй. Салбар хүрээ болон байгууллага, институци дахь тархалт, түгээмэл байдлын үзүүлэлтэд өөрчлөлт гараагүй бол төрийн байгууллагын үйл ажиллагаан дахь авлигын түвшин болон улс төрийн авлигын чиглэгдсэн байдлын үнэлгээнд бууралт гарсан.



Ингэхдээ тусгай сангуудын үйл ажиллагаа болон төсвийн зарцуулалтын үзүүлэлт дээр, чиглэлийн хувьд шүүх, хууль тогтоох, хууль сахиулах, түүнчлэн дэд бүтэц, хэвлэл мэдээллийн хэрэгсэл дээр хамгийн их бууралт мэдрэгдсэн. Түвшний хувьд авлигын түгээмэл байдал болон үйл ажиллагаан дахь авлига харьяангуй багассан нь аажмаар буурах хэтийн төлөвтэй байна.

Авлигын хэлбэрийн хувьд -0.15 хээл хахуулийн хэлбэр, авлигын хэлбэр болон бүлэглэлүүдийн нөхцөл байдлын үнэлгээн дээр харьяангуй бууралт харагдсан. Түвшний хувьд авлигын хэлбэр болон хууль бус нөлөөллийн хэлбэр хамгийн өндөр үнэлэгдсэн. Ажил, албан тушаалд томилох, албан тушаал, эрх мэдлээ урвуулах, хэтрүүлэх, эдгээрийг даган нийтийн эд хөрөнгийг төрөл бүрээр завших болон сонгогчдын саналыг худалдан авах явдал авлига, хээл хахуулийн хамгийн чухалд тооцогдох хэлбэр байсаар байна.




Хууль бус нөлөөллийн хувьд өмнөх жилээс буурсан ч төрөл бүрийн танил талын хэлхээ холбоог ашиглах үндсэн хэлбэр болохын зэрэгцээ дарамт, шахалт үзүүлэх үзүүлэлт “их”байсаар байгаа нь дээд зэрэгт үнэлэгдсэн. Бүлэглэлүүдийн нөхцөл байдлын хувьд бага зэргийн буюу -0.10 -ийн өөрчлөлт гарсан улс төр-бизнесийн бүлэглэл болон улс төр-шүүх, хууль сахиулахын албан тушаалтнуудын хууль бус ашиг сонирхлын нэгдэл голлох байр суурьтай байна.

Улс төрийн авлигын шалтгаан нөхилийн хувьд индексийн үзүүлэлт нь энэ жилд 4.11 болж +0.13 пунктийн өсөлт бага хэмжээнд гарсан ч үнэлгээ нь өндөр их өндөр хэвээр байгаа. Улс төрийн авлигад нөлөөлөх хүчин зүйлсийн дунд намын болон сонгуулийн санхүүжилтийн механизм, албан тушаалын томилгоо, шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил голлох үүрэг гүйцэтгэж байна.



Улс төрийн авлигын хор уршгийн өсөлт нь 3.84 болж -0.05 пунктээр бага зэргийн бууралт мэдрэгджээ. Улс төрийн авлигын хор уршгийн шалтгаан нөхцөл нь Ажилгүйдэл нэмэгдсэн, гадаадын хөрөнгө оруулалт буурсан, нийгмийн дэг журам алдагдсан, хүний эрхийн зөрчил нэмэгдсэн гэх хүчин зүйлс нь дээгүүрт байна.



Авлигын замаар олсон хөрөнгийн зарцуулалтын үзүүлэлт мэдэгдэхүйц буурсан. Гэхдээ дэд үзүүлэлтийн түвшинд Монгол Улсын нэр хүнд олон улсын түвшинд унасан, хүний эрхийн зөрчил нэмэгдсэн, ёс суртахууны үнэт зүйлс алдагдсан, улс орны эдийн засгийн хүч чадал суларсан гэсэн үзүүлэлт дээр тодорхой хэмжээнд өсөлт гарсан.

Харин шинжээчдийн байр суурьнаас дүгнэхэд нийгмийн дунд авлига байх ёстой үзэгдэл болсон бөгөөд далд хэлбэртээ орсон учраас монгол дахь авлигын түвшинг бууруулахад улс төрчид болон улс төрийн нам, томоохон бизнес эрхлэгчдэд хяналт тавих хууль зүйн байгууллагын хүчийг зузаатгах, иргэдэд мэдээлэх мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх гэх мэт асуудалд анхаарснаар ашиг сонирхлоос үүдэлтэй авлига бүрэн дуусгавар болохгүй ч харьцангуй түвшинд багасах дүр зураг ажиглагдаж байна





АВЛИГАТАЙ
ТЭМЦЭХ
ГАЗАР

ЗӨВ ЗӨВД ШУДАРГА ЗӨВ
соён гэгээрүүлэх аян



Г.Уянгадарь

ШУДАРГА
ҮНЭНИЙ
ЦААНА
ҮРГЭЛЖ
ШАГНАЛ
БАЙДАГ
ЮМ ШҮҮ



Авлигатай тэмцэх газар
АТГ - Олон Нийтийн Төв



110

Гомдол мэдээлэл
хүлээн авах утас



ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ - 2020 СУДАЛГАА

БҮЛЭГ 1. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хүүхдийн шударга байдлын судалгааг “Транспэрэнси Интернэшнл Солонгос” байгууллагаас боловсруулсан арга зүйн дагуу анх 2008 онд Энэтхэг, Солонгос, Бангладеш, Монгол зэрэг улсад зохион байгуулсан. Уг арга зүйн дагуу Хүүхдийн шударга байдлын судалгааг АТГ-аас зохион байгуулан явуулж байна. Өнгөрсөн хугацаанд судалгааны үр дүнг соён гэгээрүүлэх ажил, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахад ашиглаж ирлээ.

1. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШНИЙ ТООЦООЛОЛ

Хүүхдийн шударга байдлын түвшинг тогтоохдоо доорх 12 асуултад тухайн хүүхэд санал нийлж байгаа эсэхийг нь асууж, хариулт бүрийг 1-5 хүртэлх оноогоор үнэлж, үнэлгээний арифметик дунджаар гаргав. Хүүхдийн шударга байдлын түвшин нь хүүхдийн ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих, авлигыг үл тэвчих үзэл гэсэн дэд үзүүлэлтээс бүрддэг. Хүүхдийн шударга байдлын түвшин 1-д ойртох тусам шударга бус, харин 5-д ойртох тусам шударга гэж үзнэ.

Хүснэгт 1. Хүүхдийн шударга байдлыг үнэлэхэд ашигласан асуулт

Асуултын дугаар	Асуулт
1.	Дотнын найз минь шалгалт өгч байхдаа бусдаас хуулж байвал би “найз минь юм чинь за яахав дээ” гэж бодно.
2.	Том хүмүүсийн үйлдэл хууль бус байсан ч надад ашигтай байвал хүлээн зөвшөөрнө.
3.	Хүүхдүүд интернетэд байгаа бусдын бүтээлээс хуулбарлаж гэрийн даалгавараа хийхдээ эх сурвалжийг нь заавал дурдах албагүй.
4.	Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь байж болох зүйл.
5.	Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга юм.
6.	Баян байх нь шударга байхаас илүү чухал.
7.	Төрийн албан хаагч төрийн үйлчилгээ үзүүлснийхээ төлөө шан харамж авч болно.
8.	Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн нь миний сайн найз байсан ч би өөрийн итгэдэг багш, эцэг, эх, хэн нэгэнд мэдэгдэнэ.
9.	Кино үзэхийн тулд урт дараалалд зогссоноос урдуур нь дайрч хурдан кинонд ороно.
10.	Замын цагдаа-зохицуулагч байхгүй бол би замын хөдөлгөөний дүрэм зөрчиж магадгүй.
11.	Гэмт хэрэг үйлдсэн, авлига, хээл хахууль авсан хэн нэгнийг би зохих байгууллагад нь мэдэгдэнэ.
12.	Манай гэр бүл баяжиж л байвал миний аав, ээж эрх мэдлээ ашиглах, хууль зөрчих нь надад хамаагүй.

Хүүхдийн шударга байдлын түвшний дэд үзүүлэлт болох ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих болон авлигыг үл тэвчих байдлын үзүүлэлтийг тооцохдоо дээр дурдсан асуултуудын дагуу дэд үзүүлэлтийн дунжийг тооцсон болно. Дэд үзүүлэлт тооцоход ашигласан асуултыг дараахь хүснэгтээс харна уу.

Хүснэгт 2. Хүүхдийн шударга байдлын дэд үзүүлэлтийг тооцсон асуулт, асуултын дугаараар

	Ёс зүй, ёс суртахуун	Зөв төлөвшилт	Хууль сахих	Авлигыг үл тэвчих
Танин мэдэхүйн	3	4	1	2
Нөлөөллийн	6	5	7	8
Зан үйлийн	9	11	10	12

2. СУДАЛГАА ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙДАЛ

Авлигатай тэмцэх газар нь Хүүхдийн шударга байдлын судалгааг цахим хэлбэрээр “SurveyMonkey” судалгааны программыг ашиглан 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 9-12 дугаар ангийн сурагчид болон эцэг, эхчүүдээс санамсаргүй байдлаар сонгон, бэлтгэгдсэн асуулгыг бөглүүлж, судалгааг зохион байгуулав.


Судалгааны мэдээллийг цахим хэлбэрээр цуглуулах ажлыг 21 аймаг, нийслэлийн сургуулийн багш нар болон нийгмийн ажилтантай хамтран 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөс 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хооронд зохион байгууллаа. Судалгаанд аймаг, нийслэлийн хэмжээнд нийт 5469 сурагч, 534 эцэг, эх хамрагдав.

Мөн энэ удаагийн судалгаанд аймаг, нийслэлээс сонгон авсан түүврийн дагуу сургуулийн ахлах ангийн сурагчийн эцэг, эхчүүдийг хамруулсан нь тус судалгааны онцлог байв.

3. ХҮҮХДИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

“Хүүхдийн шударга байдал-2020” судалгааны дүнгээр нийт сурагчийн 36.7 хувь нь эрэгтэй, 63.3 хувь нь эмэгтэй байгаа бол 16 настай сурагчид хамгийн их буюу 30.1 хувь, 13 настай сурагчид хамгийн бага буюу 2.7 хувь байна. Байршлаар нь авч үзвэл 53.5 хувь нь аймгаас, 46.5 хувь нь нийслэлийн харьяа сургуулиудын сурагчид байна (Зураг 1).

Зураг 1. Хүүхдийн нас, хүйс



БҮЛЭГ 2. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Хүүхдийн шударга байдлын түвшинг 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн бөгөөд уг үзүүлэлтийн утга 1-д ойртох тусам шударга бус, 5-д ойртох тусам шударга гэж ойлгоно.

Хүүхдийн шударга байдлын түвшин 2020 оны судалгаагаар 4.01 гэсэн дүнтэй гарсан нь өмнөх оныхоос 0.1 пунктээр нэмэгдсэн байна. Энэ нь хүүхдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд хэрэгжүүлбэл зохих урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүртээмж, чанарт бага зэрэг өөрчлөлт гарсны үр дүн гэж үзэж болохоор байна (Зураг 2).

Зураг 2. Хүүхдийн шударга байдлын түвшин, оноор



Хүүхдийн шударга байдлын түвшинг аймгаар тооцоход 13 аймгийн үзүүлэлт 4.01-4.09-ийн хооронд харин үлдсэн 8 аймгийн үзүүлэлт 3.80-3.99-ийн хооронд гарсан байна. Шударга байдлын үзүүлэлтийн хамгийн их ба хамгийн бага утгын зөрүү нь 0.29 пункт байна (Зураг 3).

Зураг 3. Хүүхдийн шударга байдлын 2020 судалгааны түвшин, аймгаар




Хүүхдийн шударга байдлын түвшинг аймаг, нийслэлээр тооцдог ба 2020 оны судалгааны үр дүнгээр Говь-Алтай, Төв аймгийн хүүхдийн шударга байдлын түвшин бага зэрэг буурсан. Завхан, Өмнөговь аймгийн хүүхдийн шударга байдлын түвшин өнгөрсөн онтой харьцуулахад өөрчлөлтгүй гарсан. Харин бусад аймаг болон нийслэлийн хүүхдийн шударга байдлын түвшин эерэг өөрчлөлттэй гарчээ (Хүснэгт 3).

Хүснэгт 3 Аймгуудын шударга байдлын түвшин, оноор

д/д		Шударга байдлын түвшин						Зөрүү
		2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	
1	Архангай	4.01	3.89	3.95	3.79	3.88	3.99	0.12
2	Баян-Өлгий	4.18	3.74	3.98	3.72	3.61	3.80	0.18
3	Баянхонгор	4.03	4.17	4.04	3.99	3.95	4.04	0.08
4	Булган	4.26	3.67	3.95	3.98	3.88	3.92	0.04
5	Говь-Алтай	3.36	4.03	4.03	4.39	4.04	3.89	-0.14
6	Говьсүмбэр	3.71	3.92	4.09	3.90	3.88	4.04	0.15
7	Дархан-Уул	3.56	4.04	4.02	4.11	3.93	4.03	0.10
8	Дорноговь	3.99	4.22	3.70	4.14	3.95	4.08	0.13
9	Дорнод	3.38	4.08	4.11	3.96	3.93	4.02	0.09
10	Дундговь	4.26	3.79	4.26	4.19	3.93	4.07	0.14
11	Завхан	3.96	4.03	4.04	4.21	3.97	3.97	0.00
12	Орхон	4.07	4.04	3.99	3.40	3.83	4.06	0.23
13	Өвөрхангай	3.65	4.16	3.72	4.06	3.91	4.05	0.14
14	Өмнөговь	3.66	4.21	3.97	3.39	4.03	4.03	0.00
15	Сүхбаатар	4.13	3.69	3.96	3.92	3.90	4.08	0.18
16	Сэлэнгэ	3.57	4.04	4.10	4.13	3.91	4.01	0.10
17	Төв	3.87	3.98	3.81	4.11	3.97	3.95	-0.02
18	Увс	4.29	4.06	4.03	4.11	3.98	4.09	0.11
19	Ховд	4.08	4.10	4.00	3.97	3.94	3.98	0.03
20	Хөвсгөл	4.36	4.09	4.28	4.01	3.99	4.07	0.08
21	Хэнтий	4.00	4.17	4.24	3.89	3.94	3.95	0.01
22	Улаанбаатар	4.05	3.98	3.95	3.78	3.88	4.03	0.15

Хүүхдийн шударга байдлын түвшинг дүүргээр тооцоход хамгийн их ба хамгийн бага утгын зөрүү нь 0.42 пункт байна (Зураг 4).

Зураг 4. Хүүхдийн шударга байдлын 2020 судалгааны түвшин, дүүргээр




Хүүхдийн шударга байдлын түвшинг дүүргээр тооцоход Хан-Уул дүүргийн хүүхдийн шударга байдлын түвшин 0.06 пунктээр буурсан ба харин бусад дүүргийнх эерэг өөрчлөлттэй гарчээ (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Хүүхдийн шударга байдал дүүргээр, 2017-2020 он

Дүүрэг	2017 он	2018 он	2019 он	2020 он	Зөрүү
Баянзүрх дүүрэг	3.77	4.04	3.88	4.01	→ 0.13
Баянгол дүүрэг	3.84	3.96	3.83	4.12	↑ 0.29
Багануур дүүрэг	4.04	3.88	3.82	4.08	↑ 0.26
Баганхангай дүүрэг	3.91	4.00	3.69	3.71	↘ 0.02
Налайх дүүрэг	4.03	3.04	3.86	4.12	↑ 0.26
Сүхбаатар дүүрэг	4.09	3.60	4.08	4.13	↘ 0.05
Хан-Уул дүүрэг	3.86	3.92	4.06	4.00	↓ -0.06
Чингэлтэй дүүрэг	4.09	3.67	3.85	4.13	↑ 0.28
Сонгинохайрхан дүүрэг	3.93	3.87	3.83	3.97	→ 0.14


Хүүхдийн шударга байдлын түвшин сүүлийн 3 жилд нэмэгдсэн боловч эмэгтэй хүүхдийн шударга байдлын түвшинг эрэгтэй хүүхдийн шударга байдлын түвшинтэй харьцуулахад 0.18 пунктээр их байгаа байдал сүүлийн жилүүдэд хадгалагдаж байна (Зураг 5).

Зураг 5. Хүүхдийн шударга байдал, хүйсээр




Хүүхдийн шударга байдлын түвшин 9-11 дүгээр анги хүртлээ нэмэгдэж байгаа боловч төгсөх ангидаа энэ хандлага нь буурсан байна (Зураг 6).

Зураг 6. Хүүхдийн шударга байдал, суралцаж буй ангиар



Төрийн өмчийн сургуулийн хүүхдийн шударга байдлын түвшин хувийн өмчийн сургуулийн хүүхдийн шударга байдлын түвшинөөс 0.19 пунктээр их байна (Зураг 7).


Зураг 7. Хүүхдийн шударга байдал, сургуулийн өмчийн хэлбэрээр



1. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС


Шударга байх талаар гэрийнхэн нь байнга ярилцдаг хүүхдийн шударга байдлын түвшин шударга байх талаар гэрийнхэн нь хэзээч ярилцаж байгаагүй хүүхдийн шударга байдлын түвшинөөс 0.34 пунктээр их байгаа нь гэр бүлийн харилцаа, хандлага чухал нөлөөтэй болохыг илэрхийлж байна (Зураг 8).

Зураг 8. Шударга байх талаар ярилцдаг нь хүүхдийн шударга байдалд нөлөөлдөг эсэх




Шударга хандсанаа төлөө магтуулдаг хүүхдийн шударга байдлын түвшин шударга хандсанаа төлөө магтуулж, муулуулж үзээгүй хүүхдийн шударга байдлын түвшинөөс 0.13 пунктээр их байгаа нь хүүхдэд тухайн цаг хугацаанд урмын үгс хэлэх нь цаашид тухайн хүүхдийг шударга иргэн болон төлөвшихөд нь зэрэг нөлөөтэй байна (Зураг 9).

Зураг 9. Хүүхдийг шударга хандсанах нь төлөө магтах явдал шударга байдалд нөлөөлөх эсэх



Гэрийнхэн нь хүүхдээ шударга бус зүйл хийснийг нь мэдвэл хэлж ойлгуулдаг хүүхдийн шударга байдлын түвшин мэдсэн ч ямар нэгэн арга хэмжээ авдаггүй хүүхдийн шударга байдлын түвшинөөс 0.43 пунктээр их байна. Энэ нь тухайн хүүхдэд шударга бус зүйлийн үр дагаврыг хэлж ойлгуулснаараа сайн хүн болон төлөвших нөхцөлийг бүрдүүлж өгч байна (Зураг 10).

Зураг 10. Хүүхдүүд шударга бус зүйл хийхэд эцэг, эхийн гаргадаг үйлдэл тэдний шударга байдалд нөлөөлөх эсэх



Шударга бус үйлдэл хийхийг найз нөхөд нь ятгадаг хүүхдийн шударга байдлын түвшин найз нөхөд нь шударга бус үйлдэл хийхийг хэзээ ч санал болгож байгаагүй хүүхдийн шударга байдлын түвшинөөс 0.26 пунктээр бага байгаа нь найз нөхдийн хүрээлэл чухал ач холбогдолтой болохыг харуулж байна (Зураг 11).


Зураг 11. Хүүхдийн шударга байдалд найз нөхөд нь нөлөөлөх эсэх



Шударга бус үйлдлийн талаар ангийнхан болон найзтайгаа ярилцдаг хүүхдийн шударга байдлын түвшин ангийнхан болон найзтайгаа ярилцдаггүй хүүхдийн шударга байдлын


түвшинөөс 0.1 пунктээр их байгаа нь хүүхдүүд нэг нэгдээ зөв үлгэр дуурайл үзүүлж нийгэмд зөв хүн болон төлөвшихөд нь эерэг нөлөөтэй болохыг харуулж байна (Зураг 12).

Зураг 12. Хүүхдүүд шударга бус үйлдлийн талаар ангийнхан, найз нартайгаа ярилцах нь хүүхдийн шударга байдалд нөлөөлөх эсэх




Шударга бус зүйл хийсэн дотныхоо хүнийг зэмлэж сануулна гэж үзэж буй хүүхдийн шударга байдлын түвшин надад ашигтай байвал дэмжинэ гэж үзэж буй хүүхдийн шударга байдлын түвшинөөс 0.56 пунктээр их гарсан байгаа нь шударга бус ёсыг өөхшүүлсэн хэрэг болж байна (Зураг 13).

Зураг 13. Шударга бус зүйл хийсэн дотныхоо хүнд хандах хандлага ба хүүхдийн шударга байдлын түвшин



Шударга ёсны талаар хичээл заалгадаг хүүхдийн шударга байдлын түвшин хичээл заалгадаггүй хүүхдийн шударга байдлын түвшинтэй харьцуулахад 0.08 пунктээр их байгаа нь тухайн сургуулийн сургалтын хөтөлбөрт шударга ёс, хүмүүжил төлөвшлийн талаарх хичээлийг тусгах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна. (Зураг 14).

Зураг 14. Шударга ёсны талаар хичээл орох нь шударга байдалд нөлөөлөх эсэх



Шударга бус асуудал тохиолдвол эцэг, эх, багш зэрэг дотныхоо хүнд ханддаг хүүхдийн шударга байдлын түвшин шударга бус асуудал тохиолдвол ямар нэгэн үйлдэл хийдэггүй хүүхдийн шударга байдлын түвшинөөс 0.47 пунктээр их байгаа нь тухайн хүүхдийг ойлгодог, нээлттэй ярилцдаг хүний дэмжлэг хэрэгцээтэй байгааг харуулж байна (Зураг 15).

Зураг 15. Шударга бус асуудал тохиолдоход хүүхдийн үйлдэл




Шударга ёсны тухай мэдээллийг сургуулийн орчин, сонин, хэвлэл, гэр бүлийн хүрээнд авдаг хүүхдийн шударга байдлын түвшин нь интернет, зурагт радио, найз, нөхдийн хүрээлэл зэрэг бусад хүрээнээс авдаг хүүхдийн шударга байдлын түвшинөөс өндөр байна (Зураг 16).

Зураг 16. Хүүхдийн шударга ёсны талаарх мэдээлэл авах суваг ба хүүхдийн шударга байдлын түвшин



Хүүхдүүд шударга бус үйлдэл гаргасныхаа төлөө эцэг, эх, найз нөхөддөө хандан ярилцаж асуудлаа шийдвэрлэдэг болох нь судалгааны дүнгээс харагдаж байна (Зураг 17).


Зураг 17. Та шударга бус үйлдэл гаргавал хэнд ханддаг вэ?



2. ХҮҮХДИЙН ЁС СУРТАХУУНЫ ХҮМҮҮЖИЛД ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН НӨЛӨӨЛЖ БАЙГАА БАЙДАЛ

Эцэг, эхчүүдийн 30-40 насныхан хүүхэдтэйгээ байнга ярилцдаг байхад харин 40-өөс дээш насныхан хүүхэдтэйгээ бага ярилцдаг болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна (Зураг 18).

Зураг 18 Хүүхэдтэйгээ нээлттэй ярилцдаг эсэх, насны бүлгээр




Судалгааны үр дүнгээс харахад ээж нарын 54.5 хувь нь хүүхэдтэйгээ байнга ярилцдаг бол харин аав нарын ердөө 10.5 хувь нь хүүхэдтэйгээ байнга ярилцдаг байна (Зураг 19).

Зураг 19 Хүүхэдтэйгээ нээлттэй ярилцдаг эсэх, хүйсээр



Төрийн байгууллагад ажилладаг эцэг, эхчүүдийг бусад салбарт ажилладаг эцэг, эхчүүдтэй харьцуулахад хүүхэдтэйгээ илүү ойр дотно харьцдаг болох нь судалгаанаас харагдаж байна (Зураг 20).

Зураг 20 Хүүхэдтэйгээ нээлттэй ярилцдаг эсэх, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар



Хүүхэдтэйгээ байнга ярилцдаг эцэг, эхчүүд хүүхдээ аливаа асуудалд шударга хандсаных нь төлөө магтаж сайшаадаг байдал нь судалгаанаас харагдаж байна. Энэ нь эцэг,


эхчүүд хүүхдийнхээ ямар хүсэл мөрөөдөлтэй байгааг мэдэрч, тэднийг зөв зүгт чиглүүлснээр хүмүүжлийн зөв арга хэмжээ болохоор харагдаж байна. (Хүснэгт 5).

Хүснэгт 5 Хүүхэдтэйгээ нээлттэй ярилцдаг эцэг, эхчүүд хүүхдээ магтдаг эсэх

Та хүүхэдтэйгээ илэн далангүй ярилцдаг уу?	Та хүүхдээ аливаа асуудалд шударга хандсаных нь төлөө магтаж сайшаадаг уу?				Нийт
	Байнга	Заримдаа	Хааяа	Хэзээ ч үгүй	
Байнга	41.9%	20.4%	2.4%	.2%	65.0%
Заримдаа	15.5%	9.0%	1.3%		25.8%
Хааяа	2.6%	4.5%	1.7%		8.8%
Хэзээ ч үгүй		.2%		.2%	.4%
Нийт	60.1%	34.1%	5.4%	.4%	100.0%


Судалгааны үр дүнгээс харахад эцэг, эхчүүдийн 30-40 насныхан хүүхдээ аливаа асуудалд шударга хандсаных нь төлөө байнга магтаж, сайшаадаг байхад харин 40-өөс дээш насныхан хүүхдээ урамшуулдаг явдал нь харьцангуй бага байна (Зураг 21).

Зураг 21 Хүүхдээ аливаа асуудалд шударга хандсаных нь төлөө сайшаадаг эсэх, насны бүлгээр



Судалгааны үр дүнгээс харахад ээж нарын 48.9 хувь нь хүүхдээ аливаа асуудалд шударга хандсаных нь төлөө байнга магтаж, сайшаадаг байхад харин аав нарын 11.2 хувь нь хүүхдээ урмын үгээр мялаадаг байна (Зураг 22).

Зураг 22 Хүүхдээ аливаа асуудалд шударга хандсаных нь төлөө сайшаадаг эсэх, хүйсээр




Хүүхэдтэйгээ байнга ярилцдаг эцэг, эхчүүд хүүхдээ буруу зүйл, шударга бус үйлдэл хийснийг мэдвэл байнга хэлж ойлгуулдаг байхад харин хүүхэдтэйгээ нээлттэй ярилцдаггүй эцэг, эхчүүд тэр болгон хүүхэдтэйгээ тулж ажилдаггүй болох нь харагдаж байна (Хүснэгт 6).

Хүснэгт 6 Хүүхэдтэйгээ нээлттэй ярилцдаг эцэг, эхчүүд хүүхдээ буруу зүйл хийснийг мэдвэл хэлж ойлгуулдаг эсэх

Та хүүхдээ буруу зүйл, шударга бус зүйл хийснийг мэдвэл хэлж, ойлгуулдаг уу?	Та хүүхэдтэйгээ илэн далангүй ярилцдаг уу?				Нийт
	Байнга	Заримдаа	Хааяа	Хэзээ ч үгүй	
Байнга	54.3%	19.1%	5.6%		79.0%
Заримдаа	9.4%	6.0%	2.6%	.4%	18.4%
Хааяа	1.1%	.7%	.4%		2.2%
Хэзээ ч үгүй	.2%		.2%		.4%
Нийт	65.0%	25.8%	8.8%	.4%	100.0%

Судалгааны үр дүнгээс харахад эцэг, эхчүүдийн 30-40 насныхан хүүхдээ буруу зүйл, шударга бус зүйл хийснийг мэдвэл байнга хэлж ойлгуулдаг байхад харин 40-өөс дээш насныхан хүүхдээ зэмлэж, ухааруулдаг явдал бага байгааг судалгаанаас харж болохоор байна (Зураг 23).

Зураг 23 Хүүхдээ буруу зүйл, шударга бус зүйл хийснийг мэдвэл хэлж, ойлгуулдаг эсэх, насны бүлгээр



Судалгааны үр дүнгээс харахад ээж нарын 62.4 хувь нь хүүхдээ буруу зүйл, шударга бус зүйл хийснийг мэдвэл байнга хэлж ойлгуулдаг байхад аав нарын 16.7 хувь нь хүүхдийнхээ алдаа дутагдлыг засаж залруулдаг болох нь судалгаанаас харагдаж байна (Зураг 24).

Зураг 24 Хүүхдээ буруу зүйл, шударга бус зүйл хийснийг мэдвэл хэлж, ойлгуулдаг эсэх, хүйсээр



Хүүхдээ аливаа асуудалд шударга хандсаных нь төлөө үргэлж магтаж сайшаадаг эцэг, эхчүүд тэднийг буруу зүйл, хийснийг мэдвэл ихэнхдээ хэлж, ойлгуулж зөв зүгт чиглүүлдэг болох нь судалгаанаас харагдаж байна (Хүснэгт 7).

Хүснэгт 7 Хүүхдээ магтаж сайшаадаг эцэг, эхчүүд хүүхдээ буруу зүйл хийснийг нь мэдвэл хэлж ойлгуулдаг эсэх

Та хүүхдээ аливаа асуудалд шударга хандсаных нь төлөө магтаж сайшаадаг уу?	Та хүүхдээ буруу зүйл, шударга бус зүйл хийснийг мэдвэл хэлж, ойлгуулдаг уу?				Нийт
	Байнга	Заримдаа	Хааяа	Хэзээ ч үгүй	
Байнга	53.2%	6.7%	.2%		60.1%
Заримдаа	23.2%	9.9%	.9%		34.1%
Хааяа	2.6%	1.3%	1.1%	.4%	5.4%
Хэзээ ч үгүй		.4%			.4%
Нийт	79.0%	18.4%	2.2%	.4%	100.0%

ДҮГНЭЛТ

Авлигатай тэмцэх газар нь “Хүүхдийн шударга байдлын түвшин 2020 он” судалгааг аймаг, нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн багш нар болон нийгмийн ажилтантай хамтран “SurveyMonkey” судалгааны программыг ашиглан зохион байгуулав. Судалгааны үр дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна.

- ✚ Хүүхдийн шударга байдал 2020 оны судалгааны үр дүнгээс харахад сурагчийн 36.7 хувь нь эрэгтэй, 63.3 хувь нь эмэгтэй сурагчид байгаа бол эцэг, эхчүүдийн хувьд 21 хувь нь эрэгтэй, 79 хувь нь эмэгтэй байна.
- ✚ Хүүхдийн шударга байдлын түвшин 2020 оны судалгаагаар 4.01¹ гэсэн дүнтэй гарсан нь өмнөх оныхоос 0.1 пунктээр нэмэгдсэн байна. Монгол Улсын ирээдүйг тодорхойлох хүүхдийн шударга байдлын түвшин өнгөрсөн оны судалгааны түвшинөөс үл ялиг нэмэгдсэн байгаа нь хүүхдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүртээмж чанарт бага зэргийн өөрчлөлт гарсан болохыг харуулж байна.
- ✚ Хүүхдийн шударга байдлын түвшинг аймаг, нийслэлээр тооцсон ба 2020 оны судалгааны үр дүнгээр Говь-Алтай, Төв аймгийн хүүхдийн шударга байдлын түвшин буурчээ. Өмнөговь, Завхан аймгийн хүүхдийн шударга байдлын түвшин өнгөрсөн онтой харьцуулахад өөрчлөлтгүй байна. Бусад аймаг болон нийслэлийн хүүхдийн шударга байдлын түвшин эерэг өөрчлөлттэй гарчээ. Харин Баян-Өлгий, Баянхонгор, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл аймгийн хүүхдийн шударга байдлын түвшин сүүлийн хоёр жилд буурсан боловч энэ онд эерэг өөрчлөлттэй гарсан байна.
- ✚ Судалгааны дүнгээс харахад хүүхдийн шударга байдлын түвшин 9-11 дүгээр анги хүртлээ нэмэгдэж байгаад төгсөх ангидаа энэ хандлага нь буурчээ. Энэ нь сурагчийн ширээнээс оюутны амьдралд хөл тавих цаашлаад нийгэмд бие хүн болж төлөвшихөд нь эцэг, эхчүүд, багш, сурган хүмүүжүүлэгчийн хувьд тухайн хүүхдийг маш сайн чиглүүлэх хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.
- ✚ Судалгааны үр дүнгээс харахад сүүлийн хэдэн жилд эрэгтэй хүүхдийн шударга байдлын түвшин эмэгтэй хүүхдийн шударга байдлын түвшинөөс бага байна. Үүнд аав нарын хүүхэдтэйгээ бага ярилцдаг байдал нөлөөлсөн байх талтай ажиглагдаж байна.
- ✚ Төрийн өмчийн сургуулийн хүүхдийн шударга байдлын түвшин хувийн өмчийн хэлбэрийн сургуулийн хүүхдийн шударга байдлын түвшинөөс 0.19 пунктээр их байна. Энэ хандлага сүүлийн 3 жилд ижил үр дүнтэй гарсан байна. Мөн нийслэлийн хүүхдийн шударга байдлын түвшин орон нутгийн хүүхдийн шударга байдлын түвшинөөс 0.02 пунктээр их гарчээ.
- ✚ Шударга байх талаар гэрийнхэн нь байнга ярилцдаг хүүхдийн шударга байдлын түвшин шударга байх талаар гэрийнхэн нь хэзээч ярилцаж байгаагүй хүүхдийн шударга байдлын түвшинөөс их байгаа нь гэр бүлийн харилцаа, хандлага чухал нөлөөтэй болохыг илэрхийлж байна.
- ✚ Судалгааны үр дүнгээс харахад хүүхдүүд болон эцэг, эхийн хариултаас харахад хүүхэдтэйгээ байнга ярилцдаг эцэг, эхчүүд хүүхдээ аливаа асуудалд шударга хандсаныг нь төлөө магтан сайшааж харин буруу зүйл, шударга бус үйлдэл хийснийг мэдвэл тухайн зүйлээс гарах үр дүнг тайлбарлан өгдөг дотно зөвлөгч нь байж тэднийг шударга зөв зүйлд хөтөлж төлөвшсөн иргэн болох эх үндсийг нь тавьж өгч байна. Харин хүүхэдтэйгээ хааяа ярилцдаг эцэг, эхчүүд хүүхдээ аливаа асуудалд шударга хандсаныг нь төлөө урмын үгээр мялаадаггүй бөгөөд хүүхдээ шударга бус зүйл хийснийг мэдсэн ч ямар нэгэн хариу арга хэмжээ авдаггүй байдал нь тухайн хүүхдийг нийгэмд шударга бус зүйл хийж болох юм гэсэн сэдлийг төрүүлж өгч байна.

¹ Хүүхдийн шударга байдлын түвшин болон дэд үзүүлэлтийг 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн бөгөөд уг үзүүлэлтийн утга 1-д ойртох тусам шударга бус, 5-д ойртох тусам шударга гэж ойлгоно.

- ✚ Сайныг дагавал сарны гэрэл гэдэг шиг найз нөхдийн хүмүүжил, зөв хандлага, үлгэр дуурайл хүүхдийн шударга байдалд шууд нөлөөлж байна. Шударга бус үйлдлийн талаар ангийнхан, найз нартайгаа ярилцдаг хүүхдийн шударга байдлын түвшин найз нөхөдтэйгээ ярилцдаггүй хүүхдийн шударга байдлын түвшинөөс их байна. Иймд гэрийнхэн нь хүүхдийнхээ хүсэл сонирхлыг сонсож тэдний араас санаа тавьж ямар хүүхэдтэй найзалж, нөхөрлөж байгааг мэдэж байх явдал нь амьдралд нь тус дэм хүргэж байгаа маш том үүрэг хариуцлага юм.
- ✚ Шударга бус зүйл хийсэн дотныхоо хүнийг зэмлэж сануулна гэж үзэж буй хүүхдийн шударга байдлын түвшин надад ашигтай байвал дэмжинэ гэж үзэж буй хүүхдийн шударга байдлын түвшинөөс их байгаа нь шударга бус явдлыг өөхшүүлсэн хэрэг болж байна.
- ✚ Шударга ёсны талаар биеэр үлгэрлэх, зааж сургах нь хүүхдийн шударга байдалд эерэгээр нөлөөлж байна. Шударга бус асуудал тохиолдвол эцэг, эх, багш зэрэг дотныхоо хүнд ханддаг хүүхдийн шударга байдлын түвшин шударга бус асуудал тохиолдвол ямар нэгэн үйлдэл хийдэггүй хүүхдийн шударга байдлын түвшинөөс их байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.
- ✚ Шударга ёсны тухай мэдээллийг сургуулийн орчин, сонин, хэвлэл, гэр бүлийн хүрээнд авдаг хүүхдийн шударга байдлын түвшин нь интернет, зурагт радио, найз, нөхдийн хүрээлэл зэрэг бусад хүрээнээс авдаг хүүхдийн шударга байдлын түвшинөөс өндөр байна.
- ✚ Хүүхдүүд шударга бус үйлдэл гаргасныхаа төлөө эцэг, эх, найз нөхөддөө хандан ярилцаж асуудлаа шийдвэрлэдэг болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.
- ✚ Судалгааны үр дүнгээс харахад эцэг, эхчүүдийн хувьд 30-40 насныхан хүүхэдтэйгээ байнга ярилцаж аливаа асуудалд шударга хандсаных нь төлөө магтан сайшааж, шударга бус зүйл хийснийг нь мэдвэл байнга хэлж ойлгуулдаг байхад 40-өөс дээш насныхан хүүхэдтэйгээ ярилцаж тэдний зөв зүйлд урам өгч, буруу зүйлд ташуур болох явдал нь харьцангуй бага байгаа нь ажиглагдаж байна.
- ✚ Судалгааны үр дүнгээс харахад ээж нарын ихэнх нь хүүхэдтэйгээ их цаг хугацааг зарцуулж хүүхдээ аливаа асуудалд шударга хандсаных нь төлөө сайшааж, шударга бус зүйл хийснийг нь мэдвэл алдаа дутагдлыг нь засаж залруулдаг байхад харин аав нарын хувьд энэ байдал нь бага хувийг эзлэж байна.
- ✚ Төрийн байгууллагад ажилладаг эцэг, эхчүүдийн хувьд бусад салбарт ажилладаг эцэг, эхчүүдтэй харьцуулахад хүүхэдтэйгээ илүү ойр дотно ярилцаж, тулж ажилладаг болох нь судалгаанаас харагдаж байна.
- ✚ Хүн болох багаасаа хүлэг болох унаганаасаа гэдэг шиг Монгол Улсын ирээдүйг тодорхойлох хүүхдүүдэд балчир наснаас нь эхлэн зөв шударга иргэн болж авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд нь гэр бүлийн хүмүүжлээс гадна цэцэрлэг болон сургуулийн орчин найз нөхдийн хүрээлэл ихээхэн нөлөөлж байна.
- ✚ Эцэг, эхчүүд үр хүүхэдтэйгээ байнгын тасралтгүй ажиллах хэрэгцээ шаардлагатай байна. Мөн аавууд хүүхэдтэйгээ илүү ойр дотно байж тэдэнд анхаарал хандуулах хэрэгтэй байна. Үүнээс гадна эцэг, эхчүүд нас ахих тусам хүүхдэд тавих анхаарал халамж нь буурч байдаг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

ЗӨВЛӨМЖ

БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬД:

- Сургуулийн өмнөх боловсрол болон бага дунд боловсрол олгож байгаа сургалтын байгууллагын хичээлийн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөнд шударга ёсны талаарх хичээлийг үе шаттайгаар анги бүрт ялгаатай байдлаар тусган оруулах;
- Сургалтын хөтөлбөрийг жил бүр шинэчлэн сайжруулж, багш нар орчин үеийн арга хандлагаар хичээлийг удирдан явуулах;
- Багш нарын ёс зүйн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалтад тасралтгүй хамруулах болон сургууль дээр нь хэлэлцүүлэг, мэтгэлцээн зэргийг тогтмол зохион байгуулах;
- Сурагч буруу үйлдэл хийсэн бол багш нар тэднийг бусад хүүхдийн өмнө эвгүй байдалд оруулахгүйгээр тусгайлан уулзаж зөвлөгөө өгөх;
- Хүүхдийн шударга байдлын түвшингөөр нь тухайн сургууль болон хичээл заасан багш нарыг нь шалгаруулан урамшуулах;
- Сургууль бүр хичээлийн жилдээ анги, сургуулийн хэмжээнд сар, улирал бүр шударга үйлдэл хийсэн хүүхдийг шалгаруулах замаар ёс зүйн болоод ёс суртахууны хүмүүжил олгох арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН УВЬД:

- Хүүхдээ нийгэмд хэрэгтэй хүн болгон төлөвшүүлэхийн тулд эцэг, эхчүүд толины тусгал мэт үг хэл, үйл хөдлөл, биеэрээ зөв үлгэр дууриалал үзүүлж хэвших;
- Хүүхдээ шударга үйлдэл хийсэн бол магтаж, сайшааж байх, шударга бус үйлдэл хийсэн бол хор хөнөөл, учрах саад бэрхшээлийг ухааруулан тайлбарлаж өгөх;
- Хүүхдийнхээ багш нартай байнга холбоотой байж, хүүхдээ олны дунд биеэ хэрхэн авч явж байгааг судлаж мэдэх;
- Хүүхэдтэйгээ илэн далангүй дотно ярилцсанаар хүсэл зоригийг нь олж мэдэх, улмаар тэдэнд нөхөрсөг зөвлөгөө өгч өөртөө татах;
- Хүүхдээ ямар хүүхэдтэй найзалж, нөхөрлөж байгааг нь үргэлж шинжилж байх;
- Хүүхэдтэйгээ шударга ёсны талаарх ойлголтоо нэгтгэж, цаг үргэлж дэмжих;
- Хүүхдүүд олон төрлийн олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашигладаг тул тэдний интернэт хэрэглээнд хяналт тавьж байх;
- Зурагт, радиогоор соён гэгээрүүлэх хэрэгцээтэй зүйлсийг үзүүлж сонсгох
- Зөвхөн ээжүүд хүүхэдтэйгээ байнгын харилцаатай байхаас гадна аавууд ч гэсэн хүүхэдтэйгээ ойр дотно байж тэдэнд сайн сайхан байдлаар үргэлж нөлөөлж байх;
- Эцэг, эхчүүд нас ахих тусам хүүхдэд тавих хараа хяналт, анхаарал халамжаа улам бүр нэмэгдүүлэх;

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬД:

- Телевизүүдээр хүүхдийн сэтгэл зүйд нөлөөлсөн үлгэр жишээ авахаар шударга ёсны талаарх сонирхолтой кино, хөтөлбөр, нэвтрүүлгийг тогтмол бэлтгэн гаргах;
- Хүүхдийг зөв хандлагатай зөв хүн болгон төлөвшүүлэхийн тулд холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах;
- Цахим орчинд гарч байгаа мэдээллийн урсгалд хяналт тавьж ажиллах



**ХАСХОМ МЭДҮҮЛЭГЧДЭЭС
АВСАН СУДАЛГАА-2020**

ХУРААНГУЙ

Авлигын эсрэг хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд авлигатай тэмцэх үйл ажиллагааг боловсронгуй болгоход шаардлагатай зарим мэдээллийг цуглуулах зорилгоор ХАСХОМ мэдүүлэгчдийг хамруулсан судалгааг зохион байгуулав.

Судалгааны мэдээллийг цуглуулахдаа онлайн судалгааны цахим хуудас SURVEYMONKEY ашигласан бөгөөд судалгаанд ХАСХОМ-ээ гаргадаг 4800 албан тушаалтан хамрагдлаа.

Судалгаагаар мэдүүлэг гаргагчдаас хөрөнгө, орлогын мэдүүлгийн системийн ул тод байдал болон ХАСХОМ-ээ мэдүүлэхэд учирч буй бэрхшээл, төрийн байгууллагуудын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаа, авлигыг мэдээлэхэд бэлэн байдал болон мэдээлэхгүй байгаагийн шалтгаан, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа зэрэг агуулгын хүрээнд мэдээлэл цуглуулав. Цуглуулсан мэдээллийг тухайн албан тушаалтны ХАСХОМ-ын бусад мэдээлэлтэй уялдуулан дүн шинжилгээ хийхэд ашигласан болно.

ХАСХОМ-ээ мэдүүлэхэд албан тушаалтнуудын 65 хувьд нь бэрхшээл тулгараагүй байгаа бол бусад хэсэгт нь цахим системийн үйл ажиллагаа, мэдүүлэх процесс, мэдүүлгийн маягт, түүний заавар, гарын авлагатай холбоотой бэрхшээл тулгарч байна.

Мөн авлигыг ул болгоход түүнийг талаар мэдээлэл өгөх явдлыг дэмжих шаардлагатай байдаг. Энэ удаагийн судалгаагаар нийтийн албан тушаалтнуудын хувьд өөрийн байгууллага дахь авлига, хээл хахуулийг мэдээлэх үүрэг болон мэдээлэхгүй байгаагийн шалтгааныг тодорхойлсон бөгөөд мэдээлэл өгсөн этгээдийн нууцлалыг хангах, харцу дарамт шахалтад орохоос хамгаалах шаардлагатай байна.

Судалгаанд ороцогчдын үзэж байгаагаар эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг үнэлүүлсэн бөгөөд эдгээр албан тушаалтнуудын үйл ажиллагааг байгууллагуудын хувьд харилцан адилгүй байна.

Нийтийн албан тушаалтнууд Авлигатай тэмцэх газрыг харьяангүй эерэг үнэлсэн байгаа боловч байршил, албан тушаалын хувьд уг үнэлгээ харилцан адилгүй байв.


НЭГ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

1.1. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн нээлттэй байдал

Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/122 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар иргэдэд мэдээлэл өгөх журам”-ын 2.1-д “Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хураангуй хэлбэрээр, батлагдсан маягтын дагуу жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан Авлигатай тэмцэх газрын цахим мэдээллийн сүлжээнд байршуулж, иргэд, олон нийтийг энэ тухай мэдээлэл авах боломжоор хангана” гэж заасан. Энэ дагуу тус газраас хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуйг цахим хуудсанд байршуулж ирсэн.


Судалгаанд оролиогчдоос цахим хуудсанд байршуулсан мэдээллийн агуулгыг өөрчлөх шаардлагатай эсэхийг асуухад 64 хувь нь өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн байна (Зураг 1).

Зураг 1. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуйг цахим хуудсанд (<http://хасхот.иаас.mn>) байршуулдаг. Энэ мэдээллийг өөрчлөх шаардлага бий юу?



Орлогын хэмжээ нэмэгдэх тусам хөрөнгө, орлогоо ил болгох сонирхол буурч байна. Өөрөөр хэлбэл, өрхийн жилийн орлогын хэмжээ нэмэгдэх тусам “илүү хураангуй болгох” гэж харцуулсан хувь нэмэгдэх хандлагатай байна.

Зураг 2. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуйг цахим хуудсанд (<http://хасхот.иаас.mn>) байршуулдаг. Энэ мэдээллийг өөрчлөх шаардлага бий юу?, өрхийн орлогын түвшинээр




1.2. Эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ)-ын үйл ажиллагаа

Төрийн байгууллагуудад ажиллаж буй ЭБАТ нь байгууллага, салбарын хэмжээнд авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, сургалт зохион байгуулах, мэдүүлэг гаргагчдыг гарын авлага, зөвлөмжөөр хангах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг.

ХАСХОМ гаргагчдаас өөрийн байгууллагын ЭБАТ-ын үйл ажиллагааг үнэлүүлэхэд судалгаанд оролиогчдын 78 хувь нь эрх бүхий албан тушаалтан мэдээлэл, арга

зүйгээр ханган ажиллаж чаддаг гэж харуулсан байна.

Зураг 3. Танай байгууллагын ЭБАТ таныг холбогдох мэдээлэл, арга зүйгээр ханган ажиллаж чаддаг уу?



1.3. ХАСХОМ-ээ мэдүүлэхэд тулгарч буй бэрхшээл

ХАСХОМ-ээ мэдүүлэхэд тухайн албан тушаалтанд тулгардаг бэрхшээлийг нээлттэй асуултаар асуусан. Судалгаанд оролцогчдын 65 хувь нь мэдүүлгээ гаргахад ямар нэг бэрхшээл тулгардаггүй гэж харуулсан байна.

Судалгаанд оролцогчдын үзэж байгаагаар ХАСХОМ-ийн системийг боловсронгуй болгох, үүний тулд уг системээр дамжуулан бусад төрийн байгууллага, банкны мэдээллийн сангаас холбогдох албан тушаалтны мэдээллийг шууд татаж авдаг, албан тушаалтан уг мэдээлэлд нь нэмэлт, эсхүл тайлбар хийдэг байдлаар зохион байгуулах нь илүү үр дүнтэй, мөн зохион байгуулалтын хувьд оновчтой байж болохыг илэрхийлсэн байна. Тухайлбал иалингийн хэмжээг нийгмийн даатгалын байгууллагаас, орлого, татварын урамшууллын мэдээллийг татварын байгууллагаас, хадгаламж, харуулах дансны мэдээллийг банкнаас, үнэт цаас, хувьцаа болон түүнээс олсон орлогын мэдээллийг үнэт цаасны асуудал харуулсан байгууллагаас, бусад хөрөнгийн мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагаас тус тус авч байх шаардлагатайг судалгаанд оролцогчид онцлон тэмдэглэсэн байна.

Харин судалгаанд оролцогчдын 35 хувьд нь ХАСХОМ-ээ мэдүүлэхэд цахим системийн үйл ажиллагаа, мэдүүлэх процесс, мэдүүлгийн маягт, түүнийг гаргахад шаардлагатай заавар, гарын авлагатай холбоотой дараахь бэрхшээл байдгийг илэрхийлсэн байна. Үүнд:

Цахим системийн үйл ажиллагаатай холбоотой:

- Цахим системийг бусад төрийн байгууллагын сантай холбох, мэдээлэл авдаг болох, албан тушаалтан зөвхөн тайлбар хийдэг байх;
- Мэдүүлэг гаргаж буй цахим системийн ажиллагаа удаан;
- Мэдүүлгээ гаргасны дараа “Баталгаажуулах” товчлуурыг олоход төвөгтэй байдаг;
- Гэр бүлийн гишүүдийн данс, хөрөнгийн мэдээлэл оруулахад тэдний овог нэрийг заавал гараас дахин бичих болдог төвөгтэй (автоматаар гаргаж ирдэг болгох);
- Программ дахь сонголт цөөн. Тухайлбал, томилолтоор ажиллаж олсон орлого, криптовалюта зэргийг мэдүүлэх сонголтгүй;

Мэдүүлэх процесстэй холбоотой:

- Нэг гэр бүл боловч тусдаа байдаг өрхийн бусад гишүүд, эсхүл гадаадад байдаг хүний хөрөнгө, орлого, дансны мэдээллийг авах, бодитоор мэдэх, үнэн зөв

мэдүүлэхэд хүндрэлтэй;

- Мэдүүлэх бүрт банканд хандах, хуулга авах шаардлагатай болдог. Бага үлдэгдэлтэй данс бүрийг бичихэд хүндрэлтэй (мэдүүлэх дансны үлдэгдэлийн доод хэмжээг тогтоох);
- Өмнөх жилүүдэд эх үүсвэрийг нь тайлбарласан, өөрчлөлт ороогүй хөрөнгийг дараа жил нь дахин тайлбарлах нь бэрхшээлтэй;

Мэдцүлгийн маягттай холбоотой:

- УИХ-ын ХЗБХ-ноос баталсан маягт, цахимаар бөглөж буй маягт хоёр зөрүүтэй. Хэт их мэдээлэл шаарддаг, цаг хугацаа их ордог;

Заавар, гарын авлагатай холбоотой:

- Мал, газар, өөрийн барьсан амины орон сууц зэрэг хөрөнгийг өөрсдөө үнэлж бичих, зах зээлийн үнийг тодорхойлох зэрэгт хүндрэлтэй, тайлбар, бодит жишээ нэмэх шаардлагатай;
- Үнэт зүйл гэдэгт яг юуг оруулах нь тодорхойгүй байдаг. Тухайлбал, мэдүүлэг гаргаж буй хүний хувьд үнэ цэнэтэй зүйлс их байдаг.
- Сургалтад хамрагдаагүй, эсхүл сэргээн харах шаардлагатай тохиолдолд ашиглах боломжтой хичээлийг видео хэлбэрээр цахим хуудсанд байршуулах;
- Заавар, гарын авлагыг улам бүр тодорхой болгох. Жишээлбэл, татварын өмнөх болон дараахь орлогын алийг нь мэдүүлэх нь тодорхой бус байдаг.

1.4. Авлигыг мэдээлэхэд бэлэн байдал

Авлигын эсрэг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д зааснаар албан тушаалтан албаны чиг үүргээ гүйцэтгэх явидаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг АТГ-т нэн даруй мэдээлэх үүрэгтэй байдаг.


Энэ удаагийн судалгаагаар тухай албан тушаалтнаас өөрийн байгууллага дахь авлига, хээл хахуулийн талаар олж мэдвэл энэ талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх эсэхийг асуухад судалгаанд оролцогчдын 77 хувь нь тийм гэж харцуулсан бол, үлдсэн хэсэг нь “тухайн нөхцөл байдлаас хамаарна”, “үгүй”, “мэдэхгүй” гэж харцуулсан байна.

Зураг 4. Өөрийн байгууллага дахь авлига, хээл хахуулийн талаар олж мэдвэл Та энэ талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх үү?



Авлигыг мэдээлэхэд бэлэн буюу “Тийм” гэж харцуулсан байдлыг аймаг, нийслэлээр авч үзвэл Баян-Өлгий, Дорнод, Ховд, Өвөрхангай аймгаас оролцсон албан тушаалтнуудын хувь хэмжээ харьцангуй бага байна.

Зураг 5. Өөрийн байгууллага дахь авлига, хээл хахуулийн талаар олж мэдвэл холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлнэ гэж хариулсан байдал, байршлаар




“Тийм” болон “Тухайн нөхцөл байдлаас хамаарна” гэж хариулсан албан тушаалтнуудаас хаана, хэнд мэдэгдэхийг нь асуухад авлигыг мэдээлэх 110 утсанд, Авлигатай тэмцэх газарт, байгууллагынхаа удирдах албан тушаалтанд, ЭБАТ-д гэж хариулсан нь хамгийн олон байна. Харин шүүх, прокурорт гэж хариулсан байдал харьцангуй бага байна.

Зураг 6. Хэрэв мэдээлэх бол хэнд мэдэгдэх вэ? (1-3 хүртэлх хариултыг сонгоно уу)



Авлигын эсрэг хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ ихэнх албан тушаалтнууд мэдэж байна. Тухайлбал, мэдээлэх болсон шалтгааныг нь авч үзвэл судалгаанд оролиогчдын 70 хувь нь мэдээлэх нь миний үүрэг, 28 хувь нь мэдээлэх нь нийтийн тусын тулд гэж хариулсан дүнтэй байна.


Зураг 7. Авлига, хээл хахуулийн талаар мэдээлэх болсон нь ямар шалтгаантай вэ?



1.5. Авлигыг мэдээлэхгүй байгаа шалтгаан

Албан үүргээ гүйцэтгэх явцадаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг мэдээлэхгүй гэж харуулсан оролцогчдоос шалтгааныг тодруулахад мэдээлсэн талаар нууц задрах эрсдэлтэй, харуу дарамт, үр дагавраас айж байна гэж харуулсан нь харьяангүй олон байгаа бол би мэдээлснээр юу ч өөрчлөгдөхгүй гэж 40 хувь нь харуулжээ.

Зураг 8. Хэрэв мэдээлэхгүй бол шалтгаан нь юу вэ? (1-3 хүртэлх харуултыг сонгоно уу)




Эндээс харахад авлигын талаар мэдээлсэн албан тушаалтны нууцлалыг хангах, тэдгээрийг харуу дарамт, үр дагавраас хамгаалах талаар анхаарал хандуулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

1.6 Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны талаарх үнэлгээ


Судалгаанд оролцогчдоор Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг үнэлүүлэхэд 51 хувь нь “сайн” гэж харуулсан бол 38 хувь нь “дунд” гэж харуулсан байна.

Зураг 9. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг Та хэрхэн үнэлэх вэ?



Дээрх үнэлгээг 1 (маш муу)-ээс 5 (маш сайн) оноонд шилжүүлж, харцуулсан байдлыг судалгаанд оролцогчдын албан тушаалын ангилалаар авч үзвэл төрийн өндөр албан тушаал, улс төрийн албан тушаалтнууд харьцангуй бага үнэлгээ өгсөн байна.

Зураг 10. АТГ-ын үйл ажиллагаанд үнэлгээ өгсөн байдал, судалгаанд оролцогчдын албан тушаалын ангилалаар, 1 (маш муу)-5 (маш сайн) оноогоор



¹ ТӨ-төрийн өндөр албан тушаал, АА-Ажлын албаны албан тушаал, УТ-Улс төрийн албан тушаал, ТТ-төрийн тусгай албан тушаал, ТЗ-төрийн захиргааны албан тушаал, ТҮСУ-Соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаал, ТҮЭМ-Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаал, ТҮШУ-Шинжлэх ухааны байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаал, ТҮМБ-Мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаал, ТҮБД-Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаал, ТҮ-төрийн үйлчилгээний бусад албан тушаал.

ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2.1. Судалгааны үндэслэл, зорилго

“Авлигатай тэмцэх газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний 1.2.1.10-т “Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягтыг боловсронгуй болгож, мэдүүлгийг цахим хэлбэрээр хүлээн авах тогтолцоонд бүрэн шилжүүлэх”, Судалгаа шинжилгээний албаны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2-т “Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн шалтгаан, нөхцлийг судлах”-ажлын хүрээнд “Шүгэл үлээх үйлдлийн талаарх ойлголтын судалгааг зохион байгуулах”-аар тус тус заасан. Эдгээр зорилгын хүрээнд Судалгаа шинжилгээний албанаас нийтийн албан тушаалтнууд дунд “Авлигын эсрэг үйл ажиллагааны талаарх судалгаа”-г зохион байгууллаа.

Энэ судалгаагаар хөрөнгө, орлогын мэдүүлгийн систем, авлигыг мэдээлэх / шүгэл үлээх/ асуудал болон Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны талаар дараахь мэдээллийг цуглуулах, анхаарах асуудлыг тодорхойлохыг зорьсон болно. Үүнд:

- Албан тушаалтнуудын ХОМ-ийн хураангуйг цахим хуудсанд ил тод байршуулж буй байдал;
- ХАСХОМ-ээ мэдүүлэхэд учирч буй хүндрэл, бэрхшээл;
- Мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаа;
- Авлига, хээл хахуулийн талаар мэдээлэхтэй холбоотой асуудал;
- Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны талаарх үнэлгээ;

2.2. Судалгааны хамрах хүрээ

Судалгааны хамрах хүрээ нь 2019 оны ХАСХОМ-ээ цахимаар мэдүүлсэн 37529 нийтийн албан тушаалтан.

2.3. Түүврийн хэмжээ ба алдаа

ХАСХОМ-ээ цахимаар мэдүүлсэн 37529 нийтийн албан тушаалтанд цахимаар судалгаанд оролох урилга хүргүүлснээс эхний 10 хоногийн хугацаанд 4800 албан тушаалтан судалгаанд оролсон бөгөөд уг дүнгээр судалгааны мэдээллийн боловсруулалт хийсэн болно. Судалгаанд хамрагдсан албан тушаалтнуудын тоог аймаг, нийслэлээр авч үзвэл Улаанбаатар хотоос 2372, орон нутгаас 2428 албан тушаалтан хамрагдсан байна.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан нэгжийн тоо, аймгаар

Аймаг	Нэгжийн тоо	Аймаг	Нэгжийн тоо	Аймаг	Нэгжийн тоо
Архангай	106	Дорноговь	91	Сүхбаатар	89
Баян-Өлгий	87	Дорнод	134	Сэлэнгэ	133
Баянхонгор	102	Дундговь	89	Төв	138
Булган	96	Завхан	181	Увс	108
Говь-Алтай	132	Орхон	107	Ховд	147
Говь-Сүмбэр	42	Өвөрхангай	149	Хөвсгөл	157
Дархан уул	107	Өмнөговь	136	Хэнтий	97

Дээрх мэдээлэлд үндэслэн эх олонлогийн хувьд 99 хувийн итгэх магадлалтайгаар, судалгааны мэдээлэл эх олонлогоо төлөөлөх чадварыг тооцож үзэхэд +/-2 хувь гарч байна.

2.4. Мэдээлэл цуглуулалт ба боловсруулалт

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг онлайн судалгааны “SurveyMonkey” цахим хуудсаар дамжуулан 2020 оны 5 дугаар сарын 7-16-ны хооронд 10 хоногийн хугацаанд

мэдээлэл цуглуулсан болно.

Судалгааны мэдээллийг боловсруулалтыг хийхдээ судалгаагаар цуглуулсан мэдээллийг тухайн албан тушаалтны ХАСХОМ-ийн бусад мэдээлэлтэй харьцуулах байдлаар үр дүнг тооцон гаргав.

ГУРАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

1. Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг онлайн судалгааны программаар дамжуулан зохион байгуулсан нь богино хугацаанд хамралт өндөртэй мэдээлэл цуглуулах боломжийг бүрдүүллээ. Мөн түүнчлэн энэхүү зохион байгуулалт нь цаг хугацаа, хөрөнгө хэмнэх, түүвэр судалгааны явцад гардаг зарим төрлийн алдааг бууруулах зэрэг ач холбогдолтой байв. Цаашид тодорхой салбар, үйл ажиллагааны хүрээнд судалгаа зохион байгуулахдаа судалгаанд оролиогчдын и-мэйл хаяг, интернет сүлжээгээр дамжуулан мэдээлэл цуглуулах боломжтой байна.
2. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуйг цахим хуудсанд байршуулж буй мэдээллийн агуулга, хүрээг өөрчлөх шаардлагагүй гэж дийлэнх нийтийн албан тушаалтнууд үзэж байна. Энэхүү санаа бодол нь зөвхөн нийтийн албан тушаалтнуудынх бөгөөд мэдээллийг ашигладаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын санал биш болохыг онцлох шаардлагатай.
3. Төрийн байгууллагуудад ажиллаж буй ЭБАТ-ын үйл ажиллагааны үнэлгээ харьцангуй эерэг байгаа боловч цаашид анхаарал хандуулах шаардлагатай зарим ЭБАТ-ууд байгааг судалгааны дүн харууллаа.
4. Нийтийн албан тушаалтнуудаас ХАСХОМ-ээ мэдүүлэхэд ерөнхийдөө мэдүүлгийн цахим системийн үйл ажиллагаа, мэдүүлэх үе шат, маягт, түүний заавар, гарын авлагатай холбоотой тодорхой бэрхшээл тулгарч байна.
Иймд тайланд дурдсан асуудлуудыг арилгах талаар холбогдох хэлтэс, албадууд анхаарал хандуулах шаардлагатай байна.
5. ХАСХОМ-ийн мэдүүлгийн системийг боловсронгуй болгох. Ялангуяа, зарим мэдээллийг холбогдох төрийн байгууллагаас (татвар, нийгмийн даатгал, банк, үнэмт цаас, бусад эд хөрөнгийн бүртгэл хариуцсан) шууд авдаг, харин албан тушаалтнууд түүнд нь тайлбар хийдэг байх зохион байгуулалтыг хийх нь мэдүүлэг гаргагчдад учирч буй бэрхшээлийг бууруулахаар байна.
6. ХАСХОМ-ийн цахим мэдүүлгийн маягт нь УИХ-ын ХЗБХ-оос баталсан маягтаас зөрүүтэй байгаа явдлыг арилгах, шинэчлэн батлуулах. Ингэхдээ зарим төрлийн хөрөнгийг (мал, үнэмт эдлэл, газар) хэрхэн үнэлж тусгах, криптовалютыг бүртгэх хэсгийг нэмэх, мөн холбогдох заавар, гарын авлагыг боловсронгуй болгох, гарын авлагын шинэ төрөл (заавар хичээлийг видео хэлбэрээр)-ийг нэмэх шаардлагатай байна.
7. Албан тушаалтнууд өөрийн байгууллага дахь авлига, хээл хахуулийн талаар Авлигатай тэмцэх газар, 110 утсанд мэдээлэхэд бэлэн байгаа боловч, мэдээлэхгүй байгаа шалтгаан нь “мэдээлсэн талаар нууц задрах эрсдэлтэй” буюу гомдол, мэдээлэл хүлээн авч буй байгууллага, албан хаагчдад итгэх итгэл бага байгааг харуулж байна. Мөн мэдээлэхгүй байгаа дараагийн шалтгаанаар “харуу дарамт, үр дагавраас айж байна” гэж харуулсан байна.

Иймд байгууллагын зүгээс гомдол, мэдээлэл гаргасан этгээдийн нууцлалыг хангах, хамгаалах талаар онцгойлон анхаарал хандуулах, мөн этгээд харуу дарамт, шахалтад орохоос хамгаалах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

8. Нийтийн албан тушаалтнууд авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд харьяангүй эерэг үнэлгээ өгсөн байна. Гэхдээ зарим ангиллын төрийн албан хаагчид, тухайлбал төрийн өндөр албан тушаалтнууд, төрийн улс төрийн албан тушаалтан, ажлын албаны болон төрийн үйлчилгээний албан тушаалтнууд тус байгууллагын үйл ажиллагаанд харьяангүй доогуур үнэлгээ өгсөн байна. Мөн үнэлгээ нь аймгуудын хувьд харилцан адилгүй байна.
- Энэ нь дурдсан төрийн албан хаагчдад тусгайлан чиглэсэн Авлигатай тэмцэх газрын бодлого, үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах шаардлагатай байгааг харуулж байна.

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА

ХАВСРАЛТ 1. АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ СУДАЛГААНЫ АСУУЛГА

1. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн **хураангуйг** цахим хуудсанд (<http://хасхот.иаас.mn>) байршуулдаг. Энэ мэдээллийг өөрчлөх шаардлага бий юу?

- Илүү дэлгэрэнгүй болгох
- Илүү хураангуй болгох
- Өөрчлөх шаардлагагүй
- Мэдэхгүй

2. Танай байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/ таныг холбогдох мэдээлэл, арга зүйгээр ханган ажиллаж чаддаг уу?

- Чаддаг
- Чаддаггүй
- Мэдэхгүй

3. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргахад Танд ямар бэрхшээл тулгардаг вэ? /Бичнэ үү/

4. ӨӨРИЙН БАЙГУУЛЛАГА дахь авлига, хээл хахуулийн талаар олж мэдвэл Та энэ талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх үү?

- Тийм
- Тухайн нөхцөл байдлаас хамаарна
- Үгүй
- Мэдэхгүй

5. Хэрэв мэдээлэх бол хэнд мэдэгдэх вэ? (1-3 хүртэлх харцуултыг сонгоно уу)

- Авлигатай тэмцэх газарт
- Авлигыг мэдээлэх 110 утсанд
- Цагдаагийн байгууллагад
- Прокурорт
- Шүүхэд
- Байгууллагынхаа удирдах албан тушаалтанд
- Байгууллагынхаа эрх бүхий албан тушаалтанд /ЭБАТ/
- Харьяа дээд шатны байгууллагад
- Хэвлэл мэдээллийн байгууллагад
- Олон нийтийн сүлжээгээр
- Бусад (Тодорхой бичих)

6. Авлига, хээл хахуулийн талаар мэдээлэх болсон нь ямар шалтгаантай вэ?

- Мэдээлэх нь өөрт ашигтай учир
- Мэдээлэх нь нийтийн тусын тулд хэрэгтэй
- Мэдээлэх нь миний үүрэг
- Бусад

7. Хэрэв мэдээлэхгүй бол шалтгаан нь юу вэ? (1-3 хүртэлх харцуултыг сонгоно уу)

- Хаана мэдээлэхээ мэдэхгүй
- Мэдээлэхгүй байх нь өөрт ашигтай учир
- Хариу дарамт, үр дагавраас айж байна
- Хэн нэгний тухай мэдээлэх нь миний хийх зүйл биш

- Мэдээлсэн талаар нууц задрах эрсдэлтэй
- Мэдээлэл өгөхөд ямар нэгэн урамшуулал байдаггүй
- Хэрхэн мэдээлэхээ мэдэхгүй
- Би мэдээлснээр юу ч өөрчлөгдөхгүй
- Надад хамаагүй асуудал учир мэдээлэхгүй
- Бусад (Тодорхой бичнэ үү)

8. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН үйл ажиллагааг Та хэрхэн үнэлэх вэ?

- Маш сайн
- Сайн
- Дунд
- Муу
- Маш муу

ХАВСРАЛТ 2. СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ХҮСНЭГТҮҮД

Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуйг цахим хуудсанд (<http://хасхот.iaас.mn>) байршуулдаг. Энэ мэдээллийг өөрчлөх шаардлага бий юу? (аймаг, нийслэлээр)

	Илүү дэлгэрэнгүй болгох	Илүү хураангуй болгох	Өөрчлөх шаардлагагүй	Мэдэхгүй	Нийт
Архангай	9%	16%	70%	5%	100%
Баян-Өлгий	18%	8%	60%	14%	100%
Баянхонгор	18%	17%	62%	4%	100%
Булган	10%	15%	68%	7%	100%
Говь-Алтай	13%	10%	69%	8%	100%
Говь-Сүмбэр	7%	17%	69%	7%	100%
Дархан уул	14%	15%	65%	6%	100%
Дорноговь	10%	14%	67%	9%	100%
Дорнод	8%	19%	66%	7%	100%
Дундговь	9%	13%	66%	11%	100%
Завхан	12%	13%	70%	6%	100%
Орхон	7%	21%	63%	10%	100%
Өвөрхангай	8%	14%	68%	10%	100%
Өмнөговь	7%	16%	70%	7%	100%
Сүхбаатар	9%	17%	71%	3%	100%
Сэлэнгэ	9%	16%	67%	8%	100%
Төв	12%	13%	70%	5%	100%
Увс	11%	16%	69%	4%	100%
Улаанбаатар	9%	18%	61%	12%	100%
Ховд	9%	18%	67%	7%	100%
Хөвсгөл	11%	10%	70%	9%	100%
Хэнтий	10%	15%	61%	13%	100%

2. Танай байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтан / ЭБАТ/ таныг холбогдох мэдээлэл, арга зүйгээр ханган ажиллаж чаддаг уу? (аймаг, нийслэлээр)

	Чаддаг	Чаддаггүй	Мэдэхгүй	Нийт
Архангай	77%	19%	4%	100%
Баян-Өлгий	64%	26%	9%	100%
Баянхонгор	77%	17%	7%	100%
Булган	82%	14%	4%	100%
Говь-Алтай	81%	14%	5%	100%
Говь-Сүмбэр	74%	21%	5%	100%
Дархан уул	82%	10%	8%	100%
Дорноговь	80%	13%	7%	100%
Дорнод	82%	11%	7%	100%
Дундговь	73%	18%	9%	100%
Завхан	82%	13%	5%	100%
Орхон	78%	15%	8%	100%
Өвөрхангай	79%	12%	9%	100%
Өмнөговь	77%	15%	9%	100%
Сүхбаатар	73%	24%	3%	100%
Сэлэнгэ	75%	14%	11%	100%
Төв	76%	19%	5%	100%
Увс	82%	11%	7%	100%
Улаанбаатар	78%	14%	8%	100%
Ховд	78%	10%	12%	100%
Хөвсгөл	82%	12%	6%	100%
Хэнтий	85%	11%	4%	100%

3. Авлига, хээл хахуулийн талаар мэдээлэх болсон нь ямар шалтгаантай вэ? (аймаг, нийслэлээр)

	Мэдээлэх нь миний үүрэг	Мэдээлэх нь нийтийн тусын тулд хэрэгтэй	Мэдээлэх нь өөрт ашигтай учир	Бусад
Архангай	71%	27%	1%	1%
Баян-Өлгий	64%	33%	1%	1%
Баянхонгор	79%	21%	0%	0%
Булган	82%	17%	0%	1%
Говь-Алтай	72%	28%	0%	0%
Говь-Сүмбэр	76%	24%	0%	0%
Дархан уул	74%	23%	2%	0%
Дорноговь	81%	19%	0%	0%
Дорнод	69%	29%	1%	2%
Дундговь	67%	32%	0%	1%
Завхан	80%	20%	0%	0%
Орхон	79%	20%	1%	0%
Өвөрхангай	70%	30%	0%	0%
Өмнөговь	65%	33%	0%	2%
Сүхбаатар	72%	28%	0%	0%
Сэлэнгэ	69%	29%	0%	2%
Төв	67%	32%	1%	0%
Увс	68%	32%	0%	0%
Улаанбаатар	68%	30%	0%	1%
Ховд	78%	22%	0%	1%
Хөвсгөл	68%	31%	0%	1%
Хэнтий	76%	23%	0%	1%

4. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуйг цахим хуудсанд (<http://хасхот.iaас.mn>) байршуулдаг. Энэ мэдээллийг өөрчлөх шаардлага бий юу? (өрхийн жилийн орлогын хэмжээгээр)

	Илүү дэлгэрэнгүй болгох	Илүү хураангуй болгох	Өөрчлөх шаардлагагүй	Мэдэхгүй
10 сая хүртэл	11%	18%	64%	7%
10-20 сая	11%	15%	65%	9%
20-30 сая	9%	14%	67%	10%
30-50 сая	9%	16%	65%	10%
50-100 сая	10%	18%	62%	10%
100-200 сая	9%	22%	60%	10%
200 саяас дээш	11%	25%	57%	7%

5. ӨӨРИЙН БАЙГУУЛЛАГА дахь авлига, хээл хахуулийн талаар олж мэдвэл Та энэ талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх үү? (өрхийн жилийн орлогын хэмжээгээр)

	Тийм	Тухайн нөхцөл байдлаас хамаарна	Үгүй	Мэдэхгүй
10 сая хүртэл	80%	14%	1%	6%
10-20 сая	78%	14%	2%	6%
20-30 сая	78%	15%	2%	5%
30-50 сая	78%	13%	2%	7%
50-100 сая	74%	14%	2%	9%
100-200 сая	77%	13%	2%	8%
200 саяас дээш	70%	18%	0%	12%

6. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН үйл ажиллагааг Та хэрхэн үнэлэх вэ? (өрхийн

жилийн орлогын хэмжээгээр)

	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
10 сая хүртэл	5%	41%	48%	4%	2%
10-20 сая	6%	50%	38%	5%	1%
20-30 сая	6%	48%	40%	5%	1%
30-50 сая	6%	53%	35%	5%	1%
50-100 сая	6%	54%	35%	4%	1%
100-200 сая	5%	50%	41%	3%	1%
200 саяас дээш	6%	52%	37%	3%	3%

7. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуйг цахим хуудсанд (<http://хасхот.iaас.mn>) байршуулдаг. Энэ мэдээллийг өөрчлөх шаардлага бий юу? (насны бүлгээр)

	Илүү дэлгэрэнгүй болгох	Илүү хураангуй болгох	Өөрчлөх шаардлагагүй	Мэдэхгүй
30 хүртэл	12%	18%	58%	12%
30-39	12%	16%	61%	11%
40-49	8%	17%	66%	8%
50-59	7%	15%	70%	8%
60-аас дээш	10%	19%	68%	4%

8. ӨӨРИЙН БАЙГУУЛЛАГА дахь авлига, хээл хахуулийн талаар олж мэдвэл Та энэ талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх үү? (насны бүлгээр)


	Тийм	Тухайн нөхцөл байдлаас хамаарна	Үгүй	Мэдэхгүй
30 хүртэл	83%	10%	1%	6%
30-39	80%	12%	1%	7%
40-49	74%	16%	2%	8%
50-59	75%	16%	2%	7%
60-аас дээш	88%	9%	1%	2%

9. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН үйл ажиллагааг Та хэрхэн үнэлэх вэ?

	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
30 хүртэл	9%	48%	36%	5%	1%
30-39	6%	47%	39%	6%	2%
40-49	5%	52%	38%	4%	1%
50-59	4%	56%	36%	3%	1%
60-аас дээш	8%	65%	23%	3%	1%

10. Цахимаар ХАСХОМ-ээ мэдүүлсэн нийтийн албан тушаалтан ба судалгаанд хамрагдсан нийтийн албан тушаалтнуудын тоо, насаар

---oOo---





АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Ш У Д А Р Г А Ё С , Х Ö Г Ж И Л Д Э В Ш И Л Д



авлига - ашиг сонирхлын зөрчил - хүнд суртал

АВЛИГЫГ МЭДЭЭЛ



www.iaac.mn



**ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН
БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ
АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН
СУДАЛГАА-2020 ОН**

Судалгааны үндэслэл

Авлигатай тэмцэх газар 2008 оноос хойш жил тутам “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г зохион байгуулж судалгааны үр дүнг Мянганы хөгжлийн 9 дэх зорилтын “Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгох, хэвшүүлэх” 24 дүгээр зорилтын хэрэгжилтийг үнэлж дүгнэх нэг шалгуур болгож ирсэн. Судалгаа нь авлигын хандлага, авлигад өртөмтгий ажил, албан тушаал, авлигад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Мөн улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэхэд мэдээллийн чухал их сурвалж болох учиртай. 2017 он хүртэл улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын талаарх төсөөллийг нэг судалгааны хүрээнд судалж, нэгтгэсэн тайланг гаргаж байсан бол 2018 оноос эхлэн тус хоёр хүрээг тусд нь авч үзэж, “Улс төрийн хүрэн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа” болон “Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрэн авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г хийдэг болсон юм.

Судалгааны зорилго, зорилт

Монгол Улс дахь улс төр, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлига буюу “дээд (өндөр) түвшний” авлигын шинж чанарыг тодорхойлоход чиглэгдсэн. Ингэхдээ дараах хэд хэдэн зорилтыг дэвшүүлэв. Үүнд:

- Авлигын талаарх төсөөлөл, хандлага, шалтгааныг тодруулах;
- Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигад автагдсан байдал, цар хүрээ, авлигын хэлбэрийг авч үзэх;
- Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын шалтгаан, нөхцөл түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах;
- Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын хэмжээ, түүний хор уршиг, үр дагаврыг гаргах;
- Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх хүрэн дэх авлигатай тэмцэх үйл ажиллагааг үнэлүүлэх, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах зэрэг болно.


Судалгааны арга зүй

Тоон судалгааны мэдээллийг цуглуулахдаа нүүр тулсан яриулагын асуулгын аргыг ашигласан ба шинжээчдээр асуулт бүрийг “1-5” гэсэн баллаар үнэлүүлэн тооцоолсон. Баллын үнэлгээ буурах тусам эерэг утгыг илэрхийлж байгаа бол баллын үнэлгээ өсөх тусам сөрөг утгыг илэрхийлдэг. Өмнө нь дан тоон судалгааны аргыг ашигладаг байсан бол 2018 оноос эхлэн чанарын судалгааны аргыг нэмэлтээр нэвтрүүлж эхэлсэн. Судалгааны мэдээлэлд шинжилгээ хийхдээ “Улс төрийн хүрэн дэх авлигын талаарх төсөөллийн 2018 болон 2019 оны судалгаа”-ны тоо баримттай харьцуулан шинжилж, гарсан өөрчлөлт, үр дүнг тогтоосон болно.

Мэдээллийг боловсруулах арга

Анкетын аргаар цуглуулсан мэдээлэлд боловсруулалт хийх орчин үеийн багц программ “SPSS-22”-ыг хэрэглэн боловсруулалт хийв. Гаргасан өгөгдөл дээр анхдагч үр дүн болох нэг хэмжээст тархалтыг гаргахын зэрэгцээ шинээр хувьсагч үүсгэх, дундаж үзүүлэлтийг бодох, харьцуулалт, график шинжилгээ хийж, үр дүнг тодорхойллоо.


Зураг 1. Улс төрийн хүрээн дэх авлигын үнэлгээ, үзүүлэлтийн схем



НЭГ. 2020 ОНЫ АВЛИГЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВ

Монгол улс дахь авлигын ерөнхий төлөвийг гаргахдаа түвшин, салбар хүрээгээр нь үнэлүүлэхийн зэрэгцээ авлига гарч буй шалтгаан нөхцөлийг тодорхойлохыг зорилоо. Авлигын түвшинг салбар хүрээгээр нь 1-5 баллаар үнэлүүлсэн бөгөөд дундаж нь 3.68 гарлаа.

Зураг 2. Монгол улс дахь авлигын түвшин, хувиар



Судалгаанд хамрагдсан шинжээчдийн 53.2 хувь Монгол улсад авлига их, 24.2 хувь нь маш их байна гэж үзсэн. Харин 14.5 хувь нь дунд зэрэг, 3.2 хувь нь бага зэрэг, 4.8 хувь нь мэдэхгүй байна харцуулаа. Монгол улсад авлига огт байхгүй гэж харцуулсан шинжээч байгаагүйг тэмдэглэх хэрэгтэй.

Зураг 3. Авлигын түвшин, салбар хүрээгээр (Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал, 5-маш сайн, 4-сайн, 3- дунд, 2-тааруу, 1-маш муу)



Монгол Улсад улс төрийн нам, орон нутгийн төр захиргааны байгууллага, засгийн газар (яам, агентлаг), төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, улсын их хуралд авлига их байна гэж үнэлсэн. Төрийн бус байгууллага, хувийн хэвшил, боловсролын системад авлига бага байна гэж үнэлжээ.

Хүснэгт 1. Авлигын түвшин салбар, хүрээгээр 2018-2020 он харьцуулсан үзүүлэлт

	Салбар хүрээ	2018	2019	2020	Өөрчлөлт
1	Улсын Их Хурал	4.02	4.12	4.02	-0,1
2	Засгийн газар (яам, агентлаг)	4.27	4.32	4.18	-0,14
3	Шүүх	4.09	4.18	3.84	-0,34
4	Прокурор	4.00	4.25	3.88	-0,37
5	Орон нутгийн төрийн захиргааны удирдлага	3.84	4.05	4.17	+0,12
6	Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	3.57	3.72	3.80	+0,08
7	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж	3.83	4.36	4.10	-0,26
8	Төрийн бус байгууллага	2.27	2.08	2.59	+0,51
9	Улс төрийн нам	4.28	4.18	4.38	+0,2
10	Хувийн хэвшил	2.75	2.50	2.84	+0,34
11	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	3.91	3.58	3.72	+0,14

Авлигын түвшний өөрчлөлтийг дээрх хүснэгтээс харахад ихэнх салбарт өмнөх оноос өссөн (0.08-0.51) үзүүлэлт ажиглагдаж байна. Харин Улсын Их Хурал, Засгийн газар (яам, агентлаг), шүүх, прокурор, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж зэрэг салбаруудад авлигын түвшин 0.14-0.1 баллаар буурсан дүн гарчээ.

Хүснэгт 2. Сүүлийн нэг жилийн хугацаанд Монгол Улсын авлига гарахад нөлөөлсөн гол шалтгаан, хувиар


№	Хувь
Төрийн албатай холбоотой асуудал	51.4
1 Төрийн байгууллагын хүнд суртал	11.2
2 Мэдээллээ ил тод бус байдал	14.2
3 Төрийн оролцоот газруудыг хувьчлахгүй байгаа нь нөлөөлсөн	0.7
4 Төрийн хяналт хангалтгүй байна	4.5
5 Төрийн байгууллагын эрх мэдэл их байгаатай	1.5
6 Засаглалын тогтворгүй байдал	0.7
7 АТГ нь өөрөө авлигалд өртсөн байдаг	0.7
8 Төрийн албан хаагчид мөнгө төлж ажилд ордог	14.2
9 Шударга өрсөлдөөний хууль үйлчилдэггүй	2.2
10 Шүүх, прокурорын үйл ажиллагаанд тохироо их байна	1.5
Иргэдтэй холбоотой асуудал	17.1
11 Иргэдийн сэтгэлгээ, ёс зүйн хандлага сул	12.7
12 Иргэдийн хууль эрх зүйн мэдээлэл бага	2.2
13 Хүн амын тоо бага	1.5
14 Авлигыг үл тэвчих хандлага тогтоогүй	0.7
Эдийн засгийн асуудал	8.9
15 Төгрөгийн ханш суларч байна	0.7
16 Зах зээл тогтоогүй, ЖДҮ-ийн зээл нөлөөлсөн	1.5
17 Нийгэм эдийн засгийн хангалтгүй байдал	6.7
Улс төр, сонгуультай холбоотой асуудал	17.8
18 Сонгууль хууль бусаар явагддаг байдал	9.7
19 Хэт их улс төржиж байна	2.2
20 Улс төрийн хариуцлагагүй байдал	3.7
21 Улс төрийн санхүүжилт зохицуулалт муутай	0.7
22 Хууль боловсруулах батлах явц нь авлига боловсронгуй болох явцаас хоцорч байна	1.5
Бусад асуудал	4.4
23 Цахим хэлбэрт шилжихгүй байгаа учир	0.7
24 Үе солигдож байна	0.7
25 Хүлээлгэх арга хэмжээ, шийтгэл муу	1.5
26 Хариулж мэдэхгүй	1.5
НИЙТ	100.0

Шинжээчид сүүлийн нэг жилийн хугацаанд Монгол Улсад авлига гарахад нөлөөлсөн гол шалтгааныг дурдлаа. Авлига гарахад нөлөөлсөн шалтгаануудыг бүлэглэн авч үзвэл төрийн албатай холбоотой асуудал 51.4 хувь, улс төр, сонгуультай холбоотой асуудал 17.8 хувь, иргэдтэй холбоотой асуудал 17.1 хувь, эдийн засгийн асуудал 8.9 хувь, бусад асуудал 4.4 хувийг эзэллээ. Үүнээс мэдээллийн ул тод бус байдал (14.2%), төрийн албан хаагчид мөнгө төлж ажилд ордог байдал (14.2%), иргэдийн сэтгэлгээ, ёс зүйн хандлага сул (12.7%), төрийн албаны хүнд суртал (11.2%) зэрэг нь өндөр хувийг эзэлж байна.

ХОЁР. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТҮВШИН

Монгол Улс дахь шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига буюу “дээд (өндөр) түвшний” авлигын шинж чанарыг тодорхойлохын тулд цар хүрээ, хэлбэр, шалтгаан, хор уршиг зэрэг хүчин зүйлсийг үнэлүүллээ. Шүүх, хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн индексийг 2018, 2019 оныхтой ижил аргачлалаар гаргасан. Энэ онд авлигын төсөөллийн индекс 3.82 гарсан бөгөөд өмнөх оноос 0.04 пунктээр буурсан болно.


Зураг 4. Улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин 2008-2017, шүүх, хууль хяналтын хүрээний авлигын түвшин 2018-2020



ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшинг гаргахын тулд доор дурдсан 4 шалгуур үзүүлэлтийг ашиглан хэмждэг. Шүүх, хууль хяналтын байгууллагын авлигын үзүүлэлт улс төрийн хүрээнээс арай бага үнэлгээ авдаг хандлага энэ судалгаанд ч адил хэвээр байна. Авлигын шалгуур үзүүлэлтийг тогтооход 2020 онд авлигын цар хүрээ 3.72 гарч өмнөх оноос 0.03 пунктээр буурсан дүн гарлаа. Авлигын хэлбэрийн индекс нь 3.71 гарч өмнөх 0.12 пунктээр буурлаа. Харин авлигын шалтгаан нөхцөл нь 4.11 гарч өмнөх оноос 0.13 пунктээр өссөн бол хор уршиг, үр дагавар нь 3.84 гарч 0.05 пунктээр буурсан. Доорх зургаас харахад авлигын шалтгаан нөхцөлийн индекс 2018 оноос хойш тогтмол өссөн дүн харагдаж байна.

Зураг 5. Шүүх, хууль хяналтын хүрээний авлигыг гаргах шалгуур үзүүлэлт 2018-2020 (Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал, 5-маш сайн, 4-сайн, 3-дунд, 2-тааруу, 1-маш муу)




ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 1. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ЦАР ХҮРЭЭ

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын цар хүрээний үнэлгээ 3.72 гарч өмнөх оныхоос 0.03 пунктээр буурсан. Авлигын цар хүрээний үнэлгээг 5 дэд үзүүлэлтийн хүрээнд тодорхойлдог бөгөөд үнэлгээний дундаж үзүүлэлтийг дор дурдсан. Дундаж үзүүлэлтийг 1-5 баллын үнэлгээгээр тооцож зураг 6-д 2018-2020 оны өөрчлөлтийг харууллаа. Үүнд:

- Авлигын түгээмэл байдал 4.16
- Авлигын түвшний өөрчлөлт 3.67
- Авлигын цар хүрээ салбар, хүрээ/байгууллагаар дундаж 3.74
- Авлигын түвшин тодорхой үйл ажиллагааны төрлөөр дундаж 3.51
- Авлигын чиглэглэгдсэн байдлаар 3.85

Зураг 6. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын цар хүрээний үнэлгээ




Авлигын түгээмэл байдал, тодорхой үйл ажиллагаан дахь авлигын түвшин, салбар болон үйл ажиллагаанд чиглэгдсэн байдал зэрэг нь өмнөх оноос 0.05-0.19 пунктээр буурсан дүн гарлаа. Харин авлигын түвшний өөрчлөлт өмнөх оноос 0.07 пунктээр өссөн бол авлигын тархалтын цар хүрээ 0.22 пунктээр өссөн. Дурдсан хоёр шалгуур үзүүлэлт 2018 оноос хойш тогтмол өсч буй дүр зураг ажиглагдлаа. Тиймээс авлигын түвшин болон цар хүрээг хумих ажил хийх хэрэгцээтэй байна.

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 1. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТҮГЭЭМЭЛ БАЙДАЛ


Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түгээмэл байдлын индекс 4.16 гарсан.

Зураг 7. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин, хувиар



Шинжээчдийн өгсөн үнэлгээг хувьчлан харвал 77.4 хувь нь “их, маш их” гэж үзсэн бол 19.4 хувь нь дунд зэрэг, 1.6 хувь нь бага зэрэг, 1.6 хувь нь мэдэхгүй гэж хариуллаа.

Зураг 8. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин 2018-2020, хувиар




Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түгээмэл байдлын үнэлгээ 4.16 гарч өмнөх оноос 0.05 пунктээр буурсан. Энэ үзүүлэлт 2018 онд 4.13 гарч байв. Авлигын түвшинг 2018-2020 оны хооронд харьцуулан харахад “их” болон “маш их” гэсэн үнэлгээ жил ирэх тусам өсөх хандлагатай. Авлигын түвшин өмнөх оноос буурсан мэт боловч энэ дүн маш чамлалттай бөгөөд тус үзүүлэлтийг бодитойгоор бууруулах ажлуудыг шат дараатайгаар хийх хэрэгцээтэй байна.

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 2. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТҮВШНИЙ ӨӨРЧЛӨЛТ


Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшний өөрчлөлтийн индекс 3.67 гарсан.

Зураг 9. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшний өөрчлөлт, хувиар



Авлигын түвшнийг 2020 онд судалгаанд оролцогчдын гурван хүн тутмын нэг нь өөрчлөгдөөгүй, дөрвөн хүн тутмын нэг маш их нэмэгдсэн гэж тус тус үзсэн бол багассан гэж бараг таван хүн тутмын нэг харцуулжээ.

Зураг 10. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшний өөрчлөлт 2018-2020, хувиар



Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын түвшний өөрчлөлт 3.67 гарч өмнөх оноос 0.07 пунктээр өссөн. Авлигын түвшний өөрчлөлт 2018 онд 3.59 гарсан. Эндээс харахад авлигын түвшнийг үнэлсэн байдал судалгаанд оролцогчдын дундаж харцулт өөрчлөгдөөгүй гэж гарч байгаа боловч энэ дүн нэмэгдсэн гэх үзүүлэлт рүү дөхсөн байгаа нь харагдаж байна.

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 3. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГА ДАХЬ АВЛИГЫН ТАРХАЛТЫН ЦАР ХҮРЭЭ

Салбар, хүрээ/байгууллагад авлига тархсан цар хүрээний индекс 3.74 гарсан. Тус үзүүлэлт өмнөх оноосоо 0.22 пунктээр өссөн. Харин 2018 онд 3.57 гарлаа. Уг үзүүлэлт сүүлийн гурван жилийн хугацаанд өсөлт, бууралттай байж хэлбэлзсэн.

Зураг 11. Салбар, хүрээ/байгууллагад авлига тархсан цар хүрээ (Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал, 5-маш сайн, 4-сайн, 3- дунд, 2-тааруу, 1-маш муу)



Салбар, хүрээгээр нь авлигын цар хүрээг тодорхойлуулахад ихэнх байгууллагуудад авлига дунд зэрэг байна гэж үнэлэгдсэн ч ихэнх нь их гэдэг үнэлгээ рүү тун дөхсөн байлаа. Мөн прокурорын байгууллагад авлига их байна гэж үнэлэгдсэн.

Хүснэгт 3. Салбар, хүрээ/байгууллагад авлига тархсан цар хүрээ

	Салбар хүрээ	2018	2019	2020	Өөрчлөлт	"Их/ маш их" тархсан
1	Шүүх	3.97	4.07	3.90	-0,17	66,1%
2	Прокурор	4.02	4.05	4.02	-0,03	66,1%
3	Цагдаагийн байгууллага	3.68	3.64	3.92	+0,28	66,2%
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	3.54	3.51	3.79	+0,28	56,4%
5	Тагнуулын байгууллага	3.43	3.32	3.56	+0,24	40,4%
6	Шүүхийн шинжилгээний байгууллага	3.50	3.38	3.79	+0,41	64,5%
7	Авлигатай тэмцэх байгууллага	3.53	3.14	3.59	+0,45	45,1%
8	Хил хамгаалах байгууллага	3.05	2.76	3.23	+0,47	30,7%
9	Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний газар	3.42	3.50	3.69	+0,19	54,8%


Авлигын цар хүрээгээр өөрчлөлтийг нь харахад шүүх, прокурорт авлигын түвшин буурсан байхад бусад байгууллагуудад (0,19-0,47) өссөн дүн харагдлаа. Маш их болон их тархсан гэсэн үзүүлэлтүүдийг харахад дийлэнх нь 50-аас дээш хувьтай байна. Хил хамгаалах байгууллага (30.7%), тагнуулын байгууллага (40.4%), авлигатай

тэмцэх байгууллага (45.1%)-ууд их болон маш их гэсэн үнэлгээг бусдаасаа харьцангуй бага авчээ. Тэгэхээр эдгээр байгууллагуудад авлига харьцангуй гайгүй байгаа нь харагдаж байна.

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 4. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТОДОРХОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ АВЛИГЫН ТҮВШИН

Авлига тархсан байдлыг байгууллагуудаас гадна тэдгээрийг явуулдаг тодорхой үйл ажиллагааны хүрээгээр үнэлүүлэхэд 3.51 гарсан бөгөөд тус дүн өмнөх оноос 0.19 пунктээр буурсан. Харин 2018 онд тус үзүүлэлт 3.44 гарсан.

Зураг 12. Авлигын түвшин тодорхой үйл ажиллагааны төрлөөр дундаж (Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал, 5-маш сайн, 4-сайн, 3- дунд, 2-тааруу, 1-маш муу)



Авлигын түвшинг тодорхой үйл ажиллагааны төрлөөр нь харахад дээрх 10 салбарт авлига дунд хэмжээнд (3.1-3.83) байна гэж үнэлэгдсэн байна. Гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагаанд авлига бага хэмжээнд (2.65) байна гэж үнэлжээ.

Хүснэгт 4. Авлигын түвшин тодорхой үйл ажиллагааны төрөл 2018-2020

	Үйл ажиллагаа	2018	2019	2020	Өөрчлөлт
1	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа	3.85	3.80	3.57	-0,23
2	Прокурорын хяналт	3.82	4.02	3.83	-0,19
3	Эрүүгийн хэрэг шүүхэд таслан шийдвэрлэх ажиллагаа	3.71	3.95	3.83	-0,12
4	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа	3.62	3.93	3.67	-0,26
5	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа	3.40	3.80	3.59	-0,21
6	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа	3.30	3.70	3.61	-0,09
7	Шүүхийн шинжилгээ ажиллагаа	3.53	3.71	3.63	-0,08
8	Хил хамгаалах ажиллагаа	2.85	3.03	3.10	+0,07
9	Гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагаа	2.87	2.95	2.65	-0,3
10	Иргэний харьяалал, шилжилт, хөдөлгөөний бүртгэл	3.42	3.64	3.34	-0,3
11	Өмгөөлөгч, хуульчдын холбоо	-	-	3.80	-

Шүүх, хууль хяналтын байгууллага доторх үйл ажиллагааны төрлүүдийн авлигын түвшинг харахад гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагаа, иргэний харьяалал, шилжилт, хөдөлгөөний бүртгэлийн газруудад авлига буурсан байдал нь бусад үйл ажиллагаанаас арай илүү байна. Харин хил хамгаалах үйл ажиллагааны авлигын түвшин өсчээ. Мөн 2018-2020 оны хоорондох өөрчлөлтийг харахад хил хамгаалах ажиллагааны авлигын түвшин өссөн дүн гарчээ.

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 5. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ
АВЛИГЫН НӨЛӨӨЛӨЛ, ЧИГЛЭЛ

Авлигын түвшин, бусад салбар үйл ажиллагаа руу чиглэгдсэн байдлын индекс 2020 онд 3.85 гарсан бөгөөд эл үзүүлэлт өнгөрөгч оноос 0.08 пунктээр буурсан бол 2018 оноос 0.13 пунктээр өссөн дүн гарлаа.

Зураг 13. Шүүх, хууль сахиулах байгууллагын авлига бусад салбар, үйл ажиллагаа руу чиглэгдсэн байдал (Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал, 5-маш сайн, 4-сайн, 3- дунд, 2-тааруу, 1-маш муу)



Уул уурхай, ашигт малтмалын салбар, барилга, төрийн албанд авлигыг их хэмжээнд байна гэж үнэлсэн. Дэд бүтэц, шүүх, гадаадын хөрөнгө оруулалт, аж үйлдвэр гэх мэт бусад 8 салбарт авлига дунд хэмжээнд гэж үнэлэгдсэн ч тус үзүүлэлтүүдийн үнэлгээ 4 буюу их байна гэсэн үнэлгээнд тун дөхөж очжээ.

Хүснэгт 5. Шүүх, хууль сахиулах байгууллагын авлига бусад салбар, үйл ажиллагаа руу чиглэгдсэн байдал 2018-2020


	Салбар, үйл ажиллагаа	2018	2019	2020	Өөрчлөлт
1	Уул уурхай, ашигт малтмал	4,2	4,38	4,23	-0,15
2	Гадаадын хөрөнгө оруулалт	3,81	3,93	3,81	-0,12
3	Аж үйлдвэр	3,38	3,49	3,68	+0,19
4	Дэд бүтэц	3,7	4,02	3,97	-0,05
5	Барилга	3,74	3,9	4,05	+0,15
6	Шүүх	3,88	4,21	3,92	-0,29
7	Хууль сахиулах	3,63	3,95	3,73	-0,22
8	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	3,67	3,71	3,66	-0,05
9	Хууль тогтоох, шийдвэр гаргах үйл ажиллагаа	3,71	3,93	3,85	-0,08
10	Бизнес, хувийн хэвшил	3,28	3,53	3,33	-0,2
11	Төрийн алба	3,95	4,15	4,05	-0,1

Салбар, үйл ажиллагаа руу чиглэгдсэн байдлын өөрчлөлтийг харвал барилга, аж үйлдвэрийн салбарын авлигын түвшин 2018 оноос хойш өссөөр байна. 2020 оны байдлаар дурдсан 2 салбараас бусад нь 0.05-0.29 пунктээр буурсан үзүүлэлттэй.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 2. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ХЭЛБЭР

Шүүх хяналтын байгууллагын хүрээний хоёр дахь шалгуур үзүүлэлт болох авлигын хэлбэрийн индекс 3.71 гарсан бөгөөд тус үзүүлэлт 2019 онд 3.83, 2018 онд 3.52 гарсан.

Зураг 14. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хэлбэрийн үнэлгээ



Авлигын хэлбэрийг мөн адил 5 дэд үзүүлэлтээр хэмжсэн бөгөөд авлигын хэлбэрүүд өмнөх оноосоо өссөн бол хээл хахуулийн хэлбэр, бүлэглэлүүдийн нөхцөл байдал, хууль бус нөлөөллийн хэлбэр, хээл хахууль өгөх, авах аргууд буурсан. Өсөлт, бууралтийг жагсаавал:

1. Хээл хахуулийн хэлбэр -0.19
2. Хээл хахууль өгөх, авах аргууд -0.10
3. Бүлэглэлийн нөхцөл байдал -0.22
4. Хууль бус нөлөөллийн хэлбэр -0.12
5. Авлигын хэлбэр +0.03

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 1. ХЭЭЛ, ХАХУУЛИЙН ХЭЛБЭР

Шүүх, хууль хяналтын байгууллагын хээл, хахуулийн хэлбэрийн индекс 3.61 байна. Эл шалгуур үзүүлэлт 2019 онд 3.80, 2018 онд 3.57 гарсан. Эндээс харахад 2020 онд өмнөх оноосоо 0.19 пунктээр буурсан.

Зураг 15. Хээл хахуулийн хэлбэрийн үнэлгээ (Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал, 5-маш сайн, 4-сайн, 3- дунд, 2-тааруу, 1-маш муу)



Шүүх, хууль хяналтын байгууллагын албан тушаалтнаар өөрт ашигтай, давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахад түгээмэл ашигладаг хэлбэрүүдийг шинжээчдээр 1-5 баллаар үнэлсэн үнэлгээг хувиар тооцохын зэрэгцээ дундаж үзүүлэлтийг тооцсон болно. Албан тушаалтнаар өөрт ашигтай, давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахын тулд авлигын 13 хэлбэрүүдийг дурдаж шинжээчдээр үнэлүүллээ.

Авлига их хэмжээнд байна гэж үнэлэгдсэн хэлбэр:

- Ажил, албан тушаалд томилох, оруулах (4.24);
- Шагнал, цол, тэмдгээр шагнах (4.09);

Дунд хэмжээнд байна гэж үнэлэгдсэн хэлбэр:

- Бэлэн мөнгө өгөх, авах (3.9);
- Ашиг, орлогоо хуваалцах (3.84);
- Үнэтэй бэлэг сэлт өгөх /байр, машин гэх мэт/ (3.77);
- Гадаадын банкинд данс нээж өгөх (3.4);
- Гадаад арга хэмжээний зардал төлөх (3.41)
- Ажил, үйлчилгээний төлбөрийн хөнгөлөлт эдлүүлэх (3.5);
- Аялал жуулчлалын зардал төлөх (3.54);
- Өрийг нь төлөх (3.39);
- Сургалтын зардлыг төлөх (3.13);
- Хувьцаа өгөх (3.29);
- Эмчилгээ, сувилгааны зардал төлөх (3.26);

Хүснэгт 6. Хээл хахуулийн хэлбэрийн үнэлгээ

	Хээл, хахуулийн хэлбэр	2018	2019	2020	Өөрчлөлт
1	Бэлэн мөнгө өгөх	3,75	4,09	3,9	-0,19
2	Хувьцаа өгөх	3,11	3,49	3,29	-0,2
3	Гадаадын банкинд данс нээж өгөх	3,22	3,63	3,4	-0,23
4	Ашиг, орлогоо хуваалцах	3,87	4,03	3,84	-0,19
5	Аялал жуулчлалын зардал төлөх	3,58	3,81	3,54	-0,27
6	Гадаад арга хэмжээний зардал төлөх	3,6	3,8	3,41	-0,39
7	Үнэтэй бэлэг өгөх	3,61	3,96	3,77	-0,19
8	Ажил, албан тушаалд томилох, оруулах	4,38	4,32	4,24	-0,08
9	Эмчилгээ, сувилгааны зардал төлөх	3,25	3,47	3,26	-0,21
10	Сургалтын зардлыг төлөх	3,46	3,71	3,13	-0,58
11	Ажил, үйлчилгээний төлбөрийн хөнгөлөлт эдлүүлэх	3,63	3,69	3,5	-0,19
12	Өрийг нь төлөх	3,22	3,43	3,39	-0,04
13	Шагнал, цол, тэмдгээр шагнах	3,98	4,25	4,09	-0,16

Хээл хахуулийн дээрх 13 хэлбэрүүд бүгд 2019 оноос 0.04-0.58 пунктээр буурсан.

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 2. ХУУЛЬ БУС НӨЛӨӨЛЛИЙН ХЭЛБЭР

Хууль бус нөлөөллийн хэлбэрийн индекс 3.74 гарсан бөгөөд 2019 онд 3.86, 2018 онд 3.68 байв. 2020 онд нөлөөллийн хэлбэр өмнөх оноос 0.12 пунктээр буурсан дүн гарсан.

Зураг 16. Хууль бус нөлөөллийн үнэлгээ (Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал, 5-маш сайн, 4-сайн, 3- дунд, 2-тааруу, 1-маш муу)



Шинжээчид дарамт шахалт үзүүлэх, садан төрлийн хэлхээ холбоог ашиглах, албадах гэх мэт авлигын нөлөөллүүдийг дунд хэмжээнд байна гэж үнэлсэн бол намын хэлхээ холбоог ашиглах байдал их байна гэж үнэлжээ.

Хүснэгт 7. Хууль бус нөлөөллийн үнэлгээ

	Нөлөөллийн хэлбэр	2018	2019	2020	Өөрчлөлт
1	Дарамт шахалт үзүүлэх	3,75	4,17	3,82	-0,35
2	Садан төрлийн хэлхээ холбоог ашиглах	3,84	3,98	3,79	-0,19
3	Найз, танил талын хэлхээ холбоог ашиглах	4,02	3,98	3,87	-0,11
4	Нутаг орны хэлхээ холбоог ашиглах	4	3,88	3,63	-0,25
5	Намын хэлхээ холбоог ашиглах	3,93	3,97	4,07	+0,1
6	Айлган сүрдүүлэх, заналхийлэх	3,38	3,63	3,63	0
7	Албадах	3,44	3,69	3,63	-0,06
8	Амлалт өгөх	3,38	3,63	3,68	+0,05
9	Хүсэлт тавих	3,38	3,8	3,56	-0,24

Хууль бус нөлөөллийг тогтоох 9 үзүүлэлтээс намын хэлхээ холбоог ашиглах, амлалт өгөх хэлбэрүүд өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байхад айлган сүрдүүлэх, заналхийлэх үзүүлэлт өмнөх оноос өөрчлөлтгүй. Харин үлдсэн 6 үзүүлэлт буурсан үзүүлэлттэй. Найз, танил талын хэлхээ холбоог ашиглах, нутаг орны хэлхээ холбоог ашиглах нөлөөллийн хэлбэрүүд 2018 оноос хойш буурсаар байгаа дүн харагдаж байгаа бол амлалт өгч байгаа байдал өссөөр байна.

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 3. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГА, УЛС ТӨРИЙН НАМ/ БҮЛЭГЛЭЛ, УЛС ТӨР, БИЗНЕС, ГЭМТ ХЭРГИЙН БҮЛЭГЛЭЛҮҮДИЙН ХАРИЛЦАА, ХАМААРАЛ

Шүүх, хууль хяналтын байгууллагын албан тушаалтнууд, улс төрчид болон улс төрийн нам/бүлэглэл, гадаад дотоод бизнесийн бүлэглэл, гэмт бүлэглэлийн харилцаа, хамаарлын үнэлгээ 3.60 гарч өнгөрсөн оноос 0.22 пунктээр (2019 онд 3.82) буурсан. Бүлэглэлүүдийн харилцаа, хамаарлын 13 төрлийг шинжээчдээр үнэлүүлсэн.

Хүснэгт 8. Бүлэглэлүүдийн харилцаа, хамаарал, нөхцөл байдлын үнэлгээ


		2018	2019	2020	Өөрчлөлт
1	Улс төрчид шүүх/сахиулах байгууллагын албан тушаалтнуудыг эрхшээлдээ оруулсан	4.45	3.95	4.22	+0,27
2	Шүүх/хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд улс төрчдийг эрхшээлдээ оруулсан	3.75	3.49	3.46	-0,03
3	Улс төрчид шүүгч/хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн	4.29	4.11	4.03	-0,08
4	Бизнес бүлэглэл шүүх/сахиулах байгууллагын албан тушаалтнуудыг эрхшээлдээ оруулсан	3.93	3.66	3.75	+0,09
5	Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд бизнес бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан	3.83	3.57	3.43	-0,14
6	Бизнес шүүх/хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн	4.03	3.65	3.89	+0,24
7	Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд гэмт бүлэглэлийн эрхшээлд орсон	3.68	3.06	3.04	-0,02
8	Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд болон гэмт бүлэглэл нэгдсэн	3.61	3.06	3.14	+0,08
9	Гадны улс төрийн бүлэглэл Монголын хууль сахиулахын албан тушаалтнуудыг эрхшээлдээ оруулсан	3.46	2.85	3.35	+0,5
10	Гадны бизнесийн бүлэглэл Монголын хууль сахиулахын албан тушаалтнуудыг эрхшээлдээ оруулсан	3.39	2.87	3.31	+0,44
11	Гадны улс төрийн бүлэглэл Монголын хууль сахиулахын албан тушаалтнуудтай нэгдсэн	3.28	2.85	3.12	+0,27
12	Гадны бизнесийн бүлэглэл Монголын хууль сахиулахын албан тушаалтнуудтай нэгдсэн	3.19	2.55	3.54	+0,99
13	Хууль сахиулахын хүрэн дэх авлига илүү далд хэлбэрт шилжсэн	4.14	4.21	4.11	-0,1

Дээрх хүснэгтээс харахад улс төрчид, бизнесийн бүлэглэл болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудын харилцаа хамаарлын байдал аль аль талдаа өсөлт бууралттай бөгөөд ялгаа төдийлөн харагдахгүй байна. Харин гадны улс төр, бизнесийн бүлэглэлтэй холбоо харилцаатай байдал бүгд өссөн үзүүлэлттэй байгаа нь анхаарал татаж байна. Хууль сахиулахын хүрэн дэх авлига илүү далд хэлбэрт шилжсэн байдал буурсан дүн гарсан ч энэ нь чамлалттай үзүүлэлт юм.

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 4. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ХЭЛБЭР

Шүүх, хууль хяналтын байгууллагын авлигын хэлбэрийн индекс 2018 онд 3.59, 2019 онд 3.94, 2020 онд 3.97 гарсан бөгөөд энэ үзүүлэлтийн өсөлт хэдийгээр бага мэт боловч сүүлийн гурван жилийн хугацаанд тасралтгүй өссөөр байгаа нь анхаарал татаж байна.

Зураг 17. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хэлбэр



Сүүлийн гурван жилийн хугацаан дахь өөрчлөлтийг харвал ихэнх үзүүлэлтүүд тасралтгүй өссөн дүнтэй байхад зарим нь үзүүлэлт өсөлт бууралттай байна. Тасралтгүй өссөн үзүүлэлтийг дурдая. Үүнд:

1. Төрийн өмчийг хууль бус арга замаар хувьчилж авах
2. Хууль бусаар дампууруулах
3. Мөнгө угаах
4. Төсвийн хөрөнгийг зориулалтын бус зарцуулах
5. Улс төрийн зорилгоор хандив өгөх, авах
6. Төсвийг хувийн ашиг сонирхлын дагуу хуваарилах
7. Ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулах
8. Аж ахуйн нэгжид давуу байдал бий болгох
9. Төрийн өмчийг хувьдаа завших үзүүлэлтүүд байна.

Эдгээр хэлбэрүүдэд өссөн дүн хэдий бага мэт боловч анхаарал хандуулах шаардлагатай.


ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 5. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ ХЭЭЛ ХАХУУЛЬ ӨГӨХ, АВАХ АРГА

Хээл хахууль өгөх, авах аргуудыг хэрэглэсэн байдлын үнэлгээний индекс 2020 онд 3.58 гарч өмнөх оноос 0.10 пунктээр буурсан (2019 оны үзүүлэлт 3.68, 2018 оны үзүүлэлт 3.38). Энэ оны улс төрийн хүрээний үзүүлэлт 3.75, 2018 оны нэгтгэсэн үзүүлэлт 3.79 байв. Шүүх, хууль хяналтын байгууллагын индекс, улс төрийн индексээс арай бага байгаа нь харагдаж байна.

Эл үзүүлэлтийн “их” болон “маш их” үнэлгээний нийлбэрийн 50%-аас дээш гарсан үзүүлэлтийг дор харуулъя. Үүнд:

1. Зуучлагчаар дамжуулах - 75.8%
2. Ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдний компанид давуу байдал олгох - 69.4%
3. Ойр дотны хүмүүсээр дамжуулах - 61.3%
4. Эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах - 56.5%
5. Хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх - 51.6%

Зураг 18. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд хээл хахууль өгөх, авах аргуудын үнэлгээ



2019 онд биечлэн уулзаж өгч, авах аргаас бусад бүх аргууд нь өмнөх оноосоо (0.02-0.6) өсөлттэй гарч байв. Харин 2020 онд хэд хэдэн аргуудын үнэлгээ буурсан дүн гарлаа. Гэхдээ энэ дүн мэдэгдэхүйц бодит буурсан үзүүлэлт биш учир анхаарлаа хандуулах хэрэгтэй. Өссөн үзүүлэлттэй аргуудыг дурдвал:


1. Ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдний компанид давуу байдал олгох +0.07
2. Эд зүйлсийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах +0.13
3. Эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах +0.13

Тийм учраас эдгээр аргуудыг бууруулах арга хэмжээг шат дараатайгаар авах шаардлагатай.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 3. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын шалтгаан, нөхцөлийн үзүүлэлтийн индекс 4.11 гарч өнгөрсөн жилээс 0.13 пунктээр өссөн бол 2019 онд 2018 оноосоо 0.14 пунктээр өссөн. Эндээс харахад сүүлийн гурван жилд тус шалгуур тасралтгүй өсчээ. Авлигын шалтгаан нөхцөлийг а) нөлөөлсөн хүчин зүйлс, б) түвшинд нөлөөлсөн дутагдал, доголдол в) бүлэглэлүүдийн нөхцөл байдал зэргэ 3 үзүүлэлтээр хэмжиж шинжилгээ хийсэн.

Зураг 19. Авлигын шалтгаан, нөхцөл



Авлигад нөлөөлсөн хүчин зүйлс өнгөрсөн оноосоо 0.23 пункт, түвшинд нөлөөлсөн дутагдал, доголдол 0.06 пункт, бүлэглэлүүдийн нөхцөл байдал 0.12 пунктээр өссөн. Дээрх зургаас харахад эл үзүүлэлтүүд сүүлийн 3 жилд өссөөр байна.

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 1. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГАД НӨЛӨӨЛСӨН ХҮЧИН ЗҮЙЛС

Авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн индекс 2020 онд 4.19 гарч өнгөрсөн жилээс 0.23 пунктээр өссөн. Харин 2019 онд 2018 оноосоо 0.14 пунктээр өссөн байна.

Хүснэгт 9. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигад нөлөөлсөн хүчин зүйлс

	Авлигын хэлбэр	Үгүй	Бага зэрэг	Дунд зэрэг	Их	Маш их	Мэдэхгүй
1	Сонгуулийн өнөөгийн тогтолцоо	1.6	3.2	9.7	35.5	43.5	6.5
2	Сонгуулийн санхүүжилтийн механизм	3.2	3.2	6.5	30.6	53.2	3.2
3	Намын санхүүжилтийн механизм	3.2	3.2	4.8	24.2	61.3	3.2
4	Албан тушаалын томилгоо (нам дотор болон төрийн албанд)	-	4.8	6.5	24.2	61.3	3.2

5	УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	-	3.2	17.7	35.5	37.1	6.5
6	Засгийн газрын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	-	1.6	19.4	33.9	40.3	4.8
7	ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	-	3.2	21.0	37.1	32.3	6.5
8	Улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил	-	-	16.1	33.9	43.5	6.5
9	Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	1.6	1.6	19.4	41.9	30.6	4.8
10	Хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл явц	-	4.8	21.0	40.3	27.4	6.5
11	Төрийн байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалт	1.6	1.6	24.2	33.9	33.9	4.8

Шинжээчид дээрх бүх хүчин зүйлсийг авлигад их нөлөөлсөн гэж үнэлсэн. Тэр дундаа намын санхүүжилтийн механизм, албан тушаалын томилгоо (нам дотор болон төрийн албанд), сонгуулийн санхүүжилтийн механизм “маш их” нөлөөлсөн гэж үзсэн нь 50-аас дээш хувьтай байна.

Хүснэгт 10. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн үнэлгээ

		2018	2019	2020	Өөрчлөлт
1	Сонгуулийн өнөөгийн тогтолцоо	3.86	3.84	4.24	+0,4
2	Сонгуулийн санхүүжилтийн механизм	3.75	3.97	4.32	+0,35
3	Намын санхүүжилтийн механизм	3.81	3.98	4.42	+0,44
4	Албан тушаалын томилгоо (нам дотор болон төрийн албанд)	4.31	4.31	4.47	+0,16
5	УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.69	3.95	4.14	+0,19
6	Засгийн газрын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.75	3.93	4.19	+0,26
7	ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.43	3.75	4.05	+0,3
8	Улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил	3.79	3.95	4.29	+0,34
9	Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.93	4.02	4.03	+0,01
10	Хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл явц	3.86	4.07	3.97	-0,1
11	Төрийн байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалт	3.8	3.79	4.02	+0,23

Авлигад их нөлөөлсөн хүчин зүйлсийн өөрчлөлтийг харахад хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл явц л өнгөрөгч оноос буурсан үзүүлэлттэй. Харин бусад бүх хүчин зүйлс өссөн үзүүлэлттэй байгааг хүснэгт 10-аас харж болохоор байна. Тэр дундаа намын санхүүжилтийн механизм (0.44), сонгуулийн өнөөгийн тогтолоо (0.4), сонгуулийн санхүүжилтийн механизм (0.35), улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил (0.34) зэрэгт бусдаасаа арай их өсөлт гарчээ.

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 2. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ ТҮВШИНД НӨЛӨӨЛЖ БҮЙ ТӨРИЙН АЛБАН ДАХЬ ДУТАГДАЛ, ДОГОЛДОЛ

Төрийн албаны дутагдал, доголлын индекс 4.15 гарч өмнөх оноос 0.06 пунктээр өссөн. Тус пункт 2019 онд 4.09 гарч 2018 оноосоо 3.94 гарсан байна.

Зураг 20. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшинд нөлөөлж буй төрийн албан дахь дутагдал, доголдол (Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал, 5-маш сайн, 4-сайн, 3- дунд, 2-тааруу, 1-маш муу)



Төрийн албаны дээрх алдаа дутагдлууд авлига гарахад их (4.05-4.32) нөлөөлсөн, төрийн үйлчилгээний хүртээмж муу байдал дунд зэрэг (3.85) нөлөөлсөн гэж үнэлэгдлээ.

Хүснэгт 11. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшинд нөлөөлж буй төрийн албан дахь дутагдал, доголдол

		2018	2019	2020	Өөрчлөлт
1	Хүнд суртал	4.10	4.15	4.16	+0,01
2	Олон шат дамжлага, давхардал, хийдэл	3.98	4.02	4.10	+0,08
3	Төрийн үйлчилгээний хүртээмж муу	3.71	3.98	3.85	-0,13
4	Мэдээлэл нээлттэй, ил тод бус	4.10	4.11	4.17	+0,06
5	Шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдал дутмаг	4.19	4.06	4.22	+0,16
6	Албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж	4.28	4.21	4.27	+0,06
7	Хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал	4.18	4.32	4.30	-0,02
8	Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул	4.13	4.03	4.32	+0,29

9	Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналт сул	3.62	3.83	4.08	+0,25
10	Албан хаагчийн цалин, орон сууц, нийгмийн баталгаа хангалтгүй	3.56	3.79	4.03	+0,24
11	Төрийн албан хаагчийн ёс зүйн доголдол	4.17	4.32	4.25	-0,07
12	ТАХ-ийн ур чадвар дутмаг	4.24	4.36	4.05	-0,31

Сүүлийн жилийн хугацаанд хүснэгт 11-т үзүүлсэн дутагдал, доголдлуудын 4 нь буурсан бол 8 үзүүлэлт нь өссөн байна. Өссөн алдаа дутагдлууд

1. Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул +0.29
2. Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналт сул +0.25
3. Албан хаагчийн цалин, орон сууц, нийгмийн баталгаа хангалтгүй +0.24
4. Шийдвэр гаргах ажиллагааны ул тод байдал дутмаг +0.16
5. Олон шат дамжлага, давхардал, хийдэл +0.08
6. Мэдээлэл нээлттэй, ул тод бус +0.06
7. Албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж +0.06
8. Хүнд суртал +0.01

Сүүлийн нэг жилийн хугацаанд буурсан үзүүлэлтүүд

1. ТАХ-ийн ур чадвар дутмаг -0.31
2. Төрийн үйлчилгээний хүртээмж муу -0.13
3. Төрийн албан хаагчийн ёс зүйн доголдол -0.07
4. Хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал -0.02 байна.

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 3. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ БҮЛЭГЛЭЛҮҮДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Шүүх, хяналтын байгууллагын хүрээн дэх бүлэглэлүүдийн нөхцөл байдлын индекс 3.91 гарч өмнөх оноос 0.12 пунктээр өссөн.

Зураг 21. Шүүх, хууль хяналтын хүрээн дэх бүлэглэлүүдийн нөхцөл байдал (Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал, 5-маш сайн, 4-сайн, 3- дунд, 2-тааруу, 1-маш муу)



Бүлэглэлүүдийн нөхцөл байдлыг задлан харвал хувийн эрх ашгийг илүүд үзсэн нам тойрсон хүрээлэл, нам дамнасан хүрээлэл, нэг хүнийг тойрсон хүрээлэл, бизнесийн хүрээлэлүүд их (4.09-4.28) байна гэж үнэлэгдсэн. Хувийн эрх ашгийг тойрсон найз нөхдийн хүрээлэл (3.89), нэг нутаг ус тойрсон хүрээлэл дунд (3.89) зэрэг байна гэж үнэлэгдсэн бол нийтийн эрх ашгийн төлөө бий болсон хүрээлэлд авлига бага (2.82) байна гэж үнэлжээ.

Зураг 22. Шүүх, хууль хяналтын хүрээн дэх бүлэглэлүүдийн нөхцөл байдал




Өөрчлөлтийг нь харвал 2018-2019 онуудын хооронд нам тойрсон хүрээлэл, нам дамнасан хүрээлэл, нэг нутаг тойрсон хүрээллүүд буурсан үзүүлэлттэй байсан бол 2020 онд эдгээр үзүүлэлтүүд бүгд өссөн. Харин хувийн эрх ашгийг илүүд үзсэн, бизнесийн хүрээлэл дэх авлига багахан хэмжээгээр ч гэсэн буурсан.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 4. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ХОР УРШИГ, ҮР ДАГАВАР

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хор уршиг, үр дагаврын үзүүлэлт 2020 онд 3.84 гарч 2019 оноосоо 0.05 пунктээр буурлаа. Харин 2019 онд 2018 оныхоосоо 0.23 пунктээр өссөн дүн гарч байсан. Авлигын төсөөллийн индексийг тогтоох 4 дэх үндсэн шалгуур үзүүлэлтийг хор уршиг, үр дагавар болон авлигаар олсон хөрөнгийн зарцуулалт гэсэн доорх хоёр дэд үзүүлэлтээр шинжилдэг.

Зураг 23. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хор уршиг, үр дагавар



Авлигын хор уршиг, үр дагаврыг зураг 23-аас харахад 2018-2020 оны хооронд өссөн дүнтэй байгаа бол авлигаар олсон хөрөнгийн зарцуулалт нь 2019 онд өсч 2020 онд 0.26 пунктээр буурчээ.

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 1. ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ХОР УРШИГ, ҮР ДАГАВАР

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хор уршиг, үр дагаварын индекс 4.14 гарч 2019 оныхоосоо 0.16 пунктээр өссөн. Харин 2019 оны дүн 2018 оныхоосоо 0.19 пунктээр өсчээ.

Хүснэгт 12. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын улмаас учирсан хор уршиг, сөрөг үр дагаврын түвшин

№		2018	2019	2020	Өөрчлөлт
1	Монгол Улсын нэр хүнд олон улсын түвшинд унасан	3.65	4.08	4.15	+0,07
2	Улс орны эдийн засгийн хүч чадал суларсан	3.48	3.95	4.24	+0,29
3	Төрийн албаны чадавх суларсан	4.08	4.20	4.26	+0,06
4	Гадаадын хөрөнгө оруулалт буурсан	3.44	3.63	4.07	+0,44
5	Шударга ёс алдагдсан	4.05	4.14	4.29	+0,15
6	Нийгмийн дэг журам алдагдсан	3.75	3.73	3.94	+0,21
7	Ёс суртахууны үнэт зүйлс алдагдсан	4.02	4.21	4.24	+0,03
8	Өмч хөрөнгийн тэгш бус байдал нэмэгдсэн	3.86	4.10	4.28	+0,18
9	Ядуурал нэмэгдсэн	3.61	3.92	4.03	+0,11
10	Иргэдийн хууль сахиулах байгууллагад итгэх итгэд буурсан ("инфляцийн" оронд нэмсэн)	4.28	4.34	4.38	+0,04
11	Гэмт хэрэг нэмэгдсэн	3.69	3.77	3.92	+0,15
12	Ажилгүйдэл нэмэгдсэн	3.46	3.65	3.98	+0,33
13	Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдсэн	3.73	4.02	4.10	+0,08
14	Хуулийн хэрэгжилт суларсан	4.17	4.23	4.27	+0,04
15	Гадаадын зээл тусламжийн үр ашиг буурсан	3.56	3.68	3.98	+0,3
16	Хүний эрхийн зөрчил нэмэгдсэн	3.82	4.00	4.09	+0,09

Авлигын улмаас учирсан хор уршиг, сөрөг үр дагаврууд сүүлийн гурван жилийн хугацаанд тасралтгүй өссөн дүн гарсан. Шинжээчид авлигаас үүдэн хор уршиг, сөрөг үр дагаварууд маш их гарсан гэжээ. Шинжээчдийн 50-аас дээш хувь нь маш их гэж үнэлэгдсэн үзүүлэлтүүдийг дор дурдая. Үүнд:

1. Улс орны эдийн засгийн хүч чадал суларсан 53.2%
2. Хуулийн хэрэгжилт суларсан 53.2%
3. Иргэдийн хууль сахиулах байгууллагад итгэх итгэд буурсан ("инфляцийн" оронд нэмсэн) 51.6%
4. Монгол Улсын нэр хүнд олон улсын түвшинд унасан 50%
5. Төрийн албаны чадавх суларсан 50% зэрэг үзүүлэлтүүд байна.

ДЭД ҮЗҮҮЛЭЛТ 2. АВЛИГААР ОЛСОН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтийн үнэлгээ 2020 онд 3.55 гарч өмнөх оноосоо 0.26 пунктээр буурсан. Тус үзүүлэлт 2019 онд 3.81, 2018 онд 3.52 гарсан.

Зураг 24. Улс төрийн (түүнчлэн шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээний) авлигаар олсон хөрөнгийн зарцуулалт



2020 онд авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын талаарх үзүүлэлт хамаарах 19 үзүүлэлтийн 17 үзүүлэлт нь буурсан (0.03- 0.54) бол дотоодын банкинд хадгалах (+ 0.13), хандив тусламж өгөх (+ 0.03) гэх 2 үзүүлэлт өссөн дүн гарлаа.

ГУРАВ. БУСАД ҮЗҮҮЛЭЛТ

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшинг тодорхойлохдоо бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны явцад зарцуулж буй авлигын хувь, хэмжээ, авлигыг бууруулах арга зам зэргийг тодорхойлуулахыг зорьсон.

БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ЗАРЦУУЛЖ БУЙ АВЛИГЫН ХЭМЖЭЭ

Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны явцад зарцуулж буй авлигын хувийг тодорхойлуулахад төсөл, хөтөлбөрт 6-10%, тендер шалгаруулалтад ялахад 6-15%, зээл авахад 6-10%, татвараас чөлөөлүүлэх, бууруулахад 16-20%, тусгай зөвшөөрөл

авахад 21%-аас дээш, гадаадаас ажиллах хүч авахад 16%-аас дээшийг зарцуулдаг гэж хариулагсад арай илүү хувьтай байлаа.

Хүснэгт 13. Бизнес эрхлэгчдээс авлигад зарцуулсан мөнгөний хувь

		Нийт үнийн дүнд эзлэх хувь						Дундаж
		<5%	6-10%	11-15%	16-20%	21%<	Мэдэхгүй	
1	Төсөл, хөтөлбөрт хамрагдахад	9.7	33.9	11.3	22.6	11.3	11.3	2.91
2	Тендерт шалгаруулалтад ялахад		22.6	25.8	25.8	16.1	9.7	3.39
3	Зээл авахад	9.7	29.0	17.7	14.5	9.7	19.4	2.82
4	Өр төлбөр барагдуулах, иргэний нэхэмжлэл шийдвэрлүүлэхэд	6.5	19.4	30.6	14.5	6.5	22.6	2.94
5	Татвараас чөлөөлүүлэх, бууруулахад	6.5	14.5	24.2	25.8	14.5	14.5	3.32
6	Хяналт шалгалтаар зөрчил дутагдалгүй гарахад	3.2	24.2	16.1	24.2	8.1	24.2	3.13
7	Тусгай зөвшөөрөл авахад	-	11.3	22.6	22.6	27.4	16.1	3.79
8	Бараа, ажил, үйлчилгээ хүлээлгэн өгөхөд	1.6	27.4	24.2	21.0	9.7	16.1	3.12
9	Гадаадаас ажиллах хүч авахад	3.2	14.5	16.1	19.4	19.4	27.4	3.51

ХЭЭЛ ХАХУУЛЬД ЗАРЦУУЛСАН МӨНГӨНИЙ ХЭМЖЭЭ

Хээл хахуульд өгч буй мөнгөн дүнг дундаж үзүүлэлт болон хариултын хувиар тооцож үзвэл ашиг сонирхолдоо нийцүүлсэн хууль тогтоомж, шийдвэр гаргуулахад, шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход, гэмт хэрэг, зөрчлийг нуун дарагдуулахад зэрэгт хамгийн их өгдөг гэж шинжээчид хариулжээ.

Хүснэгт 14. Бизнес эрхлэгчдээс авлигад зарцуулсан мөнгөний хэмжээ /зорилгоор/, сая төгрөгөөр

	Мөнгөний хэмжээ /сая.төг/						
	1 сая хүртэл	1 - 5 сая	5 - 10 сая	10 - 20 сая	20 - 50 сая	50 < сая	Мэдэхгүй
Ажил, албан гушаалд ороход	3.2	14.5	19.4	17.7	16.1	14.5	14.5
Тусгай зөвшөөрөл авахад	1.6	6.5	17.7	16.1	21.0	24.2	12.9
Ашиг сонирхолдоо нийцсэн хууль тогтоомж, шийдвэр гаргуулахад	1.6	6.5	-	16.1	21.0	32.3	22.6
Шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход	1.6	-	8.1	11.3	17.7	37.1	24.2
Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хэргийг хэрэгсэхгүй болгоход	1.6	-	6.5	24.2	21.0	19.4	27.4
Эрүүгийн хэрэг үүсгэхэд	3.2	-	12.9	25.8	12.9	14.5	30.6
Гэмт хэрэг, зөрчлийг нуун дарагдуулахад	1.6	1.6	4.8	25.8	17.7	22.6	25.8
Хуурамч бичиг баримт үйлдэхэд	3.2	11.3	17.7	17.7	14.5	8.1	27.4

ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүснэгт 15. Авлигыг бууруулахад шаардлагатай арга хэмжээ

Код		Хувь
1	Нээлттэй ил тод байдалд шилжих	6.7
2	Шат дамжлагагүй байх	6.0
3	Хуулийн тогтолцоог сайжруулж бүтцээ цомхон байх	15.7
4	Нийтийн ёс зүйг нийтээр нь өөрчлөх	7.5

5	Хууль, шүүхийн засаглалыг сайжруулах, хүнд ял оноох	8.2
6	Цалингийн хэмжээг нэмэх	3.7
7	Дунд сургууль, их сургуульд авлигын эсрэг хөтөлбөр оруулах	2.2
8	Авлигын эсдэлийг бууруулах арга хэмжээ авах	3.0
9	Хамгаалах чиг үүргийг зарчим болгох	3.0
10	Ротацийг хөндлөнгийн хараат бус байгууллагаар хийлгэх	0.7
11	Ур чадвараар дэвшсэн албан хаагчдыг удирдах албан тушаалд томилох	4.5
12	Удирдлагуудын ажлыг тайлагнууладаг байх	3.0
13	Хууль сахиулах байгууллагын томилгоонд улс төрийн нөлөөллийг арилгах	0.7
14	Хариуцлага алдсан шүүгч нарыг эргүүлэн татах	5.2
15	Прокурорын дэргэдэх албадыг сэргээх	0.7
16	Шүүгчийн томилгоонд иргэний шууд сонгох бололцоог тусгах	2.2
17	Чанаргүй боловсон хүчнийг авахгүй байх	1.5
18	Хууль сахиулагчийн ажлын гүйцэтгэлийг хэмжих үнэлгээний тогтолцоо ба зарчим өөрчлөгдөх шаардлагатай	3.7
19	Намын нөлөөллийг багасгах	4.5
20	Сонгууль хууль, эрх зүйн тогтолцоонд хяналт тавих	3.7
21	Санхүүжилийн зүй тогтлыг өөрчлөх	0.7
22	ТББ-ыг чадавхжуулах	1.5
23	ТББ болон иргэний гаргасан мэдээлэл дээр хуулийн гаргалгаа бий болгох	1.5
24	Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	0.7
25	Авлигын хор уршигыг сурталчилах	0.7
99	Хариулж мэдэхгүй	8.2
НИЙТ		100.0


Шүүх, хууль хяналтын байгууллагын хуулийн тогтолцоог сайжруулж бүтцээ цомхон байх, хууль, шүүхийн засаглалыг сайжруулах, хүнд ял оноох, нийтийн ёс зүйг нийтээр нь өөрчлөх, нээлттэй ил тод байдалд шилжих, шат дамжлагагүй байх зэрэг нь авлигыг бууруулах арга зам гэж үнэлсэн шинжээчид ихэнх хувийг эзэлж байна.

ДӨРӨВ. ШИНЖЭЭЧДИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгаанд оролцсон шинжээчдийн ерөнхий мэдээллийг дурдахад судалгаанд оролцогчдын 27.4 хувь нь 40 хүртэл насныхан, 35.5 хувь нь 41-50 насныхан, 21 хувь нь 51-60 насныхан, 16.1 хувь нь 61-ээс дээш насныхан байна. Хүйсийн хувьд 66.1 хувь нь эрэгтэй, 33.9 хувь нь эмэгтэйчүүд хамрагдлаа.

Шинжээчдийн ажиллаж буй салбарыг харахад 42.6 хувь нь төрийн байгууллагад ажиллагсад байсан бол 24.6 хувь нь хувийн хэвшил, 13.6 хувь нь төрийн бус байгууллага, 6.6 хувь нь олон улсын байгууллага, 13.1 хувь нь судлаачид байв.

Зураг 25. Шинжээчдийн хүн ам зүйн үзүүлэлт



Авлигын хандлага, авлигад өртөмтгий ажил, албан тушаал, авлигад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхийг зорилго болгон ажилласан. Энэ хүрээнд шүүх, хууль хяналтын байгууллагын авлигын түвшинг гаргахын тулд аргачлалын дагуу индекс гаргаж, 4 үндсэн шалгуур үзүүлэлтийн үнэлгээ хийж үзэхэд дараах дүгнэлтүүд гарсаныг танилцуулж байна.

Шүүх, хууль хяналтын байгууллагын авлигын талаарх төсөөллийн үнэлгээ 2020 онд 3.82 гарч өнгөрсөн жилээс 0.04 пунктээр буурсан. Харин 2018 онд өнгөрөгч жилээсээ 0.18 пунктээр өссөн. Авлигын төсөөллийн индексийг бүрдүүлж буй үндсэн шалгуур үзүүлэлтүүдээс цар хүрээ, хэлбэр, хор уршиг, үр дагавар зэрэг нь буурсан үзүүлэлттэй бол шалтгаан нөхцөл нь өссөн дүнтэй. Шалтгаан нөхцөл гэсэн үндсэн 3 дахь үзүүлэлт 2018 оноос хойш өссөн байна. Харин цар хүрээ, хэлбэр, хор уршиг, үр дагавар нь 2018-2019 онд өссөн бол 2020 онд буурах хандлага ажиглагдаж байна.





Авлигын цар хүрээг бүрдүүлж буй үзүүлэлтүүдээс авлигын түгээмэл байдал нь өөрчлөлт, тархалтын цар хүрээ, авлигын түвшин, чиглэгдсэн байдал зэрэг үзүүлэлтүүдээсээ арай өндөр буюу 4.13 байв. Авлигын түвшний өөрчлөлт сүүлийн 3 жилийн хугацаанд өссөн үзүүлэлттэй.

Авлигын хэлбэр 2020 онд өсөлттэй байсан бол хээл хахуулийн хэлбэр, өгөх авах аргууд, бүлэглэлүүдийн нөхцөл байдал, хууль бус нөлөөллийн хэлбэрүүд өнгөрөгч оноосоо 0.10-0.22 пунктээр буурсан үзүүлэлттэй дүн гарлаа. Эдгээр үзүүлэлтүүд бага хэмжээгээр буурсан ч чамлалттай үр дүн гэж үзэхээр байна.



Хор уршиг, үр дагаварыг бүрдүүлж буй хоёр үзүүлэлтийн үнэлгээг харахад хор уршиг, үр дагавар 2018-2020 онд өссөн бол авлигаар олсон хөрөнгийн зарцуулалт 2019 онд өсч, 2020 онд буурсан үзүүлэлттэй.

Шалтгаан, нөхцөлийг бүрдүүлж буй 3 үзүүлэлт бол авлигад нөлөөлсөн хүчин зүйлс, дутагдал, доголдол, бүлэглэлүүдийн нөхцөл байдал энэ онд өссөн дүнтэй гарчээ. Түүнчлэн авлигад нөлөөлсөн хүчин зүйлс бусад хоёр үзүүлэлтээсээ өндөр үнэлгээтэй байсан.





ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ-2021

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Шударга байдлын үнэлгээний судалгааны асуулга, зааврын дагуу мэдээллийг цуглуулах, цуглуулсан мэдээлэлд үндэслэн тооцооллыг хийж, тайланг боловсруулан үр дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг гүйцэтгэх үндсэн зорилгын хүрээнд судалгаа, зөвлөх үйлчилгээний "Эс Ай Си Эй" ХХК нь энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ.

Энэхүү судалгаанд 14 яам, 32 агентлаг, 21 аймаг болон нийслэлийн ЗДТГ хамрагдсан. Үүнийг нэгжийн хувьд авч үзвэл ГШБҮ-д нийт 7,440 иргэн, ДШБҮ-д 1,550 төрийн албан хаагч, БОҮ-д 860 шинжээч буюу нийт 9,850 оролцогчийг хамруулсан.

Ерөнхий мэдээлэл

ГШБҮ-д хамрагдсан 10 оролцогч тутмын 8 нь хувь хүний хувьд төрийн байгууллагаас үйлчилгээ авсан бол 2 нь ААНБ-ыг төлөөлж үйлчилгээ авсан байлаа. Оролцогчдыг насны хувьд ангилан авч үзвэл дийлэнх нь буюу 10 оролцогч тутмын 5 нь 20-39 насныхан байв. Өөрөөр хэлбэл энэхүү судалгаанд залуу, идэр насныхан түлхүү хамрагдсан байна. Харин хүйсийн хувьд 48.2 хувь нь эрэгтэйчүүд, 51.8 хувь нь эмэгтэйчүүд байсан нь Монгол Улсын нийт хүн амын хүйсийн харьцаатай ойролцоо байв.

ДШБҮ-д хамрагдсан албан хаагчдын 23.9 хувь нь төрийн захиргааны төв байгууллага буюу яам, 49.0 хувь нь төрийн захиргааны байгууллага буюу агентлаг, 27.1 хувь нь аймаг, нийслэлийн ЗДТГ-ын төлөөлөл байсан. Албан хаагчдын ажилласан жилийн ангиллын хамгийн их хувийг буюу 44.5 хувийг 5 хүртэл жил ажилласан албан хаагч эзэлж байв.

БОҮ-д нийт 860 оролцогч хамрагдсанаас 52.4 хувийг төрийн албан хаагч, 12.8 хувийг төрийн бус байгууллагын төлөөлөл, 11.0 хувийг хувийн хэвшил, холбоодын төлөөлөл, 8.3 хувийг аудитор, хяналтын ажилтан, 6.9 хувийг хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, 4.7 хувийг эрдэмтэн судлаач, 3.8 хувийг бодлого боловсруулагч, 0.1 хувийг олон улсын байгууллагын төлөөлөл тус тус эзэлж байв.

Шударга байдлын үнэлгээ

Төрийн байгууллагуудын ШБҮ 2021 онд 72.9 болж өмнөх үнэлгээний дүнгээс 1.2 пунктээр буурсан байна. Ийнхүү буурсан үр дүнд ГШБҮ 4.7 пунктээр буурсан нь нөлөөлсөн байв.

Энэ удаагийн ШБҮ-ний судалгаагаар ДШБҮ өмнөх үнэлгээний дүнгээс 0.4 пунктээр, БОҮ 0.6 пунктээр тус тус өсжээ. ДШБҮ 2018 оноос хойш тогтвортой өсөлттэй байна. БОҮ-ний хувьд энэ удаагийн үр дүн нь ШБҮ-ний судалгаа хийгдэж эхэлснээс хойших хамгийн өндөр үнэлгээ байв. Харин ГШБҮ өмнөх үнэлгээний дүнгээс 4.7 пунктээр буурсан нь төрийн байгууллагуудын ил тод, хариуцлагатай байдлын индекс, авлигын индекс буурснаас хамаарсан байв. Өөрөөр хэлбэл төрийн үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчид ил тод, хариуцлагатай байдал буурсан, авлигын шууд болон шууд бус тохиолдол нэмэгдсэн, албан хаагчид төрийн үйлчилгээг хүргэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлдэг, ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг, бусдад хууль бусаар давуу байдал олгодог явдал ихэссэн гэж үзсэн байна.

Гадаад шударга байдлын үнэлгээ

ГШБҮ 67.0 болж 2019 онтой харьцуулахад 4.7 пунктээр, 2015 онтой харьцуулахад 2.8 пунктээр буурсан байна. ГШБҮ-ний дундаж үнэлгээ ШБҮ-ний дунджаас 5.9 пунктээр бага байгаа нь үйлчлүүлэгчдийн хувьд төрийн байгууллагуудын шударга байдалд тааруу үнэлгээ өгч байгааг илтгэж байна.

Дотоод шударга байдлын үнэлгээ

ДШБҮ 81.2 болж 2019 онтой харьцуулахад 0.4 пунктээр нэмэгджээ. ДШБҮ-ний дундаж үнэлгээ ШБҮ-ний дунджаас 8.3 пунктээр илүү байгаа нь албан хаагчид байгууллагынхаа шударга байдлыг сайнаар үнэлж байгааг илэрхийлж байна.

Бодлогод оролцогчдын үнэлгээ

БОУ 70.4 болж 2019 онтой харьцуулахад 0.6 пунктээр, өсжээ. БОУ-ний дундаж үнэлгээ ШБҮ-ний дунджаас 2.5 пунктээр бага байгаа боловч 2015 оноос хойших хамгийн өндөр үнэлгээ юм. Ийнхүү өсөхөд БОУ-д оролцогчдын авлигын талаарх төсөөлөл, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл, эрмэлзэл зэрэг үзүүлэлтүүдийг сайнаар үнэлсэн нь голлон нөлөөлжээ.

Монгол Улсын авлигын нөхцөл байдал, АТГ-ын үйл ажиллагааны үнэлгээ

Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь буюу 45.1 хувь нь Монгол Улсад авлига түгээмэл байдаг хэмээн хариулжээ. Энэхүү үр дүнг 2016 онтой харьцуулахад 6.1 пунктээр, 2019 онтой харьцуулахад 3.3 пунктээр тус тус буурчээ. Харин ихээхэн түгээмэл байдаг хэмээн хариулсан хариултын хувь 2021 онд 20.9, 2019 онд 23.0 хувийг эзэлж байв. Ийнхүү буурсан нь авлигын өнөөгийн нөхцөл байдлын талаар хэлж мэдэхгүй байна гэж үзэх иргэдийн хувь нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Ерөнхийдөө судалгаанд хамрагдсан 10 оролцогч тутмын 7 нь Монгол Улсад авлига түгээмэл байдаг гэдэгтэй санал нэгдэж байсан. Энэхүү үр дүн 2016 оноос хойш төдийлөн өөрчлөгдөөгүй байлаа.

Судалгаанд оролцсон 10 хүн тутмын 3 нь ирэх 2 жилийн хугацаанд Монгол Улсад авлигын нөхцөл байдал өөрчлөгдөхгүй гэж хариулсан бол, 2 нь буурна, 2 нь өснө гэж үзсэн байна.

Иргэд, ААНБ-ын төлөөллийн 19.8 хувь нь ирэх 2 жил авлигын нөхцөл байдал өснө гэсэн байгаа нь албан хаагчид болон бодлогод оролцогчдын төлөөллөөс харьцангуй их байна. Үр дүнгээс дүгнэхэд ирэх жилүүдэд Монгол Улс дахь авлигын түвшин буурна гэдэгт иргэд, ААНБ-ын төлөөллүүд итгэлгүй байна.

Судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хамгийн их тархсан институц аль нь болохыг тодруулахад “Эрүүл мэндийн байгууллага” гэж хариулсан бөгөөд өмнөх үнэлгээтэй харьцуулахад 5.7 пунктээр нэмэгдэж нэгт эрэмбэлэгджээ. “Шүүхийн байгууллага” өмнөх үнэлгээтэй харьцуулахад 5.3 пунктээр буурсан хэдий ч хоёрдугаарт эрэмбэлэгдсэн байна. ШБҮ-ний 2016 оноос хойших судалгаануудын үр дүнг харьцуулахад Шүүх, Газрын алба, Эрүүл мэндийн байгууллага нь авлига хамгийн их тархсан институцын эрэмбээр эхний 3 байрт эрэмбэлэгдэж байгаагаас үзэхэд эдгээр байгууллагуудад тархсан авлигыг бууруулах, таслан зогсоох тал дээр нэн тэргүүнд анхаарал хандуулж ажиллах хэрэгцээ, шаардлага байна.

Судалгаанд оролцогчдоос Монгол Улсын авлигын шалтгааныг тодруулахад цалин орлого бага, хувь хүний ёс зүйгүй, хэм, хэмжээгүй байдал, ядуурал, эдийн засгийн тогтворгүй байдал, хүнд суртал, албан тушаал эрх мэдлээ урвуулан ашигладаг байдал зэрэг хариултууд өндөр хувийг эзэлж байна. Харин 10 оролцогч тутмын 2 нь энэ талаар хэлж мэдэхүй байна гэж хариулсан байв.

Судалгаанд оролцогчдоор АТГ-ын үйл ажиллагааг үнэлүүлж үр дүнг 2019 онтой харьцуулахад үйл ажиллагаа нь үр ашигтай хэмээн үзсэн оролцогчдын үнэлгээ 28.6 пунктээр буурсан байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Энэ бүлэгт судалгааны зорилго, зорилт, арга зүй, зохион байгуулалтын талаар дурдах болно.

1.1 Шударга байдлын үнэлгээний зорилго, зорилт

Шударга байдлын үнэлгээний судалгааны асуулга, зааврын дагуу мэдээллийг цуглуулах, цуглуулсан мэдээлэлд үндэслэн тооцооллыг хийж, тайланг боловсруулан үр дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг гүйцэтгэх нь энэхүү зөвлөх үйлчилгээний зорилго байсан.

Үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан. Үүнд:

- ✓ Шударга ёсыг бэхжүүлэх, авлигын шалтгаан нөхцөлийг арилгах, авлигыг таслан зогсоох болон төрийн байгууллагаас авлигатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг суурь мэдээллээр хангах
- ✓ Тухайн байгууллагын үнэлгээг нэмэгдүүлэхэд зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлох
- ✓ Үнэлгээний үр дүнг олон нийтэд мэдээлэх замаар төрийн байгууллагын зүгээс үнэлгээний үр дүнг сайжруулах хүсэл зоригийг нэмэгдүүлэх, авлигыг бууруулах санал, санаачилга өрнүүлэх, эрмэлзлийг бий болгох

1.2 Шударга байдлын үнэлгээний бүтэц


Шударга байдлын үнэлгээ гэж тухайн байгууллагын ГШБҮ, ДШБҮ, БОҮ-ний нийт 62 дэд үзүүлэлтэд тулгуурласан үнэлгээ юм. Үүнд:

- ✓ ГШБҮ гэж тухайн байгууллагын шударга байдалд үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийн өгч буй үнэлгээг;
- ✓ ДШБҮ гэж тухайн байгууллагад ажиллаж буй албан хаагчдын зүгээс байгууллагынхаа талаар өгч буй үнэлгээг;
- ✓ БОҮ гэж тухайн байгууллагын шударга байдлын талаарх бодлого боловсруулах, төлөвлөх үе шатанд оролцогчдын өгсөн үнэлгээг тус тус ойлгоно.

1.3 Баримталсан зарчим

Дараах зарчмыг баримтлан ажилласан.

Зураг 1. Шударга байдлын үнэлгээний судалгаанд баримталсан зарчим



1.4 Шударга байдлын үнэлгээний арга зүйн загвар

Шударга байдлын үнэлгээг дараах зурагт харуулсан арга зүйн загварын дагуу гүйцэтгэсэн болно.

Зураг 2. Шударга байдлын үнэлгээний арга зүйн загвар




Үнэлгээ тооцох зарчмыг “ХАВСРАЛТ - 1”-ээс харах боломжтой.

1.5 Судалгааны хамрах хүрээ, түүвэрлэлт

1.5.1 Хамрах хүрээ

Шударга байдлын үнэлгээнд зөвхөн гүйцэтгэх эрх мэдлийн хүрээний байгууллага буюу яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ-ыг хамруулдаг. ШБҮ-ний 2021 оны судалгаанд нийтдээ **68 байгууллага** (яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ)-ыг хамруулсан.

Зураг 3. Шударга байдлын үнэлгээний систем, хамрах хүрээ



1.5.2 Түүврийн хэмжээ

Шударга байдлын үнэлгээний 2021 оны судалгаанд 14 яам, 32 агентлаг, 21 аймаг болон нийслэлийн ЗДТГ хамрагдсан. Үүнийг нэгжийн хувьд авч үзвэл ГШБҮ-д нийт 7,440 иргэн, ДШБҮ-д 1,550 төрийн албан хаагч, БОҮ-нд 860 шинжээч буюу нийт **9,850** оролцогчийг хамруулсан. Түүврийн дэлгэрэнгүй задаргааг “ХАВСРАЛТ - 2”-оос харах боломжтой.

1.6 Үнэлгээний утга

Шударга байдлын үнэлгээг 0-100 хүртэлх оноогоор гаргах бөгөөд үнэлгээний утга 100-тай тэнцүү бол хамгийн шударгыг илэрхийлнэ.


1.7 Судалгааны мэдээлэл цуглуулалт, зохион байгуулалт

Судалгааг АТГ-аас нэгдсэн удирдамжаар хангаж ажилласан бөгөөд мэдээлэл цуглуулах, тооцоолол хийх, тайлан боловсруулах үйл ажиллагааг судалгаа, зөвлөх үйлчилгээний “Эс Ай Си Эй” ХХК гүйцэтгэсэн.


Мэдээлэл цуглуулах ажлыг 2021 оны 08 дугаар сарын 09-ний өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл нийт 70 хоногийн хугацаанд амжилттай зохион байгуулсан. Мэдээлэл цуглуулалтын багт Улаанбаатар хот болон 21 аймгийн хэмжээнд нийт 32 ажилтан ажилласан.

Зураг 4. Мэдээлэл цуглуулах багийн зохион байгуулалт

Мэдээлэл цуглуулах багийн ажилчид дараах 5 үе шатын дагуу ажилласан.

Зураг 5. Мэдээлэл цуглуулах үе шат

Уг судалгаанд сургалтын болон мэдээлэл шивэлтийн гэсэн 2 төрлийн хяналтыг хийсэн. Мөн долоо хоног бүр захиалагчид явцын мэдээлэл илгээж байсан нь тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг цаг тухай бүрт нь шийдвэрлэхэд тусласан.

Зураг 6. Хяналтын үе шатууд

ШБҮ-ний 2021 оны судалгаанд хамрагдсан байгууллагууд болон оролцогчдын тоо өмнөх жилүүдээс илүү байснаараа онцлог байлаа.

1.8 Судалгааны хязгаарлагдмал байдал

Судалгаа үргэлжлэх явцад дараах хязгаарлалт тулгарсныг дурдах хэрэгтэй. Үүнд:

- Мэдээлэл цуглуулах үйл ажиллагааны үед КОВИД-19 цар тахлын дэгдэлттэй холбоотой бэрхшээл тулгарч байв. Үүсэж буй нөхцөл байдлаас шалтгаалан судалгааны асуулгын хуудсыг онлайн хэлбэрт шилжүүлэн байгууллагын дотоод сүлжээг ашиглах эсхүл тухайн байгууллагын веб сайтад байршуулах, үйлчлүүлэгч болон албан хаагчдын утасны дугаар, цахим шуудангийн хаягийг ЭБАТ-аас авч холбогдох зэрэг аргуудыг мэдээлэл цуглуулалтад нэмж ашигласан.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Энэ бүлэгт судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллийн хэсгийг хураангуйлан орууллаа.

2.1 Иргэн/хувь хүн, ААНБ-ын төлөөлөл

ГШБҮ-д хамрагдсан 10 оролцогч тутмын 8 нь хувь хүний хувьд төрийн байгууллагаас үйлчилгээ авсан бол 2 нь ААНБ-ыг төлөөлж үйлчилгээ авсан байлаа. Оролцогчдыг насны хувьд ангилан авч үзвэл дийлэнх нь буюу 10 оролцогч тутмын 5 нь 20-39 насныхан байв. Өөрөөр хэлбэл энэхүү судалгаанд залуу, идэр насныхан түлхүү хамрагдсан байна. Харин хүйсийн хувьд 48.2 хувь нь эрэгтэйчүүд, 51.8 хувь нь эмэгтэйчүүд байсан нь Монгол Улсын нийт хүн амын хүйсийн харьцаатай ойролцоо байв.¹

Хүснэгт 1. Иргэн/хувь хүн, ААНБ-ын төлөөллийн ерөнхий мэдээлэл

ДД	Ангилал	Үзүүлэлт	Оролцогчдын тоо	Хувь
Нийт			7,440	100.0%
1	Төрийн байгууллагаар үйлчлүүлэхдээ хэнийг төлөөлсөн бэ?	Хувь хүн	6,076	81.7%
		ААНБ	1,364	18.3%
2	Судалгаанд оролцогчдын нас	20 хүртэл	300	4.0%
		20-29	1,633	21.9%
		30-39	2,500	33.6%
		40-49	1,829	24.6%
		50-59	908	12.2%
		60-с дээш	270	3.6%
3	Судалгаанд оролцогчдын хүйс	Эрэгтэй	3,584	48.2%
		Эмэгтэй	3,856	51.8%

2.2 Албан хаагчдын төлөөлөл

ДШБҮ-д хамрагдсан албан хаагчдын 23.9 хувь нь төрийн захиргааны төв байгууллага буюу яам, 49.0 хувь нь төрийн захиргааны байгууллага буюу агентлаг, 27.1 хувь нь аймаг нийслэлийн ЗДТГ-ын төлөөлөл байсан. Албан хаагчдын ажилласан жилийн ангиллын хамгийн их хувийг буюу 44.5 хувийг 5 хүртэл жил ажилласан албан хаагчид эзэлж байв.

Хүснэгт 2. Албан хаагчдын төлөөллийн ерөнхий мэдээлэл

ДД	Ангилал	Үзүүлэлт	Оролцогчдын тоо	Хувь
Нийт			1,550	100.0%
1	Таны ажиллаж буй байгууллагын ангилал?	Яам	370	23.9%
		Агентлаг	760	49.0%
		Аймаг нийслэлийн ЗДТГ	420	27.1%
2	Та энэ салбар байгууллагад нийтдээ хэдэн жил ажиллаж байна вэ?	5 хүртэл жил	690	44.5%
		5-10 жил	413	26.6%
		10-20 жил	311	20.1%
		20-оос дээш жил	136	8.8%

¹ 2020 оны байдлаар Монгол Улсын нийт хүн амын 49.1 хувийг эрэгтэйчүүд, 50.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж байсан. УСХ

2.3 Бодлогод оролцогч, шинжээчдийн төлөөлөл

БОУ-д нийт 860 оролцогч хамрагдсанаас 52.4 хувийг төрийн албан хаагч, 12.8 хувийг төрийн бус байгууллагын төлөөлөл, 11.0 хувийг хувийн хэвшил, холбоодын төлөөлөл, 8.3 хувийг аудитор, хяналтын ажилтан, 6.9 хувийг хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, 4.7 хувийг эрдэмтэн судлаач, 3.8 хувийг бодлого боловсруулагч, 0.1 хувийг олон улсын байгууллагын төлөөлөл тус тус эзэлж байв.

Хүснэгт 3. Бодлогод оролцогч, шинжээчдийн төлөөллийн ерөнхий мэдээлэл

ДД	Ангилал	Үзүүлэлт	Оролцогчдын тоо	Хувь
Нийт			860	100.0%
1	Шинжээчийн төлөөлж буй хүрээ	Төрийн албан хаагч	451	52.4
		Төрийн бус байгууллага	110	12.8
		Хувийн хэвшил, холбоодын төлөөлөл	95	11.0
		Аудитор, хяналтын ажилтан	71	8.3
		Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч	59	6.9
		Эрдэмтэн, судлаач	40	4.7
		Бодлого боловсруулагч	33	3.8
		Олон улсын байгууллага	1	0.1

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН


Энэ бүлэгт ШБҮ-ний нэгдсэн үр дүн, ГШБҮ, ДШБҮ, БОУ болон Монгол Улс дахь авлигын нөхцөл байдал, авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үнэлгээний үр дүнг орууллаа.

3.1 Шударга байдлын үнэлгээний ерөнхий үр дүн

ШБҮ-г тооцохдоо АТГ-ын даргын 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/23 дугаар тушаалаар батлагдсан “Шударга байдлын үнэлгээний аргачлал”-ыг ашигласан. Тодруулбал төрийн үйлчилгээг авсан иргэд, ААНБ, төрийн үйлчилгээг хүргэж буй албан хаагчид, бодлогод оролцогчдын үнэлгээний дунджаар тооцсон. Тооцоололд нийт 62 нэгж үзүүлэлтүүдийг хамруулан авч үзсэн болно. (Хавсралт 1)

Төрийн байгууллагуудын ШБҮ 2021 онд 72.9 болж өмнөх үнэлгээний дүнгээс 1.2 пунктээр буурсан байна. Ийнхүү буурсан үр дүнд ГШБҮ 4.7 пунктээр буурсан нь нөлөөлсөн байв.


График 1. ШБҮ, оноор, оноогоор



ШБҮ-2019 оны судалгаанд 62 төрийн байгууллага хамрагдаж байсан бол энэ удаа **68 төрийн байгууллага** хамрагдсан нь онцлог байлаа.


ШБҮ-ний судалгаагаар ДШБҮ өмнөх үнэлгээний дүнгээс 0.4 пунктээр, БОУ 0.6 пунктээр тус тус өсжээ. ДШБҮ 2018 оноос хойш тогтвортой өсөлттэй байна. БОУ-ний хувьд энэ удаагийн үр дүн нь ШБҮ-ний судалгаа хийгдэж эхэлснээс хойших хамгийн өндөр үнэлгээ байв. Харин ГШБҮ өмнөх үнэлгээний дүнгээс 4.7 пунктээр буурсан нь төрийн байгууллагуудын ил тод, хариуцлагатай байдлын индекс, авлигын индекс буурснаас хамаарсан байв. Өөрөөр хэлбэл төрийн үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчид ил тод, хариуцлагатай байдал буурсан, авлигын шууд болон шууд бус тохиолдол нэмэгдсэн, албан хаагчид төрийн үйлчилгээг хүргэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлдэг, ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг, бусдад хууль бусаар давуу байдал олгодог явдал ихэссэн гэж үзсэн байна.

График 2. ШБҮ, оролцогчдын төрлөөр, оноогоор



Судалгааны үр дүнг байгууллагын төрлөөр авч үзэн 2019 онтой харьцуулахад яамдын үнэлгээ 0.4 пунктээр, агентлагуудын үнэлгээ 1.3 пунктээр, ЗДТГ-дын үнэлгээ 1.8 пунктээр буурсан байв.

График 3. ШБҮ, байгууллагын төрлөөр, оноогоор



2021 оны ШБҮ-ний судалгааны үр дүнд үндэслэн хамгийн өндөр үнэлгээ авсан 10 байгууллагын жагсаалтыг гаргахад өмнөх үнэлгээний дүнгээс ихээхэн ялгаатай байна. Өөрөөр хэлбэл ШБҮ-2019 судалгаанд хамгийн өндөр үнэлгээ авсан 5 байгууллагын аль нь ч өмнөх амжилтаа хадгалж чадаагүй байв. “Оюуны өмчийн газар” нь өмнөх жилээс 3 байраар ухарч 8 дугаарт эрэмбэлэгдсэн хэдий ч дундаж үнэлгээ 2.9 пунктээр буурчээ. ШБҮ-2021 судалгаанд хамрагдсан 68 байгууллагаас “Үндэсний хөгжлийн газар” хамгийн өндөр оноогоор үнэлэгджээ. “Хавсралт – 3” болон “Хавсралт - 4”-өөс дэлгэрэнгүйг харах боломжтой.

Хүснэгт 4. ШБҮ, хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагууд

№	Байгууллагын нэр	2019	2021	Өөрчлөлт
Хамгийн өндөр үнэлгээтэй:				
1	Үндэсний хөгжлийн газар	65.7	81.4	15.7
2	Хэнтий аймгийн ЗДТГ	75.6	81.1	5.5
3	Эрчим хүчний яам	73.5	79.9	6.4
4	Жижиг, дунд үйлдвэрийн газар	-	79.9	-
5	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	73.0	79.5	6.5
6	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	-	79.3	-
7	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	78.2	79.2	1.0
8	Оюуны өмчийн газар	81.6	78.7	-2.9
9	Өвөрхангай аймгийн ЗДТГ	77.2	78.4	1.2
10	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	75.0	78.3	3.3
Хамгийн бага үнэлгээтэй:				
59	Архангай аймгийн ЗДТГ	73.1	68.0	-5.1
60	Дорноговь аймгийн ЗДТГ	75.9	68.0	-7.9
61	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	73.9	67.9	-6.0
62	Мал эмнэлгийн ерөнхий газар	76.7	67.8	-8.9
63	Ашигт малтмал, газрын тосны газар	73.9	67.7	-6.2
64	Улсын бүртгэлийн ерөнхий газар	78.2	67.3	-10.9
65	Ховд аймгийн ЗДТГ	66.7	67.3	0.6
66	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	71.9	66.1	-5.8
67	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	67.7	61.8	-5.9
68	Хөвсгөл аймгийн ЗДТГ	71.8	59.0	-12.8

Яамдын ШБҮ ерөнхий дүнгээрээ 2019 онтой харьцуулахад 0.4 пунктээр буурсан нь ГШБҮ-ний өөрчлөлтөөс шууд хамаарч байлаа. Яамдын ШБҮ-г эрэмбэлэхэд тал нь буюу 7 яам нь улсын дунджаас дээгүүр, үлдсэн 7 нь улсын дунджаас доогуур үнэлгээтэй байна. Нийт яамдаас 4 яамны үнэлгээ өмнөх үнэлгээтэй харьцуулахад өссөн байна. Тодруулбал “Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам” 1.6, “Зам, тээврийн хөгжлийн яам” 3.2, “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2.2, “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” 4.7, “Эрчим хүчний яам”-ны үнэлгээ 6.4 пунктээр тус тус өсжээ. Хамгийн өндөр үнэлгээ авсан нь “Эрчим хүчний яам” байсан бол шинээр байгуулагдсан “Соёлын яам” нь 77.8 оноогоор хоёрдугаар байрт эрэмбэлэгдэж байлаа.


График 4. Яамдын ШБҮ, 2021 он, оноогоор



ЗГ-ын агентлагуудын ШБҮ ерөнхий дүнгээрээ 2019 онтой харьцуулахад 1.3 пунктээр буурсан байв. Судалгаанд 32 Засгийн газрын агентлаг хамрагдсан бөгөөд талаас илүү хувь нь буюу 19 нь улсын дунджаас дээгүүр, үлдсэн 13 нь доогуур үнэлгээтэй байна. Эдгээр 32 агентлагуудын 5 нь шинээр байгуулагдсан² бөгөөд 10 байгууллагын ШБҮ өмнөх үнэлгээтэй харьцуулахад өссөн, үлдсэн 17 байгууллагынх буурсан байв. Энэ удаагийн судалгааны хамгийн өндөр үнэлгээг авсан “Үндэсний хөгжлийн газар”-ын үнэлгээ өмнөх үнэлгээний дүнгээс 15.7 пунктээр өсчээ.


² Өмнөх үнэлгээний үеэр байгуулагдаагүй байсан.

График 5. Агентлагуудын ШБҮ, 2021 он, оноогоор



Аймаг, нийслэлийн 22 ЗДТГ-ын 8 нь улсын дунджаас дээгүүр үнэлгээтэй, 14 нь доогуур үнэлгээ авчээ. Эдгээр 22 ЗДТГ-ын үнэлгээг 2019 онтой харьцуулахад 9 байгууллагынх сайжирсан, харин үлдсэн 13 байгууллагынх буурсан байв. Хэнтий аймгийн ЗДТГ-ын нэлгээ 2019 онтой харьцуулахад 5.5 пунктээр нэмэгдэж хамгийн өндөр үнэлгээ³ авсан төдийгүй нийт байгууллагуудын⁴ хувьд хоёрдугаарт эрэмбэлэгдэж байсан.

График 6. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ШБҮ, 2021 он, оноогоор



Аймаг, нийслэлийн ЗДТГ-дын ШБҮ өмнөх үнэлгээний дүнгээс 1.8 пунктээр буурсан байгаа нь ГШБҮ-ийн өөрчлөлтөөс хамаарсан байв.

3.2 Гадаад шударга байдлын үнэлгээний үр дүн

Төрийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэд, ААНБ-ын төлөөллөөс ГШБҮ-ний судалгааг авсан. Энэхүү үнэлгээг ил тод, хариуцлагатай байдлын индекс, авлигын индексийн дунджаар тооцсон болно. Уг 2 дэд үзүүлэлтийн дунджийг тооцоход 5 бүлгийн 20 нэгж үзүүлэлтийг ашигласан.⁵

³ Нийт судалгаанд хамрагдсан 22 ЗДТГ-аас хамгийн өндөр үнэлгээгээр Хэнтий аймгийн ЗДТГ үнэлэгдсэн.

⁴ Судалгаанд хамрагдсан 68 байгууллага


⁵ Зураг 2-т нэгж үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй тайлбарласан.

3.2.1 ГШБҮ-ний ерөнхий дүн

2021 онд төрийн байгууллагуудын ГШБҮ 67.0 болж 2019 онтой харьцуулахад 4.7 пунктээр, 2015 онтой харьцуулахад 2.8 пунктээр буурсан байлаа. ГШБҮ-ний дундаж үнэлгээ ШБҮ-ний дунджаас 5.9 пунктээр бага байгаа нь үйлчлүүлэгчдийн хувьд төрийн байгууллагуудын шударга байдалд тааруу үнэлгээ өгч байгааг илтгэж байна.

ГШБҮ-г байгууллагын төрлөөр ангилан 2019 онтой харьцуулахад яамдын үнэлгээ 0.5 пунктээр, агентлагуудын үнэлгээ 6.4 пунктээр, ЗДТГ-уудын үнэлгээ 7.7 пунктээр тус тус буурчээ. Судалгаанд оролцогчдын хувьд яамдын шударга байдлыг агентлагууд, ЗДТГ-уудтай харьцуулахад ялимгүй өндрөөр үнэлсэн болохыг дараах графикаас харах боломжтой.

График 7. ГШБҮ, оноор, байгууллагын төрлөөр, оноогоор



Төрийн байгууллагууд ГШБҮ-ээр 46.4-84.4 оноо авсан байгаа нь 2019⁶ онтой харьцуулахад үнэлгээний доод түвшин 8.8 пунктээр буурсан байв. Судалгааны үр дүнгээс харахад төрийн байгууллагуудын гадагшаа чиглэсэн үйл ажиллагаа 2019 онтой харьцуулахад хангалтай хэмжээнд байгаагүй хэмээн дүгнэж болохоор байна. Учир нь үйлчлүүлэгчид төрийн байгууллагуудын ил тод, хариуцлагатай байдал багассан, авлигын шууд болон шууд бус тохиолдлын тоо нэмэгдсэн, албан хаагчид төрийн үйлчилгээг хүргэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлдэг, ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг, бусдад хууль бусаар давуу байдал олгодог явдал ихэссэн гэж үнэлсэн байв.

Хүснэгт 5. ГШБҮ, хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагууд

№	Байгууллагын нэр	2019	2021	Өөрчлөлт
Хамгийн өндөр үнэлгээтэй:				
1	Увс аймгийн ЗДТГ	69.6	84.4	14.8
2	Эрчим хүчний яам	69.0	81.2	12.2
3	Жижиг, дунд үйлдвэрийн газар	-	79.7	-
4	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	69.9	79.7	9.8
5	Орхон аймгийн ЗДТГ	76.3	79.6	3.3
Хамгийн бага үнэлгээтэй:				
64	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	60.7	53.4	-7.3
65	Гаалийн ерөнхий газар	60.1	52.9	-7.2
66	Дорнод аймгийн ЗДТГ	73.4	52.6	-20.8
67	Хөвсгөл аймгийн ЗДТГ	66.5	50.8	-15.7
68	Улсын бүртгэлийн ерөнхий газар	75.3	46.4	-28.9

⁶ Байгууллагууд ГШБҮ-ээр 2019 онд 55.2-82.1 оноо авсан байна.

Судалгаанд хамрагдсан 14 яамдын ГШБҮ-ний дундаж үнэлгээ өмнөх оноос 0.5 пунктээр буурсан боловч ерөнхий ГШБҮ-ээс 0.6 пунктээр их, ШБҮ-ээс 5.3 пунктээр бага байна. Эдгээр 14 яамд тус бүрийн үнэлгээг 2019 онтой харьцуулахад 6 яамны үнэлгээ нэмэгдсэн 7 яамны үнэлгээ буурсан байлаа. Үнэлгээ сайжирсан яамдад “Эрчим хүчний яам”, “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам”, “Боловсрол, шинжлэх ухааны яам”, “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам”, “Хууль зүй, дотоод хэргийн яам”, “Гадаад харилцааны яам” зэрэг хамаарч байна.

Яамдын ГШБҮ 56.1-81.2 онооны хооронд хэлбэлзэж байгаа нь 2019⁷ онтой харьцуулахад үнэлгээний доод түвшин 0.9, дээд түвшин 4.4 пунктээр сайжирсныг илэрхийлж байна.

Хүснэгт 6. Яамдын ГШБҮ, 2019, 2021 оныг харьцуулсан үнэлгээ, оноогоор

№	Байгууллагын нэр	2019	2021	Өөрчлөлт	
Яамдын ГШБҮ		68.1	67.6		-0.5
1	Эрчим хүчний яам	69.0	81.2		12.2
2	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	67.5	73.7		6.2
3	Соёлын яам	-	73.5		-
4	Боловсрол, шинжлэх ухааны яам	55.2	72.4		17.2
5	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	73.7	71.7		-2.0
6	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	67.4	69.9		2.5
7	Хууль зүй, дотоод хэргийн яам	64.8	68.3		3.5
8	Гадаад харилцааны яам	66.8	67.2		0.4
9	Барилга, хот байгуулалтын яам	70.5	67.2		-3.3
10	Сангийн яам	75.0	63.1		-11.9
11	Эрүүл мэндийн яам	68.8	62.8		-6.0
12	Батлан хамгаалах яам	76.8	60.2		-16.6
13	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	72.0	59.7		-12.3
14	Зам, тээврийн хөгжлийн яам	58.5	56.1		-2.4

Судалгаанд хамрагдсан ЗГ-ын агентлагуудын ГШБҮ-ний дундаж үнэлгээ 2019 онтой харьцуулахад 6.4 пунктээр буурсан ба ерөнхий ГШБҮ-ээс 0.5 пунктээр бага байна. Эдгээр 32 байгууллагын 5 нь шинээр байгуулагдсан ба анх удаа ШБҮ-ний судалгаанд хамрагдаж байгаа билээ. Үлдсэн 27 байгууллагын 3 байгууллагын ГШБҮ нь 2019 онтой харьцуулахад нэмэгдсэн үлдсэн 24 байгууллагынх буурсан байв. Үнэлгээ сайжирсан агентлагт “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар”, “Соёл урлагийн газар”, “Биеийн тамир, спортын улсын хороо” зэрэг хамаарч байна.

Агентлагуудын ГШБҮ 46.4-79.7 онооны хооронд хэлбэлзэж байгаа нь 2019⁸ онтой харьцуулахад үнэлгээний доод түвшин 13.7, дээд түвшин 2.4 пунктээр буурсныг илэрхийлж байна.

Хүснэгт 7. Агентлагуудын ГШБҮ, 2019, 2021 оныг харьцуулсан үнэлгээ, оноогоор

№	Байгууллагын нэр	2019	2021	Өөрчлөлт	
Агентлагуудын ГШБҮ		72.9	66.5		-6.4
1	Жижиг, дунд үйлдвэрийн газар	-	79.7		-
2	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	69.9	79.7		9.8
3	Усны газар	-	79.0		-
4	Соёл, урлагийн газар	76.8	77.9		1.1

⁷ Яамдын ГШБҮ 2019 онд 55.2-76.8 байв.

⁸ Үнэлгээнд хамрагдсан агентлагуудын ГШБҮ 2019 онд 60.1-82.1 оноо авсан.

№	Байгууллагын нэр	2019	2021	Өөрчлөлт
5	Үндэсний хөгжлийн газар	-	76.7	-
6	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	79.6	75.6	-4.0
7	Архивын ерөнхий газар	82.1	73.6	-8.5
8	Гадаадын иргэн, харьяатын газар	80.1	73.3	-6.8
9	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	-	72.6	-
10	Оюуны өмчийн газар	81.4	71.8	-9.6
11	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	78.1	71.7	-6.4
12	Иргэний нисэхийн ерөнхий газар	-	71.4	-
13	Үндэсний геологийн алба	-	69.9	-
14	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	74.0	69.4	-4.6
15	Биеийн тамир, спортын улсын хороо	66.3	69.3	↑ 3.0
16	Стандарт, хэмжил зүйн газар	75.1	69.2	-5.9
17	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	70.9	68.0	-2.9
18	Цаг уур, орчны шинжилгээний газар	-	65.8	-
19	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	65.7	64.9	-0.8
20	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	66.6	62.4	-4.2
21	Онцгой байдлын ерөнхий газар	81.0	61.9	-19.1
22	Ашигт малтмал, газрын тосны газар	71.4	61.8	-9.6
23	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	81.3	61.1	-20.2
24	Төрийн худалдан авах ажиллагааны газар	-	61.0	-
25	Татварын ерөнхий газар	68.8	60.1	-8.7
26	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	-	59.1	-
27	Мал эмнэлгийн ерөнхий газар	75.9	59.0	-16.9
28	Нийгмийн даатгалын ерөнхий газар	73.1	54.6	-18.5
29	Цагдаагийн ерөнхий газар	62.8	53.8	-9.0
30	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	60.7	53.4	-7.3
31	Гаалийн ерөнхий газар	60.1	52.9	-7.2
32	Улсын бүртгэлийн ерөнхий газар	75.3	46.4	-28.9

Судалгаанд аймаг, нийслэлийн ЗДТГ хамрагдсан бөгөөд эдгээрийн ГШБҮ-ний дундаж үнэлгээ нь 2019 онтой харьцуулахад 5.5 пунктээр буурсан байна. Энэхүү үр дүн нь ерөнхий ГШБҮ-ээс 0.4 пунктээр илүү байгаа боловч ШБҮ-ээс 5.5 пунктээр тааруу байгааг харуулж байлаа. Мөн нийт судалгаанд хамрагдсан ЗДТГ-уудын ГШБҮ-г 2019 оны үр дүнтэй харьцуулахад 6 ЗДТГ-ын үнэлгээ сайжирсан, үлдсэн 16 нь буурсан байв. Үнэлгээ сайжирсан байгууллагуудад “Увс аймгийн ЗДТГ”, “Орхон аймгийн ЗДТГ”, “Хэнтий аймгийн ЗДТГ”, “Дундговь аймгийн ЗДТГ”, “Сүхбаатар аймгийн ЗДТГ”, “Нийслэлийн ЗДТГ”, “Ховд аймгийн ЗДТГ” зэрэг хамаарч байна.

ЗДТГ-уудын ГШБҮ 50.8-84.4 онооны хооронд хэлбэлзэж байгаа нь 2019⁹ онтой харьцуулахад үнэлгээний доод түвшин 12.8 пунктээр буурсан, дээд түвшин 6.2 пунктээр нэмэгдсэнийг илэрхийлж байна.

Хүснэгт 8. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ГШБҮ, 2019, 2021 оныг харьцуулсан үнэлгээ, оноогоор

№	Байгууллагын нэр	2019	2021	Өөрчлөлт
Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ГШБҮ		72.9	67.4	↓ -5.5
1	Увс аймгийн ЗДТГ	69.6	84.4	↑ 14.8
2	Орхон аймгийн ЗДТГ	76.3	79.6	↑ 3.3
3	Хэнтий аймгийн ЗДТГ	70.3	73.9	↑ 3.6
4	Булган аймгийн ЗДТГ	75.7	73.8	-1.9
5	Дундговь аймгийн ЗДТГ	72.1	72.5	↑ 0.4

⁹ Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын хувьд ГШБҮ өнгөрсөн оноос харьцангуй өссөн үзүүлэлттэй буюу 63.6-78.2-ийн хооронд байна.

№	Байгууллагын нэр	2019	2021	Өөрчлөлт
6	Сүхбаатар аймгийн ЗДТГ	70.9	72.3	↑ 1.4
7	Төв аймгийн ЗДТГ	77.0	71.6	-5.4
8	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	74.5	71.0	-3.5
9	Өвөрхангай аймгийн ЗДТГ	78.2	70.9	-7.3
10	Дархан-Уул аймгийн ЗДТГ	72.5	69.5	-3.0
11	Нийслэлийн ЗДТГ	63.6	69.0	↑ 5.4
12	Архангай аймгийн ЗДТГ	75.4	68.0	-7.4
13	Ховд аймгийн ЗДТГ	66.2	67.3	↑ 1.1
14	Завхан аймгийн ЗДТГ	77.7	66.5	-11.2
15	Баянхонгор аймгийн ЗДТГ	69.2	62.9	-6.3
16	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	73.9	62.5	-11.4
17	Өмнөговь аймгийн ЗДТГ	73.2	62.0	-11.2
18	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	66.9	61.3	-5.6
19	Говь-Алтай аймгийн ЗДТГ	73.4	60.7	-12.7
20	Дорноговь аймгийн ЗДТГ	75.8	60.2	-15.6
21	Дорнод аймгийн ЗДТГ	73.4	52.6	-20.8
22	Хөвсгөл аймгийн ЗДТГ	66.5	50.8	-15.7


3.2.2 Ил тод, хариуцлагатай байдлын индекс

Ил тод, хариуцлагатай байдлын индекс нь ГШБҮ тооцоход ашигласан эхний үзүүлэлт бөгөөд 2021 оны үнэлгээ 57.5 гарсан нь 2019 онтой харьцуулахад 4.1 пунктээр буурсан, харин 2018 онтой харьцуулахад 0.6 пунктээр илүү байгаа үр дүн юм.

Ил тод, хариуцлагатай байдлын индексийг тооцохдоо ил тод байдал, хариуцлагатай байдал гэсэн 2 бүлгийн нэгж үзүүлэлтүүдийг ашигласан талаар өмнө дурдсан билээ. Ил тод байдлын үнэлгээ 2019 онтой харьцуулахад 3.6, хариуцлагатай байдлын үнэлгээ 4.4 пунктээр буурчээ.


Ил тод болон хариуцлагатай байдлыг сүүлийн 5 жилийн үр дүнг ашиглан хооронд нь харьцуулахад “ил тод байдал” хамгийн бага үнэлгээг авсаар ирсэн байна. Энэ нь төрийн байгууллагуудыг цаашид ил тод байдлаа сайжруулах шаардлагатайг илэрхийлж байна.

График 8. Ил тод, хариуцлагатай байдлын индекс, оноор, оноогоор



Ил тод, хариуцлагатай байдлын индексийг байгууллагын төрлөөр ангилан авч үзвэл агентлагуудын ил тод байдал болон хариуцлагатай байдал нь яамд болон ЗДТГ-уудаас ялимгүй илүү байв.

График 9. 2021 оны авлигын эрсдэлийн индекс, байгууллагын төрлөөр, оноогоор



3.2.3 Авлигын индекс


Авлигын индекс нь ГШБҮ-г тооцоход ашигласан сүүлчийн үзүүлэлт бөгөөд 2021 оны үнэлгээгээр 76.5 гарсан нь 2019 онтой харьцуулахад 5.2 пунктээр буурсан дүн юм.

Авлигын индексийг тооцохдоо авлигын талаарх төсөөлөл, авлигын шууд болон шууд бус тохиолдол гэсэн 3 бүлгийн нэгж үзүүлэлтүүдийг ашигласан. Судалгааны үр дүнг 2019 онтой харьцуулахад авлигын талаарх төсөөлөл 4.9, авлигын шууд тохиолдол 5.9, авлигын шууд бус тохиолдол 5.1 пунктээр тус тус буурчээ.

Авлигын шууд тохиолдлыг тодруулахад судалгаанд оролцогчдын 6.1 хувь нь албан хаагчид албан үүргээ гүйцэтгэснийх нь төлөө нэмэлт төлбөр өгсөн, 4.7 хувь нь төрийн албан хаагчид шууд болон шууд бус байдлаар бэлэг өгсөн, 3.3 хувь нь албан хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор хандив, бусад санхүүгийн туслалцаа үзүүлсэн хэмээн хариулжээ. Энэхүү үр дүнг 2019 онтой харьцуулахад нэмэлт төлбөр өгсөн тохиолдлын хувь 3.8 пунктээр, шууд болон шууд бус байдлаар бэлэг өгсөн тохиолдлын тоо 2.7 пунктээр, хандив, бусад санхүүгийн туслалцаа үзүүлсэн тохиолдлын тоо 0.5 пунктээр тус тус нэмэгджээ.


Мөн судалгаанд оролцогчоос “Танай найз нөхөд, хамт ажиллагсад, ойр дотнын хэн нэгэн тухайн байгууллагаас үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэргийг сүүлийн 12 сарын хугацаанд өгч байсныг мэдэх үү? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 9.1 хувь нь “ тийм” гэж хариулсан байгаа нь өмнөх оноос 3.6 пунктээр нэмэгдсэн байна. 2019 онд авлигын шууд болон шууд бус тохиолдол харьцангуй багасаж байсан бол энэ онд эргэн нэмэгдсэн нь таатай үр дүн байсангүй.

График 10. Авлигын индекс, оноор, оноогоор



Авлигын индексийг байгууллагын төрлөөр ангилан авч үзэхэд яамдын үнэлгээ агентлаг болон ЗДТГ-уудаас ялимгүй илүү байна. Агентлагуудын авлигын шууд тохиолдлын үнэлгээ 80.8, шууд бус тохиолдлын үнэлгээ 85.6 буюу яамд, ЗДТГ-тай харьцангуй бага байгаагаас харахад агентлагуудад авлигын шууд тохиолдлууд түлхүү ажиглагддаг болох нь харагдаж байна. Энэхүү үр дүн нь 2019 онд яамдад түлхүү ажиглагддаг байжээ.

График 11. Авлигын индекс, байгууллагын төрлөөр, оноогоор, 2021 он



Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, бэлэг, хандив өгсөн хэмээн хариулсан оролцогчдоос аль үед өгснийг нь тодруулахад 26.5 хувь нь үйлчилгээ авахаас өмнө, 23.7 хувь нь үйлчилгээ авсны дараа, 20.2 хувь нь үйлчилгээ авч байхдаа хэмээн хариулсан байна. Ямар шалтгааны улмаас нэмэлт, төлбөр, бэлэг, хандивыг өгөх болсныг тодруулахад 38.2 хувь нь ажлаа хурдан бүтээхийн тулд гэсэн байв.

График 12. Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, бэлэг, хандив зэргийг яг аль үед өгсөн, өгөх болсон шалтгаан



3.3 Дотоод шударга байдлын үнэлгээний үр дүн


Төрийн байгууллагуудын үйлчилгээ үзүүлж буй албан хаагчдын төлөөллөөс ДШБҮ-ний судалгааг авсан. Энэхүү үнэлгээг соёлын индекс, үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн дунджаар тооцсон болно. Уг 2 дэд үзүүлэлтийн дунджийг тооцоход 7 бүлгийн 26 нэгж үзүүлэлтийг ашигласан.

3.3.1 ДШБҮ-ний ерөнхий дүн

2021 онд төрийн байгууллагуудын ДШБҮ 81.2 болж 2019 онтой харьцуулахад 0.4 пунктээр нэмэгджээ. ДШБҮ-ний дундаж үнэлгээ ШБҮ-ний дунджаас 8.3 пунктээр илүү байгаа нь албан хаагчид байгууллагынхаа шударга байдлыг сайнаар үнэлж байгааг илэрхийлж байна.

ДШБҮ-г байгууллагын төрлөөр ангилан 2019 онтой харьцуулахад яамдын үнэлгээ 2.0 пунктээр буурсан, агентлагуудын үнэлгээ 1.2 пунктээр, ЗДТГ-уудын үнэлгээ 0.6 пунктээр нэмэгдсэн байв. Судалгаанд оролцогчдын хувьд яамдын шударга байдлыг агентлагууд, ЗДТГ-уудтай харьцуулахад ялимгүй доогуур түвшинд үнэлсэн болохыг дараах графикаас харах боломжтой.

График 13. ДШБҮ, оноор, байгууллагын төрлөөр



Судалгааны үр дүнг 2019 онтой харьцуулахад ДШБҮ-ээр хамгийн өндөр үнэлгээ авсан 5 байгууллагаас 3 байгууллагынх нь үнэлгээ сайжирсан байна. Харин хамгийн өндөр үнэлгээ авсан үлдсэн 2 байгууллага нь өмнө судалгаанд хамрагдаж байгаагүй шинэ байгууллагууд байв.

ДШБҮ-ээр хамгийн бага үнэлгээ авсан 5 байгууллагуудын үнэлгээ 2019 онтой харьцуулахад бүгд их хэмжээгээр буурсан байлаа. Хамгийн их хэмжээгээр буурсан байгууллага нь “Соёл урлагийн газар” байв.

Хүснэгт 9. ДШБҮ, хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагууд

№	Байгууллагын нэр	2019	2021	Өөрчлөлт
Хамгийн өндөр үнэлгээтэй:				
1	Хэнтий аймгийн ЗДТГ	84.3	89.8	5.5
2	Үндэсний хөгжлийн газар	69.8	89.7	19.9
3	Цагдаагийн ерөнхий газар	82.7	88.8	6.1
4	Жижиг, дунд үйлдвэрийн газар	-	88.0	-
5	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	-	87.8	-

№	Байгууллагын нэр	2019	2021	Өөрчлөлт
Хамгийн бага үнэлгээтэй:				
64	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	-	72.4	-
65	Ашигт малтмал, газрын тосны газар	84.6	71.2	-13.4
66	Завхан аймгийн ЗДТГ	85.5	70.4	-15.1
67	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	77.6	69.6	-8.0
68	Соёл, урлагийн газар	86.9	62.6	-24.3

Судалгаанд хамрагдсан 14 яамдын ДБШУ-ний дундаж 2019 онтой харьцуулахад 2.0 пунктээр буурсан байна. Энэ нь 2019 оноос хойш яамдын дотоод үйл ажиллагаа хангалттай түвшинд сайжирч чадаагүй болохыг илэрхийлж байна.









Нийт яамдаас 5 яамны үнэлгээ өмнөх үнэлгээтэй харьцуулахад сайжирсан, 8 яамны үнэлгээ буурсан байв.

Хүснэгт 10. Яамдын ДШБҮ, 2019, 2021 оныг харьцуулсан үнэлгээ

№	Байгууллагын нэр	2019	2021	Өөрчлөлт
Яамдын ДШБҮ		82.0	80.0	 -2.0
1	Батлан хамгаалах яам	85.7	87.5	 1.8
2	Сангийн яам	86.6	86.6	0.0
3	Эрчим хүчний яам	82.7	84.6	 1.9
4	Зам, тээврийн хөгжлийн яам	84.0	84.5	 0.5
5	Барилга, хот байгуулалтын яам	84.1	82.9	-1.2
6	Соёлын яам	-	82.0	-
7	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	79.8	79.4	-0.4
8	Гадаад харилцааны яам	85.1	79.2	-5.9
9	Эрүүл мэндийн яам	76.9	78.1	 1.2
10	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	76.5	77.6	 1.1
11	Хууль зүй, дотоод хэргийн яам	85.5	77.2	-8.3
12	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	76.5	74.8	-1.7
13	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	79.5	73.0	-6.5
14	Боловсрол, шинжлэх ухааны яам	82.9	73.0	-9.9

2019 онд хийгдсэн ШБҮ-ний судалгаанд 27 агентлаг хамрагдсан бол энэ удаа 32 агентлаг хамрагдсан талаар өмнө дурдсан билээ. Эдгээр 32 агентлагийн дундаж үнэлгээг 2019 оны үнэлгээтэй харьцуулахад 1.2 пунктээр өссөн байлаа. Түүнчлэн 15 агентлагийн үнэлгээ өмнөх үнэлгээтэй харьцуулахад сайжирсан байгаа нь агентлагуудын дотоод үйл ажиллагаа тасралтгүй сайжирч байгааг батлах чухал үр дүн юм.

Хүснэгт 11. Агентлагуудын ДШБҮ, 2019, 2021 оныг харьцуулсан үнэлгээ

№	Байгууллагын нэр	2019	2021	Өөрчлөлт
Агентлагуудын ДШБҮ		80.7	81.9	 1.2
1	Үндэсний хөгжлийн газар	69.8	89.7	 19.9
2	Цагдаагийн ерөнхий газар	82.7	88.8	 6.1
3	Жижиг, дунд үйлдвэрийн газар	-	88.0	-
4	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	-	87.8	-
5	Оюуны өмчийн газар	-	87.4	 -
6	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	84.3	87.2	 2.9
7	Нийгмийн даатгалын ерөнхий газар	84.7	86.5	 1.8
8	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	-	85.8	 -
9	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	85.7	85.7	0.0
10	Стандарт, хэмжил зүйн газар	71.0	85.4	 14.4
11	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	87.2	85.3	-1.9
12	Үндэсний геологийн алба	-	85.1	-

№	Байгууллагын нэр	2019	2021	Өөрчлөлт
13	Цаг уур, орчны шинжилгээний газар	85.0	85.0	0.0
14	Усны газар	-	84.5	-
15	Архивын ерөнхий газар	79.2	84.4	↑ 5.2
16	Онцгой байдлын ерөнхий газар	87.1	84.4	-2.7
17	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	79.2	83.5	↑ 4.3
18	Гаалийн ерөнхий газар	84.0	82.0	-2.0
19	Гадаадын иргэн, харьяатын газар	85.7	81.5	-4.2
20	Татварын ерөнхий газар	79.1	81.1	↑ 2.0
21	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	80.2	81.1	0.9
22	Улсын бүртгэлийн ерөнхий газар	83.1	80.6	-2.5
23	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	80.9	80.0	-0.9
24	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	77.4	79.4	↑ 2.0
25	Төрийн худалдан авах ажиллагааны газар	-	79.3	-
26	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	76.5	79.2	↑ 2.7
27	Иргэний нисэхийн ерөнхий газар	73.4	78.3	↑ 4.9
28	Биеийн тамир, спортын улсын хороо	60.5	77.6	↑ 17.1
29	Мал эмнэлгийн ерөнхий газар	-	72.4	-
30	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	-	71.4	-
31	Ашигт малтмал, газрын тосны газар	84.6	71.2	-13.4
32	Соёл, урлагийн газар	86.9	62.6	-24.3

Судалгаанд аймаг, нийслэлийн 22 ЗДТГ хамрагдсан бөгөөд эдгээрийн ДШБҮ өмнөх үнэлгээтэй харьцуулахад 0.6 пунктээр өсжээ. Нийт ЗДТГ-уудаас 14 нь дотоод үйл ажиллагаагаа сайжруулан ажилласны үр дүнд үнэлгээгээ нэмэгдүүлснийг дараах хүснэгтээс харах боломжтой.


Хүснэгт 12. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ДШБҮ, 2019, 2021 оныг харьцуулсан үнэлгээ

№	Байгууллагын нэр	2019	2021	Өөрчлөлт
ЗДТГ-ын ДШБҮ		80.2	80.8	↑ 0.6
1	Хэнтий аймгийн ЗДТГ	84.3	89.8	↑ 5.5
2	Говь-Алтай аймгийн ЗДТГ	78.0	87.6	↑ 9.6
3	Өвөрхангай аймгийн ЗДТГ	85.5	85.2	-0.3
4	Дорнод аймгийн ЗДТГ	81.0	85.2	↑ 4.2
5	Дархан-Уул аймгийн ЗДТГ	81.0	84.9	↑ 3.9
6	Ховд аймгийн ЗДТГ	72.7	84.0	↑ 11.3
7	Сүхбаатар аймгийн ЗДТГ	74.6	83.3	↑ 8.7
8	Дорноговь аймгийн ЗДТГ	82.8	83.0	↑ 0.2
9	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	82.3	82.8	↑ 0.5
10	Дундговь аймгийн ЗДТГ	79.9	82.1	↑ 2.2
11	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	80.8	82.0	↑ 1.2
12	Баянхонгор аймгийн ЗДТГ	75.8	81.7	↑ 5.9
13	Увс аймгийн ЗДТГ	79.9	81.6	↑ 1.7
14	Булган аймгийн ЗДТГ	84.1	80.8	-3.3
15	Төв аймгийн ЗДТГ	81.9	80.0	-1.9
16	Орхон аймгийн ЗДТГ	85.1	79.8	-5.3
17	Нийслэлийн ЗДТГ	72.7	78.4	↑ 5.7
18	Өмнөговь аймгийн ЗДТГ	77.0	77.6	↑ 0.6
19	Архангай аймгийн ЗДТГ	82.1	76.0	-6.1
20	Хөвсгөл аймгийн ЗДТГ	79.9	72.4	-7.5
21	Завхан аймгийн ЗДТГ	85.5	70.4	-15.1
22	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	77.6	69.6	-8.0

3.3.2 Соёлын индекс


ДШБҮ-г тооцоход ашигласан эхний үзүүлэлт бол соёлын индекс юм. Соёлын индекс 73.3 гарсан нь 2019 онтой харьцуулахад 0.8 пунктээр өссөн байв. Энэхүү үр дүн нь ДШБҮ-ийн дунджаас 8.8 пунктээр бага байгаа нь албан хаагчдын хэм хэмжээг хэтрүүлэн ашиглах тохиолдол нэлээдгүй байдаг болон тухайн байгууллагад авлигын эсрэг тогтолцоо хангалттай бүрдээгүй зэргээс шалтгаалж байна.

График 14. Соёлын индекс, дэд үзүүлэлтээр, оноор



Яамдын албан бус хэм хэмжээ 78.8, авлигын эсрэг тогтолцоо 63.7 буюу агентлагууд, ЗДТГ-тай харьцуулахад ялимгүй бага байгаа нь цаашид албан хаагчдаа албан үүргээ ил тод байдлаар гүйцэтгэх, танил талынхаа нөлөөнд автах, ашиг сонирхлоо дээгүүр тавих, бусдад дарамт, шахалт үзүүлэх, нөлөөлөх байдлаас сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг авах шаардлагатайг илэрхийлж байна. Иймд энэ чиглэлд дотоод үйл ажиллагаа, сургалт, хөтөлбөр аяныг зохион байгуулах нь үр дүнтэй байна.

График 15. Соёлын индекс, дэд үзүүлэлтээр, байгууллагын төрлөөр, 2021 он




3.3.3 Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс

ДШБҮ-г тооцоход ашигласан сүүлийн үзүүлэлт нь үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс юм. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс нь хүний нөөц, төсвийн зарцуулалт, үүрэг даалгаврын шударга байдал, гадаад орчин дахь авлигатай тэмцэх,

удирдлагын хүсэл, эрмэлзэл зэрэг 5 бүлгийн нэгж үзүүлэлтүүдээс хамаарч байна. Уг индекс нь 2019 онтой харьцуулахад өөрчлөлтгүй буюу ижил оноогоор үнэлэгдсэн байна.


Индексийг хэмжихэд ашигласан 5 бүлгээс хамгийн тааруу үнэлэгддэг бүлэг нь удирдлагын хүсэл эрмэлзэл боловч 2019 онтой харьцуулахад 0.6 пунктээр өссөн байв. Харин гадаад орчин дахь авлигатай тэмцэх тогтолцоо, хүний нөөцийн асуудлууд тогтмол өндөр үнэлгээгээр үнэлэгдэж байгааг дараах графикаас харах боломжтой.

График 16. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтээр, оноор




Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийг байгууллагын төрлөөр ангилан авч үзэхэд төдийлөн ялгаа харагдахгүй байгаа боловч удирдлагын хүсэл, эрмэлзлийн үнэлгээ яамдын хувьд ялимгүй бага байна.

График 17. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтээр, байгууллагын төрлөөр, 2021 он



Төрийн албан хаагчдаас сүүлийн 12 сарын хугацаанд тухайн байгууллагад төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан тохиолдол байгаа эсэхийг тодруулахад 2.6 хувь нь “тийм” гэж хариулсан нь 2019 онтой харьцуулахад 0.5 пунктээр буурсан сайн үр дүн гарчээ. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах болсон шалтгааныг тодруулахад 42.3 хувь нь удирдах албан тушаалтны шийдвэрээр, 23.1 хувь нь уламжлал болсон учир, 15.4 хувь нь хяналт сул байдаг зэргээр хариулжээ. Хэдийгээр удирдлагын шийдвэрээр гэж хариулсан албан хаагчдын хувь 2019 онтой харьцуулахад 5.8 пунктээр буурсан боловч төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах явдал нь удирдлагын шийдвэртэй шууд хамааралтай байдаг нь хэвээр хадгалагдсаар л байна.

График 18. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах болсон шалтгаан



3.4 Бодлогод оролцогчдын үнэлгээний үр дүн


Төрийн байгууллагуудын БОУ-д тухайн байгууллагын харьяа дээд байгууллагын төлөөлөл, бодлого боловсруулагч болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, холбоодын төлөөлөл, аудитор, хяналтын ажилтан, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, эрдэмтэн, судлаачдын төлөөллийг хамруулсан. Энэхүү үнэлгээг авлигын талаарх төсөөлөл, авлигын хяналт, авлигын бодит тохиолдол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл зэрэг үзүүлэлтүүдийн дунджаар тооцсон болно.

3.4.1 БОУ-ний ерөнхий дүн

2021 онд төрийн байгууллагуудын БОУ 70.4 болж 2019 онтой харьцуулахад 0.6 пунктээр өсжээ. БОУ-ний дундаж үнэлгээ ШБҮ-ний дунджаас 2.5 пунктээр бага байгаа боловч 2015 оноос хойших хамгийн өндөр үнэлгээ юм. Ийнхүү өсөхөд БОУ-д оролцогчдын авлигын талаарх төсөөлөл, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл, эрмэлзэл зэрэг сайжирсан нь ихээхэн нөлөөлжээ.

БОУ -г байгууллагын төрлөөр ангилан 2019 онтой харьцуулахад ЗДТГ-уудын үнэлгээ 0.5 пунктээр буурсан байгаа нь судалгаанд оролцогчдын хувьд ЗДТГ-уудын шударга байдлыг агентлагууд, яамдуудтай харьцуулахад ялимгүй багаар үнэлсэн болохыг дараах графикаас харах боломжтой.

График 19. БОУ, оноор, байгууллагын төрлөөр



Хамгийн өндөр үнэлгээ авсан 5 байгууллагын үнэлгээг 2019 онтой харьцуулахад бүгд сайжирсан байв. Харин хамгийн бага үнэлгээ авсан 5 байгууллагаас 4 байгууллагын үнэлгээ өмнөх жилээс буурсан. Үлдсэн 1 байгууллага буюу “Иргэний нисэхийн ерөнхий газар”-ын үнэлгээ 0.8 пунктээр сайжирсан хэдий ч хамгийн бага үнэлгээ авсан байгууллагын тоонд хамарч байна.

Хүснэгт 13. БОУ, хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагууд

№	Байгууллагын нэр	2019	2021	Өөрчлөлт
Хамгийн өндөр үнэлгээтэй:				
1	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	79.0	83.7	4.7
2	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	66.7	82.1	15.4
3	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	76.4	81.1	4.7
4	Зам, тээврийн хөгжлийн яам	68.9	80.3	11.4
5	Хэнтий аймгийн ЗДТГ	72.1	79.6	7.5
Хамгийн бага үнэлгээтэй:				
64	Булган аймгийн ЗДТГ	65.5	59.9	-5.6
65	Иргэний нисэхийн ерөнхий газар	58.7	59.5	0.8
66	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	58.7	54.5	-4.2
67	Хөвсгөл аймгийн ЗДТГ	68.9	53.7	-15.2
68	Ховд аймгийн ЗДТГ	61.1	50.6	-10.5

Судалгаанд хамрагдсан 14 яамдын БОУ-ийн дундаж үнэлгээ 2019 онтой харьцуулахад 1.0 пунктээр өсжээ. Эдгээр 14 яамдын 6 яамны үнэлгээ өмнөх үнэлгээтэй харьцуулахад сайжирсан байна.

Хүснэгт 14. Яамдын БОУ, 2019, 2021 оныг харьцуулсан байдлаар

№	Байгууллагын нэр	2019	2021	Өөрчлөлт
Яамдын БОУ				
		69.6	70.6	↑ 1.0
1	Зам, тээврийн хөгжлийн яам	68.9	80.3	↑ 11.4
2	Соёлын яам	-	77.9	-
3	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	65.5	77.5	↑ 12.0
4	Гадаад харилцааны яам	78.4	74.7	-3.7
5	Эрчим хүчний яам	68.7	73.9	↑ 5.2
6	Боловсрол, шинжлэх ухааны яам	73.8	71.4	-2.4
7	Сангийн яам	64.8	70.4	↑ 5.6
8	Барилга, хот байгуулалтын яам	65.2	68.9	↑ 3.7
9	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	66.5	68.6	2.1
10	Хууль зүй, дотоод хэргийн яам	70.6	67.3	-3.3

№	Байгууллагын нэр	2019	2021	Өөрчлөлт
11	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	70.4	66.9	-3.5
12	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	64.3	65.7	↑ 1.4
13	Эрүүл мэндийн яам	68.9	63.7	-5.2
14	Батлан хамгаалах яам	78.7	60.8	-17.9

Судалгаанд хамрагдсан 32 агентлагийн БОУ-ийн дундаж үнэлгээ 2019 онтой харьцуулахад 1.3 пунктээр өсжээ. Эдгээр 32 агентлагаас 13 агентлагийн үнэлгээ өмнөх үнэлгээний үр дүнгээс сайжирсан байна.

Хүснэгт 15. Агентлагуудын БОУ, 2019, 2021 оныг харьцуулсан байдлаар

№	Байгууллагын нэр	2019	2021	Өөрчлөлт
Агентлагуудын БОУ		72.1	73.4	↑ 1.3
1	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	79.0	83.7	↑ 4.7
2	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	66.7	82.1	↑ 15.4
3	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	76.4	81.1	↑ 4.7
4	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	80.1	79.6	-0.5
5	Үндэсний хөгжлийн газар	61.6	77.8	↑ 16.2
6	Төрийн худалдан авах ажиллагааны газар	-	77.6	-
7	Цагдаагийн ерөнхий газар	78.2	77.6	-0.6
8	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	-	77.6	-
9	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	83.3	77.0	-6.3
10	Оюуны өмчийн газар	78.0	76.9	-1.1
11	Стандарт, хэмжил зүйн газар	64.7	76.5	↑ 11.8
12	Гадаадын иргэн, харьяатын газар	81.0	75.5	-5.5
13	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	70.0	75.3	↑ 5.3
14	Улсын бүртгэлийн ерөнхий газар	76.1	74.9	-1.2
15	Соёл, урлагийн газар	87.4	73.8	-13.6
16	Цаг уур, орчны шинжилгээний газар	76.4	73.6	-2.8
17	Биеийн тамир, спортын улсын хороо	68.0	72.9	↑ 4.9
18	Архивын ерөнхий газар	76.3	72.7	-3.6
19	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	69.7	72.0	↑ 2.3
20	Мал эмнэлгийн ерөнхий газар	72.7	72.0	-0.7
21	Жижиг, дунд үйлдвэрийн газар	-	71.8	-
22	Үндэсний геологийн алба	-	71.2	-
23	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	57.8	70.7	↑ 12.9
24	Нийгмийн даатгалын ерөнхий газар	75.5	70.3	-5.2
25	Ашигт малтмал, газрын тосны газар	65.6	70.2	↑ 4.6
26	Татварын ерөнхий газар	62.3	69.9	↑ 7.6
27	Гаалийн ерөнхий газар	50.2	69.6	↑ 19.4
28	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	82.7	69.6	-13.1
29	Усны газар	-	67.7	-
30	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	70.5	65.2	-5.3
31	Онцгой байдлын ерөнхий газар	77.0	61.9	-15.1
32	Иргэний нисэхийн ерөнхий газар	58.7	59.5	↑ 0.8

Судалгаанд хамрагдсан 22 аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ-ний дундаж үнэлгээ 1.2 пунктээр буурсан байлаа. Эдгээр 22 ЗДТГ-аас 8 ЗДТГ-ын үнэлгээ өмнөх үеэс сайжирсан байна.


Хүснэгт 16. ЗДТГ - уудын БОУ, 2019, 2021 оныг харьцуулсан байдлаар

№	Байгууллагын нэр	2019	2021	Өөрчлөлт
ЗДТГ-дын БОУ		67.1	65.9	↓ -1.2
1	Хэнтий аймгийн ЗДТГ	72.1	79.6	↑ 7.5
2	Өвөрхангай аймгийн ЗДТГ	67.9	79.0	↑ 11.1
3	Дорнод аймгийн ЗДТГ	72.7	76.5	↑ 3.8
4	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	74.3	75.1	↑ 0.8

№	Байгууллагын нэр	2019	2021	Өөрчлөлт
5	Төв аймгийн ЗДТГ	73.1	71.9	-1.2
6	Орхон аймгийн ЗДТГ	68.5	70.2	1.7
7	Дархан-Уул аймгийн ЗДТГ	76.4	69.6	-6.8
8	Говь-Алтай аймгийн ЗДТГ	53.6	68.8	↑ 15.2
9	Нийслэлийн ЗДТГ	77.1	68.6	-8.5
10	Завхан аймгийн ЗДТГ	80.2	67.7	-12.5
11	Увс аймгийн ЗДТГ	67.7	67.4	-0.3
12	Өмнөговь аймгийн ЗДТГ	56.0	65.5	↑ 9.5
13	Дундговь аймгийн ЗДТГ	57.5	63.8	↑ 6.3
14	Сүхбаатар аймгийн ЗДТГ	64.0	63.2	-0.8
15	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	61.4	61.9	↑ 0.5
16	Баянхонгор аймгийн ЗДТГ	68.0	61.8	-6.2
17	Дорноговь аймгийн ЗДТГ	69.1	60.8	-8.3
18	Архангай аймгийн ЗДТГ	62.0	60.0	-2.0
19	Булган аймгийн ЗДТГ	65.5	59.9	-5.6
20	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	58.7	54.5	-4.2
21	Хөвсгөл аймгийн ЗДТГ	68.9	53.7	-15.2
22	Ховд аймгийн ЗДТГ	61.1	50.6	-10.5


БОУ-ний судалгаанд оролцогчид авлигыг хянах механизмд өгч буй үнэлгээ хамгийн бага буюу 50.2 байв. Энэ нь 2019 онтой харьцуулахад 0.7 пунктээр буурсан үр дүн юм. Үүнийг сайжруулахын тулд төрийн байгууллагууд дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцох, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалах, шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх зэрэг чиглэлд ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

График 20. БОУ, оноор, дэд үзүүлэлтээр



БОУ-ний судалгаанд оролцогчид аймаг, нийслэлийн ЗДТГ-т авлигын бодит тохиолдол хамгийн их байдаг, үүнийг дагаад удирдлагын авлигатай тэмцэх хүсэл, эрмэлзэл бага, хянах механизм нь яам, агентлагуудтай харьцуулахад тааруу гэж үзсэн байна.

График 21. БОУ, байгууллагын төрлөөр, дэд үзүүлэлтээр, 2021 он




3.5 Монгол Улс дахь авлига

Монгол Улс дахь авлигын өнөөгийн нөхцөл байдал, ирэх 2 жилийн авлигын талаарх төсөөлөл, авлига хамгийн их тархсан институц, авлигын шалтгаан зэргийг хамруулан үр дүнг энэ дэд бүлэгт багтаалаа.

3.5.1 Монгол Улс дахь авлигын өнөөгийн нөхцөл байдал


Монгол Улсын авлигын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлохдоо судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хэр түгээмэл байна вэ? гэсэн асуултаар тодруулсан ба хариултуудын хувьд ихээхэн түгээмэл, түгээмэл, дунд зэрэг, бага, огт байхгүй, мэдэхгүй гэсэн хариултуудын үр дүнг авч дараах байдлаар нэгтгэсэн. Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь буюу 45.1 хувь нь Монгол Улсад авлига түгээмэл байдаг хэмээн хариулжээ. Энэхүү үр дүнг 2016 онтой харьцуулахад 6.1 пунктээр, 2019 онтой харьцуулахад 3.3 пунктээр тус тус буурчээ. Ийнхүү буурсан нь авлигын өнөөгийн нөхцөл байдлын талаар хэлж мэдэхгүй байна гэж үзэх иргэдийн хувь нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Харин ихээхэн түгээмэл байдаг хэмээн хариулсан хариултын хувь 2021 онд 20.9, 2019 онд 23.0 хувийг эзэлж байв. Ерөнхийдөө судалгаанд хамрагдсан 10 оролцогч тутмын 7 нь Монгол Улсад авлига түгээмэл байдаг гэдэгтэй санал нэгдэж байсан. Энэхүү үр дүн 2016 оноос хойш төдийлөн өөрчлөгдөөгүй байлаа.

График 22. Монгол Улсын авлигын өнөөгийн байдал, оноор



Бодлогод оролцогчид, албан хаагчид, иргэд, ААНБ-ын төлөөллийн 10 оролцогч тутмын 5 нь Монгол Улсад авлига түгээмэл байдаг гэж үзсэн байна.

График 23. Монгол Улсын авлигын өнөөгийн байдал, оролцогч талуудын үнэлгээгээр, 2021 он




3.5.2 Ирэх 2 жилд Монгол Улс дахь авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх талаарх төсөөлөл

Монгол Улсын ирэх 2 жилийн авлигын нөхцөл байдлыг тодорхойлохдоо судалгаанд оролцогчдоос ирэх 2 жилд Монгол Улс дахь авлигын түвшин хэр өөрчлөгдөх вэ? гэсэн асуултаар тодруулсан ба хариултуудын хувьд их өснө, өснө, өөрчлөгдөхгүй, буурна, их буурна, мэдэхгүй гэсэн хариултуудын үр дүнг авч нэгтгэсэн.


Судалгаанд оролцсон 10 хүн тутмын 3 нь ирэх 2 жилийн хугацаанд Монгол Улсад авлигын нөхцөл байдал өөрчлөгдөхгүй хэмээсэн бол, 2 нь буурна, 2 нь өснө гэж үзсэн байна.

График 24. Монгол Улсын авлигын нөхцөл байдлын талаарх ирэх 2 жилийн төсөөлөл, оноор



Иргэд, ААНБ-ын төлөөллийн 19.8 хувь нь ирэх 2 жил авлигын нөхцөл байдал өснө гэсэн байгаа нь албан хаагчид болон бодлогод оролцогчдын төлөөллөөс харьцангуй их байна. Үр дүнгээс дүгнэхэд ирэх жилүүдэд Монгол Улс дахь авлигын түвшин буурна гэдэгт иргэд, ААНБ-ын төлөөллүүд итгэлгүй байна.

График 25. Монгол Улсын авлигын нөхцөл байдлын талаарх ирэх 2 жилийн төсөөлөл, оролцогчдын төрлөөр, 2021 он



3.5.3 Авлига хамгийн их тархсан институц

Судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хамгийн их тархсан институц аль нь болохыг тодруулахад дийлэнх нь “Эрүүл мэндийн байгууллага” гэж хариулсан бөгөөд өмнөх үнэлгээтэй харьцуулахад 5.7 пунктээр нэмэгдэж нэгт эрэмбэлэгджээ. “Шүүхийн байгууллага” өмнөх үнэлгээтэй харьцуулахад 5.3 пунктээр буурсан хэдий ч хоёрдугаарт эрэмбэлэгдсэн байна. Үүний дараа “Газрын алба”, “Гаалийн байгууллага”, “Цагдаагийн байгууллага” эрэмбэлэгдсэн байв. ШБҮ-ний 2016 оноос хойших судалгаануудын үр дүнг харьцуулахад Шүүх, Газрын алба, Эрүүл мэндийн байгууллага нь авлига хамгийн их тархсан институцын эрэмбээр эхний 3 байрт эрэмбэлэгдэж байгаагаас үзэхэд эдгээр байгууллагуудад тархсан авлигыг бууруулах, таслан зогсоох тал дээр нэн тэргүүнд анхаарал хандуулж ажиллах хэрэгцээ, шаардлага байна.

Хүснэгт 17. Монгол Улсад авлига их тархсан институц, оноор

№	Төрөл	2016	2018	2019	2021
1	Эрүүл мэндийн байгууллага	44.7%	46.4%	42.6%	48.3%
2	Шүүх	38.6%	49.2%	53.3%	48.0%
3	Газрын алба	46.4%	47.0%	42.9%	41.8%
4	Гаалийн байгууллага	37.7%	35.4%	48.0%	36.9%
5	Цагдаагийн байгууллага	30.9%	38.2%	33.9%	35.3%
6	Мэргэжлийн хяналтын байгууллага	32.2%	33.9%	44.6%	33.4%
7	Боловсролын байгууллага	30.5%	41.0%	32.9%	32.7%
8	Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг	33.0%	43.9%	35.0%	31.7%
9	Улс төрийн нам	31.5%	35.8%	33.7%	30.5%
10	Прокурорын байгууллага	22.3%	29.9%	33.2%	29.8%
11	Татварын байгууллага	24.0%	25.2%	26.7%	26.5%

№	Төрөл	2016	2018	2019	2021
12	Нутгийн захиргааны байгууллага	18.1%	25.8%	19.6%	22.2%
13	Хэвлэл мэдээллийн байгууллага	12.0%	15.9%	19.5%	16.1%
14	Төрийн бус байгууллага	6.5%	10.8%	6.6%	11.6%
15	Хувийн хэвшил	7.0%	10.4%	6.5%	10.5%
16	Мэдэхгүй	-	-	-	5.5%
17	Байхгүй	-	-	-	0.5%
18	Бусад	5.4%	3.3%	-	0.1%

Монгол Улсад авлига хамгийн их тархсан институцын үнэлгээ судалгаанд оролцогчдын төрлөөр ялгаатай эсэхийг тодруулж дараах графикт дүнг харууллаа. Үр дүнгээс үзэхэд иргэдийн төлөөлөл эрүүл мэндийн байгууллагыг хамгийн их авлига тархсан институц гэж үзсэн байна. Харин албан хаагчид болон бодлогод оролцогчид шүүхийн байгууллагыг нэгдүгээрт эрэмбэлсэн байв. Энэхүү үр дүн нь судалгаанд оролцогчдын төрөл тус бүрийн өдөр тутамд тулгамдаж буй асуудлаас шалтгаалсан хэмээн таамаглаж байна. Тухайлбал: иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг авах хэрэгцээ зайлшгүй тулгардаг. Харин эрүүл мэндийн байгууллагуудын хүртээмжгүй байдал нь иргэдийн бухимдлыг ихээхэн төрүүлдэг билээ. 2019 оны ШБҮ-ийн судалгаатай харьцуулахад иргэдийн хандлага өөрчлөгдөөгүй байгаа нь энэ салбарт өөрчлөлт, шинэчлэлт зайлшгүй хэрэгцээтэй байгааг илэрхийлж байна.

Хүснэгт 18. Монгол Улсад авлига их тархсан институц, байгууллагын төрлөөр

№	Төрөл	Бодлогод оролцогчид	Албан хаагчид	Иргэд/ААНБ-ын төлөөлөл
1	Эрүүл мэндийн байгууллага	43.1%	41.7%	50.2%
2	Шүүх	49.1%	51.0%	47.3%
3	Газрын алба	46.9%	47.0%	40.2%
4	Гаалийн байгууллага	37.2%	48.1%	34.5%
5	Цагдаагийн байгууллага	32.2%	28.4%	37.1%
6	Мэргэжлийн хяналтын байгууллага	33.1%	42.8%	31.5%
7	Боловсролын байгууллага	31.2%	27.2%	34.1%
8	Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг	36.3%	26.1%	32.3%
9	Улс төрийн нам	29.3%	32.6%	30.2%
10	Прокурорын байгууллага	26.6%	30.9%	29.9%
11	Татварын байгууллага	24.1%	26.9%	26.6%
12	Нутгийн захиргааны байгууллага	20.8%	20.1%	22.8%
13	Хэвлэл мэдээллийн байгууллага	15.3%	17.1%	15.9%
14	Төрийн бус байгууллага	7.6%	6.2%	13.2%
15	Хувийн хэвшил	7.0%	5.5%	11.9%
16	Мэдэхгүй	5.6%	6.6%	5.3%
17	Байхгүй	1.0%	0.2%	0.4%
18	Бусад	0.6%	0.1%	0.0%

3.5.4 Монгол Улс дахь авлигын шалтгаан

Судалгаанд оролцогчдоос Монгол Улсын авлигын шалтгааныг тодруулахад хамгийн их хувь нь буюу 11.7 хувь нь цалин орлого бага байдаг хэмээн хариулсан байлаа. Энэхүү үр дүнг оролцогчдын төрлөөр харьцуулахад иргэн, ААНБ-ын төлөөлөл болон бодлогод оролцогчдын хувьд төдийлөн ялгаагүй байв. Харин албан хаагчдын 13.0 хувь нь Монгол Улсын авлигын шалтгаан, нөхцөлийг цалин, орлого бага байгаагаас хамаарч байна хэмээн хариулсан байгаа нь дундаж хариултын хувиас 1.3 пунктээр, иргэд, ААНБ-ын

төлөөллийн хариултын хувиас 1.6 пунктээр, бодлогод оролцогчдын хариултын хувиас 1.4 пунктээр тус тус илүү байсан.

Иргэн, ААНБ-ын төлөөллийн хувьд албан хаагчдын ёс зүйгүй байдал, хүнд суртал, үйлчлүүлэгчдийн ажлаа хурдан шуурхай, амжилттай бүтээх хүсэл, авлига авсан болон өгсөн хүнд хариуцлага тооцдоггүй тогтолцоо зэрэг нь Монгол Улсын авлигын шалтгаан, нөхцөл болж байна хэмээн үзэж буй нь түлхүү ажиглагдаж байв.

Бодлогод оролцогчдын хувьд ядуурал, эдийн засгийн тогтворгүй байдал, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашигладаг байдал, хуулийн хэрэгжилт, зохицуулалт сул, улс төр, намын нөлөө их, иргэдийн авлигын талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг, ил тод бус байдал, ажилгүйдэл болон ажлын байрны хомсдол зэрэг нь Монгол Улсын авлигын шалтгаан, нөхцөл хэмээн хариулсан хувьд бусад оролцогчдын хариулт болон дунджаас дээгүүр байна.


Харин 10 оролцогч тутмын 2 нь энэ талаар хэлж мэдэхүй байна гэж хариулсан байв.

Хүснэгт 19. Монгол Улс дахь авлигын үндсэн шалтгаан

№	Төрөл	Нэгдсэн дүн	Иргэд/ААНБ-ын төлөөлөл	Албан хаагчид	Бодлогод оролцогчид
1	Цалин, орлого бага	11.7%	11.4%	13.0%	11.6%
2	Хувь хүний ёс зүйгүй, хэм хэмжээгүй байдал	9.8%	10.2%	9.2%	7.2%
3	Ядуурал, Эдийн засгийн тогтворгүй байдал	6.5%	6.0%	7.5%	8.5%
4	Хүнд суртал	6.5%	6.7%	6.5%	5.3%
5	Албан тушаал, Эрх мэдлээ урвуулан ашигладаг байдал	6.3%	6.3%	6.1%	6.4%
6	Хуулийн хэрэгжилт, зохицуулалт сул	5.4%	4.9%	6.7%	7.3%
7	Ажлаа хурдан шуурхай, амжилттай бүтээх	4.4%	4.8%	2.9%	4.4%
8	Танил талын хүрээг ашиглан асуудлаа шийддэг байдал	3.9%	4.2%	2.6%	4.5%
9	Улс төр, намын нөлөө	3.8%	3.4%	4.5%	5.6%
10	Авлига авсан, өгсөн хүнд хариуцлага тооцдоггүй	3.4%	3.6%	3.2%	2.5%
11	Хялбар аргаар ашиг хонжоо олох хүсэл	3.2%	3.3%	2.9%	2.8%
12	Төрийн үйлчилгээ удаан, цаг хугацаа их шаарддаг	3.2%	2.8%	5.0%	2.7%
13	Иргэдийн авлигын мэдлэг, мэдээлэл дутмаг	2.5%	2.3%	2.3%	4.0%
14	Төрийн буруу тогтолцоо	2.2%	2.1%	2.1%	2.8%
15	Ил тод бус байдал	2.1%	1.5%	3.5%	4.2%
16	Ажилгүйдэл болон ажлын байрны хомсдол	1.9%	1.9%	1.4%	2.4%
17	Хээл хахууль өгч, авч сурсан байдал	1.5%	1.5%	0.8%	2.1%
18	Монголын нийгмийн өнөөгийн байдал	1.3%	1.1%	1.2%	2.4%
19	Төрийн албан хаагчийн боловсрол мэдлэг ур чадвар дутмаг	0.9%	0.6%	1.4%	2.7%
20	Хэлж мэдэхгүй байна	19.7%	21.4%	17.2%	10.8%

Авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд хийх шаардлагатай ажлуудад ил тод байх, цалин хөлс нэмэгдүүлэх, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, албан хаагчийн ёс зүйг сайжруулах, хуулийн хэрэгжилт, зохицуулалтыг сайжруулах зэрэг ажлыг хамгийн түрүүнд хийх шаардлагатай байна гэж үзжээ.

График 26. Авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд хийх шаардлагатай ажлууд




3.6 Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр дүн

Судалгаанд оролцогчдоор АТГ-ын үйл ажиллагааг үнэлүүлж үр дүнг 2019 онтой харьцуулахад үйл ажиллагаа нь үр ашигтай хэмээн үзсэн оролцогчдын үнэлгээ 28.6 пунктээр буурсан байна. Тодруулбал үйл ажиллагааг ихээхэн үр ашигтай гэж хариулсан хариултын хувь өмнөх оноос 1.9 пунктээр, үр ашигтай гэсэн нь 21.8 пунктээр, дунд зэрэг гэсэн нь 4.9 пунктээр тус тус буурчээ. Энэ нь АТГ-ын хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар болон авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гэмт хэргийн бүртгэл, шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл олон нийтэд төдийлөн нээлттэй биш байгааг

илэрхийлж байна. Иймд цаашид үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээ, мэдээлэл тогтмол хүргэж байх нь чухал юм.


График 27. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үнэлгээ, оноор



Дээрх үр дүнг үнэлгээнд оролцогчдын төрлөөр ангилан харвал бодлогод оролцогчдын үр ашигтай гэж үзсэн хувь хамгийн өндөр байна. Харин иргэдийн ихээхэн үр ашигтай гэж хариулсан хувь бусад төрөлтэй харьцуулахад бага зэрэг их байв. Албан хаагчдын тухайд энэ асуултад хэлж мэдэхгүй байна гэсэн хариултыг өгсөн хувь хамгийн өндөр байна.

АТГ-ын үйл ажиллагааг үр ашиггүй болон огт үр ашиггүй хэмээн хариулсан хариултын хувь иргэд, ААНБ-ын төлөөллийн хувьд хамгийн их байгааг дараах графикаас харах боломжтой.

График 28. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үнэлгээ, оролцогчдын төрлөөр



ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Төрийн байгууллагыг авлигаас ангид байлгах, урьдчилан сэргийлэх, авлига үүсэх шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны нэг хэлбэр нь ШБҮ-ний судалгаа юм. Судалгааны үр дүнд үндэслэн авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тэдгээрийг арилгахад чиглэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй бөгөөд дараах дүгнэлтэд хүрч байна.

- ✓ 2021 оны ШБҮ-ээр 100 онооноос дунджаар 72.9 оноо авсан нь өмнөх оноос 1.2 пунктээр буурсан байна. ШБҮ ийнхүү буурахад төрийн байгууллагаас үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж байгууллагын өгсөн үнэлгээ 4.7 пунктээр буурсан нь ихээхэн нөлөөлсөн байна.
- ✓ Үйлчлүүлэгч иргэд ААНБ-ын төлөөлөл яамдыг, албан хаагчид болон бодлогод оролцогчид агентлагуудыг хамгийн өндөр үнэлгээгээр үнэлсэн байна.
- ✓ ГШБҮ буюу төрийн байгууллагаар үйлчлүүлэгч, иргэдийн үнэлгээнээс харахад байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлагатай байдалд анхаарч ажиллах шаардлагатай байна.
- ✓ Түүнчлэн ГШБҮ-г буурахад нөлөөлсөн өөр нэгэн үзүүлэлт болох авлигын индексийн дэд үзүүлэлтүүд болох авлигын шууд болон шууд бус тохиолдол нэмэгдсэн байгаа нь цаашид төрийн үйлчилгээг хүргэхдээ үйлчлүүлэгчдээс нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах зэрэг үйлдлийг таслан зогсоох шаардлагатай байна.
- ✓ ДШБҮ өмнөх онтой харьцуулахад 0.4 пунктээр, ШБҮ-ний дундажтай харьцуулахад 8.3 пунктээр өссөн байгаагаас харахад албан хаагчид байгууллагынхаа шударга байдлыг хамгийн өндрөөр үнэлдэг хандлага хадгалагдаж ирсэн байлаа.
- ✓ ДШБҮ-г тооцоход ашигласан үзүүлэлт болох Соёлын индекс 73.3 гарсан нь 2019 онтой харьцуулахад 0.8 пунктээр өссөн байв. Энэхүү үр дүн нь ДШБҮ-ийн дундаж үнэлгээнээс 8.8 пунктээр бага байгаа нь албан хаагчдын хэм хэмжээг хэтрүүлэн ашиглах тохиолдол нэлээдгүй байдаг болон тухайн байгууллагад авлигын эсрэг тогтолцоо хангалттай бүрдээгүй зэргээс шалтгаалж байсан тул цаашид төрийн байгууллагууд энэ чиглэлд дотоод үйл ажиллагаагаа сайжруулах шаардлагатай.
- ✓ ДШБҮ-г тооцоход ашигласан үзүүлэлт болох төсвийн зарцуулалтыг зарим тохиолдолд яагаад зориулалтын бусаар ашигладаг болохыг тодруулахад удирдлагын шийдвэрээр гэж хариулсан албан хаагчдын хувь 2019 онтой харьцуулахад 5.8 пунктээр буурсан боловч төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах явдал нь удирдлагын шийдвэртэй шууд хамааралтай байдаг нь хэвээр хадгалагдсаар байгаа нь бодлого боловсруулагчдын хувьд анхаарал хандуулж хяналтын механизмыг сайтар ажиллуулах хэрэгцээ байна.
- ✓ БОҮ-ний судалгаанд оролцогчид төрийн байгууллагуудын авлигыг хянах механизм тааруу байна хэмээн үнэлсэн байгаагаас үзэхэд цаашид дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлэх, хариуцлага тооцох, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалах, шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх зэрэг чиглэлд ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

- ✓ Судалгаанд хамрагдсан 10 оролцогч тутмын 7 нь Монгол Улсад авлига түгээмэл байдаг гэдэгтэй санал нэгдэж байсан ба ирэх жилүүдэд Монгол Улс дахь авлигын түвшин буурна гэдэгт иргэд, ААНБ-ын төлөөллүүд итгэлгүй байна.
- ✓ Судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хамгийн их тархсан институц аль нь болохыг тодруулахад “Эрүүл мэндийн байгууллага” өмнөх үнэлгээтэй харьцуулахад 5.7 пунктээр нэмэгдэж нэгт эрэмбэлэгджээ. “Шүүхийн байгууллага” өмнөх үнэлгээтэй харьцуулахад 5.3 пунктээр буурсан хэдий ч хоёрдугаарт эрэмбэлэгдсэн байна. Үүний дараа “Газрын алба”, “Гаалийн байгууллага”, “Цагдаагийн байгууллага” эрэмбэлэгдсэн байв. Энэхүү үр дүнг 2018 онтой мөн харьцуулахад Шүүх, Газрын алба, Эрүүл мэндийн байгууллага 3 онд дараалан эхний 5-д эрэмбэлэгдсэн тул эдгээр байгууллагуудад тархсан авлигыг бууруулах, таслан зогсоох тал дээр нэн тэргүүнд анхаарал хандуулж ажиллах хэрэгцээ, шаардлага байна.
- ✓ Албан хаагчдын 13.0 хувь нь Монгол Улсын авлигын шалтгаан, нөхцөлийг цалин, орлого бага байгаагаас хамаарч байна хэмээн үзэж байна. Иргэд, ААНБ-ын төлөөллийн хувьд албан хаагчдын ёс зүйгүй байдал, хүнд суртал, үйлчлүүлэгчдийн ажлаа хурдан шуурхай, амжилттай бүтээх хүсэл, авлига авсан болон өгсөн хүнд хариуцлага тооцдоггүй тогтолцоо зэрэг нь Монгол Улсын авлигын шалтгаан, нөхцөл болж байна хэмээн үзэж буй нь түлхүү ажиглагдаж байв. Харин бодлогод оролцогчдын хувь ядуурал, эдийн засгийн тогтворгүй байдал, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашигладаг байдал, хуулийн хэрэгжилт, зохицуулалт сул, улс төр, намын нөлөө их, иргэдийн авлигын талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг, ил тод бус байдал, ажилгүйдэл болон ажлын байрны хомсдол зэрэг нь Монгол Улсын авлигын шалтгаан, нөхцөл хэмээн үзсэн байна.
- ✓ АТГ-ын үйл ажиллагааг ихээхэн үр ашигтай гэж хариулсан хариултын хувь өмнөх оноос 1.9 пунктээр, үр ашигтай гэсэн нь 21.8 пунктээр, дунд зэрэг гэсэн нь 4.9 пунктээр тус тус буурчээ. Энэ нь АТГ-ын хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар болон авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гэмт хэргийн бүртгэл, шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл олон нийтэд төдийлөн нээлттэй биш байгааг илэрхийлж байна. Иймд цаашид үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээ, мэдээлэл тогтмол хүргэж байх нь чухал юм.

“ХАВСРАЛТ -1” - ҮНЭЛГЭЭГ ТООЦОХ АРГА

- A.** Шударга байдлын үнэлгээний үр дүнг байгууллага бүрийн болон улсын дүнгээр гаргана.
- B.** Шударга байдлын үнэлгээг 0-100 хүртэл оноогоор гаргах бөгөөд үнэлгээний утга 100-тай тэнцүү бол хамгийн шударгыг илэрхийлнэ.
- C.** Шударга байдлын үнэлгээ болон түүнийг бүрдүүлэгч үнэлгээний үзүүлэлтүүдийг дараах байдлаар тооцно.

Гадаад шударга байдлын үнэлгээ

$$E_i = (A_i + B_i + C_i) / 3$$

E_i – i байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ

A_i – Авлигын индексийн оноо

B_i – Ил тод байдлын индексийн оноо

C_i – Хариуцлагатай байдлын оноо

Дотоод шударга байдлын үнэлгээ

$$I_i = (A_i + B_i) / 2$$

I_i – i байгууллагын дотоод шударга байдлын үнэлгээ

A_i – Соёлын индексийн оноо

B_i – Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын оноо

Бодлогод оролцогчдын үнэлгээ

$$P_i = (A_i + B_i + C_i) / 3$$

P_i – Байгууллагын бодлогод оролцогчдын үнэлгээ

A_i – Авлигын талаарх төсөөллийн оноо

B_i – Авлигын хяналтын оноо

C_i – Авлигын бодит тохиолдлын оноо

Авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээ

$K_i =$ Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээ, (АТГ-ын даргын 2015 он 09 дүгээр сарын 1-ний өдрийн А/88 дугаар тушаалын дагуу тооцно)

Байгууллагын ерөнхий үнэлгээг тооцох томьёо

$$J_i = (E_i + I_i + P_i + K_i) / 4$$

J_i - Байгууллагын шударга байдлын үнэлгээ

- D.** Хариулагчийн хувийн үнэлгээгээр тооцох

Шударга байдлын үнэлгээний судалгаанд ашиглагдаж буй асуулт бүрийг үнэлгээнд үзүүлэлт болгон хамруулах бөгөөд үзүүлэлтийг хариулагчийн хувийн үнэлгээнд үндэслэн оноожуулах эсхүл байгууллагын үнэлгээнд үндэслэн оноожуулах гэсэн 2 аргын аль тохирохыг ашиглана.

1-5 хүртэл хэмжээс бүхий хариултыг шилжүүлэх

1-5 хүртэл хэмжээс бүхий хариултыг шударга байдлын үнэлгээний 0-100 хүртэлх хэмжээст шилжүүлэхдээ дараах загварыг баримтална. Тухайн хариулт эерэг утгатай бол 100 оноог, сөрөг утгатай бол 0 оноог өгөх зарчмыг баримтална.

Хүснэгт 20. Хэмжээст утгад шилжүүлэх загвар

Хариулт	5 оноо	Шилжүүлэх оноо
Ихээхэн түгээмэл	1	0 эсвэл 100 оноо
Түгээмэл	2	25 эсвэл 75 оноо
Дунд зэрэг	3	50
Бага зэрэг	4	75 эсвэл 25 оноо
Огт байхгүй	5	100 эсвэл 0 оноо

Үзүүлэлтийн дундаж оноог тооцох

Тухайн байгууллагын судалгаанд оролцсон хүмүүсийн хариулсан онооны байдалд нь үндэслэн байгууллагын дундаж оноог тооцоход дараах томъёог ашиглана.

$$\text{Үзүүлэлтүүдийн дундаж оноо} = \frac{\text{Тухайн үзүүлэлтийн нийт онооны нийлбэр}}{\text{Тухайн судалгаанд хамрагдсан нийт хүний тоо}}$$

E. Байгууллагын үнэлгээгээр тооцох

Хариулагчийн хувийн үнэлгээгээр тооцох боломжгүй, давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтийн үнэлгээг гаргахдаа бусад байгууллагатай харьцуулах замаар буюу байгууллагын ерөнхий үнэлгээгээр тооцно.

Давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтүүдийг оноожуулах

Байгууллага бүрийн давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтүүдийг оноожуулахад тухайн хариултын интервалыг нэг үнэлгээнд шилжүүлэх шаардлагатай ба дараах байдлаар шилжүүлнэ.

Хүснэгт 21. Давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтүүдийг оноожуулах

Төрөл	Давтамж болон үнийн дүн			
Дотоод шударга байдал	Албан тушаал ахих, дэмжлэг авах, өөр ажилд шилжих, дүр үнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө, бусад үнэ бүхий эд зүйлс өгсөн тохиолдлын давтамжийг оноожуулах 1удаа=1 2удаа=2 3удаа=3 4-5удаа=4.5 6-10удаа=8 11 ба түүнээс дээш удаа=11	Албан тушаал ахих, дэмжлэг авах, өөр ажилд шилжих, дүр үнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө, бусад үнэ бүхий эд зүйлсийн үнийн дүнг оноожуулах 20000₮=20 21000-50000₮=35 51000-100000₮=77 101000-300000₮=205 301000-500000₮=405 501000-1сая₮=755 1.1-2.0сая₮=1550 2.1-5.0сая₮=3550 5.1-10сая₮=7550 10.1сая₮-өөс дээш=10100	Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах байдлын үнийн дүнг оноожуулах 200,000₮ хүртэл=200 201,000-500,000₮=355 501,000-1 сая₮=775 1.1-3.0 сая₮=2050 3.1-5.0 сая₮=4050 5.1-10.0 сая₮=7550 10.1-20.0сая₮ =15050 20.1-50.0сая₮=35050 50.1-100 сая₮=75050 110.1сая₮-өөс дээш=110100	Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/хууль бус үүрэг даалгавар өгөх явдлын давтамжийг оноожуулах Жилд 1 удаа=1 Жилд 2-3 удаа=2.5 Улиралд 1 удаа=4 Сард 1 удаа=12 Сард 2 удаа= 24 Сард 3 болон түүнээс дээш=48
Гадаад шударга байдал	Албан үүргээ гүйцэтгэснийх нь төлөө нэмэлт төлбөр өгөх, хандив бусад санхүүгийн туслалцаа өгөх байдлыг оноожуулах	Албан үүргээ гүйцэтгэснийх нь төлөө нэмэлт төлбөр өгөх, хандив бусад санхүүгийн туслалцаа өгөх байдлыг оноожуулах 20000₮=20 21000-50000₮=35 51000-100000₮=77 101000-300000₮=205 301000-500000₮=405 501000-1сая₮=755 1.1-2.0сая₮=1550		

Төрөл	Давтамж болон үнийн дүн	
	<p>1 удаа=1 Хоёр удаа=2 Гурван удаа=3 4-5 удаа=4.5 6-7 удаа =6.5 8-9 удаа=8.5 10-аас дээш удаа=10</p>	<p>2.1-5.0сая₮=3550 5.1-10сая₮=7550 10.1сая₮-өөс дээш=10100</p>
Дунджийг тооцох	<p>Тухайн байгууллагын давтамж, үнийн дүнгийн онооны нийлбэрт үндэслэн тухайн байгууллагын судалгаанд хамрагдсан нэг хүнд оногдох давтамж, үнийн дүнгийн онооны дунджийг дараах томъёогоор олно. Нэг хүнд оногдох давтамж, үнийн дүнгийн онооны дундаж = $\frac{\text{Онооны нийлбэр}}{\text{Судалгаанд хамрагдсан нийт хүн}}$</p>	
Оноожуулах	<p>Дунджид үндэслэн бусад байгууллагатай жиших замаар байгууллагын давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтүүдийг оноожуулах бөгөөд дараах томъёогоор олно. $\text{Давтамж үнийн дүн бүхий үзүүлэлтүүдийн оноо} = 100 * (1 - \text{Тухайн байгууллагын давтамж(үнийн дүн)-ийн дундаж/USP})$ USP1= бүх байгууллагын давтамж, үнийн дүнгийн дунджаас тооцсон өсөн нэмэгдэх гамма тархалтын 95%-тай тэнцүү утга буюу тухайн жилд хамгийн өндөр давтамж, үнийн дүн бүхий байгууллагын дундаж</p>	

Ф. Нийт шударга байдлын үнэлгээг тооцох

Судалгаанд хамрагдсан бүх төрийн байгууллагын шударга байдалд үндэслэн тухайн оны шударга байдлын үнэлгээг гаргах бөгөөд дараах томъёог ашиглана.

$$\text{Шударга байдлын үнэлгээ} = \frac{X_1 + X_2 + \dots + X_i + \dots + X_n}{n}$$

X_i – i дугаар байгууллагын шударга байдлын үнэлгээ


n – судалгаанд хамрагдсан байгууллагын тоо

“ХАВСРАЛТ -2” – ТҮҮВРИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ

Но.	Байгууллагын нэр	Иргэн	Албан хаагч	Шинжээч	Бүгд
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	90	30	15	135
2	Барилга, хот байгуулалтын яам	90	20	15	125
3	Батлан хамгаалах яам	90	20	15	125
4	Боловсрол, шинжлэх ухааны яам	90	30	15	135
5	Гадаад харилцааны яам	90	30	15	135
6	Зам, тээврийн хөгжлийн яам	90	30	15	135
7	Сангийн яам	90	30	15	135
8	Соёлын яам	90	20	15	125
9	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	90	20	15	125
10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	90	30	15	135
11	Хууль зүй, дотоод хэргийн яам	90	30	15	135
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	90	30	15	135
13	Эрүүл мэндийн яам	90	30	15	135
14	Эрчим хүчний яам	90	20	15	125
15	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	90	20	10	120
16	Үндэсний хөгжлийн газар	90	20	10	120
17	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	90	20	10	120
18	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	90	30	10	130
19	Онцгой байдлын ерөнхий газар	90	30	10	130
20	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	90	15	10	115
21	Стандарт, хэмжил зүйн газар	90	30	10	130
22	Цаг уур, орчны шинжилгээний газар	90	20	10	120
23	Гаалийн ерөнхий газар	90	20	10	120
24	Татварын ерөнхий газар	90	30	10	130
25	Цагдаагийн ерөнхий газар	90	30	10	130
26	Улсын бүртгэлийн ерөнхий газар	90	30	10	130
27	Архивын ерөнхий газар	90	20	10	120
28	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	90	30	10	130
29	Гадаадын иргэн, харьяатын газар	90	30	10	130
30	Нийгмийн даатгалын ерөнхий газар	90	20	10	120
31	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	90	20	10	120
32	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	90	15	10	115
33	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	90	20	10	120
34	Биеийн тамир, спортын улсын хороо	90	20	10	120
35	Соёл, урлагийн газар	90	10	10	110
36	Иргэний нисэхийн ерөнхий газар	90	30	10	130
37	Ашигт малтмал, газрын тосны газар	90	30	10	130
38	Мал эмнэлгийн ерөнхий газар	90	20	10	120
39	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	90	30	10	130
40	Оюуны өмчийн газар	90	20	10	120
41	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	90	15	10	115
42	Төрийн худалдан авах ажиллагааны газар	90	20	10	120
43	Усны газар	90	15	10	115
44	Үндэсний геологийн алба	90	15	10	115
45	Жижиг, дунд үйлдвэрийн газар	90	15	10	115
46	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	90	20	10	120
47	Архангай аймгийн ЗДТГ	150	20	15	185
48	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	150	20	15	185
49	Баянхонгор аймгийн ЗДТГ	150	20	15	185
50	Булган аймгийн ЗДТГ	150	20	15	185

Но.	Байгууллагын нэр	Иргэн	Албан хаагч	Шинжээч	Бүгд
51	Говь-Алтай аймгийн ЗДТГ	150	20	15	185
52	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	150	20	15	185
53	Дархан-Уул аймгийн ЗДТГ	150	20	15	185
54	Дорноговь аймгийн ЗДТГ	150	20	15	185
55	Дорнод аймгийн ЗДТГ	150	20	15	185
56	Дундговь аймгийн ЗДТГ	150	20	15	185
57	Завхан аймгийн ЗДТГ	150	20	15	185
58	Орхон аймгийн ЗДТГ	150	20	15	185
59	Өвөрхангай аймгийн ЗДТГ	150	20	15	185
60	Өмнөговь аймгийн ЗДТГ	150	20	15	185
61	Сүхбаатар аймгийн ЗДТГ	150	20	15	185
62	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	150	20	15	185
63	Төв аймгийн ЗДТГ	150	20	15	185
64	Увс аймгийн ЗДТГ	150	20	15	185
65	Ховд аймгийн ЗДТГ	150	20	15	185
66	Хөвсгөл аймгийн ЗДТГ	150	20	15	185
67	Хэнтий аймгийн ЗДТГ	150	20	15	185
68	Нийслэлийн ЗДТГ	150	50	15	215
	Нийт	7,440	1,550	860	9,850

“ХАВСРАЛТ -3” – 2021 ОНЫ ҮНЭЛГЭЭ



“ХАВСРАЛТ -4” – ШБҮ, 2019, 2021 ОН

№	Байгууллагын нэр	2019	2021	Өөрчлөлт
Шударга байдлын үнэлгээ		74.1	72.9	-1.2
Яам		73.2	72.8	-0.4
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	71.9	66.1	-5.8
2	Барилга, хот байгуулалтын яам	73.2	73.0	-0.2
3	Батлан хамгаалах яам	80.4	69.5	-10.9
4	Боловсрол, шинжлэх ухааны яам	70.6	72.2	1.6
5	Гадаад харилцааны яам	76.7	73.7	-3.0
6	Зам, тээврийн хөгжлийн яам	70.4	73.6	3.2
7	Сангийн яам	75.5	73.4	-2.1
8	Соёлын яам	-	77.8	-
9	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	70.2	72.4	2.2
10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	70.9	75.6	4.7
11	Хууль зүй, дотоод хэргийн яам	73.6	70.9	-2.7
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	73.5	72.1	-1.4
13	Эрүүл мэндийн яам	71.5	68.2	-3.3
14	Эрчим хүчний яам	73.5	79.9	6.4
Агентлаг		75.2	73.9	-1.3
15	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	73.9	67.9	-6.0
16	Үндэсний хөгжлийн газар	65.7	81.4	15.7
17	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	73.0	79.5	6.5
18	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	72.4	71.5	-0.9
19	Онцгой байдлын ерөнхий газар	81.7	69.4	-12.3
20	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	78.2	79.2	1.0
21	Стандарт, хэмжил зүйн газар	70.3	77.1	6.8
22	Цаг уур, орчны шинжилгээний газар	80.7	74.8	-5.9
23	Гаалийн ерөнхий газар	64.8	68.2	3.4
24	Татварын ерөнхий газар	70.1	70.4	0.3
25	Цагдаагийн ерөнхий газар	74.6	73.4	-1.2
26	Улсын бүртгэлийн ерөнхий газар	78.2	67.3	-10.9
27	Архивын ерөнхий газар	79.2	76.9	-2.3
28	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	78.7	75.7	-3.0
29	Гадаадын иргэн, харьяатын газар	82.3	76.8	-5.5
30	Нийгмийн даатгалын ерөнхий газар	77.8	70.5	-7.3
31	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	75.0	78.3	3.3
32	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	79.3	73.3	-6.0
33	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	75.1	74.3	-0.8
34	Биеийн тамир, спортын улсын хороо	65.0	73.2	8.2
35	Соёл, урлагийн газар	83.7	71.4	-12.3
36	Иргэний нисэхийн ерөнхий газар	66.0	69.7	3.7
37	Ашигт малтмал, газрын тосны газар	73.9	67.7	-6.2
38	Мал эмнэлгийн ерөнхий газар	76.7	67.8	-8.9
39	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	69.5	74.8	5.3
40	Оюуны өмчийн газар	81.6	78.7	-2.9
41	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	82.3	72.2	-10.1
42	Төрийн худалдан авах ажиллагааны газар	-	72.6	-
43	Усны газар	-	77.1	-
44	Үндэсний геологийн алба	-	75.4	-
45	Жижиг, дунд үйлдвэрийн газар	-	79.9	-
46	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	-	79.3	-
ЗДТГ		73.2	71.4	-1.8
47	Архангай аймгийн ЗДТГ	73.1	68.0	-5.1
48	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	67.7	61.8	-5.9
49	Баянхонгор аймгийн ЗДТГ	71.3	68.8	-2.5
50	Булган аймгийн ЗДТГ	75.1	71.5	-3.6
51	Говь-Алтай аймгийн ЗДТГ	68.3	72.4	4.1
52	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	72.0	68.8	-3.2
53	Дархан-Уул аймгийн ЗДТГ	76.6	74.6	-2.0
54	Дорноговь аймгийн ЗДТГ	75.9	68.0	-7.9
55	Дорнод аймгийн ЗДТГ	75.7	71.4	-4.3
56	Дундговь аймгийн ЗДТГ	69.8	72.8	3.0
57	Завхан аймгийн ЗДТГ	81.1	68.2	-12.9
58	Орхон аймгийн ЗДТГ	76.6	76.5	-0.1

№	Байгууллагын нэр	2019	2021	Өөрчлөлт
59	Өвөрхангай аймгийн ЗДТГ	77.2	78.4	1.2
60	Өмнөговь аймгийн ЗДТГ	68.7	68.4	-0.3
61	Сүхбаатар аймгийн ЗДТГ	69.8	72.9	3.1
62	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	77.0	76.3	-0.7
63	Төв аймгийн ЗДТГ	77.3	74.5	-2.8
64	Увс аймгийн ЗДТГ	72.4	77.8	5.4
65	Ховд аймгийн ЗДТГ	66.7	67.3	0.6
66	Хөвсгөл аймгийн ЗДТГ	71.8	59.0	-12.8
67	Хэнтий аймгийн ЗДТГ	75.6	81.1	5.5
68	Нийслэлийн ЗДТГ	71.2	72.0	0.8

“ХАВСРАЛТ -5” – 2021 ОНЫ ГШБҮ

№	Байгууллагын нэр	Ил тод байдал	Хариуцлагатай байдал	Авлигын эрсдэлийн индекс	Авлигын талаарх төсөөлөл	Авлигын шууд тохиолдол	Авлигын шууд бус тохиолдол	Авлигын индекс	ГШБҮ
Гадаад шударга байдлын үнэлгээ		54.4	60.7	57.5	57.8	84.7	87.1	76.5	67.0
Яам		53.4	60.3	56.8	56.5	90.8	88.1	78.5	67.6
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	45.9	50.5	48.2	47.9	86.8	78.9	71.2	59.7
2	Барилга, хот байгуулалтын яам	54.8	58.3	56.6	52.4	94.1	87.0	77.8	67.2
3	Батлан хамгаалах яам	47.3	56.6	51.9	49.7	70.3	85.7	68.6	60.2
4	Боловсрол, шинжлэх ухааны яам	51.1	64.6	57.8	63.5	100.0	97.2	86.9	72.4
5	Гадаад харилцааны яам	54.9	61.4	58.1	49.4	95.3	84.2	76.3	67.2
6	Зам, тээврийн хөгжлийн яам	48.6	54.1	51.3	48.3	54.9	79.4	60.9	56.1
7	Сангийн яам	48.8	52.4	50.6	48.1	93.3	85.2	75.5	63.1
8	Соёлын яам	54.3	63.8	59.1	64.2	99.3	100.0	87.8	73.5
9	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	61.8	65.2	63.5	59.4	98.4	93.9	83.9	73.7
10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	48.8	63.2	56.0	67.7	98.6	85.0	83.8	69.9
11	Хууль зүй, дотоод хэргийн яам	54.4	59.8	57.1	60.8	92.7	85.3	79.6	68.3
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	55.1	64.0	59.5	59.8	95.1	96.8	83.9	71.7
13	Эрүүл мэндийн яам	49.8	52.8	51.3	48.3	93.8	80.6	74.2	62.8
14	Эрчим хүчний яам	71.5	77.4	74.4	71.7	98.0	94.2	88.0	81.2
Агентлаг		54.9	60.9	57.9	58.8	80.8	85.6	75.0	66.5
15	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	45.2	53.5	49.4	55.8	92.0	58.5	68.8	59.1
16	Үндэсний хөгжлийн газар	60.8	70.4	65.6	78.5	95.0	90.0	87.9	76.7
17	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	54.7	75.8	65.3	82.5	100.0	100.0	94.2	79.7
18	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	49.0	54.6	51.8	56.3	75.4	87.3	73.0	62.4
19	Онцгой байдлын ерөнхий газар	40.9	57.7	49.3	54.7	79.5	89.2	74.5	61.9
20	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	50.9	60.4	55.6	59.8	92.2	97.8	83.3	69.4
21	Стандарт, хэмжил зүйн газар	60.8	66.0	63.4	71.7	64.8	88.7	75.1	69.2
22	Цаг уур, орчны шинжилгээний газар	56.3	59.3	57.8	53.6	77.4	90.6	73.9	65.8
23	Гаалийн ерөнхий газар	48.5	49.7	49.1	47.6	53.9	68.2	56.6	52.9
24	Татварын ерөнхий газар	50.4	54.2	52.3	50.3	85.6	68.2	68.0	60.1
25	Цагдаагийн ерөнхий газар	42.3	51.5	46.9	51.3	53.1	77.9	60.8	53.8
26	Улсын бүртгэлийн ерөнхий газар	41.8	44.3	43.1	36.8	53.0	59.3	49.7	46.4
27	Архивын ерөнхий газар	58.7	69.1	63.9	66.8	93.1	90.1	83.3	73.6
28	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	49.5	54.3	51.9	52.2	95.0	86.6	77.9	64.9
29	Гадаадын иргэн, харьяатын газар	67.1	67.8	67.4	62.4	87.7	87.5	79.2	73.3
30	Нийгмийн даатгалын ерөнхий газар	40.8	50.4	45.6	44.5	73.0	73.5	63.7	54.6
31	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	64.4	63.7	64.0	57.1	89.0	91.9	79.4	71.7
32	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	49.8	53.5	51.7	45.7	83.8	82.1	70.5	61.1
33	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	51.6	51.8	51.7	46.9	44.0	74.6	55.2	53.4
34	Биеийн тамир, спортын улсын хороо	55.1	62.1	58.6	59.6	86.9	93.2	79.9	69.3
35	Соёл, урлагийн газар	65.1	73.4	69.2	70.8	93.2	95.7	86.5	77.9
36	Иргэний нисэхийн ерөнхий газар	61.0	62.9	61.9	58.6	93.0	90.8	80.8	71.4
37	Ашигт малтмал, газрын тосны газар	52.9	59.0	56.0	58.0	66.1	78.6	67.6	61.8

№	Байгууллагын нэр	Ил тод байдал	Хариуцлагатай байдал	Авлигын эрсдэлийн индекс	Авлигын талаарх төсөөлөл	Авлигын шууд тохиолдол	Авлигын шууд бус тохиолдол	Авлигын индекс	ГШБҮ
38	Мал эмнэлгийн ерөнхий газар	48.3	51.0	49.7	44.2	71.0	89.7	68.3	59.0
39	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	67.3	62.8	65.1	61.4	67.8	83.9	71.0	68.0
40	Оюуны өмчийн газар	61.7	65.0	63.3	67.5	74.9	98.6	80.3	71.8
41	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	65.0	70.5	67.7	67.9	88.3	93.9	83.4	75.6
42	Төрийн худалдан авах ажиллагааны газар	48.0	53.6	50.8	49.6	89.1	75.0	71.2	61.0
43	Усны газар	68.0	76.8	72.4	72.5	89.4	94.5	85.5	79.0
44	Үндэсний геологийн алба	57.7	62.5	60.1	63.0	84.9	90.9	79.6	69.9
45	Жижиг, дунд үйлдвэрийн газар	66.8	75.5	71.2	68.9	100.0	96.1	88.3	79.7
46	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	56.2	65.6	60.9	65.2	92.5	95.2	84.3	72.6
ЗДТГ		54.3	60.6	57.5	57.2	86.4	88.6	77.4	67.4
47	Архангай аймгийн ЗДТГ	53.4	63.0	58.2	56.4	92.7	84.4	77.8	68.0
48	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	50.6	53.9	52.3	53.9	73.5	83.8	70.4	61.3
49	Баянхонгор аймгийн ЗДТГ	45.5	51.8	48.6	49.0	91.7	91.0	77.2	62.9
50	Булган аймгийн ЗДТГ	61.3	66.8	64.1	57.0	98.1	95.3	83.5	73.8
51	Говь-Алтай аймгийн ЗДТГ	50.6	52.8	51.7	57.9	74.3	77.2	69.8	60.7
52	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	50.3	55.9	53.1	55.6	74.3	86.0	71.9	62.5
53	Дархан-Уул аймгийн ЗДТГ	55.0	61.2	58.1	51.9	97.2	93.6	80.9	69.5
54	Дорноговь аймгийн ЗДТГ	55.8	54.1	54.9	51.3	63.1	82.1	65.5	60.2
55	Дорнод аймгийн ЗДТГ	47.3	46.1	46.7	44.2	63.6	67.7	58.5	52.6
56	Дундговь аймгийн ЗДТГ	60.3	64.2	62.3	62.7	92.5	93.1	82.8	72.5
57	Завхан аймгийн ЗДТГ	51.0	57.7	54.4	58.1	85.2	92.5	78.6	66.5
58	Орхон аймгийн ЗДТГ	66.4	75.9	71.2	66.1	99.3	98.4	88.0	79.6
59	Өвөрхангай аймгийн ЗДТГ	57.4	62.2	59.8	59.4	92.9	93.9	82.1	70.9
60	Өмнөговь аймгийн ЗДТГ	39.0	56.0	47.5	48.6	97.9	83.0	76.5	62.0
61	Сүхбаатар аймгийн ЗДТГ	52.8	64.8	58.8	65.5	95.3	96.4	85.7	72.3
62	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	61.9	59.7	60.8	65.0	82.7	96.1	81.2	71.0
63	Төв аймгийн ЗДТГ	57.1	62.7	59.9	62.5	93.3	93.9	83.2	71.6
64	Увс аймгийн ЗДТГ	75.4	81.7	78.6	75.0	95.9	100.0	90.3	84.4
65	Ховд аймгийн ЗДТГ	57.9	57.4	57.6	51.9	93.9	84.9	76.9	67.3
66	Хөвсгөл аймгийн ЗДТГ	34.3	44.2	39.3	38.3	77.0	71.9	62.4	50.8
67	Хэнтий аймгийн ЗДТГ	51.6	75.1	63.4	68.0	89.0	96.4	84.5	73.9
68	Нийслэлийн ЗДТГ	59.3	66.4	62.9	60.1	78.1	87.4	75.2	69.0

“ХАВСРАЛТ -6” – 2021 ОНЫ ДШБҮ

№	Байгууллагын нэр	Албан бус хэм хэмжээ	Авлигын эсрэг тогтолцоо	Соёлын индекс	Хүний нөөц	Төсвийн зарцуулалт	Үүрэг даалгаврын шударга байдал	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	Удирдлагын хүсэл эрмэлзэл	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	ДШБҮ
ДШБҮ		80.4	66.2	73.3	96.1	92.7	87.1	98.9	70.6	89.1	81.2
Яам		78.8	63.7	71.2	96.3	92.6	87.3	99.6	68.4	88.8	80.0
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	72.2	56.4	64.3	96.7	68.3	79.9	100.0	63.7	81.7	73.0
2	Барилга, хот байгуулалтын яам	81.0	65.8	73.4	97.9	97.9	91.9	100.0	74.6	92.5	82.9
3	Батлан хамгаалах яам	85.3	75.9	80.6	99.7	96.9	93.9	100.0	81.9	94.5	87.5
4	Боловсрол, шинжлэх ухааны яам	70.3	49.4	59.8	97.7	96.7	78.7	100.0	57.6	86.1	73.0
5	Гадаад харилцааны яам	79.3	64.3	71.8	94.8	94.5	83.9	98.3	61.9	86.7	79.2
6	Зам, тээврийн хөгжлийн яам	83.4	68.0	75.7	98.1	99.6	89.2	100.0	79.5	93.3	84.5
7	Сангийн яам	85.2	73.4	79.3	99.0	99.5	93.7	100.0	77.4	93.9	86.6
8	Соёлын яам	80.1	65.4	72.7	99.5	97.6	91.2	100.0	68.1	91.3	82.0
9	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	72.1	53.1	62.6	97.5	96.9	79.8	100.0	60.7	87.0	74.8
10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	77.7	63.1	70.4	96.8	93.6	90.0	100.0	61.2	88.3	79.4
11	Хууль зүй, дотоод хэргийн яам	79.4	62.2	70.8	78.9	86.9	85.0	100.0	67.2	83.6	77.2
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	79.0	63.2	71.1	95.1	71.8	84.4	100.0	69.2	84.1	77.6
13	Эрүүл мэндийн яам	74.1	63.0	68.6	97.5	96.4	86.7	96.7	61.3	87.7	78.1
14	Эрчим хүчний яам	83.4	68.8	76.1	99.1	100.0	93.7	100.0	72.7	93.1	84.6
Агентлаг		81.0	68.1	74.5	97.5	93.5	86.9	98.3	70.6	89.4	81.9
15	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	84.0	57.0	70.5	98.5	90.3	85.4	100.0	67.6	88.4	79.4
16	Үндэсний хөгжлийн газар	87.3	83.2	85.2	98.1	99.6	93.9	100.0	79.2	94.2	89.7
17	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	81.5	69.5	75.5	98.8	97.5	92.6	100.0	68.3	91.4	83.5
18	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	80.4	60.3	70.3	98.8	97.5	84.2	100.0	67.6	89.6	80.0
19	Онцгой байдлын ерөнхий газар	85.8	66.6	76.2	98.0	93.8	93.5	100.0	77.4	92.5	84.4
20	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	85.2	78.5	81.8	98.0	98.2	87.0	100.0	79.1	92.5	87.2
21	Стандарт, хэмжил зүйн газар	83.2	74.4	78.8	98.9	96.6	90.1	100.0	74.6	92.0	85.4
22	Цаг уур, орчны шинжилгээний газар	83.5	75.1	79.3	98.6	94.8	90.3	100.0	70.2	90.8	85.0
23	Гаалийн ерөнхий газар	81.1	67.7	74.4	95.4	99.0	90.9	100.0	63.1	89.7	82.0
24	Татварын ерөнхий газар	75.9	69.9	72.9	95.0	94.4	91.3	96.7	69.3	89.3	81.1
25	Цагдаагийн ерөнхий газар	86.4	83.5	84.9	97.8	98.8	90.8	98.3	77.9	92.7	88.8
26	Улсын бүртгэлийн ерөнхий газар	80.0	71.0	75.5	97.5	70.6	85.1	100.0	75.6	85.8	80.6
27	Архивын ерөнхий газар	79.8	74.9	77.3	97.1	96.4	89.6	100.0	74.2	91.5	84.4
28	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	81.5	73.1	77.3	98.5	98.6	93.6	100.0	75.7	93.3	85.3
29	Гадаадын иргэн, харьяатын газар	77.3	67.7	72.5	98.5	96.9	89.8	98.3	69.6	90.6	81.5
30	Нийгмийн даатгалын ерөнхий газар	86.3	75.1	80.7	97.7	96.5	91.2	100.0	75.6	92.2	86.5
31	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	83.5	66.1	74.8	100.0	94.0	85.1	100.0	57.5	87.3	81.1
32	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	77.8	64.1	71.0	97.7	93.8	79.7	100.0	65.9	87.4	79.2
33	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	86.8	74.7	80.8	98.2	98.0	94.1	92.5	70.6	90.7	85.7
34	Биеийн тамир, спортын улсын хороо	77.6	59.1	68.4	98.4	83.0	84.1	100.0	68.2	86.7	77.6
35	Соёл, урлагийн газар	69.4	42.0	55.7	94.4	73.4	49.4	90.0	40.7	69.6	62.6
36	Иргэний нисэхийн ерөнхий газар	75.6	64.9	70.3	91.0	97.3	85.2	96.7	61.8	86.4	78.3
37	Ашигт малтмал, газрын тосны газар	68.7	54.6	61.7	94.0	73.9	81.7	93.3	60.9	80.8	71.2
38	Мал эмнэлгийн ерөнхий газар	72.2	49.6	60.9	97.4	84.3	81.8	95.0	60.7	83.9	72.4
39	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	85.3	71.8	78.5	97.9	98.1	89.5	96.7	82.6	93.0	85.8
40	Оюуны өмчийн газар	87.3	78.4	82.8	93.4	99.0	96.1	95.0	76.4	92.0	87.4
41	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	72.1	53.2	62.7	96.0	84.5	74.1	96.7	49.5	80.2	71.4
42	Төрийн худалдан авах ажиллагааны газар	78.7	58.8	68.8	99.6	100.0	81.4	100.0	67.8	89.8	79.3
43	Усны газар	85.7	68.8	77.2	99.2	99.3	85.8	100.0	74.5	91.7	84.5
44	Үндэсний геологийн алба	82.1	69.0	75.5	98.6	98.1	92.8	100.0	84.3	94.8	85.1
45	Жижиг, дунд үйлдвэрийн газар	83.6	78.1	80.8	100.0	97.9	88.9	100.0	89.4	95.2	88.0
46	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	86.5	77.3	81.9	99.7	97.6	90.7	97.5	82.8	93.7	87.8
ЗДТГ		80.6	65.1	72.8	94.1	91.6	87.3	99.1	72.0	88.8	80.8
47	Архангай аймгийн ЗДТГ	75.2	66.0	70.6	56.7	92.5	85.5	100.0	72.5	81.5	76.0
48	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	74.1	48.3	61.2	92.3	62.9	77.6	95.0	61.9	78.0	69.6

№	Байгууллагын нэр	Албан бус хэм хэмжээ	Авлигын эсрэг тогтолцоо	Соёлын индекс	Хүний нөөц	Төсвийн зарцуулалт	Үүрэг даалгаврын шударга байдал	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	Удирдлагын хүсэл эрмэлзэл	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	ДШБҮ
49	Баянхонгор аймгийн ЗДТГ	82.9	62.4	72.7	97.6	91.2	87.6	100.0	77.5	90.8	81.7
50	Булган аймгийн ЗДТГ	75.6	71.8	73.7	96.5	91.3	83.4	100.0	67.9	87.8	80.8
51	Говь-Алтай аймгийн ЗДТГ	87.9	73.9	80.9	99.7	98.8	93.4	100.0	79.9	94.4	87.6
52	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	83.2	62.9	73.1	99.1	93.3	91.0	100.0	71.1	90.9	82.0
53	Дархан-Уул аймгийн ЗДТГ	83.6	72.0	77.8	92.7	98.2	93.7	100.0	75.0	91.9	84.9
54	Дорноговь аймгийн ЗДТГ	82.4	66.1	74.3	99.1	98.1	88.2	100.0	73.2	91.7	83.0
55	Дорнод аймгийн ЗДТГ	85.4	69.0	77.2	98.8	97.8	94.4	100.0	75.0	93.2	85.2
56	Дундговь аймгийн ЗДТГ	83.6	68.5	76.1	98.8	92.4	85.6	97.5	66.2	88.1	82.1
57	Завхан аймгийн ЗДТГ	70.6	50.8	60.7	82.0	63.6	79.1	100.0	75.6	80.0	70.4
58	Орхон аймгийн ЗДТГ	78.9	63.0	71.0	99.2	96.6	77.8	100.0	69.7	88.7	79.8
59	Өвөрхангай аймгийн ЗДТГ	83.2	73.1	78.1	99.1	98.3	91.9	100.0	72.3	92.3	85.2
60	Өмнөговь аймгийн ЗДТГ	75.0	58.0	66.5	94.3	97.9	88.4	100.0	62.9	88.7	77.6
61	Сүхбаатар аймгийн ЗДТГ	84.6	63.6	74.1	99.6	96.3	91.3	100.0	75.4	92.5	83.3
62	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	83.6	67.8	75.7	83.9	95.0	95.9	100.0	74.4	89.8	82.8
63	Төв аймгийн ЗДТГ	76.6	59.8	68.2	97.8	96.4	88.9	100.0	76.2	91.9	80.0
64	Увс аймгийн ЗДТГ	82.4	72.0	77.2	93.2	82.2	85.2	95.0	74.1	85.9	81.6
65	Ховд аймгийн ЗДТГ	81.5	72.7	77.1	96.2	96.2	81.9	100.0	80.2	90.9	84.0
66	Хөвсгөл аймгийн ЗДТГ	72.5	47.6	60.1	95.5	94.3	82.6	95.0	56.4	84.8	72.4
67	Хэнтий аймгийн ЗДТГ	89.9	78.6	84.3	99.4	100.0	96.0	100.0	81.0	95.3	89.8
68	Нийслэлийн ЗДТГ	79.9	63.7	71.8	97.5	82.7	80.8	98.0	65.5	84.9	78.4

“ХАВСРАЛТ -7” – 2021 ОНЫ БОУ

№	Байгууллагын нэр	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	БОУ
Бодлогод оролцогчдын үнэлгээ		73.2	50.2	95.5	62.6	70.4
Яам		75.1	51.1	96.3	59.8	70.6
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	68.9	40.2	100.0	53.7	65.7
2	Барилга, хот байгуулалтын яам	70.3	55.6	91.7	58.1	68.9
3	Батлан хамгаалах яам	60.1	48.3	84.7	50.0	60.8
4	Боловсрол, шинжлэх ухааны яам	75.2	54.4	92.5	63.5	71.4
5	Гадаад харилцааны яам	82.0	56.7	95.5	64.8	74.7
6	Зам, тээврийн хөгжлийн яам	82.8	61.4	100.0	77.1	80.3
7	Сангийн яам	80.3	50.8	88.5	62.0	70.4
8	Соёлын яам	81.0	63.9	100.0	66.7	77.9
9	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	71.5	48.0	100.0	54.8	68.6
10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	91.1	53.8	100.0	65.2	77.5
11	Хууль зүй, дотоод хэргийн яам	66.7	49.1	100.0	53.4	67.3
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	65.5	44.6	100.0	57.5	66.9
13	Эрүүл мэндийн яам	75.5	34.8	95.5	49.1	63.7
14	Эрчим хүчний яам	80.8	53.5	100.0	61.2	73.9
Агентлаг		77.7	52.5	96.8	66.4	73.4
15	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	69.8	50.4	87.5	52.9	65.2
16	Үндэсний хөгжлийн газар	87.4	54.4	100.0	69.3	77.8
17	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	87.0	41.9	100.0	72.2	75.3
18	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	69.4	54.0	100.0	64.7	72.0
19	Онцгой байдлын ерөнхий газар	65.7	43.1	76.2	62.5	61.9
20	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	82.8	66.7	100.0	75.0	81.1
21	Стандарт, хэмжил зүйн газар	73.2	54.4	100.0	78.6	76.5
22	Цаг уур, орчны шинжилгээний газар	84.6	50.9	100.0	58.7	73.6
23	Гаалийн ерөнхий газар	72.9	54.0	100.0	51.5	69.6
24	Татварын ерөнхий газар	69.4	62.8	92.9	54.3	69.9
25	Цагдаагийн ерөнхий газар	92.1	41.7	100.0	76.6	77.6
26	Улсын бүртгэлийн ерөнхий газар	82.5	57.7	100.0	59.4	74.9
27	Архивын ерөнхий газар	81.1	54.2	88.8	66.7	72.7
28	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	87.9	47.8	100.0	72.2	77.0
29	Гадаадын иргэн, харьяатын газар	81.5	63.7	94.4	62.5	75.5
30	Нийгмийн даатгалын ерөнхий газар	67.7	50.9	100.0	62.5	70.3
31	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	91.2	60.8	100.0	76.3	82.1
32	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	92.4	54.1	100.0	71.8	79.6
33	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	92.4	63.8	100.0	78.8	83.7
34	Биеийн тамир, спортын улсын хороо	67.1	51.1	100.0	73.5	72.9
35	Соёл, урлагийн газар	81.2	52.8	100.0	61.1	73.8
36	Иргэний нисэхийн ерөнхий газар	53.8	49.7	90.0	44.6	59.5
37	Ашигт малтмал, газрын тосны газар	74.5	49.2	100.0	57.1	70.2
38	Мал эмнэлгийн ерөнхий газар	75.3	49.9	100.0	62.8	72.0
39	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	66.5	57.3	92.9	66.1	70.7
40	Оюуны өмчийн газар	78.0	55.2	100.0	74.6	76.9
41	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	64.3	51.7	87.3	75.0	69.6
42	Төрийн худалдан авах ажиллагааны газар	78.3	50.3	100.0	81.9	77.6
43	Усны газар	72.8	45.7	88.9	63.5	67.7
44	Үндэсний геологийн алба	79.1	43.3	100.0	62.3	71.2
45	Жижиг, дунд үйлдвэрийн газар	83.8	43.3	100.0	60.0	71.8
46	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	81.7	52.4	100.0	76.3	77.6
ЗДТГ		65.4	46.4	93.1	58.8	65.9
47	Архангай аймгийн ЗДТГ	56.0	46.6	100.0	37.5	60.0
48	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	48.8	33.7	95.5	40.1	54.5
49	Баянхонгор аймгийн ЗДТГ	45.1	46.4	100.0	55.8	61.8
50	Булган аймгийн ЗДТГ	55.8	45.5	79.8	58.3	59.9

№	Байгууллагын нэр	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	БОУ
51	Говь-Алтай аймгийн ЗДТГ	67.6	47.0	85.9	74.8	68.8
52	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	64.3	41.1	92.3	50.0	61.9
53	Дархан-Уул аймгийн ЗДТГ	71.0	54.0	96.2	57.2	69.6
54	Дорноговь аймгийн ЗДТГ	48.5	47.9	95.8	50.9	60.8
55	Дорнод аймгийн ЗДТГ	76.8	54.4	96.4	78.6	76.5
56	Дундговь аймгийн ЗДТГ	66.1	37.8	100.0	51.1	63.8
57	Завхан аймгийн ЗДТГ	57.2	45.5	100.0	68.1	67.7
58	Орхон аймгийн ЗДТГ	78.2	50.4	91.7	60.4	70.2
59	Өвөрхангай аймгийн ЗДТГ	79.3	66.4	100.0	70.2	79.0
60	Өмнөговь аймгийн ЗДТГ	71.1	38.2	96.2	56.4	65.5
61	Сүхбаатар аймгийн ЗДТГ	61.8	39.7	100.0	51.3	63.2
62	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	84.6	54.9	100.0	60.8	75.1
63	Төв аймгийн ЗДТГ	72.4	51.3	91.3	72.8	71.9
64	Увс аймгийн ЗДТГ	71.4	51.8	83.0	63.4	67.4
65	Ховд аймгийн ЗДТГ	52.4	35.0	66.4	48.8	50.6
66	Хөвсгөл аймгийн ЗДТГ	56.2	25.0	77.3	56.4	53.7
67	Хэнтий аймгийн ЗДТГ	82.7	68.2	100.0	67.5	79.6
68	Нийслэлийн ЗДТГ	71.4	39.9	100.0	63.0	68.6

“ХАВСРАЛТ -8” - БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТАД АШИГЛАСАН АРГА, АРГАЧЛАЛЫН ХУРААНГУЙ

№	Байгууллагын нэр	Иргэн	Албан хаагч	Шинжээч
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	CAPI	CAPI	CAPI
2	Барилга, хот байгуулалтын яам	CATI	CAPI	CATI, Online
3	Батлан хамгаалах яам	CAPI	CAPI	CATI
4	Боловсрол, шинжлэх ухааны яам	CATI	Online	CATI, Online
5	Гадаад харилцааны яам	CAPI	Online	CATI
6	Зам, тээврийн хөгжлийн яам	CAPI	CAPI	CATI
7	Сангийн яам	CAPI	Online	CATI, Online
8	Соёлын яам	CATI	CATI, Online	CATI
9	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	CATI, Online	Online	CATI, Online
10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	CAPI	CAPI	CATI
11	Хууль зүй, дотоод хэргийн яам	CAPI	Online	CATI
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	CAPI	Online	CATI, Online
13	Эрүүл мэндийн яам	CAPI	CATI, Online	CATI, Online
14	Эрчим хүчний яам	CATI, CAPI	Online	CATI, Online
15	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	CAPI	CAPI	CAPI
16	Үндэсний хөгжлийн газар	CATI	CAPI	CAPI
17	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	CAPI	CAPI	CAPI
18	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	CAPI	CAPI	CAPI
19	Онцгой байдлын ерөнхий газар	CAPI	CAPI	CAPI
20	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	CATI	CAPI	CATI
21	Стандарт, хэмжил зүйн газар	CAPI	CAPI	CAPI
22	Цаг уур, орчны шинжилгээний газар	CAPI	CAPI	CAPI
23	Гаалийн ерөнхий газар	CAPI	CAPI	CAPI
24	Татварын ерөнхий газар	CAPI	CAPI	CAPI
25	Цагдаагийн ерөнхий газар	CAPI	CAPI	CAPI
26	Улсын бүртгэлийн ерөнхий газар	CAPI	CAPI	CAPI
27	Архивын ерөнхий газар	CAPI	CAPI	CAPI
28	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	CAPI	Online	CATI, Online
29	Гадаадын иргэн, харьяатын газар	CAPI	CAPI	CAPI
30	Нийгмийн даатгалын ерөнхий газар	CAPI	CAPI	CAPI
31	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	CAPI	CAPI	CAPI
32	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	CAPI	CAPI	CAPI
33	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	CAPI	CAPI	CAPI
34	Биеийн тамир, спортын улсын хороо	CAPI	CAPI	CAPI
35	Соёл, урлагийн газар	CATI	CAPI	CATI, CAPI
36	Иргэний нисэхийн ерөнхий газар	CAPI	CAPI	CAPI
37	Ашигт малтмал, газрын тосны газар	CAPI	CAPI	CAPI
38	Мал эмнэлгийн ерөнхий газар	CAPI	CAPI	CAPI
39	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	CAPI	CAPI	CAPI
40	Оюуны өмчийн газар	CAPI	CAPI	CAPI
41	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	CAPI	CAPI	CAPI
42	Төрийн худалдан авах ажиллагааны газар	CAPI	CAPI	CAPI
43	Усны газар	CAPI	CAPI	CAPI
44	Үндэсний геологийн алба	CAPI	CAPI	CAPI
45	Жижиг, дунд үйлдвэрийн газар	CATI	CAPI	CAPI
46	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	CAPI	CAPI	CAPI
47	Архангай аймгийн ЗДТГ	CAPI	CAPI	CAPI
48	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	CAPI	CAPI	CAPI
49	Баянхонгор аймгийн ЗДТГ	CAPI	CAPI	CAPI
50	Булган аймгийн ЗДТГ	CAPI	CAPI	CAPI
51	Говь-Алтай аймгийн ЗДТГ	CAPI	CAPI	CAPI
52	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	CAPI	CAPI	CAPI
53	Дархан-Уул аймгийн ЗДТГ	CATI	Online	CATI, Online
54	Дорноговь аймгийн ЗДТГ	CAPI	CAPI	CAPI
55	Дорнод аймгийн ЗДТГ	CAPI	CAPI	CAPI
56	Дундговь аймгийн ЗДТГ	CAPI	CAPI	CAPI
57	Завхан аймгийн ЗДТГ	CAPI	CAPI	CAPI
58	Орхон аймгийн ЗДТГ	CAPI	CAPI	CAPI
59	Өвөрхангай аймгийн ЗДТГ	CAPI	CAPI	CAPI
60	Өмнөговь аймгийн ЗДТГ	CAPI	CAPI	CAPI

№	Байгууллагын нэр	Иргэн	Албан хаагч	Шинжээч
61	Сүхбаатар аймгийн ЗДТГ	CAPI	CAPI	CAPI
62	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	CAPI	CAPI	CAPI
63	Төв аймгийн ЗДТГ	CAPI	CAPI	CAPI
64	Увс аймгийн ЗДТГ	CAPI	CAPI	CAPI
65	Ховд аймгийн ЗДТГ	CAPI	CAPI	CAPI
66	Хөвсгөл аймгийн ЗДТГ	CAPI	CAPI	CAPI
67	Хэнтий аймгийн ЗДТГ	CAPI	CAPI	CAPI
68	Нийслэлийн ЗДТГ	CAPI	Online	CATI, Online



АВЛИГАТАЙ
ТЭМЦЭХ
ГАЗАР



ХҮҮХЭНХҮҮГИЙН

АМАРТҮВШИН

ACKSON WINK MMA ACADEMY-ийн тамирчин,
холимог тулааны Монгол Улсын аварга

... **ШУДАРГА СПОРТЫГ**
ХӨГЖҮҮЛЭХ НЬ
МИНИЙ ЗОРИЛГО...



Авлигатай тэмцэх газар
АТГ - Олон Нийтийн Төв



110

Авлигыг
мэдээл



**УЛС ТӨР БОЛОН ШҮҮХ, ХУУЛЬ
ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН
ДЭХ АВЛИГЫН ТӨСӨӨЛЛИЙН
СУДАЛГАА - 2021 ОН**

Удиртгал

Монголчуудын хамгийн сайн мэддэг «Трансперэнси интернэшнл» олон улсын төрийн бус байгууллагаас жил бүр боловсруулдаг улс орны төрийн албан дахь авлигын талаар шинжээч, бизнес эрхлэгчдийн төсөөлөлд үндэслэсэн Авлигын төсөөллийн индексийн 2020 оны дүнгээр Монгол Улс 35 оноо авч 180 улс орноос 111 дүгээр байрт эрэмбэлэгджээ. Энэ нь өмнөх оныхтой ижил боловч 5 байраар ухарсан үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл, авлигын төсөөллийн индексээр дэлхийн улс орныг жагсаасан энэхүү жагсаалтад тухайн улс орны эзэлж буй байр бага зэрэг өөрчлөгдөх нь юуг ч илэрхийлэхгүй, учир нь жил бүр судалгаанд хамрагдах орны тоо өөрчлөгддөг. Гол нь индексийн агуулга хэрхэн өөрчлөгдөж буйд анхаарах нь чухал юм.

Зураг 1. Монгол Улсын авлигын төсөөллийн индексийн дундаж (2008-2020)

2008		2009		2010		2011		2012		2013		2014	
оноо	Эрэмбэ	оноо	Эрэмбэ	оноо	Эрэмбэ	оноо	Эрэмбэ	оноо	Эрэмбэ	оноо	Эрэмбэ	оноо	Эрэмбэ
▲ 31	102/180	▼ 2.7	120/130	▼ 2.7	127/178	▼ 2.7	120/183	▼ 36	94/176 (+2)	■ 38	83/177 (+1)	▲ 39	80/175
2015		2016		2017		Авлигын төсөөллийн индекс	2018		2019		2020		
оноо	Эрэмбэ	оноо	Эрэмбэ	оноо	Эрэмбэ		оноо	Эрэмбэ	оноо	Эрэмбэ	оноо	Эрэмбэ	
▲ 39	72/168 (-1)	■ 38	87/176 (-1)	▼ 36	103/180 (-2)	▲ 37	93/180 (+1)	▼ 35	106/180 (-2)	▼ 35	111/180		

Эх сурвалж: Трансперэнси интернэшнл. <https://www.transparency.org/en/cpi/2020/index/mng>

Дээрх харьцуулсан шинжилгээнээс Монгол Улс сүүлийн 13 жилийн хугацаанд тус байгууллагын авлигын төсөөллийн индексийн дундаж 38-40 оноогоор үнэлэгдэж, улмаар дэлхийн улс орнуудаас 111-115 дугаар байрт эрэмбэлэгдэж ирсэн харагдана. Энэ нь тус судалгаанд оролсон улс орнуудын гуравны хоёр нь 50-иас бага оноо авсан бөгөөд дунджаар 43 оноо буюу «илүү их авлигад автсан» гэсэн утгыг илэрхийлж байна. Үүнээс л, манай улсын авлигын түвшин буурахгүй байгаагийн гол шалтгаан бол улс төрийн авлигын түвшин өссөнтэй холбоотой гэж үзэх үндэслэлтэй. Тус байгууллага ийнхүү авлигын төсөөллийн индексийг тооцохдоо дараах судалгааны байгууллагуудаас гаргадаг тоон үзүүлэлтүүдэд тулгуурлан нэгдсэн индексийг тооцон гаргадаг.

1 Авлигын төсөөллийн индекс нь 0-100 онооны хооронд тодорхойлогд ба 0 оноо нь өндөр авлигатай, 100 оноо нь цэвэр гэсэн утгыг илэрхийлнэ. Дэлгэрэнгүйг <https://www.transparency.org/en/news/cpi-2020-asia-pacific>-ээс үзнэ үү.

2 МХЗ9 төсөл, НҮБХХ, ФСЭХ. Монголын засаглалын үзүүлэлтүүд. Боловсруулсан. Хатанболд О. ред. Цэцэнбилэг Ц., Очирсүх Я. Сансудай ХХК. Уб., 2010. 114 дэх тал.

3 <https://www.transparency.org/en/cpi/2008>; <https://www.transparency.org/en/cpi/2009>; <https://images.transparencycdn.org/images/CPI2011map.pdf>; <https://www.transparency.org/en/cpi/2014/index/mng>; <https://www.transparency.org/en/cpi/2015/index/mng>; <https://www.transparency.org/en/cpi/2016/index/mng>; <https://www.transparency.org/en/cpi/2017/index/mng>; <https://www.transparency.org/en/cpi/2018/index/mng>; <https://www.transparency.org/en/cpi/2019/index/mng>;

Зураг 2. Монгол Улсын үнэлгээнд ашигласан эх сурвалжуудын сүүлийн 4 жилийн онооны харьцуулалт

№	Судалгааны эх сурвалжийг ашигласан байгууллагуудын нэр	2017	2018	2019	2020	өөрчлөлт (2020-2021)	Эх сурвалж
1	PRS Group Risk assessment 2020 (ПиАрЭс) группын Эрсдэлийн үнэлгээ 2020	32	32	35	41	➔ 6	https://www.prsgroup.com/explore-our-products/international-country-risk-guide/
2	Varieties of Democracy (V-Democracy) Project (Ардчиллын олон талт байдлын судалгаа 2020)	35	33	31	34	⬇ 3	https://www.v-dem.net/en/publications/democracy-reports/
3	IMD World Competitiveness Ranking 2020 (Дэлхийн өрсөлдөх чадварын эмхэтгэл Үзэл бодлын судалгаа 2020)	33	30	28	32	⬇ 4	https://www.imd.org/news/updates/IMD-2020-World-Competitiveness-Ranking-revealed/
4	Word Economic Forum: Global Competitiveness Report Special Edition 2020 (ДЭЗФ: Дэлхийн өрсөлдөх чадварын Тусгай тайлан 2020)	30	31	28	28	➔	https://www.weforum.org/reports/the-global-competitiveness-report-2020
5	BTI Bertelsmann Transformation Index (Бертелсманн Сангийн Шилжилтийн индекс 2020)	41	41	37	37	➔	https://www.bti-project.org/en/home.html?&d=D&cb=00000
6	The World Bank Country Policy And Institutional Assessment (ДБ, Улс орны бодлого институцийн үнэлгээ 2019)	43	43	35	35	➔	https://datacatalog.worldbank.org/dataset/country-policy-and-institutional-assessment
7	The Economist Intelligence Unit Country Risk Service Report 2019 (Экономист интеллигенс судалгааны нэгж - Улс орнуудын эрсдэлийн үнэлгээ)	37	37	37	37	➔	https://store.eiu.com/product/country-risk-service
8	World Justice Project: The Rule of Law Index 2019 (Дэлхийн эрх зүйн төсөл- Хууль дээдлэх ёсны индекс 2019)	36	36	36	33	⬇ 3	https://worldjusticeproject.org/our-work/publications/rule-law-index-reports/wjp-rule-law-index-2019
9	Global Insight - Economics and Country Risk Survey 2019 (Глобал инсайт- байгууллага Улс орнуудын эрсдэлийн түвшингийн судалгаа 2019)	35	47	47	35	⬆ 12	https://ihsmarket.com/btp/global-insight-economics-country-risk.html
Дундаж оноо		36	37	35	35		

Олон улсын судалгааны байгууллагуудын дээрх дүнгээс төрийн албан хаагчид эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах байдал нэмэгдснээс авлига нийгэмд газар авч, улмаар байдал үлэмж ужгирвал түүний хор нөлөөнөөс ангид үлдэх нийгмийн ямар ч салбар байхгүйг харуулж байна. Энэхүү хор хөнөөл нь улс төр, эдийн засаг, оюун санааны бүх хүрээнд үүрлэж, тогтолоононы шинжтэй болсон авлига тухайн улсын үндэсний аюулгүй байдлын баталгааг алдагдуулахад хүргэх эрсдэлтэй. Тиймээс авлига бол улс төрийн хүрээнд газар авч, ужгирвал улс орны болоод нийгмийн үйл явц, түүний хэтийн хөгжилд асар их хор хөнөөл учруулж, улмаар нийгмийн оюун санааг хүчтэй хордуулж шударга ёсыг ганхуулдаг.

Аливаа нэгэн байдлаар ийм нөхцөл байдалд хүрсэн бол түүний хор хөнөөлийг бүрэн арилгах, нийгмийг дахин сэргээх, эрүүлжүүлэхэд маш урт хугацаа, хүчин чармайлт, хөрөнгө мөнгө шаардах нь дамжиггүй. Хэрэв авлига нийгэмд улам бүр газар авснаар хүүхдүүдийн тэгш боловсрол эзэмших, сурч боловсрох, мэргэжил эзэмших, эрүүл аюулгүй орчинд өсч торних, амьдрах зэрэг суурь эрх үндсээрээ зөрчигдөнө гэсэн үг. Цаашлаад шударгаар өрсөлдөж төрийн албанд ажиллах, томилогдох асуудал үгүй болж, бүх асуудлууд танил тал, хээл хахуульгүйгээр бүтэх зүйлгүй болно. Өөрөөр хэлбэл, алхам тутамд нь авлига шаарддаг болсон бол нийгмийн гишүүд эхлээд иочирдон бухимдаж байснаа сүүлдээ энэ байдал даамжрахын хэрээр иохөрч, улмаар дасан зохицохоос өөр аргагүйд хүргэдэг болохыг дурдах нь зүйтэй.

Нэг. Авлигын ерөнхий төлөв байдалд хийсэн шинжилгээ

Энэ удаагийн шинжээчдийн төсөөллийн судалгааны хүрээнд гүнзгийрүүлсэн яриулагын хэлбэрээр чанарын судалгааг гүйцэтгэв. Шинжээчдээс «авлига» гэсэн үгийг сонсохул хамгийн түрүүнд санаанд нь орсон үгсээр нь дамжуулан тэдний төсөөллийг тайлбарын хамт бичүүлэхийг зорив. Энэ ч дараах сонирхолтой хариултуудыг олж авахад ихээхэн тусалсан гэж болно. Эдгээр хариултуудыг багилан дараах зургаан

ангилалд хуваагдах боломжтой хэмээн үзсэнийг энд толилуулж байна.

<p>1. Хээл хахууль, мөнгө, эрх мэдлээр дулдайдан хууль зөрчих</p> <p>а.Хээл хахууль - мөнгө - эрх мэдэл б.Хээл хахууль - гар цайлгах - хоолонд орох в.Хээл хахууль - шунаг сэдэл – авлага г.Шан харамж - өөртөө ашигтай байдал бий болгох д.Төр - нам - эрх мэдэл (Угаасаа авлига энэ гурваар дамждаг) е.Эрх мэдэл, мэдээлэлд ойр байдал албан тушаалаа урвуулан ашиглах, мөнгө олох хэрэгсэл болсон ё.Хууль, журам зөрчиж бусдад давуу байдал бий болгосныхоо төлөө шан харамж, эд зүйл авах ж.Албан тушаалтанд дээрх үйлдлийнх нь төлөө эд зүйл өгөх з.Бусдаас эд зүйл авах, өгөх.</p>
<p>2.Авлигыг үл тэвчих сэтгэлгээний доройтол, мотивацийн сул, идэвхгүй байдал</p> <p>а.Хүнд суртал - Төрийн алдаатай процессуудын нэгдэл - иргэд б.Шархадсан үнэг - эвдэрхий байшин - хар саарал өнгө хамгийн түрүүнд бууж байна в.Авлигыг үл тэвчих сэтгэлгээ, дуу хоолойгоо хаана гаргахаа төдийлэн мэддэггүй, идэвхгүй байдал нь авлигыг өөгшүүлдэг. г.Ямар ч шийтгэл оногдуулахгүй байгаа тул авлига ердийн зүйл болсон. д.Авлигатай тэмцэх газарт ажиллаж байгаа хүмүүс өөрсдөө авлигачид болжээ. е.Цөхрөл - аль ч шатанд авлига цэцэглэж байгаа тул сайн нийгмийн тухай мөрөөдөөд ч хэрэггүй.</p>
<p>3.Албан тушаал, давуу байдлаа урвуулан ашиглах замаар авлига, хээл хахууль авах</p> <p>а.Бусдыг худалдан авах, өөрийн эрх ашгийг хохироох б.Шунал - улс төрчид - их мөнгө в.Нийтийн хөрөнгийг шамшигдуулах г.Эрх бүхий этгээд хувийн эрх ашгийг нийтийн эрх ашгаас тэргүүнд тавьж хэрэгжүүлэх д.Хээл хахууль авах замаар ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргах е.Өөрийн эрх ашгийн төлөө давуу байдлаа урвуулан ашиглах ё.Албан тушаалаа ашиглан хялбар аргаар хөрөнгөжих үндсэн арга хэлбэр ж.Албан тушаалд томилох хэлбэрээр шалгуур, шаардлагад тэнцэхгүй хүнийг томилох з.Нээлтэй болон зохих ёсны хязгаарлагдмал хүрээнд сонгон шалгаруулалт явуулахгүйгээр албан тушаалд томилох нь газар авсан.</p>
<p>4.Хууль бус шийдвэрээс үүдэлтэй шударга бус үйлдэл газар авч тэгш бус байдал улам бүр нэмэгдэж байна</p> <p>а.Тэгш бус байдлаас үүдэлтэй боломжийн алдагдал б.Авлига нь хэн нэгэнд давуу тал олгодог учир нөгөө хэсгийн боломжийг үгүй хийдэг в.Эрх мэдэл ба шударга бус хуваарилалт г.Хувийн хэвшил (компани) - ажлаа бүтээх хүсэл эрмэлзэл нь авлигад хөтөлдөг д.Санаатайгаар хууль бус шийдвэр гаргах е.Эрх бүхий албан тушаалтан, шүүгчид хууль бус гэдгийг мэдсээр байтал санаатай хууль бус шийдвэр гаргадаг. ё.Шийдвэрийн сөрөг үр дагаварыг нь мэддэг атлаа өөрийн эрх ашгийн төлөө санаатайгаар хууль бус шийдвэр гаргадаг. ж.Хууль бус, танил талаараа далайлган шударга бус үйлдэл гаргаж, өөрт ашигтайгаар үр дүн, ач тусыг хүртдэг.</p>
<p>5.Ёс зүй - ёс суртахуун, шударга ёс нийгэмд үгүйлэгдэж байна.</p> <p>а.Хүн чанар, хомхой сэтгэл, ёс суртахуун б.Улс төрд санхүүжилтээр авлига өгөх ёс суртахуунгүй үйлдэл газар авах болсон. в.Улс төрчид болон төрийн өндөр албан тушаалтнууд, төрийн албан хаагчдын ёс зүйн асар их доголтой байгаатай шууд г.Хувийн хэвшлийнхэн аливаа ашгийн төлөө улс төрчидтэй хамтран ашиг хүртэх болсонтой холбоотой д.Хувийн ашиг сонирхлын зөрчил өндөр байдагтай шууд холбоотой. е.Ёс суртахуун, ёс зүйн төлөвшил асар доогуур байгаагаас улс төрийн хүрээнд авлига үлэмж нэмэгдэж байна. ё.Авлигаас ангид байх, түүнийг үл тэвчих сэтгэлгээ, эр зориг байхгүй нь асуудлыг улам хэцүү, далд хэлбэрт оруулж байна.</p>
<p>6.Нийгмийг талцуулж, ялгаварлан гадуурхалт, хуваагдалд хүргэх аюул нүүрлэхэд хүргэж байна.</p>

а. Эвдэрхий байшинд амьдарч буй зальт бөгөөд сэтгэл зүйн болон оюун сэтгэлгээний хувьд шархадсан хар саарал үнэг яахаа мэдэхгүй сууж буй дүр зураг ажиглагдана.

б. Амьдралыг булингардуулагч авлига, хээл хахуулийн хорт утаанд мансуурах нь нийгмийн бүхэлд нь талцуулж, ялгаварлахад хүргэж байна.

в. Авлига гэж албан тушаал эрх мэдэлээ хувийн ашиг сонирхолдоо урвуулан ашигласан үйлдэл

г. Улсын хэмжээнд ч, компанины хэмжээнд ч мөн адил ашиг сонирхлын зөрчлөөс үүдэлтэйгээр аливаа зүй зохистой хэрэгжилтийг гацааж буй сөрөг үр дагавар бүхий хууль бус үйлдэл.

Шинжээчдийн дээрх харцултаас авлига ийнхүү өсч байгаагийн нэг шалтгаан нь төрийн өндөр албан тушаалтнуудын түвшинд ёс зүй, ёс суртахууны асар их хэмжээний доройтол газар авсантай холбоотойг харуулна. Нэг талаараа, энэ бол парламентын болон орон нутгийн сонгуулийн будлиан түүний тогтолцооны механизм суларсаны илрэл. Түүнчлэн улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийн ил тод бус байдал нэмэгдэж, бизнесийн бүлэглэлийн санхүүжилт, мөнгөний оролцоо улс төрд хэт давамгайлах болсон нь эргээд улс төрийн хүрээнд том авлигын барьцаанд орох үндэслэл болсныг илтгэсэн тод жишээ.

Улс орны хэмжээнд хийгдэж буй томоохон бүтээн байгуулалтын асуудал зарим талаар том хэмжээний авлигын суурь болоод зогсохгүй авлигын хэлбэрийг илүү далд, нарийн боловсронгуй хэмжээнд хүргэж байгааг шинжээчдийн өгсөн харцулт дэлгэрэнгүй харуулсан юм. Үүнээс улбаалан авлигын төлөв байдал нийгэмд нэмэгдэхийн хирээр өндөр түвшний авлигын цар хүрээ тэлсэн гэж үзэх үндэслэлтэй. Улмаар үүдэн гарах хохирлын хэмжээ өсч, тэр хэмжээгээрээ нийгэмд үзүүлэх хор нөлөөлөл нэмэгдэж, үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц хэмжээнд хүрсэнийг чанарын шинжилгээний үр дүн харуулав. Чанарын судалгаанд хамрагдсан шинжээчдээс тус улсад авлига хэр түгээмэл байгааг тодруулахад, тэдний дийлэнх нь «авлига их буюу өндөр хэмжээнд байна» гэж харуулсан. Ийнхүү авлига түгээмэл байгаа нь авлигаас үүдэлтэй нийгмийн тэгш бус байдал үлэмж нэмэгдэхийн хирээр нийгэм дэх шударга ёсны үнэт зүйлсийг сааруулахад хүргэж буйг онцолж байв. Цаашлаад авлигын түгээмэл байдал нийгмийн дунд сөрөг үзэгдэл гарах шалтгаан болоод зогсохгүй шударга бус байдал зонхилоход хүргэж байгаа талаар шинжээчид ихээхэн шүүмжлэлтэй хандаж байв.

Шинжээчдийн ийнхүү үнэлэх болсон шалтгааныг лавшруулан дараах байдлаар ангилал үүсгэн багцалвал зарим нэгэн сонирхолтой санал, дүгнэлтүүд илэрсэн юм. Тухайлбал, авлига нэмэгдэх болсон шалтгааны нэг нь улс төрийн хүрээнд ёс зүйгүй, хуулиас гажууд шударга бус явдал нэмэгдэхийн хирээр нийгэмд тэгш бус байдал бий болох өндөр эрсдэл нүүрлэсэн. Хэдийгээр авлигын төлөв байдал харьцангуй хэмжээнд буурч байгаа дүр зураг ажиглагддаг ч зарим талаар авлигыг бууруулахад чиглэгдсэн зарим шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаатай холбоотой аж. Тухайлбал, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн дуу хоолой нийгмийн сүлжээгээр хүчтэй нөлөө үзүүлэх болсон. Нөгөө талаар, төрийн өндөр албан хаагчдад ёс зүйн харцулага хүлээлгэх олон нийтийн сүлжээнд тулгуурласан цахим «давалгаа» бүхий нийтийг хамарсан улс төрийн соёлын нэг хандлагыг нийгэмд төлөвших болсон нь мэдээллийн технологийн дэвшилтэт арга технологид тулгуурласан нэг чухал арга хэмжээ гэдэг нь бодит амьдралаас урган гарсан практик ач холбогдол болохыг шинжээчдийн өгсөн харцултаас дүгнэж болохоор байна. Үүнийг дараах илэрхийлэмжээс дэлгэрэнгүй харж болно.

<p>1. Авлига маш их буюу өндөр хэмжээнд оршсоор байна.</p> <ul style="list-style-type: none"> o Угаасаа шударга бус байдал газар авсан тул авлига хэвийн үзэгдэл болж хувирсан. o Авлига улам бүр ихсэж нийгмийн бүхий л салбарт түгээмэл болж байгаа нь биднийг ангалын ирмэгт хүргэж байна. o Авлига нилээд түгээмэл байдал руу шилжих болсон нь үнэндээ улс төрчид, улс төрийн намуудыг дагасан авлига, албан тушаалын гэмт хэргүүд сүүлийн жилүүдэд илт нэмэгдсэнтэй холбоотой. o Төрийн үйлчилгээний олон шат дамжлага, хүнд сурталтай холбоотойгоор иргэд төрийн үйлчилгээ авахдаа заавал танил тал харах ёстой мэтээр ойлгож улмаар авлига, албан тушаалаа урвуулан ашиглах явдлыг эрс нэмэгдүүлж байна. o Сүүлийн үед хууль хяналтын, шүүхийн байгууллагуудын төлөөлөл ч авлигын томоохон хэргүүдтэй ил, далдаар холбогдож байна.
<p>2. Авлигын түгээмэл байдал нийгмийн дунд сөрөг үзэгдэл гарах шалтгаан болоод зогсохгүй шударга бус байдал зонхилоход хүргэж байна.</p> <ul style="list-style-type: none"> o Дээд шатанд авлига нилээд түгээмэл болж байгаа нь нийгэмд шударга бус байдал зонхилох гол үндэс суурь болж байна. o Мэдээлэлд ойр хэсгийнхэний дунд авлига илүү түгээмэл болж, улмаар мэдээллийн олдоцод суурилсан авлигажих, хууль бусаар хөрөнгөжих явдал газар авч байна. o Өнөөдрийн байдлаар авлига бүх шатанд түгээмэл оршиж байгаа нь түүнтэй дорвитой тэмцэх шаардлагатайг харуулж байна. Үүнд сэтгэлгээний болон хүсэл зориг дутагдаж байна. o Авлига түгээмэл болсныг мэдэж буй хэрнээ хий хоосон улс төржилт, биенийгээ намнах хэрэгсэл төдийхнөөр ард түмнийг хуурч байна. o Хоосон жүжиглэлт, хий улс төржилт авлигыг улам бүр далд хэлбэрт оруулж байна.
<p>3. Авлигаас үүдэлтэй нийгмийн тэгш бус байдал нь шударга ёсны үнэт зүйлсийг сааруулж байна.</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Манайд авлига түгээмэл байсан. Сүүлийн жилүүдэд гаргасан эрх зүйн актууд болон иргэдийн идэвх, оролцоо, олон нийтийн ил тод байдлын хүрээнд авлига хумигдаж, хяналт сайжирж байна. <input type="checkbox"/> Сүүлийн үед авлига бол маш өндөр түвшинд хүрсэн гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, боловсролын системд төрийн нэгдсэн бодлого алдагдаж улмаар энэ салбарт тогтолцооны гажуудал улам бүр нэмэгдэж байна. <input type="checkbox"/> Төрийн албан хаагчид, улс төрд ажиллагсадын хувьд шуналаа тодорхой түвшинд барьж чадахгүй байгаа нь авлигын гол үндэс нь болоод байна. <input type="checkbox"/> o Монголын нийгмийн амьдралын түвшин болон нийгмийн сэтгэхүй дор байгаагаас улбаатай.


Мөн засгийн газраас иргэдэд төрийн үйлчилгээг технологи (E-Mongolia)-ийн дэвшлээр дамжуулан хүргэх үйлчилгээ нэвтэрч эхэлсэн нь авлигыг бууруулах нэг гол хүчин зүйл болж буй гэж болно. Гэсэн хэдий ч, авлига бол ажил амжуулах, асуудлаа шийдвэрлүүлэх хамгийн хурдан шуурхай арга хэрэгсэл хэмээн үзэх хандлага нийтийн дунд нийтлэг байгаа нь үнэн. Хэдийгээр үүнийг үлэмж хэмжээнд оршиж байгаагийн шалтгаан нь сүүлийн жилүүдэд тархалт нь хумигдаж буй атлаа, илүү далд хэлбэрт шилжих магадлал өндөр байгаа нь шинжээчдийн дунд хийсэн чанарын судалгаагаар илэрсэн болно.

Шинжээчдийн гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцогчдоос Монгол Улс дахь авлигын ерөнхий төлөв байдлын талаар тодруулж, улмаар тэдний харуулмад шинжилгээ хийхэд дараах байдал ажиглагдсан. Тодруулбал, шинжээчдийн зүгээс авлигын ерөнхий төлөв «нэмэгдэж байна», «харьцангуй буурч байна», «эрх мэдэл, албан тушаалын төлөөх хувийн сонирхол авлига нэмэгдэх шалтгаан болж байна» хэмээн гурван хэсэгт бүлэглэхэд тэдний дийлэнх нь авлигын ерөнхий төлөв нэмэгдэж байна гэж харуулсан. Ийнхүү харуулах болсон шалтгааныг тодруулахад улс төрчид, ялангуяа төрийн өндөр албан тушаалтнуудын хооронд албан тушаалын наймаа, эрх мэдлийн төлөөх ил далд өрсөлдөөн улам бүр нэмэгдсэн нь авлигын ерөнхий төлөв байдал хурдацтай нэмэгдэх болсон аж. Үүнээс гадна, өөрсдийн эрх ашгийг хуульд тусгах хэлбэрээр эрх мэдлээ баталгаажуулах ёс суртахуунгүй үйлдэл их, бага хэмжээгээр үйлдэх, бас гаргах болсон нь ч үүнтэй холбоотой болохыг шинжээчид тайлбарласан.

Чанарын судалгааны хүрээнд шинжээчдээс тодруулсан нэг зүйл бол Монгол Улс дахь авлигын түвшинг үнэлүүлсэн явдал юм. Чингэхэд, нийт шинжээчдийн 80

хувь нь «өндөр» гэж үнэлсэн. Үүнээс Монгол Улсын авлигын ерөнхий түвшинд дээр дурдсан хүчин зүйлс шууд утгаараа нөлөөлж буйг гэрчилж байна.

Зураг 3. Монгол Улс дахь авлигын түвшинд өгсөн шинжээчдийн үнэлгээ




Дээрх шалтгаан нөхцөлөөс улбаалан шинжээчдээс ийнхүү үзсэн шалтгааныг тодруулбал, улс төрийн сонгуулийн жилийн дараагаас авлига мэдэгдэхүйц өсдөг. Цаашилбал, эрх мэдэлтнүүдийн «хязгааргүй их шунал»-аас үүдэлтэйгээр улс төр-бизнесийн бүлэглэлийн ашиг сонирхолд хөтлөгдөн тэдний ашиг сонирхлыг гүйцэлдүүлэхийн төлөө ажиллах явдал гардаг болохыг үгүйсгэхгүй. Нөгөө талаар, төрийн захиргааны байгууллагуудаас өөрт ашигтай ажил үйлчилгээг авахын тулд зарим талаар авлига санал болгох хэлбэрээр ажил, албан тушаалын давуу байдлаа ашиглан нөлөөлдөг нь авлигын нөхцөл байдлыг ийнхүү нэмэгдүүлэх гол хүчин зүйлс болдог аж. Үүнийг шинжээчид «манайх шиг том газар нутагтай, цөөхөн хүн амтай улсын иргэд нь нийгэмдээ орж амьдарч чаддаггүй. Энэ нь магадгүй, тархай бутархай амьдардагтай холбоотой. Нөгөө талаар тэдний хамгийн ойрын нийгэм нь гэр бүл, ах дүүс, хамаатан садан нь байдаг. Цаашлаад саахалт айл руугаа тэлэхгүйгээр ойр зууртаа эргэлдэж байгаа нь авлигын нөхцөл байдал ийнхүү газар авч хүндрэх болсон» хэмээн тайлбарласан юм.

Хоёр. Авлигын цар хүрээ, тархалтын байдалд хийсэн шинжилгээ

Шинжээчдийн төсөөллийн судалгааны хүрээнд хийгдсэн чанарын судалгаагаар авлигын цар хүрээ сүүлийн нэг жилд хэрхэн өөрчлөгдсөнийг тодруулсан юм. Чингэхэд судалгаанд хамрагдсан шинжээчдийн 40 хувь нь авлигын цар хүрээ, түүний нөхцөл байдал «нэмэгдсэн» хэмээн үнэлсэн. Харин 35 хувь нь «хэвэндээ», 20 хувь нь «буурсан» гэж тус тус үнэлсэн. Энэ нь авлигын цар хүрээ, түүний нөхцөл байдал сүүлийн нэг жилд хэрхэн өөрчлөгдсөнийг тодорхой харуулж буй үзэгдэл юм.

Зураг 4. Авлигын цар хүрээ сүүлийн 1 жилд хэрхэн өөрчлөгдсөн талаарх шинжээчдийн үнэлгээ



Сүүлийн нэг жилийн хугацаанд авлигын цар хүрээ, түүний нөхцөл байдал өөрчлөгдөхөд шинжээчдийн ийнхүү үнэлсэний учир шалтгааныг тодруулах зорилгоор ангилал үүсгэвэл дараах нөхцөл байдал ажиглагдав. Тухайлбал, шинжээчид авлигын цар хүрээг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээ авч хэрэгжүүлж, түүний үр дүнд буурах хандлага зарим тохиолдолд ажиглагдаг ч бодит амьдрал дээр илүү далд хэлбэрт шилжиж байх боломж бүрдэх үндэслэлтэй хэмээн онцолж байв.



Авлигын цар хүрээ нэмэгдэхэд хамгийн ихээр нөлөөлсөн шалтгаан, нөхцөл

- Зүүсэ хувилгасан далд хэлбэртэй болж цар хүрээ нь улам тэлсэн нь авлигыг түгээмэл хэлбэртэй болгоход нөлөөлсөн.
- Авлигын цар хүрээ илүү өргөжиж далд хэлбэрт буюу хуйвалдааны байдалд хүрсэн.
- Авлигын цар хүрээ улам бүр нарийсч, арга нь гүнзгийрэх шатандаа орсон.
- Сүүлийн нэг жилийн хугацаанд авлигын цар хүрээ дээд төвшинд нилээд газар авч, улмаар мэдээлэлд ойр нэгэн нь албан тушаалаа ашиглан хууль хэмээх нэрийн дор өөрсдөө сонирхлын бүлэглэл хэлбэрээр шунаг сэтгэлд автагддаг болсон.
- Хэрэв тухайн бүлэглэлийн гишүүд нь хоорондоо тохиролцоогүй бол маргалдаж, бие биенийгээ намнах аргаар замаасаа зайлуулах явдал газар авсан.
- Дэлхийн нийтийг хамарсан цар тахал авлигыг нэмэгдүүлэх үндсэн шалтгааны нэг болон хувирсан.



Авлигын цар хүрээ, түүний нөхцөл байдал одоогийн төвшинд хэвээр үлдэхэд нөлөөлсөн шалтгаан

- Сүүлийн нэг жилийн хугацаанд улс төрийн нам дотор болон улс төрчдийн хоорондын зөрчил хагарал, тэмцэл, хуйвалдаан их гарсан авлигын цар хүрээг бууруулах боломжийг бүрдүүлж чадаагүй.
- Эрх мэдэл, авлигын эрх ашгийн зөрчилдөөн нь сүүлийн нэг жилд авлигын шинжтэй зөрчлийг хэвэнд байлгахад нөлөөлсөн.
- Амьдралын хэв маягын бүрдэл болчихсон.
- Төрийн албан хаагчид, улс төрд ажиллагсадын хувьд шуналаа тодорхой түвшинд барьж чадахгүй байгаа нь авлигын гол үндэс нь болоод байна
- Үнэхээр ядуу амьдарч ирсэн гэж үзэн тэр хорссон сэтгэл чинь авлигад автуулж байна гэж бодож байна.
- Авлигатай тэмцэж байгаа нэрийдлээр намнах эргээд авлигачид нь авлигачдаа намнадаг. Авлигачдын хооронд үүссэн зөрчил үүсдэг.
- Авлигачдын цензур нь үнэлгээ нь өсдөг хандлага харагдаад байдаг. Энэ нь эргээд авлига илүү нарийн зохион байгуулалттай болж, далд хэлбэрт шилжих төлөв бүрдсэн гэж болно.




Авлигын цар хүрээ, түүний нөхцөл байдал буурахад нөлөөлсөн шалтгаан

- Үйл явц цахимжихын хирээр авлига багасаж байгаа үзэгдэл ажиглагдаж байна.
- Авлигын цар хүрээ хумигдсан ч далд хэлбэрт илүү их шилжсэн магадлалтай.
- Авлигын хэлбэр өөрчлөгдсөн нь зөвхөн мөнгө, эрх мэдэл биш болсон.
- Хүүхдүүд нь эцэг эхийнхээ буруу замаар олсон мөнгөөр би боловсрол эзэмшихгүй гэж хэлсэн цагт л тэр авлига алга болох байх. 10 хүүхдээс 6 хүүхэд нь тэгж л хэлвэл гайгүй болжээ гэж үзнэ шүү дээ.
- Хууль хяналтын байгууллагын хяналт-шалгалтыг сайжруулах. Нэг талдаа авлигатай тэмцээд байгаа боловч нөгөө талдаа ихэсч байна. Тэгэхээр авлигачид нэг нэгнээ намнана гэдэг нь болж байдаг.
- Авлигын процесс нь өөрөө нарийн далд хэлбэрт орж өндөр өртөгтэй болсон. Авлига гэдэг нь өөрөө төсвөөс гарч байгаа мөнгө байдаг. Төсвөөс гарч байгаа мөнгийг л хувааж "идэх" санаа юм л даа.

Үүнээс улбаалан, байгууллагын удирдлагын үйл ажиллагаа, томилгоог бүлэглэлээр томилж, улмаар бүлэглэлээр нэгнийгээ хамгаалах хэлбэрийг устгахгүйгээр энэ байдал огтм арилахгүй байгааг шинжээчид тусгайлан дурдсаныг хэлэх нь зүйтэй.

Зураг 5. Авлига аль түвшинд илүү тархаж буйд шинжээчдийн өгсөн үнэлгээ



Дээрх зургаас харахад, улс төр, шүүх, хууль сахиулах салбарын хүрээнд авлигыг бүрдүүлэгч шалтгаан нөхцөл мэдэгдэхүйц хэмжээнд буурахгүй байгаа нь ийнхүү үнэлгээнд нөлөөлсөн байж болох талтай. Түүнээс гадна, улс төрийн намын нөлөөнд автах, улмаар улс төр-бизнесийн, улс төр-хууль эрх зүйн, хууль-шүүхийн болон улс

төр-хууль хяналт-бизнесийн гурвалсан холбоо, сүлжээ нь төрийн болон нийтийн албан дахь суурь зарчмыг алдагдуулаад зогсохгүй нийгмийн харилцааны бүхий л шатанд хүнийсэх байдлаас хандах, хүнд суртал гаргах байдал, албан хаагчид нь мэдлэг ур чадварын дутмагшил, ёс суртахуун-ёс зүйн доголдол, улс төрийн соёлын хомсдол нумгэн зэрэг нь салбарын авлигатай тэмцэх үйл ажиллгааг үр ашигтай бодит төвшинд хүргэхэд төдийлэн хангалттай бус байгааг илтгэнэ. Ийнхүү авлига дээрх түвшинд өссөн шалтгааныг цааш нь лавшруулбал, дараах зүйлтэй холбоотой хэмээн шинжээчид тайлбарласан нь сонирхолтой санагдав. Эдгээрийг багцлан үзүүлбэл:



Үүнээс дүгнэвэл, сүүлийн үед улс төрийн намын нөлөөгөөр (Жнь: Ковидын үед баримтлах хууль гэгчээр далимдуулан) мэдлэг чадвар дутмаг албан хаагчдыг төрийн дунд, дээд, анхан шатанд томилж болсон. Чингэснээр ажил, албан үүрэгтээ харууцлагагүй хандах, хүнд суртал гаргах, иргэдийг чирэгдүүлэх, албан үүргээ гүйцэтгэхэд бусадтай ёс бус харьцаж албаны болон мэргэжлийн ёс зүйн буруу хандлага гаргах явдлыг улам бүр нэмэгдүүлэх боллоо. Энэ нь авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдох, албан тушаалаараа ашиг хонжоо олох замаар төр-бизнесийн болон бусад төрлийн зохисгүй холбоо хамаарлыг бүрдүүлэх суурь үндэслэл болсон хэмээн дүгнэж болно.

Гурав. Авлигын хэлбэр түүний төлөв байдалд хийсэн шинжилгээ

Чанарын судалгааны хүрээнд хийгдсэн гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцогчдоос авлигын ямар хэлбэр манай улсад хамгийн түгээмэл байгаад өгсөн харуулмад ангилал үүсгэн дараах шинжилгээг хийв. Ингэхэд, бэлэн мөнгөний хэлбэр нилээд түгээмэл байгаагийн зэрэгцээ мөнгө санхүүгээр дамжуулах авлигыг өөгшүүлэх хандлага нийтлэг байна. Түүнчлэн албан тушаалын давуу байдлаа ашиглах замаар өөрт буй эрх мэдлийн ашиглах явдал улс төр, хууль хяналтын байгууллагын авлигын хэлбэрийг илүү түгээмэл болоход нөлөөлсөөр байгааг шинжээчид онцолсон.

Тухайлбал, шинжээчдийн зүгээс манай улсад авлигын хамгийн түгээмэл хэлбэр нь «илүү далд хэлбэр»-т шилжсэн гэж үзсэн явдал байв. Тэднийхээр авлига бол илт тод гэхээсээ илүүтэй далд хэлбэрээр үйлдэгддэг бөгөөд урьд өмнө нь бэлэн мөнгө

их өгдөг байсан бол, одоо арга нь улам нарийсаад тухайн албан тушаалтны болон түүний хамаарал бүхий этгээдийн өр, зээлийг нь дарах, аль эсхүл их хэмжээний хөрөнгө оруулалтын нэрийн дор мөнгөөр барьцаалан өөрийн эрхшээлдээ оруулах зэргээр өөрчлөгдөх болжээ. Үүнээс гадна, хуулийг тухайн байгууллагад ашигтайгаар тайлбарлах, хэрэглэх замаар өөрт ашигтай шийдвэр гаргуулж түүнээс олсон ашиг орлогоо хуваалцах явдал түгээмэл болсоор байгааг чанарын судалгаанд оролцогчид онцолж байлаа.

Эндээс, авлигын хэлбэр нь олон шат дамжлагатай болж, уламжлалт бэлэн мөнгө өгч, авах арга хэлбэрээс илүү нарийсч байгууллага болон хувь хүнд давуу байдал бий болгох хэлбэр түгээмэл болсон хэмээн үзэхэд хүргэв. Мөн албан тушаалд томилох эсвэл байгууллага, бүлэглэлийн хувьд эрх зүйн орчноор дамжуулан давуу нөхцөл олгох зэрэг хэлбэртэй болсон хэмээн дүгнэж болохоор байна. Үүнийг доорх зурагт харуулсан илэрхийлэмжээс тодорхой харж болно.

1	<p>Авлига далд хэлбэрт шилжсэн</p> <ul style="list-style-type: none"> o Эрх мэдлээ ашиглаж өөртөө болон бусдад давуу байдал олгох хэлбэр нь далд тойруу замаар хууль ёсны мэт болж хувирсан. o Авлигын цар хүрээ илүү өргөн болж далд буюу хуйвалдааны хэлбэрт шилжснээр бизнес-улс төр холилдсон бүлэглэлүүд нийгэмд үүсч, улмаар газар авах болсон. o Бүлэглэлүүдэд тулгуурласан авлига, албан тушаалын хэрэг, хээл хахуулийн хэлбэр хамгийн түгээмэл болж хувирсан o Бусдад давуу байдал олгож түүнийхээ хариуд шан харамж авах, улс төрийн авлига өгөх хэлбэр нийтлэг болсон.
---	--

2	<p>Бэлэн мөнгө өгөх, төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаанд нөлөөлөх</p> <ul style="list-style-type: none"> o Шүүхийн шийдвэр, худалдан авах үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх явдал газар авсан. o Төрийн хяналт, шалгалт сул байгаа нь төрийн дунд шатанд улс төрийн үйл ажиллагаанд нөлөөлөх гол хэрэгсэл болсон. улмаар бэлэн мөнгө өгөх, авах, хахууль өгөх хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргах явдал ихэссэн. o Эрх мэдэл, албан тушаалын давуу байдлаа ашиглах замаар хөрөнгө мөнгө, ашиг олох хэлбэрт шилжсэн.
---	---

3	<p>Танил тал харж ажлаа бүтээх</p> <ul style="list-style-type: none"> o Нам, төрийн байгууллагуудад хандив өгөх хэлбэрээр хээл хахууль өгөх явдал түгээмэл болсон. o Иргэд хувийн ажил хэргээ биелүүлэхийн тулд бусдад эд зүйл, мөнгө, хөрөнгө аргадан өгөх хандлага түгээмэл болсон o Мөнгө бус байдлаар танил талаараа бие биендээ харилцан туслах замаар авлига авах хэлбэр түгээмэл үзэгдэл болсон . Энэ нь нэг талаар, улс төрийн хүрээнд түгээмэл хэрэглэгдэх болсон «улс төрийн ургийн мод» хэмээх хэлцийг бий болгох нэг чухал үндэслэл болсон. o Дэд төвшинд дүр исгэсэн байдал газар авч, улмаар авлигачдыг мэдсэн ч мэдээгүй хандлагаар тэднийг өмгөөлж хамгаалсан үйлдэл хийх явдал олширсон нь олон нийтийн дургүйцэл, эгдүүцлийг хүргэж байна.
---	---

Дөрөв. Авлига бий болох шалтгаан, нөхцөлд хийсэн шинжилгээ

Чанарын судалгааны хүрээнд шинжээчдээс Монгол Улсын авлигын ерөнхий түвшинд нөлөөлж буй гол хүчин зүйлсийг тодруулахыг зорьсон нь тодорхой шалтгаантай юм. Үүний гол шалтгаан бол, төрийн өндөр удирдах түвшний албан хаагчдын ёс зүй дутмаг, улс төр, эдийн засаг, эрх мэдэлд төвлөрсөн бизнесийн бүлэглэлүүд сонгуулийн санхүүжилтийг «босгож» асуудлыг шийдэж байгаа нь эргээд авлигын барьцаанд орох шалтгаан болхыг шинжээчид нэг бус удаа дурдаж байсан юм. Түүнчлэн авлигатай тэмцэх үйл ажиллагаа тодорхой хүрээнд хийгдээд байгаа хэдий ч эл хавтгайрсан үзэгдэл нь ганц, хоёр арга хэмжээг хэрэгжүүлснээр шууд арилах боломжгүй. Хэдийгээр зарим нэг арга хэмжээ үр дүнгээ өгсөн байдаг ч хууль хяналтын болон шүүхийн байгууллагаар шийдэгдэх нь удаашралтай байсаар аажимдаа «бүдгэрч, замхрах» байдлаар сураг тасарч байгаа нь энэ хүрээнд механизм маш сул, хангалтгүй байгаагаас гадна улс төрийн хүсэл зориггүй байгаатай

холбоотой. Нэг үгээр бол, хариуцлагын асуудал маш хангалтгүйг илтгэнэ. Үүнийг ч эл чанарын судалгаанд хамрагдсан шинжээчид дэлгэрэнгүй тайлбарласан бөгөөд судалгааны үр дүнг дараах байдлаар танилцуулж байна.

1	<p>Авлига далд хэлбэрт шилжсэн</p> <ul style="list-style-type: none"> o Улс төрийн буруу тогтолцоо-нийтийн (төрийн) албаны чадваргүй байдал-Н/ТАХ-ын ёс зүй-нийгэмд үнэт зүйл алдагдсан. o Бүртгэл мэдээллийн тогтолцоо, ялангуяа хяналтын механизм сул o Хувийн ашиг сонирхлоос үүдэлтэйгээр бие биендээ барьцаалагдсан бүлэглэлүүд бий болоод удаж байгаа учраас түүний нөлөөлөл нийгэмд нэмэгдэж, бас сөргөөр нөлөөлж байна.
	<p>Хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй</p> <ul style="list-style-type: none"> o Хуулий засаглал сул байгаагаас эрх ашгийн зөрчлүүд үүсэх үндэслэл бий болсон. o Улс төрийн буруутай шийдвэрээс үүдэлтэй нийгмийн талцал, хуваагдал бий болсон нь зарим талаар нийгэм-эдийн засгийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлөх болсон. o Төрийн бодлогын залгамж чанарыг алдагдуулахад шууд ба шууд бус байдлаар нөлөөлөх явдал газар авсан.

2	<p>Шударга бус байдал бий болсон</p> <ul style="list-style-type: none"> o Иргэний болон улс төрийн боловсролын соёл дутмаг. o Авлигатай тэмцэх хүсэл зориг сул учраас авлигыг үд гэвчих соёл бүрэн төлөвшихгүй байна. o Олон нийт, ИНБ-уудын зохистой шаардлага, тэмцэл сул.
	<p>Улс төрд нөлөөллөө тогтоох эрмэлзэлтэй бүлэглэлүүд бий болсон</p> <ul style="list-style-type: none"> o Улс төр, хууль хяналтын байгууллагуудын бүлэглэлүүдийн нөлөөлөл ихэссэн. o Шударга шүүхт итгэх итгэл буурсан. o Бүлэглэл дамжсан улс төрийн хэлхээ холбоо үлэмж нэмэгдсэн.

Дээр дурдсан нөхцөл байдлаас улбаалан авлига үүсэх шалтгаан нөхцөлийг бүрдүүлж буй хүчин зүйлсийг ангилал үүсгэн танилцуулах энэ удаагийн чанарын судалгааны нэг чухал зорилт байв. Тиймээс шинжээчдийн зүгээс тухайн асуудалд баримталж байсан байр суурийг тэдний хамгийн түгээмэл хөндсөн сэдвүүдийн хүрээнд баглан дээрх байдлаар танилцуулахыг бид зорьсон болно.


Энэхүү ангиллаас, нийгэмд «авлига» хэмээх үзэгдэл ийнхүү бий болсон шалтгаан нь (i) шилжилтийн нийгэмд мөнгө, хөрөнгө, хувийн эрх ашгийг дээгүүрт тавих үнэт зүйл гэнэт давамгайлах болсноор эрх мэдлээ хэтрүүлэх, албан тушаалаа ашиглаж амин хувьдаа ашиг хонжоо олох гэсэн нийтлэг хандлага төлөвших болсон; (ii) монгол орны эрдэс баялаг, түүхий эдийн төлөөх гадны эрх ашиг, түүнийг аялдан дагадаг бүлэглэл бий болсноор гадны аливаа ашиг сонирхол, явуулгад автах үйл ажиллагаа аажим аажмаар нэмэгдэх болсон; (iii) олон шатанд шийдвэр гаргах эрх мэдэлтнүүд нэмэгдснээр тус бүртээ ашиг сонирхолоо гүйцэлдүүлэхийн тулд элдэв төрлийн дарамт шахалт учруулах явдал ихсэж тэр бүрийд ёс суртахууны болон ёс зүйн хэм хэмжээ алдагдсан; (iv) улмаар дотоодын улс төрчдийн эд материалын болон оюуны хоосрол, хэт туйлширсан өрөөсгөл хандлага зэрэг нь авилгад өртөх шалтгааныг бүрдүүлэх болсон; (v) нийгмийн хөгжлийн өнөөгийн байдалтай холбоотойгоор төрийн хэт монополь байдал ихэсэж аливаа шийдвэр, тусгай зөвшөөрөл, тендэрт гар тэнийлгэх зан үйл нэмэгдэх суурь үндэс болсон; (vi) дотоодын улс төрийн намуудын эрх мэдлийн төлөөх тэмцэл хуйвалдаан нь авлигын шинж чанартай болж эрх ашгаа хангах болсноос үүдэлтэй гэж үзэж болно.

Цаашилбал, авлига бидний өнөөгийн оршин буй нийгэмд тулгарч буй хамгийн том бэрхшээл, ирээдүйн сорилт болж байна. Яагаад гэвэл, улс төрийн авлигын түвшин дэх авлигын хор уршиг, үр дагаврын үзүүлэлтэд нөлөөлж буй байдлыг дараах хоёр дэд үзүүлэлтийн хүрээгээр өнгөрсөн хугацаанд гарсан өөрчлөлтийг харьцуулбал дараах өөрчлөлтүүд илрэв. Тодруулбал, 1990-ээд оны төгсгөл 2000-аад оны эхээр бол хувийн банк санхүү, хувийн тансаг хэрэглээг бий болгох, өөрийн

ирээдүйн амьдралын баталгааг бий болгох явдал түлхүү байсан бол, сүүлийн жилүүдэд гадны улс орны бизнесийн нөлөөллүүдийн санаархлыг биелүүлэх буюу монгол дахь гадны улс орны ашиг сонирхлыг хэрэгжүүлэх, эсвэл бизнесийн ашиг сонирхлыг гүйцэлдүүлэхийн тулд зарцуулагдсан зэрэг таамаглалуудыг шинжээчид илэрхийлсэн байдаг. Тэрхүү тамааглалууд бодит амьдралд хэр нийцэж, бас үнэн зөв болохыг чанарын судалгааны шинжилгээгээр тодруулан шинжээчдээр тухайлан үнэлүүлсэн юм. Чингэхэд, улс төрийн намуудын хувьд авлига ийнхүү түгээмэл хэмээн үнэлэгдэх болсон нь улс төрийн намын тухай хууль, түүний санхүүжилтийн талаар хуульд нарийн тодорхой зааж өгөхгүйгээр хэн нэгнээс хараат бус бие даасан байх асуудал бүрэн шийдэгдэхгүй хэвээр байгаатай холбоотой хэмээн үзэж байна.


Энэ бол бизнес-улс төрийн бүлэглэлийг задлахгүйгээр улс төрийн нам доторх мөнгөтэй хүнээс «төр»-ийн аливаа үйл ажиллагаа, улс төрийн томилгоо хамаардаг хууль бус үйлдлээс ангижрах боломжгүй гэдгийг илтгэсэн бодит үнэн. Дээр харуулсанчлан, сүүлийн нэг жилийн хугацаанд авлигын нөхцөл байдал хамгийн түгээмэл хэмээн үнэлэгдсэн дараагийн байгууллагууд бол шүүх болон Засгийн газрын харьяа байгууллагууд дахь авлигын түгээмэл байдал нилээд өндрөөр үнэлэгдсэн. Энэ нь магадгүй төрийн албан хаагчдын дархлааг нэмэгдүүлэх шаардлага нэгэнт болсныг харуулна (Зураг 6).

Зураг 6. Сүүлийн нэг жилийн хугацаанд дараах төрийн байгууллагуудад авлигын нөхцөл байдал хэр түгээмэл байгаад шинжээчдийн өгсөн үнэлгээ



Эл чанарын судалгаагаар Монгол дахь улс төрийн намуудын авлигад автсан байдлын талаар тухайлан авч үзэхийг зорьсон юм. Чингэхэд, монголын улс төрийн нам, улс төрийн сонгууль, төрийн алба нь авлигаас ангид байхын тулд эрх зүйн орчныг илүү боловсронгуй, ил тод болгохыг зорин ажиллаж, тэрхүү зорилтдоо хүрэхийн тулд тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсээр ирснийг шинжээчид ониолж байлаа. Үнэндээ, эл арга хэмжээ бодит байдалд төдийлэн үр дүнтэй байж чадахгүй байгаа нь тухайн улс төрийн намуудын авч хэрэгжүүлж буй аливаа үйл ажиллагаа нь хөрсөн дээр бодитоор буухгүй байгаагийн тод илрэл. Үүний бодит жишээг энд танилцуулж буй шинжээчдийн судалгааны дүн ч харуулж байна.

Зураг 7. Монгол Улс дахь улс төрийн намуудын авлигад автсан талаарх шинжээчдийн өгсөн үнэлгээ




Шинжээчдийн төсөөллөөр манай улс төрийн голлох намуудаас хамгийн их «авлигад автсан» байж болох намыг тодруулахад, нийт судалгаанд хамрагдсан хорин зургаан шинжээчдийн 22.5 хувь нь өнөөгийн эрх барьж буй Монгол Ардын Нам (МАН) болон Ардчилсан (АН)-ыг авлигад автагдсан хэмээн үзжээ. Харин тэдний 15 хувь нь бүх намуудыг, тус бүр 2.5 хувь нь бусад намууд (ИЗНН, ХҮН)-ыг нэрлэсэн. Судалгаанд хамрагдсан шинжээчдээс ийнхүү улс төрийн намууд авлигад автах явдал өндөр байгаагийн шалтгааныг тодруулахад нам хооронд дамжсан бүлэглэл, төрийн эрх хэт удаан барих, харцулагагүй хяналтгүй байдал газар авсан, улс төрийн соёл төлөвшөөгүй, эрх ашгийн бүлэглүүд бий болсон зэргийг түгээмэл онцолж байв.

Тав. Авлигын хэлбэр дэх улс төрийн нам, бүлэглэл, улс төр, бизнес, гэмт хэргийн бүлэглэлүүдийн харилцаа хамааралд хийсэн шинжилгээ

Өмнөх дэд хэсэгт дурдагдсан сөрөг үзэгдлүүд өнөөдрийн авлигын эх үүсвэр болж буйн дээр тасралтгүй цэцэглүүлж буй үндэс суурь улс төрийн нам болсоор буйг илтгэж байна. Үүнийг зогсооход улс төрийн намын санхүүжилтийн асуудлыг ил тодорхой болгож, төрийн албыг улс төрийн томилгоогоор бус шударга өрсөлдөөн, сонгон шалгаруулалтаар явуулдаг механизмыг улам боловсронгуй шударга болгох цаг үеийн шаардлага нэгэнт бий болсныг гэрчилнэ. Үүнээс улбаалан улс төрийн байгууллагын хүрээнд авлига түгээмэл орших болсон шалтгааныг шинжээчдээс тодруулахад нөхцөл байдал дараах байдалтай гэж дүгнэхэд хүргэсэн юм.

Зураг 8. Монгол Улсын улс төрийн байгууллагын хүрээнд авлига хэр түгээмэл байгаад шинжээчдийн өгсөн үнэлгээ



Үүнээс харвал, Монгол Улс дахь улс төрийн байгууллагын хүрээнд авлига хэр түгээмэл байгаа талаар шинжээчдийн дийлэнх буюу 87 хувь орчим нь авлига далд боловч маш их, түгээмэл байгаа нь ажиглагдсан.

Шинжээчдийн ийнхүү үнэлсэн шалтгааныг тодруулах үүднээс тэдний өгсөн харцуултыг задлахул, (i) засаглалын тогтворгүй байдал авлигын өсөлтөд маш их нөлөөлж байна; (ii) сонгуулийн тогтолцоо, сонгуулийн санхүүжилт, сонгуулийн дараа төрийн албаны томилгооноос үүдэж авлигын түвшин нэмэгдэж; (iii) улс төрийн намууд сонгуулийн тогтолцоог өөрсдөө тохируулан өөрчлөн засч, улмаар сонгуулийн санхүүжилтээ мөнгөтэй хүмүүсээр босгуулж, эргээд барьцаалагдан төрийн албан тушаалуудыг наймаалцаг. Энэ нь төрийн албыг чадавхгүй болгож баг бүрдүүлэх нэрээр ойрын хүрээний мэргэжлийн бус хүмүүсийг мөнгөөр томилж байгаа нь авлигын гол эх үндэс болж байна хэмээх үзэл бодол экспертүүдийн гүнзгийрүүлсэн яриулагад түлхүү дурдагдсан юм. Дээр дурдсан үзэл бодлыг багцлан шинжилгээ хийвэл дараах үндэслэлүүд чухалчлагдаж байна.

ҮНДЭСЛЭЛҮҮД

- o Сүүлийн жилүүдэд улс төрийн байгууллагуудын хүрээнд авлигын хэлбэрүүд илүү зохион байгуулалттай болох явдал нэмэгдсэн.
- o Ялангуяа хээл хахууль өгөх, авах арга хууль бус нөлөөллийн хэлбэрээр илрэх болсон.
- o Улс төрийн шийдвэр гаруулах түвшинд илүү зохион байгуулалттай байдал сүүлийн үед нэмэгдэх болсон.
- o Авлигын үндсэн шалтгаан нөхцөл нь улс төрийн хүрээнд буюу түүнд оролцдог субъект, гишүүдийг эрх ашгаас үүдэлтэй.
- o Өнөөгийн нийгэмд улс төрд орох, улс төр хийх ашиг сонирхол нь эрх мэдэл, мөнгө, дотоод гадаадын хэсэг бүлгийн эрх ашиг болж хувирсан нь улс төрийн салбарт авлига түгээмэл байна гэж үзэх шалтгааныг бүрдүүлж байна.

Зургаа. Авлигатай тэмцэх үйл ажиллагаа буюу улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хор уршиг, үр дагаварт хийсэн шинжилгээ

Авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь зөвхөн шийтгэл хүлээлгэх арга хэмжээ төдийгүй нийгмийн амьдралд шударга ёсыг тогтоож, дэмжих уоги стратегид тулгуурлах ёстой. Шударга, мэргэшсэн байдлыг хангахад төрийн алба, удирдах албан тушаалтнуудын манлайллыг чиглүүлэгч зарчмын гүйцэтгэх үүргийг сахин биелүүлэх учиртай. Өөрөөр хэлбэл, шударга байдал, ёс зүйн удирдлагын тогтолцоог тулган шалгах, заавар чиглэл, удирдлага, хяналтын чиг үүргийг тодорхойлсон бөгөөд шударга ёсыг тодорхойлон тогтоох, шударга байдалд чиглүүлэх, шударга байдлыг хянах, шударга ёсыг сахиулах гэсэн шударга ёсны удирдлагын тогтолцоог бүрдүүлэн сахих нь сайн засаглалыг хангах үйл ажиллагааны чухал зорилт болсоор байна. Чингэхлээр авлигын эсрэг тэмцэл нь зөвхөн ёс суртахууны тэмцэл биш бөгөөд ёс суртахуун, шударга ёсны асуудал чухал болох дэлхийн гол шашин, нийгмийн үнэлэмжүүдийн хүрээнд хамгийн гол нь авлигаас үүдэлтэй ядуурал, зовлон, өлсгөлөн гачаал, баян хоосны ялгаа нь бидний өмнө хамгийн хүнд сорилт болж буй бөгөөд үүнтэй тэмцэх нь гол утга учир болж байна.

Дээр дэвшүүлсэн үндсэн санааг чанарын судалгаанд хамрагдсан шинжээчдээр үнэлүүлэх байдлаар авлигатай тэмцэх үйл ажиллагаа, улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлигын хор уршиг, үр дагаврын бодит нөхцөлийг тодруулахад дараах дүр зураг ажиглагдав. Тухайлбал, шинжээчид улс төрийн шийдвэр гаргах болон

4 ЕАБХАБ, Монгол Улсын Авлигатай тэмцэх газар. Авлигатай тэмцэх гарын авлага. «Орчуулга24» мэргэжлийн орчуулгын товчоо. «Урангар пресс» ХХК. Уб., 58, 59 дэх тал.


түүнд тавих хяналт сул, ашиг сонирхлын зөрчлийг саармагжуулах явдал хурцаар тавигдах нь авлигыг бууруулахад чухал арга хэрэгсэл болохыг дурдсан. Тэдгээр арга хэрэгслийг ангилбал, улс төрчид-бизнесийнхэний нийлсэн эрх ашгийн төлөөх сонирхлын нэгдлийг саармагжуулах, түүний хувиран өөрчлөгдөж буй арга хэрэгслийг таслан зогсоох явдал хэмээн үзжээ. Үүнийг арилгахын тулд өнөөгийн авч хэрэгжүүлж буй авлигын эсрэг арга хэмжээ бодит амьдралд хэр үр өгөөжтэй, амжилттай хэрэгжиж буйд анхаарал хандуулахыг зөвлөсөн. Үүний илрэл нь ч шинжээчдийн өгсөн үнэлгээний тайлбарт чанарын шинжилгээ хийхэд дараах илэрхийлэмжүүд чухалчлагдаж байсныг ангилал үүсгэн танилцуулж байна.

<p>1. Авлигын эсрэг тэмцэл, сурталчилгаа хэт ерөнхий байна</p> <ul style="list-style-type: none"> o Аливаа явуулж байгаа үйл ажиллагаа нь хэт ерөнхий бөгөөд бодит үр дүн өгч хангалттай хэмжээнд хүрч чадахгүй байна. o Авлигын эсрэг тэмцэж буй үйл ажиллагааны үр нөлөө харьцангуй сул байгаагийн шалтгаан нь АТГ-ын хараат бус байдалтай холбоотой. o АТГ-ын үйл ажиллагаа, түүний удирдлага нь улс төрийн намуудаас шууд хамааралтайн дээр сонгуулийн дараа удирдлагууд тогтмол солигдож байна.
<p>2. Авлигын хор уршигийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа ба үр дүн</p> <ul style="list-style-type: none"> o Авлигын эсрэг нийгмийн соён гэгээрүүлэх ажил нь зөвхөн АТГ-ын чиг үүрэг биш гэдгийг олон нийт хүлээн зөвшөөрч эхэлсэн нь нийгэмд АТГА-ны эерэг хандлага бий болсоны илрэл. o Иргэдийг ядуу байлгах сонирхол улс төрийн бүлэглэлүүдэд байгааг үгүйсгэхгүй. o ХОМ болон ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт, төсөв зарцуулалтын ил тод байдлын хангахад чиглэсэн ахиц дэвшил гарч байна. o Авлига, албан тушаалын тодорхой гэмт хэргүүдийг шийдвэрлэх явц хэт удаашралтай байна.
<p>3. Шударга ёсонд халдаж буй саад бэрхшээл</p> <ul style="list-style-type: none"> o Сүүлийн жилүүдэд гаргасан эрх зүйн актууд болон иргэдийн идэвх, оролцоо, олон нийтийн ил тод байдлын хүрээнд авлига хумигдаж, хяналт сайжирж байна. o АТ үйл ажиллагааг хэт улс төржсөн байдлаар бие биенээ намнах хэрэгсэл төдий болгож байгаа нь АТГА-ны эрч, үр нөлөөг саармагжуулж, улмаар нийгэмд хэт их улс төржилт, хийрхэлийг бий болгож байна. o АТГ шүүхийн шударга ёсыг сахиулахад чиглэгдсэн үйл ажиллагааг хамгаалах хэрэгтэй.

Шинжилгээнээс эдгээр үзүүлэлтүүд их, бага хэмжээгээр нэмэгдэх тусам улс төрийн хүрээн дэх авлига, албан тушаалын гэмт хэргээс үүдэлтэй хор уршиг нийгэм, эдийн засгийн болон нийгмийн сэтгэл зүй, ёс суртахуунд сөргөөр нөлөөлж байна. Нөгөөтээгүүр, дурдсан сөрөг үр дагаварууд болон түүний их, бага зэргээр өссөн үзүүлэлтүүд цаашид даамжирвал илүү хүнд сорилтууд тулгарч болзошгүйг шинжээчдийн өгсөн илэрхийлэмжүүд тодорхой харуулав.

Чанарын судалгаагаар улс төрийн авлигын хүрээн дэх авлигын гол хор уршиг, үр дагаварыг тодруулахад дараах илэрхийлэмжүүд түлхүү илэрхийлэгдсэн юм. Улс төрийн хүрээний авлигын хор уршиг нь нийт улс үндэстнийг хамарч, улмаар нийгмийн үйл явц, улс орны нийгэм-эдий засаг, улс төр- хууль эрх зүйн соёлын төлөвшилд аюултай, хор хөнөөл үлдээх сөрөг үр дагавартай учраас монголын нийгэмд авлига «бугших»-аас сэргийлэх нэн шаардлагатай хэмээн шинжээчид үзжээ. Тодруулбал, улс төрийн хүрээн дэх улс төрийн авлига бий болох шалтгаан нөхцөлийг бүрдүүлэхэд хууль хяналтын хүрээн дэх авлига тодорхой байдлаар нөлөөлдөг хэмээн үзсэн байна.

Зураг 9. Хууль хяналтын хүрээнд авлига хэр түгээмэл байгаад шинжээчдийн өгсөн үнэлгээ



Энэ хүрээнд шинжээчдийн үзэл бодол, илэрхийлэмжид шинжилгээ хийвэл, тэдний дийлэнх нь хууль хяналтын хүрээнд авлига «маш их» гэж 73.1 хувь (25/18 шинжээч), харин хууль хяналтын бүх шатанд авлига «түгээмэл» үзэгдэл болсон хэмээн шинжээчдийн 26.9 хувь (25/7 шинжээч) нь үзжээ. Дээрх тоон үзүүлэлтэд тулгуурлан тухайн асуудалд шинжээчдийн өгсөн илэрхийлэмжүүдийг дараах байдлаар задалж, ангилал үүсгэх боломжтой гэж үзэв.

1. Авлигын эсрэг тэмцэхэд холбогдох хууль тогтоомжийг сайжруулах, хяналтын механизмы бүрдүүлэх

- o Төрийн үйл ажиллагаа нь тодорхой биш, албан тушаалтан өөрийн үзэмжээр асуудлыг шийддэг нь авлигад нөлөөлөх шалтгаан болдог.
- o Хяналт, харууллагын тогтоолоо, механизмыг бүрдүүлэх, авлигын хэргийг үнэн зөвөөр шийдвэрлэх жишиг тогтоох, авлигын хэргийн шийдвэрлэлтийг улстөржилтөөс ангид байлгах, авлига үүсэх нөхцөл байдалд үнэлгээ хийж, авлигын болзошгүй эрсдлийг бууруулах арга хэмжээ авах.
- o Авлигатай тэмцэх олон улсын сайн туршлагыг ул суурьтай судлах, авлигын эсрэг хэрэгжүүлэх баги арга хэмжээг өөрийн улсын онцлог, эдийн засаг, түүх, газар зүй, соёлын хүчин зүйлүүдийг харгалзан тодорхой боловсруулах шаардлагатай. Тухайлбал: 1.холбогдох хууль тогтоомжийг чангатгах, шүүхийн тогтоолоог бие даасан, үр дүнтэй болгох, авлигын эсрэг уогц харуу арга хэмжээг хатуу авах, авлига авсан албан тушаалтнуудад хатуу харууллага тооцох (тэдэнд шүүхээс ердийн шийтгэл оногдуулахаас гадна авсан авлигын зардлыг заавал нөхөн төлүүлэх, бүрэн нөхөн төлөх боломжгүй этгээдэд илүү хатуу харууллага тооцох, авлигын хэрэгт холбогдсон ялагдагч нь нас барсан бол эд хөрөнгийг нь хурааж авах гм); 2.нийт ард түмний эдийн засгийн байдлыг сайжруулах (ядууралтай тэмцэх), нийгмийн тэгш байдлыг хангах, шударга байдлыг албан ёсны зан үйлийн хэм хэмжээ болгох; 3.төрийн алба хоорондын үйл ажиллагааг уялдаа холбоотой болгох, мэргэшсэн захиргааны боловсон хүчин бэлтгэх, ёс зүйн өндөр хэм хэмжээг дагаж мөрдөх, түүнд хатуу хяналт тавих, төрийн албан хаагчдын иалинг нэмэгдүүлэх; 4.АТГ-ын шалгах ажлын төрөлд төрийн албаны бүх төвшингийн албан хаагчийн албан үүргийн хайхрамжгүй байдал, хайнга хандсан хэргийг нэмж оруулах.

2. Авлигаас ангид байх соён гэгээрүүлэх ү/а-г эрчимжүүлэх, нэгдсэн арга зүй бодлоготой байх

- o Хууль, хяналтын байгууллагын удирдлагуудыг томилоходоо олон нийтийг оролцуулсан нээлттэй сонголт заавал хийж томилох үйл ажиллагааг бүх шатанд хэвшүүлэх /тухайн албан тушаалтан үнэхээр хараат бусаар, хуулийн дагуу, шударга ёс, эрх зүйт ёсны дагуу ажиллаж чадах эсэх бүх мэдээллийг иргэдэд нээлттэй мэдээлж, хэлэлцүүлэг өрнүүлэх боломжоор хангах/;
- o Танилцах, зөвшилцөх, томилгооны үр дүнд үнэхээр тухайн албан тушаалтанд тохирохгүй болох нь ил болсон мэдээллээс харагдвал тухайн хүнийг томилохоос татгалзах;
- o Хууль хяналтын байгууллагын дэргэд олон нийтийн хяналтын зөвлөл ажиллуулах /үр нөлөөтэй/;
- o Тухайн байгууллагад албан хаагчийг албан тушаал дэвшүүлэхдээ ур чадвараас гадна хувь хүний төлөвшил, ёс зүй, хүн чанарыг /энэ тийм хийсвэр зүйл биш гэж бодож/ заавал харгалзан үзэж дэвшүүлэх; (iv) -соён гэгээрүүлэх ажлыг үр дүнтэй л хийх.

3. Улс төрийн болон авлигаас нагид байх соёлыг төлөвшүүлэх

- Ядуурлыг бууруулах, хүүхэд залуучуудыг багаас нь эх оронч болон хүмүүжүүлж, төлөвшүүлэх.
- АТГ байгуулагдаад олон жил боллоо маш тодорхой хэргүүдийг илрүүлж чадахгүй өнгөц төдий шийдвэрлээд байгаа нь газрын мөн чанар, үйл ажиллагаанд итгэх байдлыг эргэлзүүлэхэд хүргэж байна.
- иргэд, олон нийтийн улс төрийн соёл, улс төрийн боловсролын сайжруулахгүйгээр авлигыг бууруулах боломж бага. Нөгөөтэйгүүр, улс төрчид, намын нөхдүүд болон хууль хяналтын байгууллагынханы алда азавхрал, хуийн ашиг сонирхлын хийрхэл авлигыг өөгшүүлж байна. нэгэнт авлига, албан тушаалын гэмт хэрэг нь илэрхсэн бол харуулаага бодитоор, үнэн зөв хуулийн дагуу шийдвэрлэж байх хэрэгтэй.

4. Шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх, ёс зүй-шударга ёсны тогтооцоог бэхжүүлэх

- Авлигын мэдээлэгчийг үнийн дүнгийн тодорхой хувиар урамшуулах тогтооцоог бий болгож, энэ талаар олон нийтэд тодорхой ямар үр ашиг хүртэх талаар сурталчилгаа хийх. Одоогийн сурталчилгааны ажлууд хэт ерөнхий уриалгын шинжтэй байдгаас олон нийтэд хүрэхлээ хэт хоосон хөндий байдлыг харагдуулж байна.
- Авлигын гэрчийг нууцлах, хамгаалах тогтооцоотой болох.
- Авлига өгөгчийг харуулаагаас чөлөөлөх. Ингэснээр цаашид авлига авах нь эрсдэлтэй болохыг албан тушаалтнууд ухамсарладаг болно
- Шүүх, хууль хяналтын байгууллагуудад ажиллагасдын ёс зүй, шударга ёсны тэнгэр алдагдсан, бие биенийгээ өмгөөлөн хамгаалах явдал газар авсаар байна.
- Хууль боловсруулахдаа ял шийтгэлээс илүү нийгэм/субъектууд дагаж мөрдөх зан байдлын хэм хэмжээ буюу гэмт хэргийн тодорхойлолтыг чанглах концепцид шилжсэн нь үр дүнтэй болно.
- Цагдаа, прокурор, шүүгч мэргэшсэн, туйлбартай, ёс зүйтэй үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хангах, мөн олон нийтийн хуулийн мэдлэг (иргэний эрхзүйн нийгэмшил) дээшлүүлэхийг шаардана.

5. Хууль тогтоомжид заасан авлига, гэмт хэргийн тодорхойлолтууд тодорхой болгох

- Хууль тогтоомжид заасан авлига, гэмт хэргийн тодорхойлолтуудыг дэлхийн тэргүүн жишгийн дагуу илүү нарийн болгох. Эрүүгийн хуулиас 2017 онд хүчингүй болгож хассан 22.2-р зүйлийг сэргээж “албаны эрх нөлөөг урвуулан ашиглах” (trading in influence/influence peddling) гэх албан нөлөөгөө ашиглан шийдвэр гаргуулах тухай бие даасан ойлголт, үзэгдлийг “эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” гэх шийдвэр гаргагч эрх хэмжээгээ хууль бусаар ашиглах тухай ойлголт, үзэгдэлтэй нэгтгэн хоёр өөр субъектыг 22.1-р заалтад хамруулсаныг засч залруулах.
- Албаны эрх нөлөөгөө урвуулан ашиглах нь өндөр түвшний авлигын гол шалтгааны нэг мөн. Эрх нөлөөг урвуулан ашиглах тухай ойлголтыг авлигын эсрэг үйл ажиллагаанд зөв хэрэглэхийн тулд лобби үйл ажиллагааны тухай хууль тогтоомжийг боловсруулж батлах шаардлагатай.
- Гэмт хэрэг болон давтан үйлдлээс урьдчилан сэргийлэхэд ял шийтгэлийн шинж (хатуу зөөлөн) нь бус, харин шийтгэлийн зайлшгүй чанар (certainty of punishment) нь илүү үйлчлэлтэйг ялын бодлогоороо ихээхэн ялгаатай АНУ, Герман, Швед улсын харьцуулсан судалгаа нотолсон байдаг.

Шинжээчдийн өгсөн эдгээр илэрхийлэмжүүдээс хууль хяналтын байгууллагад авлига түгээмэл болсон гэдэгтэй экспертүүд санал нэгтэй байгааг харуулахын зэрэгцээ үүнийг дараах байдалтай холбон тайлбарлах боломжтойг харуулав. Тодруулбал, хууль хяналтын байгууллагын хараат бус байдал алдагдаж улс төрийн нөлөөлөлд бүрэн автсан нь хууль хяналтын байгууллагад шударга бус байдал газар авах нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн хууль хяналтын байгууллагын удирдлагын томилгооноос шууд хамааралтайгаар доош чиглэсэн танил талаараа хүрээлүүлэх, дээшээ улс төрийн намд үйлчлэх явдалтай шууд холбогдоно. Тиймээс ч энэ хүрээнд авлигыг цэцэглүүлэх суурь болоод зогсохгүй түүний эсрэг арга хэмжээ авах сонирхол, сэдэлгүй болсоныг харуулж буйн бодит жишээ гэж үзэж болно.

Цаашилбал, улс төрийн авлигын хор уршиг, сөрөг үр дагаваруудыг бага, дунд зэргээр ангилахаас илүүтэй эдгээр үзүүлэлтүүдийн үнэлгээ улам бүр нэмэгдэх аваас байдал үлэмж даамжирч, улмаар улс орны тусгаар тогтнол, эдийн засгийн аюулгүй байдал эрсдэл учруулж болзошгүй. Үнэндээ авлигаас олсон «бохир» хөрөнгө нь нийгэм болоод үндэстэн доройтох, ардчиллын үнэт зүйлс алдагдах хамгийн гол шалтгаан болсон нь энд хөндөгдөх асуудалтай шууд холбогдоно. Энэ бол улс төрийн авлигаас олсон хөрөнгийн зарцуулалт түүний хэмжээ үр дагавар хэрхэн нөлөөлж буйгаар илэрнэ.

Энэ удаагийн чанарын судалгаагаар авлигын нөхцөл байдлыг арилгахад эрх зүйн бус ямар шийдлүүд байж болох талаар тодорхой санал дэвшүүлэхийг оролдсон юм.

Ингэхдээ эл гүнзгийрүүлсэн яриллагад хамрагдсан шинжээчдээс авлигыг бууруулахад шаардагдаж эрх зүйн бус ямар шийдлүүд байж болох талаар тодруулав. Тэдгээрийг багцлан үзэхүл:

1	<p>Иргэд, олон нийтийн улс төрийн соёл</p> <ul style="list-style-type: none"> ○ Олон нийтийн улс төрийн боловсролыг сайжруулахгүйгээр авлигыг бууруулах боломж хомс. ○ Улс төрчид, намын нөхдүүд болон хууль хяналтын байгууллаагынханы алдаа завхрал, хувийн ашиг сонирхлын хийрхэл авлигыг өөгшүүлж байна. ○ Авлига, албан тушаалын гэмт хэрэг нь илэрсэн бол хариуцлагаа бодитоор, үнэн зөв хуулийн дагуу шийдвэрлэж байх хэрэгтэй. ○ Хэрэг үүсгэж, мөрдөн байцаалтын шатанд байгаа гэдгээр мэдээллийг нууж, мартагнуулдаг, хэрэгсэхгүй болгодог байдлыг халах. Өөрөөр хэлбэл, нотлох баримтуудыг ил болгох гадаад орны туршлага (АНУ-ын шүүх бүх нотлох баримтыг вэб хуудсанд ил байршуулдаг)-ыг нэвтрүүлэх.
	<p>Хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байдлаас үүдэн нийтийн албанд үл итгэхүй</p> <ul style="list-style-type: none"> ○ АТГ-ын соён гэгээрүүлэх үйл ажиллагааг сүүлийн үед харьцангуй сайн явагдаж байгаа хэдий ч яг холбогдсон авлига албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэлт тодорхой бус байгаа нь тус байгууллагад эргэлзэх сэтгэгдэл төрүүлдэг. ○ Санхүүгийн орчныг эрүүлжүүлж, бүрэн цахим болгох замаар улс төрийн намуудын санхүүжилт, тэдний намын хандив нэртэй илүүдэл, орлогыг ил тод болгох шилэн улс төрийн намыг бий болгох. ○ Иргэдэд авлигыг үл тэвчих сэтгэлгээ, хандлагыг бий болгох талаар нөлөөллийн ажил хийх; Авлига авсан, өгсөн этгээдийг нийтэд ил тод зарлах, тэдний хийсэн үйлдлийг өөрсдөөр нь жигшүүлж ухааруулах.

2	<p>Шударга бус байдал, ёс зүйн асуудал</p> <ul style="list-style-type: none"> ○ Хууль, шүүхийн байгууллагуудад ажиллагсдын ёс зүй, хариуцлагын тогтолцоог өндөржүүлэх, аливаа төрлийн хэлхээ холбоог таслан зогсоох. ○ Улс төрийн байгууллагын хүрэн дэх авлигын асуудалд улс төрийн нам, улс төрчдийн нөлөөллийг бууруулах. ○ Төрийн өндөр албан тушаалтнууд ёс зүйн хариуцлага хүлээдэг байх; ○ Хууль тогтоогчдын хувийн сонирхол, албан тушаалын хэрэгт холбогдсон этгээдүүдэд ногдуулах шийтгэл, хариуцлагыг шударга шүүхээр шийдвэрлэдэг болгох. ○ Улс төрийн намуудын дотоод ардчилал, бодлогын шинэчлэл хийхэд АТГ-аас тодорхой хэмжээний нөлөөллийн ажил явуулж байх хэрэгтэй байна.
	<p>Улс төрийн хариуцлага хүлээлгэх, хяналтын механизм бүрдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> ○ Мэргэжлээрээ дахин ажиллах боломжгүй болгож хуульчлах. ○ Мэргэжлийн холбоодын оролцоо, хяналтыг хүчирхэгжүүлэх, хуульчдын чадамжид суурилсан бодит өрсөлдөөнийг дэмжсэн сонгон шалгаруулалтад үндэслэсэн томилгооны тогтолцоог хөгжүүлэх. ○ Үнэнч шударга, авлигаас ангид ажилласных нь төлөөх эдийн засгийн урамшууллын өгөөжтэй механизмыг нэвтрүүлэх. ○ Төрийн байгууллагыг чиг үүргээ хараат бус, шударгаар хэрэгжүүлэх нөхцөл боломжоор бүрэн хангах. ○ Улс төрийн нам, улс төрчдийн ёс зүй, хүн чанар, эх орон ард түмний төлөө гэсэн чин хүсэл зоригийг сайжруулах. Улс орны хөгжил, дэвшил, иргэдийн сайн сайхны төлөө ажиллах улс төрч, лидерүүдийг бэлтгэх, сонгох.

3	<p>Хариуцлага, нээлттэй байдал</p> <ul style="list-style-type: none"> o Хэн ямар хууль санаачлав, хэнийг хаана томилов? эдгээр шийдвэрийн үр дагаварт тогтолцооны шинжилгээ хийгээд, хамаарал бүхий этгээдүүдийн ХОМ, ХАС гадна хамаарал бүхий компаниудын орлогыг шилэн нээлттэй болгох. o ТББ-ууд зөвхөн авлигын асуудлаар 5-аас дээш жил мониторинг хийх, сэтгүүлчид мөн 10 жилийн эрэн сурвалжлага хийж, аюулгүй байдлыг төр хангах, хамгаалалтад авах хэрэгтэй. o Хариуцлагыг дээшлүүлж, олон нийтийн оролцоо, хяналтыг бодитой сайжруулах. o Төрөл бүрийн шатны боловсролын байгууллагууд болон мэргэшүүлэх сургалтуудаар дамжуулан соён гэгээрүүлэх, ёс зүйн хэм хэмжээ суулгах, нээлттэй ёс суртахууны боловсрол олгох. <p>Нийгмийн хэм хэмжээ, хууль эрх зүйн орчныг хатуу чангатгах бодлого авч хэрэгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> o Намын тогтолцоо, санхүүжилт, сонгуулийн тогтолцоог сайжруулах. o Парламентын үйл ажиллагааг сонгодог парламентын хэлбэрт оруулахгүй бол мэргэжлийн биш парламент нь авлига хээл хахуульд автах, мөнгөний нөлөөлд өртөх эрсдэл өндөр хэвээр байна. o Сонгодог, мэргэшсэн парламентыг хөгжүүлэх бэхжүүлснээр төрөөс эрх ашиг нь хаагдаж авлигаас үүдэлтэй аливаа сөрөг үзэгдэлүүдийн үр нөлөө багасна. o Төрийн өндөр албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээдэг соёлыг бий болгож байгаа. Мөн мэдээллийн технологийн дэвшилтэт арга технологи төрийн үйлчилгээний салбарт эрчимтэй нэвтэрч эхэлсэн нь авлигыг бууруулах нэг хүчин зүйл болж байна.
---	---

Энэхүү багцалсан эрх зүйн бус шийдлүүдэд хуулийн хэрэгжилтийн сахин хангах замаар хяналт-хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх шаардлагатайг шинжээчид чухалчилсан. Тэдний үзэж буйгаар хариуцлагыг дээшлүүлж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар хяналтыг илүү бодиттой сайжруулахыг онцолж байв. Нөгөө талаар, улс төрийн намын тогтолцоо, түүний санхүүжилт болоод парламентын үйл ажиллагаанд сонгодог хэлбэрээр явагдах, үр дүнтэй шударга ажиллах зарчим бүрдүүлж төрөөс хууль бусаар хүртэх эрх ашиг хумигдаж улс төрийн хүрээгээр дамжуулан авлига авах явдал эрс буурах боломжтой хэмээн онцлон дүгнэж байна.

Дүгнэлт

Чанарын судалгааны дүгнэлт нь шинжээчдийн төсөөлөлд тулгуурлан гарсан санал, мэдрэмжийн илэрхийлэмж бөгөөд улс төрийн болон шүүх, хууль хяналтын хүрээ, өнөөгийн бодлого боловсруулагчдын төвшинд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ зэргээр зааглагдсан болно. Үүнийг дараах байдлаар танилцуулж байна.

Нэг. Чанарын судалгаанд хамрагдсан шинжээчид улс төр, хууль хяналын байгууллагуудын хүрээнд авлигын түвшин буурах хандлага ажиглагддаг хэдий ч нөхцөл байдал дээр бодиттой үр дүн харагдахуйц төвшинд хүрэхгүй байгааг онцолсон. Тодруулбал, намын тогтолцоо, улс төрийн намын санхүүжилт, сонгуулийн тогтолцоог сайжруулахгүйгээр улс төр, шүүх, хууль хяналтын хүрээн дэх авлигыг бууруулах боломжгүй хэмээн үзсэн. Сүүлийн жилүүдэд төрийн зарим албан хаагчид эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигладаг байдал нэмэгдэх болсон үүний нэг шалтгаан болж буй. Төрөөс энэхүү эрх ашгийг хуулийн хүрээнд бодитоор хааж чадахуу авлига бий болох явдал эрс багасах боломж бүрдэнэ.

Улс төр, шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигад ихээхэн нөлөөлж буй зүйл бол албан тушаалын давуу байдлаа ашиглах замаар өөрт буй эрх мэдлийг ашиглах явдал энэ хүрээний авлигын хэлбэр илүү түгээмэл болсонтой холбоотой. Нэг үгээр бол, бусдын эрх ашгийг хангахад чиглэх байдлаар аль нэг банкиг дампууруулах, эсхүл үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс зориудаар нөлөөлж дампууруулах, улмаар ял шийтгэл багатайгаар шүүхийн шийдвэр гаргуулах тодорхой кэйсүүд⁵ сүүлийн үед

5 Улсын дээд шүүх Б.Ундармааг оноосон ялыг хэвээр нь үлдээв. Дэлгэрэнгүй мэдээллийг <https://news.mn/r/2454686/> -ээс үзнэ үү (Assessed by 22.07.2021).

гарах болсон нь улс төрчид, төрийн өндөр албан тушаалтнуудын зүгээс төрийн аливаа үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх гэсэн хууль бус нөлөөлөл харьцангуй нэмэгдэх хандлагыг бий болгож байна.

Өнөөгийн монголын нийгэмд хүндрэл үзүүлж буй асуудал бол бизнесийн бүлэглэл юм. Эл бүлэглэл нь албан тушаалд томилж эсвэл байгууллага, бүлэглэлийн хувьд эрх зүйн орчноор дамжуулан давуу нөхцөл олгох байдлаар эрх ашгаа хамгаалах, ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх явдал илт нэмэгдэх болсон. Үүнээс гадна, бизнесийн бүлэглэлийнхэн улс төрчдийг эрхшээлдээ оруулж, өөрсдийн аясаар хөдөлгөх, өөрсдөө ашигтай улс төрийн болон сонирхлын шийдвэр гаргуулахад улс төрчдийг «бүлэг, фракцаар нь» ашигладаг талаар шинжээчид дурдаж байсныг энд онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Хоёр. Улс төрчид шүүгч, хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдэн нийлэх замаар холбоо сүлбээ тогтоосноор авлига, албан тушаалын хэрэг үлэмж даамжирч, улмаар арга хэрэгсэл нь нарийсч, өөрсдийн гэмт хэргийг хууль, шүүхийн механизмыг ашиглан далдах, цаашлаад бусдыг дарамтлах, айлган сүрдүүлэх аргаар бизнесийг нь дээрэмдэх зэрэг бусармаг үйлдэл хийх сэдлийн үндэс болсоор байгаагийн зэрэгцээ шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлига их байгаа нь чанарын судалгааны тодорхой үр дүнгүүд харуулсан.

Шүүх, хууль хяналтын байгууллагын байгууллагын удирдлагын үйл ажиллагаа, томилгоог бүлэглэлээр дамжуулан томилдог хандлага нэмэгдсэнээр бүлэглэлээр нэгнийгээ хамгаалдаг, алдаа дутагдлыг нь хаацайлах зэргээс хуулиас гадуур шударга бус байдал даамжирах нөхцөлийг бүрдүүлж байна. Үүнийг ч шинжээчдийн зүгээс шүүх, хууль хяналтын бүх шатанд, дунд болон дундаас дээш өндөр албан тушаалтнууд намын даалгавраар «өөрийн гарын хүнээ» томилдогоос энэ түвшинд авлига, албан тушаалын гэмт хэрэг нүүрлэх гол шалтгаан болсоныг онцолж байсныг энд дурдах нь зүйтэй. Тухайлбал, авлигатай тэмцэх үйл ажиллагаа тодорхой хүрээнд хийгдээд байгаа хэдий ч эл хавтгайрсан үзэгдэл нь ганц, хоёр арга хэмжээг хэрэгжүүлснээр шууд арилах боломжгүй. Хэдийгээр зарим нэг арга хэмжээ үр дүнгээ өгсөн байдаг авч хууль хяналтын болон шүүхийн байгууллагаар шийдэгдэх нь удаашралтай байсаар арга хэрэгч, замхрах» байдлаар сураг тасарч байгаа нь энэ хүрээнд механизм хангалтгүй байгаагаас гадна улс төрийн хүсэл зориг дутагдаж байгаатай уяа холбоотой. Энэ нь харууллагын асуудал маш хангалтгүйг илтгэнэ. Үүнийг ч эрх зориг судалгаанд хамрагдсан шинжээчид дэлгэрэнгүй тайлбарласан бөгөөд судалгааны үр дүнг дараах байдлаар танилцуулж байна. Ерөөсөө төрийн өндөр удирдах түвшний албан хаагчдын ёс зүй дутмаг, улс төр, эдийн засаг, эрх мэдэл төвлөрсөн бизнесийн бүлэглэлүүд сонгуулийн санхүүжилтийг «босгож» асуудлыг шийдэж байгаа нь эргээд авлигын барьяанд орох шалтгааныг үүсгэж байна.

Гурав. Авлигын хор уршиг, үр дагавар нь нэгд, өмч хөрөнгийн тэгш бус байдлыг нэмэгдүүлэх, хоёрт, улс орны эдийн засгийн хүч чадлыг сульдаан ганхуулах, гуравт, шударга ёсыг алдагдуулж, нийгэмд шударга бус ёс зүй, ёс суртахуунгүй үйлдэл автах, дөрөвт, төрийн албаны чадавхыг сулруулахад сөрөг үр нөлөөтэй. Мөн нийгмийн итгэлцэлийг бууруулж, улмаар улс төрийн хүрээний авлига буюу төрийн өндөр албан тушаалтнуудын авлигад автах сэдэлийг улам бүр өөгшүүлэх хандлага түгээмэл болсон. Үүний хор нөлөө ч өнөөгийн нийгэм, эдийн засаг, олон нийтийн сэтгэл зүй, хөгжлийн үйл явцад хамгийн их хор уршиг, сөрөг үр дагаврыг учруулах нь тодорхой ажиглагдсаар байна.

Хууль тогтоох байгууллагын зүгээс найм дах удаагийн парламентын сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан энэ хаврын УИХ-ын чуулганаар шийдсэн нэг чухал шийдвэр бол төрийн томоохон байгууллагуудын удирдлагыг томилгооны сонголт хийж томилдог болсон. Үүний эхний жишээ бол АТГ-ын дэд даргын томилгоог олон нийтэд нээлттэйгээр анх удаа томилгооны сонголт хийж томилсон явдал байв.

Ингэснээр «халаасны» дарга нарыг томилдог жишгийг халах эхлэлийг тавьсан гэж болно.

Ийнхүү Монгол Улсад тулгараад буй нөхцөл байдлыг харгалзан төрийн албан хаагчдын эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглаж буй байдлыг таслан зогсоох, бизнес эрхлэгчдэд учирч буй дарамт, хүнд суртал, авлигыг бууруулах төрийн байгууллагуудын ажлын уялдааг хангах явдал нэн чухал болохыг олон жилийн судалгааны дүнгүүдэд хөндөгдсөөр ирсэн. Улмаар төрийн байгууллагын хүнд суртлыг арилгах, авлига хээл хахууль нэмэгдэж, нийгэмд баян хоосны ялгаа нэмэгдэх болсон зэрэг нь иргэдийн амьдралын чанарт нөлөөлж, дундаж давхаргыг бүрдүүлэхэд саад болж буй тул авлигатай тэмцэх үйл ажиллагааг илүү өргөн хүрээтэй явуулах үндсэн шаардлага нийгэмд үлэмж дутагдаж байгаагийн илрэл гэж үзэх үндэслэлтэй.

Санал, зөвлөмж



Ардчилсан нийгэмд иргэний нийгмийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг нь төрөл бүрийн сувгаар тухайлбал, улс төрийн намууд, сонгуулийн кампанит ажлуудаар иргэдийн улс төр, засаглалын харилцаанд оролцох оролцоог бий болгож, улмаар тэдний эрх ашгийг хамгаалах цэвэр дуу хоолойг бүрдүүлэх замаар авлигыг бууруулах, түүнд хяналт тавих зөв зохистой хандлага, шинэ дадал юм. Нөгөөтээгүүр, авлига авах нөхцөл боломжийг хэрхэн арилгах талаар шинжээчдийн дэвшүүлсэн саналуудад шинжилгээ хийж дараах зөвлөмжийг багцлан танилцуулж байна.

1. Эрх зүйт төр нь хуулийг дээдлэх, төр, иргэний харилцан үүрэг хүлээх, хүний жам ёсны эрх, эрх чөлөөг хангах зэрэг үндсэн зармуудаар биелэлээ олдог жамтай. Тэр агуулгаараа гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, цаашлаад хохирлын төрөл хэмжээг тогтоох, үнэлэх, шийдвэрлэх, нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага өнөөдөр улам бүр үгүйлэгдэж байна. Энэ хүрээнд хууль, ёс суртахуунд захирагддаг улс төрийн соёлыг төлөвшүүлэхийг зөвлөмж болгож байна.
2. Авлигын бүх хэлбэрт эрүүгийн харуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох явдал бол авлигатай тэмцэх үйл ажиллагааны нэг чухал бүрэлдэхүүн мөн боловч шүүх тогтолцооны тусламжтайгаар шударга бус явдлыг таслан зогсоож, зөрчигдсөн эрхийг сэргээж, авлигын эсрэг хууль тогтоомжийг шударгаар хуулийн хүрээнд хэрэгжиж буй байдлын өнөөгийн төвшинд үнэлэлт дүгнэлт өгөх явдал мөрдөн шалгах ажиллагааны нэг чухал зорилт байх учиртай. Энэ хүрээнд Төрийн албыг цомхон, чадварлаг болгоход чиглэгдсэн шинэчлэлийг нэн даруй эхлүүлэх, мөн цахим засаглалын хэрэгжилтийг бодитоор ханган биелүүлэхийн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна.
3. Хуулийн хэрэгжилтэд тавих бүх талын хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлж, хууль зөрчсөн албан тушаалтанд харуцлага хүлээлгэх зарчмыг хэрэгжүүлэх талаар бодит алхам хийх замаар хуулийн хэрэгжилт ба шүүх, хууль хяналт - харуцлагын тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

6 Бямбаогт С. Халаасны дарга нарыг томилдог жишгийг халсан. (нийтлэлч. Э.Аруунаа. 2021.07.20). Дэлгэрэнгүйг <https://news.mn/r/2454047/> -ээс үзнэ үү.

7 Хууль зүйн үндэсний хүрээлэн. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол. Судалгааны тайлан. Уб., 1 дэх тал. Дэлгэрэнгүйг https://nli.gov.mn/pdf/gemtherguinulmaas_uchirsanhohirol.pdf -ээс үзнэ үү. (Assessed by 4.07.2021)

4. Улс төр, хувийн ашиг сонирхлоос ангид байх зарчмыг хэвшүүлэхэд улс төрчдийн ёс зүйн хэм хэмжээг батлан мөрдүүлэхэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Шүгэл үлээгчдийн хамгаалах эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгор замаар хуулийг баталж бүх шатанд төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах.
- 5.. Мэдээллийн тогтвортой байдлыг хангах, ил тод, нээлттэй, «шилэн» болгох хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Цахим хэлбэрт шилжих замаар мэдээллийг ил тод болгож аливаа гажуудал, эрүүл бус тогтолцоо арилгахад чиглэгдсэн цахим шилжилт хийх. Түүний мэдээллийн нууцлал, хамгаалалтын тогтолцоо, механизмыг бүрдүүлэх.
6. Иргэн бүрт авлигын хор уршиг, түүний нийгэмд үзүүлж буй хор хөнөөлийг онцолсон зан үйлийн соёлыг бүх шатны боловсролын байгууллагын хүрээнд сурталчлан танцуулах, улмаар энэ төрлийн соёлыг төлөвшүүлэх хүрээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх аяныг давтамжтайгаар өрнүүлэх. Энэ хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.



**ШҮҮХ, ХУУЛЬ ХЯНАЛТЫН
БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН
ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ
ТӨСӨӨЛӨЛ - 2021 ОН**

УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл: Авлигатай тэмцэх газар 2008 оноос хойш жил тутам «Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа»-г зохион байгуулж судалгааны үр дүнг Мянганы хөгжлийн 9 дэх зорилтын «Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгох, хэвшүүлэх» 24 дүгээр зорилтын хэрэгжилтийг үнэлж дүгнэх нэг шалгуур болгож ирсэн. Судалгаа нь авлигын хандлага, авлигад өртөмтгий ажил, албан тушаал, авлигад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Мөн улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэхэд мэдээллийн чухал их сурвалж болох учиртай.

2017 он хүртэл улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын талаарх төсөөллийг нэг судалгааны хүрээнд судалж, нэгтгэсэн тайланг гаргаж байсан бол 2018 оноос эхлэн тус хоёр хүрээг тусад буюу «Улс төрийн хүрэн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа» болон «Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрэн авлигын талаарх төсөөллийн судалгаа» хэмээн нь авч үзэж, тайланг гаргадаг болсон юм.

Судалгааны зорилго, зорилт: Монгол Улс дахь шүүх, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлига буюу «дээд (өндөр)» түвшний авлигын шинж чанарыг тодорхойлоход чиглэгдсэн. Ингэхдээ дараах хэд хэдэн зорилтыг дэвшүүлэв. Үүнд:

- Авлигын талаарх төсөөлөл, хандлага, шалтгааныг тодруулах;
- Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигад автагдсан байдал, цар хүрээ, авлигын хэлбэрийг авч үзэх;
- Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын шалтгаан, нөхцөл түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах;
- Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын хэмжээ, түүний хор уршиг, үр дагаврыг гаргах;
- Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигатай тэмцэх үйл ажиллагааг үнэлүүлэх, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах зэрэг болно.

Судалгааны арга зүй: Энэ удаагийн тоон судалгааны мэдээллийг дэлхий нийтийг хамарсан КОВИД 19 цар тахлын улмаас улс орон даяар зарласан УОК-ийн улбар шар төвшний онцгой байдлын нөхцөл байдлаас шалтгаан утсаар мэдээлэл хүргэн зөвшөөрөл авч, судалгаанд хамрагдахаа илэрхийлсэн шинжээчдийн цахим шуудангийн хаягаар асуулгыг илгээн мэдээлэл цуглуулав. Ингэхдээ шинжээчдээр асуулт бүрийг «1-5» гэсэн баллаар үнэлүүлж, улмаар цуглуулсан мэдээллийг боловсруулан тооцоолсон болно. Баллын үнэлгээ буурах тусам эерэг утгыг илэрхийлж байгаа бол, баллын үнэлгээ өсөх тусам сөрөг утгыг илэрхийл буйг энд тэмдэглэх нь зүйтэй. Өмнө нь дан тоон судалгааны аргыг ашигладаг байсан бол 2018 оноос эхлэн чанарын судалгааны аргыг нэмэлтээр нэвтрүүлж эхэлсэн. Судалгааны мэдээлэлд шинжилгээ хийхдээ «Шүүх, хууль хяналтын байгууллагын авлигын талаарх төсөөллийн 2018-2020 оны судалгаа»-ны тоо баримттай харьцуулан шинжилж, гарсан өөрчлөлт, үр дүнг тогтоосон болно.

Мэдээллийг боловсруулах арга: Цахим хэлбэрээр зохион байгуулж анкетын аргаар цуглуулсан мэдээлэлд боловсруулалт хийх орчин үеийн багц программ «SPSS-22»-ыг хэрэглэн боловсруулалт хийв. Гаргасан өгөгдөл дээр анхдагч үр дүн болох нэг хэмжээст тархалтыг гаргахын зэрэгцээ шинээр хувьсагч үүсгэх, дундаж

үзүүлэлтийг бодох, харьцуулалт, график шинжилгээ хийж, үр дүнг тодорхойллоо. Энэхүү шинжилгээний хүрээнд доорх зураг (Зураг 1)-т харуулсан үр дүнг товчоолон танилцуулж байна.

Зураг 1. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын үнэлгээ, үзүүлэлтийн ерөнхий схем




Нэг. 2021 оны Авлигын ерөнхий төлөв

Энэхүү бүлэгт Монгол Улс дахь авлигын ерөнхий төлөвийг гаргах, чингэхдээ авлигын төлөв байдлыг түвшин, салбар хүрээгээр нь үнэлүүлж, улмаар авлига гарч буй шалтгаан, нөхцөлийг тодорхойлохыг зорьсон болно.

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгаанд хамрагдсан шинжээчдээр Монгол Улсын авлигын ерөнхий төлөв, түгээмэл байдлыг салбар хүрээгээр нь 1-5 баллаар үнэлүүлэхэд түүний дундаж 3.82 гарав.

Зураг 2. Монгол Улс дахь авлигын түвшин, түгээмэл байдал (хувиар)



Монгол Улс дахь авлигын өнөөдрийн түвшинг тодруулах зорилгоор хийгдсэн энэ удаагийн шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгаанд хамрагдсан шинжээчдийн 87.4 хувь нь Монгол Улс авлигад «их автсан» хэмээн үзжээ. Үүнийг тодруулбал, нийт судалгаанд хамрагдсан шинжээчдийн 26.6 хувь нь «маш их», 60.9 хувь нь «их» гэж хариулсан байна. Үүнээс Монгол Улс авлигад

«их автсан» гэж үзэгсэд өмнөх оноос даруй 10.1 хувиар өссөн нь харагдана. Тэгвэл, шинжээчдийн 9.4 хувь нь «дунд зэрэг», 3.1 хувь нь авлига «бага зэрэг» байна хэмээн тус тус илэрхийлсэн. Харин «огт байхгүй», «хэрхэн харуулахаа мэдэхгүй» гэсэн харцулт эл судалгааны дүнд дурдагдаагүй болно.

Авлигын хүрээний түгээмэл байдлын талаарх тойм

Энэ удаагийн (2021) төсөөллийн судалгаанд хамрагдсан шинжээчдийн хувьд, Монгол Улс дахь улс төрийн нам, засгийн газар (яам, агентлаг), орон нутгийн төрийн захиргааны удирдлага болон Улсын Их Хуралд авлигын төвшинг «их байна» хэмээн үнэлсэн байна. Тухайлбал, төрийн байгууллага, прокурор, шүүх, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд авлига «дунд зэрэг»-ийн тархалттай байна гэж үзжээ. Харин авлига «бага зэрэг» тархсан хэмээн үнэлэгдсэн институциудад боловсрол, хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудыг тус тус багтаасан байна.

Зураг 3. Авлигын түвшинг салбар, хүрээгээр авч үзвэл (үнэлгээний дунджаар)



Тайлбар: Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал (5-маш сайн, 4-сайн, 3- дунд, 2-мааруу, 1-маш муу)

Монгол Улсад улс төрийн нам, орон нутгийн төр захиргааны байгууллага, засгийн газар (яам, агентлаг), төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, УИХ-д авлига **их** (үзүүлэлтүүд 4.02-4.43 хооронд хэлбэлзсэн) байна гэж үнэлэгдсэн. Тэгвэл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, шүүх, прокурорын салбарт авлига **дунд** (үзүүлэлтүүд 3.71-3.98 хооронд хэлбэлзсэн) хэмжээнд буй хэмээн үнэлэгдсэн байна. Харин төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн салбарт авлига **бага** (үзүүлэлтүүд ихэвчлэн 2.61-2.77 хооронд хэлбэлзсэн)-аар үнэлэгджээ. Энэ удаагийн судалгаагаар авлигын түвшин салбар бүрт өмнөх оны дүнгээс өссөн нь ажиглагдаж байна.

Хүснэгт 1. Авлигын түвшин салбар, хүрээг 2018-2021 оноор харьцуулсан үзүүлэлт

№	Салбар хүрээ	2018	2019	2020	2021	Өөрчлөлт
Авлигын түвшин өссөн салбар						
1	Засгийн газар (яам, агентлаг)	4.27	4.32	4.18	4.43	+0.25
2	Улсын Их Хурал	4.02	4.12	4.02	4.15	+0.13
3	Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	3.57	3.72	3.80	3.91	+0.11
4	Прокурор	4.00	4.25	3.88	3.98	+0.1
5	Шүүх	4.09	4.18	3.84	3.90	+0.06

6	Улс төрийн нам	4.28	4.18	4.38	4.40	+0.02
7	Төрийн бус байгууллага	2.27	2.08	2.59	2.61	+0.02
8	Орон нутгийн төрийн захиргааны удирдлага	3.84	4.05	4.17	4.18	+0.01
Авлигын түвшин буурсан салбар						
9	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж	3.83	4.36	4.10	4.02	-0.08
10	Хувийн хэвшил	2.75	2.50	2.84	2.77	-0.07
11	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	3.91	3.58	3.72	3.71	-0.01

Дээрх хүснэгтээс дурдсан 8 салбарт өмнөх оны мөн үеийн дүнгээс (0.01-0.25) өссөн нь ажиглагдав. Ийнхүү авлигын түвшний байдлаас үзвэл, Засгийн газар (яам, агентлаг)-ын авлига «хамгийн их» буюу **+0.25 пунктээр** өссөн үнэлгээтэй байна. Үүнийг 2019-2020 оны өсөлттэй харьцуулахад 2 салбарын үзүүлэлт нэмэгджээ. Харин төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн салбаруудад авлигын түвшин **-0.01-0.08 пунктээр** буурсан дүн гарчээ. Шинжээчид ийнхүү буурсан хэмээн үзсэнээ тодорхой шалтгаанаар тайлбарлаж байв. Тэдний үзэж буйгаар хувийн хэвшлийнхний хувьд өгөрсөн хугацаанд КОВИД 19 цар тахал эрчимтэй нэмэгдсэнээс үүдэлтэйгээр эл салбарт үйлчилгээ явуулахад хүндрэл учирч, харьцангуй удаан хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй нь авлига өгөх гэхээсээ илүүтэйгээр ААН байгууллагуудын, хувийн хэвшлийнхэн ажиллагсдынхаа цалин орлогыг хэрхэн хамгаалах, хадгалах гэдэгт түлхүү анхаарч байсантай холбож байлаа.

Харин төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой ААН-уудын хувьд мөн адил тендер шалгаруулалт, бараа үйлчилгээ худалдан авах, зөвлөх үйлчилгээ авах зэрэг үйл ажиллагаанд зарцуулдаг хөрөнгө мөнгө, түүнтэй холбогдон гарч болох аливаа нэг ашиг сонирхлын сэдэлтэй арга хэмжээ хумигдсан гэж тайлбарлаж байв. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн салбар дахь авлига сүүлийн дөрвөн жилд 3.91-3.71 үзүүлэлтийн хооронд тогтмол хэлбэлзэж буй нь тийм ч сайн үзүүлэлт огт биш болохыг шинжээчдийн төсөөллийн судалгааны харьцуулсан дүн харуулж байна. Шинжээчдийн зүгээс ХМХ-ийн салбар бүхэлдээ авлигаас ангид, тунгалаг, хараат бус байх ёстой болохоос хэн нэгэн этгээд, хувь хүн, албан байгууллага, хувийн хэвшлээс хараат байх нь шударга, ил тод, эрэн сурвалжлах сэтгүүл зүйг төлөвшүүлэхэд ихээхэн бэрхшээл учруулдаг болохыг онцолсон байна.

Авлигын түвшинд нөлөөлсөн гол хүчин зүйлс

Энэ удаагийн шинжээчдийн төсөөллийн судалгаагаар Монгол Улс дахь авлигын түвшинд нөлөөлж буй хүчин зүйлсийг нээлттэй асуулгын хэлбэрээр асууж, гарсан үр дүнг өнгөрөгч оны мөн үед хийгдсэн судалгааны дүнтэй харьцуулав. Чингэхэд, нийтдээ 23 төрлийн санал, илэрхийлэмж давхардсан тоогоор харцуулсныг судлаачдын баг тухайн давхардсан саналуудыг адил утгаар нь кодлол үүсгэн гол хүчин зүйлсийг тодорхойлсон юм. Тэрхүү тодорхойлолтыг дараах байдлаар танилцуулбал: (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Сүүлийн нэг жилийн хугацаанд Монгол Улсын авлигын түвшинд нөлөөлсөн гол хүчин зүйлс, нөхцөл-шалтгаан (хувиар)

№	Хувь	№	Хувь
Төрийн алба, хууль тогтоомжийн хэрэгжилт, үйл ажиллагаатай холбоотой асуудал	72.3	Иргэдийн улс төрийн болон эрх зүйн мэдлэг, боловсролтой холбоотой асуудал	9.3
1 Хуулийн хэрэгжилт, хяналт сул	12.3	16 Ёс суртахууны доройтол	1.4
2 Төрийн бодлого алдагдсан, төрийн эрх бүхий албан тушаалтны шийдвэр буруу	10.1	17 Иргэдийн төрд итгэх итгэл үнэмшил сул	1.4
3 Цар тахал, түүнээс урган гарч буй шийдвэр	10.9	18 Хүмүүсийн хандлага буруу	2.9
4 Төрийн захиргаа, тусгай, үйлчилгээний аль ч байгууллагын боловсон хүчний томилгоо мэдлэг чадвар дээр үндэслэдэггүй.	6.5	19 Иргэдийн мэдлэг, боловсрол дутмаг	3.6
5 Эрх зүйн орчны оновчтой зохицуулалт дутмаг.	6.5	Эдийн засгийн асуудал	7.9
6 Танил тал, цусан холбоо, мөнгө төгрөгөөр шийдэгддэг явдал хавтгайрсан.	6.5	20 Ажилгүйдэл, ядуурал	6.5
7 Менежерийн чадваргүй байдал, дээд шатны байгууллага, удирдлагын манлайлал байхгүй.	5.1	21 Үнийн өсөлт	1.4
8 Оногдуулах харуцлага сул	3.6	Улс төр, сонгуультай холбоотой асуудал	10.1
9 Албан тушаал наймаалцаг	2.9	22 Улс төрийн нам тохироо хийдэг	6.5
10 Төрийн байгууллагын уялдаа холбоог сайжруулах	2.2	23 Улс төрийн дарамт, төлөвшөөгүй байдал	3.6
11 АТГ-ын үйл ажиллагаа оновчтой биш	2.2		
12 Бүлэглэлийн эрх ашгийн зөрчил нэмэгдсэн.	1.4		
13 Байгууллагын ашиг сонирхолд хандах хандлага сул.	0.7	Нийт	100.0
14 Нэг нэгнийхээ ажлыг үгүйсгэдэг байдал	0.7		
15 Хуулийн уялдаа холбоо муу, хоёр талаас нь хэрэглэх боломжтой байдаг.	0.7		


Шинжээчдээс сүүлийн нэг жилийн хугацаанд Монгол Улсад авлига гарахад нөлөөлсөн гол шалтгааныг тодруулахад дараах зүйлсийг онцолж байв. Тэрхүү шалтгаан нөхцөлүүдэд нөлөөлсөн байдлыг бүлэглэн үзвэл, төрийн алба, хуультай холбоотой асуудал 72.3 хувь, улс төр, сонгуультай холбоотой асуудал 10.1 хувь, иргэдтэй холбоотой асуудал 9.3 хувь, эдийн засгийн асуудал 7.9 хувийг эзлэв. Үүнийг задлахул, хуулийн хэрэгжилт, хяналт сул, цар тахлаас үүдэн гарч буй шийдвэр, төрийн бодлого алдагдсан, төрийн эрх бүхий албан тушаалтны шийдвэр буруу, эрх зүйн орчны оновчтой зохицуулалт дутмаг, улс төрийн нам тохироо хийдэг зэрэг асуудлууд өндөр хувийг эзэлж байна. Энэ удаагийн судалгаагаар (2021 онд) хөндөгдсөн асуудлуудын дийлэнх нь төрийн алба, хуультай холбоотой байгаа зэрэг нь 2020 оныхоос даруй 20.9 хувиар илүү байна.

Хоёр. Монгол Улс дахь шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын түвшин - 2021 он

Монгол Улс дахь шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээний «дээд (өндөр) түвшний» авлигын шинж чанарыг тодорхойлохын тулд цар хүрээ, хэлбэр, шалтгаан, хор уршиг зэрэг хүчин зүйлсийг үнэлүүлэхийг бид зорив. Ингэхдээ шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн индексийг өмнөх онуудтай ижил аргачлалаар тооцон гаргалаа. Бидний гүйцэтгэсэн энэ удаагийн судалгааны

дүнгээр авлигын төсөөллийн индекс 3.85 гарч өмнөх оныхоос +0.03 пунктээр өссөн үзүүлэлттэй байв.

Зураг 4. Шүүх, хууль хяналтын хүрээний авлигын түвшин 2018-2021




Шалгуур үзүүлэлтүүдийн тухайд

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшинг гаргахдаа доор дурдсан дөрвөн шалгуур үзүүлэлтийг ашиглан хэмждэг. Чингэхэд, шүүх, хууль хяналтын байгууллагын авлигын үзүүлэлт улс төрийн хүрээнээс арай бага үнэлгээ гардаг хандлага энэ судалгаанд мөн адил байв.

Энэ удаагийн шинжээчдийн төсөөллийн судалгаагаар шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын шалгуур үзүүлэлтийг тогтооход 2021 онд авлигын цар хүрээ 3.57 гарсан нь өмнөх оныхоос -0.15 пунктээр буурчээ. Харин авлигын хэлбэрийн индекс нь 3.73 гарч өнгөрөгч оноос +0.02 пунктээр өссөн. Харин авлигын шалтгаан нөхцөлийн индекс 4.14 гарч өмнөх оноос +0.03 пунктээр нэмэгдсэн бол, авлигын хор уршиг, үр дагаврын индекс 3.98 гарч 2020 оноос мөн +0.14 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Тэгвэл, доорх зурагт харуулсанчлан авлигын цар хүрээ өмнөх оноос буурсан байхад, авлигын хэлбэр, шалтгаан нөхцөл, хор уршиг, үр дагавар нь эсрэгээрээ өссөн дүнтэй байна. Үүнээс авлигын шалтгаан нөхцөлийн индекс 2018 оноос хойш тогтмол өсч байгааг доорх зургаас тодорхой харж болохоор байна.

Зураг 5. Шүүх, хууль хяналтын хүрээний авлигын шалгуур үзүүлэлтийн индекс (2018-2021)




Тайлбар: Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал (5-маш сайн, 4-сайн, 3- дунд, 2-тааруу, 1-маш муу)

ШҮ 1. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын цар хүрээ

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын цар хүрээний үнэлгээ 3.57 гарч өмнөх оныхоос -0.15 пунктээр буурсан. Авлигын цар хүрээний үнэлгээ нь 5 дэд үзүүлэлтийн хүрээгээр тодорхойлогддог бөгөөд энэ онд салбар болон үйл ажиллагаанд авлигын чиглэгдсэн байдал гэх үзүүлэлтийг үнэлүүлээгүй.

Зураг 6. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын цар хүрээний үнэлгээ



Дээрх зураг (Зураг 6)-т дундаж үзүүлэлтийг 1-5 баллын үнэлгээгээр хэмжиж 2018-2021 оны өөрчлөлтийг харуулав.



Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түгээмэл байдлын индекс **3.97**



Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын цар хүрээ, салбар/байгууллагын дундаж **3.45**

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшний өөрчлөлтийн дундаж **3.51**



Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин тодорхой үйл ажиллагааны төрлийн дундаж **3.35**


Авлигын түгээмэл байдал, авлигын түвшний өөрчлөлт, авлигын цар хүрээ болон тодорхой үйл ажиллагаан дахь авлигын түвшин өмнөх оноос 0.16-0.29 пунктээр буурчээ. Эл онд авлигын цар хүрээг бүрдүүлж буй 4 дэд үзүүлэлт буурсан дүнтэй байгаа ч энэ нь харьцангуй бага үзүүлэлт бөгөөд цар хүрээг хумих асуудалд

тухайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай болохыг энэхүү дүр зураг харуулж байна.

ДҮ 1. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түгээмэл байдал


Энэ удаагийн шинжээчдийн төсөөллийн судалгаагаар шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түгээмэл байдлын үнэлгээ 3.97 гарч өмнөх оны дүнгээс 0.19 пунктээр буурчээ. Энэ үзүүлэлтийн дундаж 2019 онд 4.21 гарч байжээ.

Зураг 7. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин (хувиар)



Шинжээчдийн өгсөн үнэлгээг хувьчлан үзвэл, тэдний 71.9 хувь нь «их, маш их» гэж үзсэн нь өмнөх он (2020)-ы үзүүлэлтээс -5.5 хувиар буурсан байна. Харин 15.6 хувь нь «дунд зэрэг», 3.1 хувь нь «бага зэрэг», 1.6 хувь нь «огт үгүй», 7.8 хувь нь «мэдэхгүй» хэмээн тус тус харцуулсан байна.

Зураг 8. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин 2018-2021 (хувиар)




Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин, түүний дүнг 2018-2021 онуудтай харьцуулахад «их» гэсэн үнэлгээ жилээс жилд улам нэмэгдэх хандлага ажиглагдав. Хэдийгээр судалгааны дүнгээр авлигын түвшин өмнөх оныхоос буурсан мэт боловч энэ нь харьцангуй бага байна. Учир нь тухайн үзүүлэлтийг бодитойгоор бууруулахын тулд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, улс төрийн хүсэл тэмүүлэл, сэтгэлгээний болон ёс зүйн томоохон өөрчлөлт бүхий сэдэл, санаачилгыг далайцтай өрнүүлэхийг биднээс шаардаж буйг илтгэнэ.

ДҮ 2. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшний өөрчлөлт


Энэ удаагийн төсөөллийн судалгаанд хамрагдсан шинжээчдээр шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшинг үнэлүүлэхэд үнэлгээний дундаж 3.51 гарч өмнөх оноос -0.16 пунктээр буурсан. Тэгвэл, эл үзүүлэлт 2018 онд 3.59, 2019 онд 3.60 тус тус үнэлэгдэж байв. Үүнээс авлигын түвшнийг үнэлсэн байдал болон судалгаанд оролцогчдын дундаж харцулт өөрчлөгдөөгүй нь харагдаж байна.

Зураг 9. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшний өөрчлөлт (хувиар)



Авлигын түвшинг 2021 онд судалгаанд оролцогч гурван хүн тутмын нэг нь «өөрчлөгдөөгүй», таван хүн тутмын нэг нь «маш их» нэмэгдсэн хэмээн үзсэн бол, таван шинжээч тутмын нэг нь «багассан» гэж үзжээ. Угтаа сүүлийн жил шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшинг бууруулахад чиглэгдсэн зарим арга хэмжээ нийгмийн хүрээнд бодит үйл явц хэмээн ойлгох хандлагад өөрчлөлт гарсны илрэл хэмээн үзэх болсонтой холбоотой.

Зураг 10. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшний өөрчлөлт 2018-2021 (хувиар)



2021 оны судалгаагаар авлигын түвшний өөрчлөлтөөр «маш их нэмэгдсэн» гэж үзсэн үнэлгээ өмнөх оноос -16.4 пунктээр буурсан бол, «нэмэгдсэн» гэж үзсэн

үзүүлэлт өмнөх оны дүнгээс **+19.6 пунктээр** буюу даруй 2 дахин өсчээ. Харин «багассан» гэж үзсэн шинжээчдийн үнэлгээ **+2.8 пунктээр** өссөн байна. Чингэвэл, «маш их буурсан» гэж үзсэн шинжээчдийн үнэлгээ сүүлийн 3 жилийн хугацаанд огт байгаагүйг дээрх зураг (Зураг 10)-аас харагдаж байна.

ДҮ 3. Шүүх, хууль хяналтын байгууллага дахь авлигын тархалтын цар хүрээ

Шинжээчдийн төсөөллийн судалгаагаар шүүх, хууль хяналтын салбар, түүний хүрээ болон тухайн байгууллагуудын авлигын тархалтын цар хүрээний индекс **3.45** гарсан нь өмнөх оныхоос **-0.29 пунктээр** буурчээ. Энэ үзүүлэлтийн индекс 2019 онд 3.52 гарч байжээ. Үүнээс уг үзүүлэлт сүүлийн гурван жилийн хугацаанд хэлбэлзэж өсөлт бууралттай дүн гарч байсныг доорх хүснэгт (Хүснэгт 3)-ээс дэлгэрүүлэн харж болно.

Зураг 11. Салбар, хүрээ/байгууллагад авлига тархсан цар хүрээ



Тайлбар: Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал (5-маш сайн, 4-сайн, 3- дунд, 2-тааруу, 1-маш муу)

Төсөөллийн судалгаанд хамрагдсан шинжээчдээр хууль хяналтын байгууллагууд дахь авлигын цар хүрээг салбар, хүрээгээр нь тодорхойлуулахад дараах дүр зураг ажиглагдав. Тухайлбал, шүүх, хууль хяналтын байгууллагуудад авлига «дунд зэрэг» байна хэмээн шинжээчид үнэлсэн боловч тэдний ихэнх нь дурдсан байгууллагуудад авлигын цар хүрээ «их» гэсэн үнэлгээ рүү нэлээд дөхсөн дүн гарсан. Үүнээс прокурор, шүүхийн байгууллагад авлига «их» байна гэж үзэн үнэлэхэд хүргэсэн юм.

Хүснэгт 3. Шүүх, хууль хяналтын салбар, хүрээ/байгууллага дахь авлигын тархалтын цар хүрээ

Салбар, хүрээ	2018	2019	2020	2021	Өөрчлөлт	«Их/маш их» тархсан
Авлигын цар хүрээ буурсан салбар						
1 Хил хамгаалах байгууллага	3.05	2.76	3.23	3.14	-0.09	31.3
2 Шүүх	3.97	4.07	3.90	3.73	-0.17	64.1
3 Прокурор	4.02	4.05	4.02	3.83	-0.19	64.1
4 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	3.54	3.51	3.79	3.53	-0.26	46.9

5	Авлигатай тэмцэх байгууллага	3.53	3.14	3.59	3.26	-0.33	32.8
6	Шүүхийн шинжилгээний байгууллага	3.50	3.38	3.79	3.46	-0.33	34.3
7	Цагдаагийн байгууллага	3.68	3.64	3.92	3.59	-0.33	51.6
8	Тагнуулын байгууллага	3.43	3.32	3.56	3.20	-0.36	23.4
9	Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний газар	3.42	3.50	3.69	3.06	-0.63	26.6

Авлигын цар хүрээнд гарсан өөрчлөлтийг харахад бүх байгууллагуудын авлигын түвшин (0.09-0.63 пунктээр) буурсан дүн харагдлаа. Харин шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын авлигын тархалт «маш их», «их» гэж үнэлсэн нь 50-аас дээш хувьтай байна. Түүнчлэн авлигын тархалтын цар хүрээг шинжээчид «маш их, их» гэж үнэлсэн бол, Хил хамгаалах байгууллага (31.3%), Тагнуулын байгууллага (23.4%), Авлигатай тэмцэх байгууллага (32.8%)-ууд харьцангуй багаар үнэлэгдсэн. Энэ нь тухайн байгууллагуудад авлигын эсрэг үйл ажиллагаа, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ харьцангуй боломжийн түвшинд авч хэрэгжүүлдэгээс гадна авлига харьцангуй бага байгааг харуулав.

ДҮ 4. Шүүх, хууль хяналтын байгууллагын тодорхой үйл ажиллагаан дахь авлигын түвшин

Тодорхой үйл ажиллагаан дахь авлига тархсан байдлыг байгууллагуудаас гадна тэдгээрийн хуулиар хүлээсэн үйл ажиллагааны хүрээгээр үнэлүүлэхэд авлигын түвшний индекс 3.35 гарав. Энэ нь өмнөх оны дүнгээс -0.16 пунктээр буурсан бол, 2019 оны индекс 3.70, 2018 оны индекс 3.44 гарч байжээ (Зураг 12).

Зураг 12. Авлигын түвшинг тодорхой үйл ажиллагааны төрлөөр үнэлүүлсэн үнэлгээний дундаж



Тайлбар: Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал (5-маш сайн, 4-сайн, 3- дунд, 2-тааруу, 1-маш муу)

Дээрх дурдсанчлан, шүүх, хууль хяналтын байгууллагуудын тодорхой үйл ажиллагааны төрлүүд дэх авлигын түвшинг тодруулах үүднээс дор дурдсан 9 салбар дахь авлигын түвшинг шинжээчдээр үнэлүүлэв. Чингэхэд, тухайн салбарт авлигын түвшинг «дунд» хэмжээнд (3.1-3.53) буй дүн гарчээ. Үүнээс гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагаан дахь авлигын түвшинг «бага» хэмжээнд (2.71) байна гэж үнэлсэн нь нэг талаас тухайн салбарын үзүүлэлт өнгөрөгч оныхоос +0.06 пунктээр өссөнийг харуулав.

Хүснэгт 4. Авлигын түвшинг харуулсан тодорхой үйл ажиллагааны төрөл 2018-2021


	Үйл ажиллагаа	2018	2019	2020	Өөрчлөлт
Авлига буурсан үйл ажиллагааны төрөл					
1	Гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагаа	2.87	2.95	2.65	-0.3
2	Иргэний харьяалал, шилжилт, хөдөлгөөний бүртгэл	3.42	3.64	3.34	-0.3
3	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа	3.62	3.93	3.67	-0.26
4	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа	3.85	3.80	3.57	-0.23
5	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа	3.40	3.80	3.59	-0.21
6	Прокурорын хяналт	3.82	4.02	3.83	-0.19
7	Эрүүгийн хэрэг шүүхэд таслан шийдвэрлэх ажиллагаа	3.71	3.95	3.83	-0.12
8	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа	3.30	3.70	3.61	-0.09
9	Шүүхийн шинжилгээ ажиллагаа	3.53	3.71	3.63	-0.08
Авлига өссөн үйл ажиллагааны төрөл					
10	Хил хамгаалах ажиллагаа	2.85	3.03	3.10	+0.07
11	Өмгөөлөгч, хуульчдын холбоо	-	-	3.80	-

Дээрх хүснэгтэд харуулсанчлан, шүүх, хууль хяналтын байгууллага доторх үйл ажиллагааны төрлүүдийн авлигын түвшин, ялангуяа гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагаа, иргэний харьяалал, шилжилт, хөдөлгөөний бүртгэлийн газруудад авлига буурсан байдал нь бусад үйл ажиллагаанаас арай илүү байна. Харин хил хамгаалах үйл ажиллагааны авлигын түвшин +0.07 пунктээр өсчээ. Үүнийг өмнөх онууд (2018-2020)-ын дүнтэй харьцуулбал, хил хамгаалах ажиллагааны авлигын түвшин тасралтгүй өссөн өөрчлөлт харагдав. Шинжээчдийн зүгээс эл байдлыг тухайн салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах, эл салбарт ажиллаж буй албан хаагчдад авлигын эсрэг соён гэгээрүүлэх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх, цаашлаад тус салбар дахь авлигын эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж үр дүнг олон нийтэд ил тод мэдээлж байхыг онцолж байв. Хэдийгээр эндээс тухайн салбарын үйл ажиллагааны төрлийн дийлэнх үзүүлэлт буурсан мэт боловч энэ нь чамлалттай дүн юм.

ШҮ 2. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хэлбэр

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээний хоёр дахь шалгуур үзүүлэлт болох авлигын хэлбэрийн индекс энэ удаагийн шинжээчдийн төсөөллийн судалгаагаар 3.73 гарав. Тус үзүүлэлт 2020 онд 3.71, 2019 онд 3.83, 2018 онд 3.52 гарч байжээ. Үүнээс, авлигын хэлбэрийн индекс т сүүлийн 4 жилийн хугацаанд өсөлт тодорхой байдлаар хэлбэлзэж, харин бууралт жигд байгаа нь ажиглагдсан юм. Энэ нь нэг талаас тухайн салбарт авч хэрэгжүүлж буй арга хэмжээ төдийлөн оновчтой бус байгааг илтгэнэ.

Зураг 13. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хэлбэрийн үнэлгээ



Авлигын хэлбэрийг мөн адил 5 дэд үзүүлэлтээр хэмжихэд, шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын 4 хэлбэр нь өмнөх оныхоос өссөн бол, үлдсэн нэг нь **-0.03 пунктээр** буурсан үзүүлэлттэй гарчээ. Тэрхүү таван дэд үзүүлэлтийг дараах байдлаар танилцуулж байна.



ДҮ 1. Хээл, хахуулийн хэлбэр

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх хээл, хахуулийн хэлбэрийн 2021 оны индекс **3.63** гарав. Эл үзүүлэлт 2020 онд **3.61**, 2019 онд **3.80**, 2018 онд **3.57** гарч байжээ. Эндээс 2021 оны индекс өмнөх оныхоос **-0.02 пунктээр** өссөн дүн харагдаж байна.

Зураг 14. Хээл, хахуулийн хэлбэрийн үнэлгээ



Тайлбар: Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал (5-маш сайн, 4-сайн, 3- дунд, 2-тааруу, 1-маш муу)

Шүүх, хууль хяналтын байгууллагын албан тушаалтнаар өөрт ашигтай, давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахад түгээмэл ашигладаг хэлбэрүүдийг 1-5 баллаар төсөөллийн судалгаанд хамрагдсан шинжээчдээр үнэлүүлэв. Ийнхүү гарсан дүнг хувиар тооцон гаргаж, түүний дундаж үзүүлэлтийг гаргалаа. Ингэхэд, авлигын 13 хэлбэрүүдийг нэг бүрчлэн дурдаж шинжээчдээр үнэлүүлэхэд, оролиогчдын дийлэнх олонхын үнэлгээ «их болон дунд» гарав. Нийт үзүүлэлтүүдээс 2 нь их хэмжээнд өссөн, 11 үзүүлэлт нь авлига дунд хэмжээнд өссөн хэмээн үнэлэгдсэн болно.

Авлига дунд хэмжээнд буй гэж үнэлэгдсэн хэлбэр:

Ашиг, орлогоо хуваалцах: 3.82	Эмчилгээ, сувилгааны зардал төлөх: 3.48
Үнэтэй бэлэг, сэлт өгөх (байр, машин): 3.91	Сургалтын зардлыг төлөх: 3.51
Аялал жуулчлалын зардал төлөх: 3.43	Шагнал, цол, тэмдгээр шагнах: 3.85
Гадаад арга хэмжээний зардал төлөх: 3.34	Ажил, үйлчилгээний төлбөрийн хөнгөлөлт эдлүүлэх: 3.69
Өрийг нь төлөх: 3.38	Гадаадын банканд данс нээж өгөх: 3.06
Хувьцаа өгөх: 3.00	



Авлига их хэмжээнд буй гэж үнэлэгдсэн хэлбэр:

Ажил, албан тушаалд томилох, оруулах: 4.00
Бэлэн мөнгө өгөх: 4.00



2021 онд хээл, хахуулийн нийт 13 хэлбэрүүдийн 5 хэлбэрийн үнэлгээ +0.1-0.38 пунктээр өссөн. Түүний дотор, сургалтын зардлыг төлөх (0.38), эмчилгээ, сувилгааны зардал төлөх (0.22), ажил, үйлчилгээний төлбөрийн хөнгөлөлт эдлүүлэх (0.19), үнэтэй бэлэг өгөх (0.14), бэлэн мөнгө өгөх (0.1) хэлбэрүүд тус тус өссөн

байна. Тиймээс эдгээр үзүүлэлтүүдийг бууруулахад тодорхой шат дараалсан арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна. Харин үлдсэн 8 үзүүлэлтүүд 0.01-0.34 пунктээр буурсан. Хэдийгээр буурсан үзүүлэлт нь өссөн үзүүлэлтээсээ их байгааг үнэлгээнээс харагдаж байгаа ч, маш бага пунктээр буурсан нь тухайн үзүүлэлтүүдийг бууруулахад авч хэрэгжүүлж буй арга хэмжээг эрчимжүүлэн цаашид шаталсан арга хэмжээг авч хэрэгжүүлж байхын шаардаж байна.


Хүснэгт 5. Хээл, хахуулийн хэлбэрийн үнэлгээ

№	Хээл, хахуулийн хэлбэр	2018	2019	2020	2021	Өөрчлөлт
Өссөн хээл, хахуулийн хэлбэр						
1	Сургалтын зардлыг төлөх	3.46	3.71	3.13	3.51	+0.38
2	Эмчилгээ, сувилгааны зардал төлөх	3.25	3.47	3.26	3.48	+0.22
3	Ажил, үйлчилгээний төлбөрийн хөнгөлөлт эдлүүлэх	3.63	3.69	3.5	3.69	+0.19
4	Үнэтэй бэлэг өгөх	3.61	3.96	3.77	3.91	+0.14
5	Бэлэн мөнгө өгөх	3.75	4.09	3.90	4.00	+0.1
Буурсан хээл, хахуулийн хэлбэр						
6	Гадаадын банкинд данс нээж өгөх	3.22	3.63	3.4	3.06	-0.34
7	Хувьцаа өгөх	3.11	3.49	3.29	3.00	-0.29
8	Шагнал, уол, тэмдгээр шагнах	3.98	4.25	4.09	3.85	-0.24
9	Ажил, албан тушаалд томилох, оруулах	4.38	4.32	4.24	4.00	-0.24
10	Аялал жуулчлалын зардал төлөх	3.58	3.81	3.54	3.43	-0.11
11	Гадаад арга хэмжээний зардал төлөх	3.6	3.8	3.41	3.34	-0.07
12	Ашиг, орлогоо хуваалцах	3.87	4.03	3.84	3.82	-0.02
13	Өрийг нь төлөх	3.22	3.43	3.39	3.38	-0.01

ДҮ 2. Хууль бус нөлөөллийн хэлбэр

Монгол Улс дахь шүүх, хууль хяналтын байгууллагуудад буй хууль бус нөлөөллийн хэлбэрийн индекс энэ онд 3.77 гарав. Уг хэлбэрийн индекс 2020 онд 3.74 гарсан бөгөөд 2019 онд 3.86, 2018 онд 3.68 байв. Үүнээс үзэхэд, 2021 оны нөлөөллийн хэлбэр өмнөх оноос +0.03 пунктээр өсчээ.

Зураг 15. Хууль бус нөлөөллийн үнэлгээ



Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал (5-маш сайн, 4-сайн, 3- дунд, 2-тааруу, 1-маш муу)

Судалгаанд хамрагдсан шинжээчид хууль бус нөлөөллийн 9 хэлбэрийг үнэлснээс 8 үзүүлэлт нь «дунд»-аар үнэлэгдсэн байна. Үүнээс нутаг орны хэлхээ холбоог ашиглах, найз, танил талын хэлхээ холбоог ашиглах, садан төрлийн хэлхээ холбоог ашиглах зэрэг үзүүлэлтүүд «их» гэж үнэлэгдсэн нь харьцангуй өндөр үнэлгээ рүү дөхөж буйг илтгэнэ. Мөн намын хэлхээ холбоог ашиглах байдал «их» байна хэмээн шинжээчид үнэлжээ (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Хууль бус нөлөөллийн үнэлгээ

№	Нөлөөллийн хэлбэр	2018	2019	2020	2021	Өөрчлөлт
Хууль бус нөлөөлөл өссөн үзүүлэлт						
1	Нутаг орны хэлхээ холбоог ашиглах	4.0	3.88	3.63	3.97	+0.34
2	Намын хэлхээ холбоог ашиглах	3.93	3.97	4.07	4.38	+0.31
3	Садан төрлийн хэлхээ холбоог ашиглах	3.84	3.98	3.79	3.97	+0.18
4	Найз, танил талын хэлхээ холбоог ашиглах	4.02	3.98	3.87	3.97	+0.1
Хууль бус нөлөөлөл буурсан үзүүлэлт						
5	Албадах	3.44	3.69	3.63	3.43	-0.2
6	Амлалт өгөх	3.38	3.63	3.68	3.50	-0.18
7	Хүсэлт тавих	3.38	3.8	3.56	3.42	-0.14
8	Айлган сүрдүүлэх, заналхийлэх	3.38	3.63	3.3	3.26	-0.04
9	Дарамт шахалт үзүүлэх	3.75	4.17	3.82	3.80	-0.02

Намын болон нутаг орны хэлхээ холбоог ашиглах, садан төрлийн болон найз, нөхөд, танил талын хэлхээ холбоог ашиглах зэрэг хэлбэрүүд өмнөх оны дүнгээс өссөн үзүүлэлттэй гарчээ. Харин дарамт шахалт үзүүлэх, хүсэлт тавих, албадах, айлган сүрдүүлэх зэрэг таван үзүүлэлт буурсан байна. Нэмж хэлэхэд, намын хэлхээ холбоог ашиглах байдал 2018 оноос хойш зогсолтгүй өсч буйг дээрх хүснэгтээс дэлгэрэнгүй харж болно.

ДҮ 3. Шүүх, хууль хяналтын байгууллага, улс төрийн нам, бүлэглэл, улс төр, бизнес, гэмт хэргийн бүлэглэлүүдийн харилцаа, хамаарал

Шүүх, хууль хяналтын байгууллагын албан тушаалтнууд болон улс төрчид, улс төрийн нам/бүлэглэл, гадаад дотоод бизнесийн бүлэглэл, гэмт бүлэглэлийн харилцаа, хамаарлын үнэлгээ 3.63 гарч өнгөрсөн оныхоос +0.03 пунктээр (2019 онд 3.82) өссөн байна. Энэ хүрээнд дурдсан бүлэглэлүүдийн харилцаа, хамаарлын 13 төрлийг судалгаанд хамрагдсан шинжээчдээр үнэлүүлэхэд дараах дүр зураг ажиглагдсан болно (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Бүлэглэлүүдийн харилцаа, хамаарал, нөхцөл байдлын үнэлгээ

№	Бүлэглэлүүдийн харилцаа хамаарал	2018	2019	2020	2021	Өөрчлөлт
Үнэлгээ өссөн үзүүлэлт						
1	Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд бизнес бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан.	3.83	3.57	3.43	3.76	+0.33
2	Бизнес бүлэглэл шүүх/сахиулах байгууллагын албан тушаалтнуудыг эрхшээлдээ оруулсан.	3.93	3.66	3.75	3.96	+0.21
3	Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд гэмт бүлэглэлийн эрхшээлд орсон.	3.68	3.06	3.04	3.22	+0.18
4	Гадны улс төрийн бүлэглэл Монголын хууль сахиулахын албан тушаалтнуудыг эрхшээлдээ оруулсан.	3.46	2.85	3.35	3.45	+0.1
5	Шүүх/хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд улс төрчдийг эрхшээлдээ оруулсан.	3.75	3.49	3.46	3.53	+0.07
6	Гадны бизнесийн бүлэглэл Монголын хууль сахиулахын албан тушаалтнуудыг эрхшээлдээ оруулсан.	3.39	2.87	3.31	3.35	+0.04
7	Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд болон гэмт бүлэглэл нэгдсэн.	3.61	3.06	3.14	3.17	+0.03
Үнэлгээ буурсан үзүүлэлт						
8	Гадны бизнесийн бүлэглэл Монголын хууль сахиулахын албан тушаалтнуудтай нэгдсэн	3.19	2.55	3.54	3.08	-0.46
9	Хууль сахиулахын хүрээн дэх авлига илүү далд хэлбэрт шилжсэн	4.14	4.21	4.11	3.98	-0.13
10	Улс төрчид шүүх/сахиулах байгууллагын албан тушаалтнуудыг эрхшээлдээ оруулсан	4.45	3.95	4.22	4.14	-0.08


11	Бизнес шүүх/хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн	4.03	3.65	3.89	3.83	-0.06
12	Улс төрчид шүүгч/хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн	4.29	4.11	4.03	3.97	-0.06
13	Гадны улс төрийн бүлэглэл Монголын хууль сахиулахын албан тушаалтнуудтай нэгдсэн	3.28	2.85	3.12	3.09	-0.03

Дээрх хүснэгтээс дурдсан 7 бүлэглэлийн харилцаа хамаарлын үзүүлэлт өссөн дүнтэй байгаа бол, үлдсэн 6 бүлэглэлийн харилцаа хамаарлын үзүүлэлт бага зэрэг буурчээ. Тухайлбал, хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд бизнес бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан, бизнес бүлэглэл шүүх/сахиулах байгууллагын албан тушаалтнуудыг эрхшээлдээ оруулсан зэрэг үзүүлэлтүүд бусдаасаа харьцангуй **өндөр пунктээр** өссөн. Харин гадны бизнесийн бүлэглэл Монголын хууль сахиулахын албан тушаалтнуудтай нэгдсэн, хууль сахиулахын хүрээн дэх авлига илүү далд хэлбэрт шилжсэн зэрэг үзүүлэлт **харьцангуй бага пунктээр** буурсан байна.

ДҮ 4. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хэлбэр


Шүүх, хууль хяналтын байгууллагын авлигын хэлбэрийн индекс 2019 онд 3.94, 2020 онд 3.97 гарч байсан бол, энэ он (2021)-д **3.94** гарсан. Энэ үзүүлэлтийн бууралт маш бага байгаа нь анхаарал хандуулах хэрэгцээ байгааг илэрхийлнэ.

Зураг 16. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хэлбэр




Сүүлийн дөрвөн жилийн хугацаанд гарсан өөрчлөлтөөс харвал, ихэнх үзүүлэлтүүд тасралтгүй өссөн дүнтэй байхад зарим үзүүлэлт өсөлт бууралттай байгаа нь харагдаж байна (Зураг 16). Эдгээр үзүүлэлтийн өсөлт нь маш бага мэт боловч сүүлийн жилүүдэд тасралтгүй өсч байгаа нь тууштай арга хэмжээ авч хэрэгжүүлэх

шаардлага нэгэнт бий болсныг илтгэнэ.




ДҮ 5. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх хээл хахууль өгөх, авах арга

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх хээл хахууль өгөх, авах аргуудын хэрэглэгдсэн 2021 оны үнэлгээний индекс 3.64 гарч өмнөх оноос +0.06 пунктээр өссөн байна. Эл үзүүлэлт 2020 онд 3.58, 2019 онд 3.68, 2018 онд 3.38 дүнтэй гарч байжээ. Тухайн үзүүлэлтийн «их», «маш их» гэсэн үнэлгээний нийлбэр 50 хувиас дээш гарсан үзүүлэлтийг доорх зураглалаас харна уу.




Энэ удаагийн шинжээчдийн төсөөллийн судалгаагаар хээл, хахуулийг ойр дотны хүмүүсээр дамжуулах 71.9, зуучлагчаар дамжуулах 65.7, ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдний компанид давуу байдал олгох 61 хувь, биечлэн уулзаж өгч, авах 53.2 хувийг эзэлж буй нь дээрх 7 үзүүлэлтийн үнэлгээг «их, маш их» гэж харцуулахад хүргэсэн байна. 2021 онд хэд хэдэн аргуудын үнэлгээ буурсныг доорх зураг (Зураг 17)-аас харч болохоор байна.

Зураг 17. Хууль хяналтын байгууллагын хүрээнд хээл хахууль өгөх, авах аргуудын үнэлгээ



Гэхдээ энэ дүн мэдэгдэхүйц байдлаар бодитой буурсан үзүүлэлт биш учир анхаарал хандуулахгүй өнгөрөх учиргүй. Тухайлбал, хээл хахууль өгөх, авах аргуудаас дараах гурван арга харьяангүй их өссөнийг онцлон тэмдэглэж байна.




Үнэндээ, эдгээр аргуудыг бууруулах арга хэмжээг шат дараатайгаар авах шаардлагатай болохыг энэ удаагийн шинжээчдийн төсөөллийн судалгааны үр дүн харуулсныг энд дурдах нь зүйтэй.

ШҮ 3. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын шалтгаан, нөхиөл

Шинжээчдийн төсөөллийн судалгаагаар хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын шалтгаан, нөхиөлийн үзүүлэлтийн индекс 4.14 гарч өнгөрсөн оны эл дүнгээр +0.03 пунктээр өссөн бол, 2020 онд энэ дүн 2019 оныхоос 0.13 пунктээр өссөн дүнтэй гарч байв. Ер нь эл үзүүлэлт сүүлийн жилүүдэд тус шалгуур үзүүлэлтийн үнэлгээ тасралтгүй өсчээ. Тодруулбал, авлигын шалтгаан нөхиөлийг а) нөлөөлсөн хүчин зүйлс, б) түвшинд нөлөөлсөн дутагдал, доголдол в) бүлэглэлүүдийн нөхиөл байдал зэрэг гурван үзүүлэлтээр хэмжиж шинжилгээ хийхэд дараах дүр зураг ажиглагдав.

Зураг 18. Авлигын шалтгаан, нөхцөл



Авлигад нөлөөлсөн хүчин зүйлс өнгөрсөн оноосоо -0.04 пунктээр буурч, харин түвшинд нөлөөлсөн дутагдал, доголдол $+0.07$ пунктээр, бүлэглэлүүдийн нөхцөл байдал $+0.08$ пунктээр тус тус өсчээ.

ДҮ 1. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлигад нөлөөлсөн хүчин зүйлс

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн индекс 2021 онд 4.15 гарч, 2020 онд 4.19 гарч өнгөрсөн жилийнхээс $+0.23$ пунктээр, харин 2019 онд 2018 оныхоос $+0.14$ пунктээр тус тус өссөн байна.

Хүснэгт 8. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлигад нөлөөлсөн хүчин зүйлс

№	Авлигын хэлбэр	Үгүй	Бага зэрэг	Дунд зэрэг	Их	Маш их	Мэдэхгүй
1	Албан тушаалын томилгоо (нам дотор болон төрийн албанд)	1.6	-	4.7	20.3	70.3	3.1
2	УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	1.6	3.1	18.8	28.1	42.2	6.3
3	Засгийн газрын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	-	1.6	17.2	32.8	43.8	4.7
4	Шүүх, хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	1.6	4.7	12.5	32.8	42.2	6.3
5	Хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл явц	1.6	7.8	21.9	31.3	31.3	6.3
6	Төрийн байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалт	3.1	6.3	23.4	28.1	32.8	6.3

Шинжээчид дээрх бүх хүчин зүйлсийг авлигад их нөлөөлсөн хэмээн үнэлсэн. Ялангуяа, албан тушаалын томилгоо (нам дотор болон төрийн албанд), шүүх, хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил, засгийн газрын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил зэрэг үзүүлэлтүүдийг «маш их» нөлөөлсөн гэж үзсэн шинжээчдийн хувь нэлээдгүй өсчээ.

Хүснэгт 9. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн үнэлгээ

№	Нөлөөлж буй хүчин зүйлс	2018	2019	2020	2021	Өөрчлөлт
Өссөн үзүүлэлт						
1	Засгийн газрын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.75	3.93	4.19	4.25	+0.06
2	Албан тушаалын томилгоо (нам дотор болон төрийн албанд)	4.31	4.31	4.47	4.63	+0.16
3	Шүүх, хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.93	4.02	4.03	4.17	+0.14
Буурсан үзүүлэлт						
4	Хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл явц	3.86	4.07	3.97	3.88	-0.09
5	Төрийн байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалт	3.8	3.79	4.02	3.87	-0.15
6	УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.69	3.95	4.14	4.13	-0.01

Дээрх хүснэгт дэх авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн өөрчлөлтөөс харахад, өнгөрөгч оноос 3 үзүүлэлт буурсан бол, 3 үзүүлэлтийн хувьд (Хүснэгт 9) өссөн дүнтэй байна. Тухайлбал, албан тушаалын томилгоо (+0.16 пунктээр), шүүх, хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил (+0.14 пунктээр), засгийн газрын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил (+0.06 пунктээр) өсчээ.

ΔУ 2. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшинд нөлөөлж буй төрийн албан дахь дутагдал, доголдол

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшинд нөлөөлж буй төрийн албаны алдаа дутагдал, доголдлын индекс 4.22 гарч өмнөх оноос +0.07 пунктээр өссөн. Тус пункт 2019 онд 4.09 гарч, 2018 онд 3.94 гарсан байв.

Зураг 19. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшинд нөлөөлж буй төрийн албан дахь дутагдал, доголдол




Тайлбар: Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал (5-маш сайн, 4-сайн, 3- дунд, 2-тааруу, 1-маш муу)

Төрийн албаны дээрх алдаа дутагдлууд авлига гарахад их (4.03-4.32 хооронд хэлбэлзэж) нөлөөлсөн, төрийн үйлчилгээний хүртээмж муу байдалд дунд зэрэг (3.85) нөлөөлсөн гэж үнэлэгдсэн.

Хүснэгт 10. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшинд нөлөөлж буй төрийн албан дахь дутагдал, доголдол

№	Нөлөөлж буй алдаа дутагдал, доголдлууд	2018	2019	2020	2021	Өөрчлөлт
Өссөн үзүүлэлтүүд						
1	Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул	4.13	4.03	4.32	4.48	+0.16
2	Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналт сул	3.62	3.83	4.08	4.44	+0.36
3	Албан хаагчийн цалин, орон сууц, нийгмийн баталгаа хангалтгүй	3.56	3.79	4.03	4.45	+0.42
4	Шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдал дутмаг	4.19	4.06	4.22	4.63	+0.41
5	Олон шат дамжлага, давхардал, хийдэл	3.98	4.02	4.10	4.44	+0.34
6	Албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж	4.28	4.21	4.27	4.47	+0.2
7	Мэдээлэл нээлттэй, ил тод бус	4.10	4.11	4.17	4.45	+0.28
8	Хүнд суртал	4.10	4.15	4.16	4.48	+0.32
9	ТАХ-ийн ур чадвар дутмаг	4.24	4.36	4.05	4.27	+0.22
10	Төрийн үйлчилгээний хүртээмж муу	3.71	3.98	3.85	4.16	+0.31
11	Хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал	4.18	4.32	4.30	4.53	+0.23
Буурсан үзүүлэлт						
12	Төрийн албан хаагчийн ёс зүйн доголдол	4.17	4.32	4.25	4.13	-0.12

2020 онд хууль хяналтын байгууллагын хүрээнд авлигын түвшинд нөлөөлсөн төрийн албан дахь алдаа дутагдал, доголдуудаас дөрвөн үзүүлэлт нь буурсан. Харин 2021 онд 1 үзүүлэлт буурч, үлдсэн 11 үзүүлэлтэд өссөн дүн гарчээ. Эдгээр өссөн алдаа дутагдлуудыг дараах байдлаар танилцуулж байна.



ДҮ 3. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх бүлэглэлүүдийн нөхцөл байдал

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх бүлэглэлүүдийн нөхцөл байдлын индекс энэ удаагийн шинжээчдийн төсөөллийн судалгаагаар 3.93 үнэлэгдсэн нь өмнөх оныхоос +0.08 пунктээр өссөн.

Зураг 20. Шүүх, хууль хяналтын хүрээн дэх бүлэглэлүүдийн нөхцөл байдал



Тайлбар: Дундаж үзүүлэлт, 1-5 баллаар эрэмбэлсэн байдал (5-маш сайн, 4-сайн, 3- дунд, 2-тааруу, 1-маш муу)

Шүүх, хууль хяналтын хүрээн дэн бүлэглэлүүдийн нөхцөл байдлыг задлахуул, хувийн эрх ашгийг илүүд үзсэн нам тойрсон хүрээлэл, нам дамнасан хүрээлэл, нэг хүнийг тойрсон хүрээлэл, нам тойрсон, нэг хүнийг тойрсон хүрээлэл их (4.06-4.64 баллын хооронд хэлбэлзсэн) байгаагаар үнэлэгдсэн байна. Тэгвэл, хувийн эрх ашгийг тойрсон найз нөхдийн хүрээлэл (3.98), хувийн эрх ашгийг илүүд үзсэн бизнесийн бүлэглэл дунд (3.97) зэрэг байгаа аж. Харин нийтийн эрх ашгийн төлөө бий болсон

хүрээлэлд авлига бага (2.91) байна гэж үнэлэгдлээ.

Зураг 21. Шүүх, хууль хяналтын хүрээн дэх бүлэглэлүүдийн нөхцөл байдал




Дээрх бүх бүлэглэлүүдийн нөхцөл байдлын үнэлгээ 2021 онд (0.06-0.54 пунктийн хооронд хэлбэлзсэн) өссөн үзүүлэлттэй гарав. Хэдийгээр эдгээр нь харьяангүй бага мэт боловч үүнд анхаарал хандуулж, эрчимтэй арга хэмжээ авах хэрэгцээ буйг илтгэж байна. Тэр тусмаа, нийтийн эрх ашгийн төлөө бий болсон хүрээлэл, хувийн эрх ашгийг илүүд үзсэн, найз нөхдийн хүрээлэл, нэг хүнийг тойрсон хүрээлэлүүдийн авлига сүүлийн дөрвөн жилд тасралтгүй өссөн дүн харагдана.

ШҮ 4. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хор уршиг, үр дагавар

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хор ур уршиг, үр дагаврын үзүүлэлт 2021 онд 3.98 гарч өмнөх оныхоос +0.14 пунктээр өссөн дүн гарав. Эл үнэлгээ 2020 онд 3.84 гарч 2019 оноосоо -0.05 пунктээр буурч байсан бол 2019 онд 2018 оныхоосоо +0.23 пунктээр өссөн дүн гарч байв. Авлигын төсөөллийн индексийг тогтоох 4 дэх үндсэн шалгуур үзүүлэлтийг хор уршиг, үр дагавар болон авлигаар олсон хөрөнгийн зарцуулалт гэсэн доорх хоёр дэд үзүүлэлтээр шинжилдэг.

Зураг 22. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хор уршиг, үр дагавар



Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хор уршиг, үр дагавар (Зураг 22)-аас харахад, 2018-2021 оны хооронд эл үзүүлэлт өссөн дүнтэй гарсан. Авлигаар олсон хөрөнгийн зарцуулалт нь 2021 онд өмнөх оныхоос мөн адил өсчээ.

ДҮ 1. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хор уршиг, үр дагавар

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хор уршиг, үр дагаврын индекс энэ удаагийн судалгаагаар 4.27 гарч 2020 оныхоос +0.13 пунктээр өссөн байна. Энэ үзүүлэлт сүүлийн 4 жилийн хугацаанд тасралтгүй өссөөр байгааг доорх хүснэгт (Хүснэгт 11)-ээс харагдана.

Хүснэгт 11. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын улмаас учирсан хор уршиг, сөрөг үр дагаврын түвшин

№	Авлигын улмаас учирсан хор уршиг, сөрөг үр дагаврын түвшин	2018	2019	2020	2021	Өөрчлөлт
Өссөн үзүүлэлтүүд						
1	Гадаадын хөрөнгө оруулалт буурсан	3.44	3.63	4.07	4.32	+0.25
2	Ажилгүйдэл нэмэгдсэн	3.46	3.65	3.98	4.05	+0.07
3	Гадаадын зээл тусламжийн үр ашиг буурсан	3.56	3.68	3.98	4.20	+0.22
4	Улс орны эдийн засгийн хүч чадал суларсан	3.48	3.95	4.24	4.44	+0.2
5	Нийгмийн дэг журам алдагдсан	3.75	3.73	3.94	4.26	+0.32
6	Өмч хөрөнгийн тэгш бус байдал нэмэгдсэн	3.86	4.10	4.28	4.35	+0.07
7	Ёс суртахууны үнэт зүйлс алдагдсан	4.02	4.21	4.24	4.46	+0.22
8	Шударга ёс алдагдсан	4.05	4.14	4.29	4.52	+0.23
9	Ядуурал нэмэгдсэн	3.61	3.92	4.03	4.43	+0.4
10	Хүний эрхийн зөрчил нэмэгдсэн	3.82	4.00	4.09	4.23	+0.14
11	Монгол Улсын нэр хүнд олон улсын түвшинд унасан	3.65	4.08	4.15	4.19	+0.04
12	Төрийн албаны чадавх суларсан	4.08	4.20	4.26	4.38	+0.12
13	Иргэдийн хууль сахиулах байгууллагад итгэх итгэд буурсан ("инфляцийн" оронд нэмсэн)	4.28	4.34	4.38	4.42	+0.04
14	Хуулийн хэрэгжилт суларсан	4.17	4.23	4.27	4.29	+0.02
Буурсан үзүүлэлт						
15	Гэмт хэрэг нэмэгдсэн	3.69	3.77	3.92	3.62	-0.3
16	Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдсэн	3.73	4.02	4.10	4.08	-0.02


Авлигын улмаас учирсан хор уршиг, сөрөг үр дагаврууд сүүлийн гурван жилийн хугацаанд тасралтгүй өсч байна. Энэ удаагийн судалгаанд хамрагдсан шинжээчид авлигаас үүдэлтэйгээр хууль хяналтын байгууллагуудад их хэмжээний хор уршиг, сөрөг үр дагаврууд гарсан хэмээн үзсэн байна. Тодруулбал, дээрх хүснэгтэд дурдсан 16 үзүүлэлтээс гэмт хэрэг, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдсэн зэрэг хоёр үзүүлэлтүүдийн хувьд маш бага хувьтай буурчээ. Үүнээс хамгийн их өссөн үзүүлэлтүүдийг дараах байдлаар танилцуулж байна.



ДҮ 2. Авлигаар олсон хөрөнгийн зарцуулалт

Авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын талаарх үнэлгээний индекс 2021 онд 3.70 гарч өмнөх оныхоос +0.15 пунктээр өссөн. Эл үзүүлэлт 2019 онд 3.81, 2018 онд 3.52 тус тус гарч байжээ.

Зураг 23. Улс төрийн (түүнчлэн шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээний) авлигаар олсон хөрөнгийн зарцуулалт



2021 онд хийгдсэн судалгаагаар хууль хяналтын хүрээний авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын талаарх үзүүлэлтэд хамаарах нийт 19 үзүүлэлтээс ердөө нэг л үзүүлэлт буюу хөшөө дурсгал, суварга босгох нь буурч (0.02), үлдсэн 18 үзүүлэлт 0.03-1.79 пунктээр өссөн нь анхаарал татаж байна.

Гурав. Бусад үзүүлэлт

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшинг тодорхойлохдоо үйл ажиллагааны явцад зарцуулж буй авлигын хэмжээ болон авлигыг бууруулах арга замын талаарх өнөөгийн бодит нөхцөлийг шинжээчдээр тодруулав. Чингэхэд дараах нөхцөл байдал илэрхийлэгдсэн болно.

Хээл, хахуульд зарцуулж буй авлигын хэмжээ

Үйл ажиллагааны явцад зарцуулж буй авлигын хувийг энэ удаагийн шинжээчдээр тодорхойлуулаагүй, харин мөнгөн дүн, түүний хэмжээг тодорхойлуулахыг чухалчилсан болно.

Хүснэгт 12. Авлигад зарцуулсан мөнгөний хэмжээ (зорилгоор), сая төгрөгөөр

Авлигад зарцуулсан мөнгөний зорилгын төрөл	Мөнгөний хэмжээ /сая.төг/						
	1 сая хүртэл	1 - 5 сая	5 - 10 сая	10 - 20 сая	20 - 50 сая	50 < сая	Мэдэхгүй
Ажил, албан тушаалд ороход	3.1	14.1	18.8	18.8	6.3	18.8	20.3
Ашиг сонирхолдоо нийцсэн хууль тогтоомж, шийдвэр гаргуулахад	-	6.3	6.3	18.8	12.5	34.4	21.9
Шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход	1.6	-	3.1	12.5	32.8	20.3	29.7
Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хэргийг хэрэгсэхгүй болгоход	-	3.1	18.8	21.9	17.2	12.5	26.6
Эрүүгийн хэрэг үүсгэхэд	-	7.8	9.4	21.9	18.8	6.3	35.9
Гэмт хэрэг, зөрчлийг нуун дарагдуулахад	-	6.3	15.6	10.9	23.4	14.1	29.7
Хуурамч бичиг баримт үйлдэхэд	3.1	15.6	18.8	6.3	15.6	7.8	32.8

Хээл, хахуульд өгч буй мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт болон харцуултын хувиар нь тооцож үзвэл, ашиг сонирхолдоо нийцсэн хууль тогтоомж, шийдвэр гаргуулахад, шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгох зэрэгт хамгийн их буюу 20-50 сая төгрөгийг зарцуулдаг болов уу гэсэн төсөөллийг шинжээчид түлхүү авч үзжээ. Харин ажил, албан тушаалд орох, хуурамч бичиг баримт үйлдэхэд 5-10 саяыг зарцуулдаг гэж үзсэн (Хүснэгт 12).

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигатай тэмцэх үйл ажиллагаа

Авлигыг бууруулах нэг арга зам бол түүнийг арилгах гарцыг тодорхойлох явдал юм. Тиймээс шинжээчид авлигыг бууруулах арга замыг хэрхэн тодорхойлсныг дараах хүснэгт (Хүснэгт 14)-ээс харна уу.

Хүснэгт 13. Авлигыг бууруулахад шаардлагатай арга хэмжээ

Код		Хувь
1	Авлигыг илрүүлэх үйл ажиллагаагаа оновчтой зөв зохион байгуулах	5.7
2	Хүлээлгэх харцуулагыг нэмэгдүүлэх	7.3
3	Байгууллагын хүнээс хамааралтай үйл ажиллагааг цахимжуулах	2.4
4	Урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль эрх зүйн болон соён гэгээрүүлэх сургалтуудыг тогтмол явуулах	6.5
5	Төрийн албанд томилгодох болон албан тушаал дэвших бүрт нь баталгаа авах	3.3
6	Төрийн албан хаагчдын тангарагт тусгаж өгөх	2.4
7	Нэг намын бүлэглэлийн бодлогыг арилгах	3.3
8	Төрийн албаны томилгоо, үйл ажиллагааг системээр нь засахаас өөр сонголт байхгүй	8.1
9	Ёс суртахуун, шударга ёс, мэргэжлийн нэр хүндийг эрхэмлэх шинж чанарыг сайн тодорхойлдог систем бий болгох	8.1
10	Олон нийтийн хараа хяналтыг сайжруулах, хяналтын тогтолоог сайжруулах	4.9
11	Мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах	1.6
12	Мэдээллийг ил тод нээлттэй болгож иргэд, аж ахуй нэгж, хууль хяналтын байгууллагынханыг мэдээллээр хангах	11.4
13	Хүнд суртлыг арилгах	0.8
14	Авлигад өртөгсдөд хуулийн дагуу шударга шийтгэл оногдуулж	1.6
15	Цалин хөлс нэмэх	1.6
16	Улс төрийн томилгоогоо болих, улс төрийн дарамтыг зогсоох	1.6
17	Хуулийг чангатгах	4.9
18	Хууль тогтоомжийг сайжруулж оновчтой болгох	1.6
19	Төсвийн зарцуулалтын хяналтыг нэмэгдүүлэх	1.6
20	Төрийн албаны мерит зарчмыг мөрдлөг болгох	3.3
21	Сонгуулийн системийг өөрчлөх	0.8

22	Авлигын гэмт хэргийн шүүх шийдвэрийг олон нийтэд нээлттэй хийж, хариуцлага шийтгэлийг олонд зарлаж мэдээлж байх,	2.4
23	АТГ болон Прокурор, ЦЕГ дарга ажилтнуудыг бүгдийг нь Улс төрөөс ангид байдлаар сонгогдох зарчмаар сонгох	2.4
24	УИХ-ын дэргэд Хуулийн судалгааны нэгжийг шат шатны хуулийн байгууллагад ажиллаж байсан туршлагатай хуульч, судлаачаар бүрдүүлэх	0.8
25	Хуулийн мэргэжилтэн бэлтгэхдээ ёс суртахууны үнэт зүйлтэй болгох	0.8
26	Авлига авсан өгсөнд хуулийн харуцлага хүлээлгэж байгаа хуулиа өөрчилж тухайн нөхцөл бааидалд тохирсон тусгай хууль журам батлах	2.4
27	Авлигатай тэмцэх газрыг улс төрөөс хараат бус, шударга ажиллуулах, үйл ажиллагааг нь ард иргэдийн хүчтэй төлөөллөөр хянуулах,	0.8
28	Шүүхийн тогтолцоог бие даасан, үр дүнтэй болгох	0.8
29	Авлигын гэмт хэргийг илрүүлэхэд тусласан иргэдийн мэдээллийг нууцалж шагналын хэмжээг нэмэгдүүлэх	3.3
30	БНХАУ-аас үлгэр жишээ авах	1.6
31	Иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх	0.8
99	Хариулж мэдэхгүй	0.8
НИЙТ		100.0

Мэдээллийг ил тод нээлттэй болгож иргэд, аж ахуй нэгж, шүүх, хууль хяналтын байгууллагынхны мэдээллээр хангах, ёс суртахуун, шударга ёс, мэргэжлийн нэр хүндийг эрхэмлэх шинж чанарыг агуулсан тогтолцоог бэхжүүлэхийг чухалчилсан байна. Түүнчлэн төрийн албаны томилгоо, үйл ажиллагааг системээр нь засахаас өөр сонголт байхгүй, хүлээлгэх харуцлагыг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль эрх зүйн, соён гэгээрүүлэх сургалтуудыг тогтмол явуулах зэргийг авлигыг бууруулах оновчтой арга хэмжээ хэмээн судалгаанд хамрагдсан шинжээчдийн дийлэнх хувь нь үзсэн байна.

Дөрөв. Шинжээчдийн талаарх ерөнхий мэдээлэл

Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгаанд оролцсон шинжээчдийн ерөнхий мэдээллийг дараах байдлаар танилцуулж байна.

Судалгаанд оролцогчдын 34.4 хувь нь 33 хүртэл насныхан, 29.7 хувь нь 34-41 насныхан, 35.9 хувь нь 42-оос дээш насныхан байна. Хүйсийн хувьд 51.6% нь эрэгтэй, 48.4% нь эмэгтэйчүүд хамрагдсан болно.

Шинжээчдийг ажиллаж буй салбараар ангилавал, 39.1 хувь нь төрийн байгууллага (шүүх, хууль, нийтийн алба)-д ажиллагсад, 23.4 хувь нь хувийн хэвшил, 14.1 хувь нь төрийн бус байгууллага, 4.7 хувь нь олон улсын байгууллага, 9.4 хувь нь төрийн болон хувийн хэвшлийн судалгаа, шинжилгээний байгууллагад ажил эрхэлдэг судлаачид, 9.4 хувь нь хэвлэл мэдээллийн салбарын шинжээчид тус тус хамрагдав.

Зураг 24. Шинжээчдийн хүн ам зүйн үзүүлэлт



Дүгнэлт

Авлигын хандлага, авлигад өртөмтгий ажил, албан тушаал, авлигад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхийг зорилго болгон ажиллав. Энэ хүрээнд шүүх, хууль хяналтын байгууллагын авлигын түвшинг гаргахын тулд аргачлалын дагуу индекс гаргаж, 4 үндсэн шалгуур үзүүлэлтийн үнэлгээ хийж үзэхэд дараах дүгнэлтүүд гарсныг танилцуулж байна.



Шүүх, хууль хяналтын байгууллагын авлигын талаарх төсөөллийн үнэлгээ 2021 онд **3.85** гарч өнгөрсөн жилээс **+0.03** пунктээр өссөн. Харин 2019 онд 2018 оноосоо 0.18 пунктээр өссөн. Авлигын төсөөллийн индексийг бүрдүүлж буй үндсэн шалгуур үзүүлэлтүүдээс цар хүрээ, хэлбэр, хор уршиг, үр дагавар зэрэг нь буурсан үзүүлэлттэй боловч шалтгаан нөхцөл нь өссөн дүнтэй байна. Шалтгаан нөхцөл гэсэн үндсэн 3 дахь үзүүлэлт сүүлийн 4 жил тасралтгүй өссөөр байна. Харин цар хүрээ 2021 онд буурах хандлагатай байсан бол хэлбэр, хор уршиг, үр дагавар нь 2020 онд буурч, 2021 онд өссөн.

Авлигын цар хүрээг бүрдүүлж буй үзүүлэлтүүдээс авлигын түгээмэл байдал нь өөрчлөлт, тархалтын цар хүрээ, авлигын түвшин нь харьцангуй өндөр буюу **3.97** байв. Хэдийгээр авлигын цар хүрээ өсөх хандлагатай байдаг ч, 2021 онд бүрдүүлж буй үзүүлэлтүүд бүгд буурсан үзүүлэлттэй гарав.



Авлигын хэлбэр гэх үндсэн 2 дахь шалгуур үзүүлэлт нь сүүлийн 4 жил тасралтгүй өссөн ч, 2021 онд 5 дэд үзүүлэлтийн 4 үзүүлэлт нь **0.03-0.06** пунктээр өссөн. Харин авлигын хэлбэр 2021 онд **3.94** гарч өнгөрөгч оноос **-0.03** пунктээр буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь хэдий бага хэмжээгээр буурсан дүн боловч бусад 4 үзүүлэлт өссөн нь анхаарах хэрэгтэйг сануулж байна.

Авлигын хор уршиг, үр дагаврыг бүрдүүлж буй хоёр үзүүлэлт 2021 онд өссөн үзүүлэлттэй гарчээ. Авлигын хор уршиг, үр дагавар **0.13** пунктээр, хөрөнгийн зарцуулалт **0.15** пунктээр өссөн. Харин авлигаар олсон хөрөнгийн зарцуулалт 2019 онд өсч, 2020 онд буурсан үзүүлэлттэй байна. Тэгвэл, авлигын шалтгаан, нөхцөлийг бүрдүүлж буй 3 үзүүлэлтээс авлигад нөлөөлсөн хүчин зүйлс буурсан бол, дутагдал, доголдол, бүлэглэлүүдийн нөхцөл байдал энэ онд өссөн дүнтэй гарчээ. Энэ онд бүлэглэлүүдийн нөхцөл байдлын үнэлгээ хоёр үзүүлэлтээсээ өндөр үнэлгээтэй байсан.





Төрийн албадын авлигын түвшин 2020 онтой харьцуулахад өссөн дүнтэй гарав. Ийнхүү гарсан нь авлигын шалтгаан нөхцөл төрийн алба, хуультай холбоотой асуудлууд дийлэнх хувийг эзэлсэнтэй холбоотой. Тодруулбал, үндэсний хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, түүнд тавих хяналтын механизм сул байгаатай шууд холбогдож байна. Төрийн байгууллагуудын хувьд дэлхий нийтэд гарсан КОВИД 19 цар тахалын дэгдэлтэй холбоотойгоор гарсан зарим нэг хууль тогтоомж нь албан тушаал, эрх мэдлээ хэтрүүлэх зэргээр авлига, албан тушаалын хэргийг үлэмж нэмэгдүүлэхэд нөлөөлсөн нь ийнхүү өндөр хувьтай үнэлэгдэх нэг шалтгаан болов. Цаашлаад шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын индекс өмнөх оноос өссөн үзүүлэлттэй гарах нөхцөлийг бүрдүүлсэн гэж болно. Нөгөөтээгүүр, үүнийг бүрдүүлж буй 4 шалгуур үзүүлэлтүүдээс нэг үзүүлэлт (цар хүрээ) л буурсан нь хангалттай зүйл огт биш.

Эцэст нь хэлэхэд, шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн ерөнхий үнэлгээ болон цаг үеийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд энэ хандлага цаашид өсөх магадлал өндөр буйг харуулж байна. Иймд тус салбарын авлигыг нэмэгдүүлж буй шалтгаан нөхцөлд түлхүү анхаарч, бууруулах арга хэмжээг оновчтой тодорхойлох бодит хэрэгцээ шаардлага бий болсныг илтгэж байна.

Санал, зөвлөмж

Шүүх, хууль хяналтын байгууллагын авлигын төсөөллийн судалгааны хүрээнд дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

1. Төрийн албан хаагчдыг томилох систем, процессыг илүү сайжруулж, тодорхой болгох, гадны нөлөөллийг багасгах.
2. Төрийн албан хаагчдын ажлын байрны тогтвортой байдлыг хангах, хамгаалах ажлуудыг тодотгох.
3. Иргэдийн сэтгэлгээ, ёс зүйн хандлагыг өөрчлөх үүднээс авлигын талаарх ойлголт, зөрүү, хор уршгийг тайлбарлан танцуулах, сурталчлах, аян өрнүүлэх.
4. Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн оролцоо, төрийн бус байгууллагуудын зүгээс тавих хяналтыг сайжруулах механизмыг бүрдүүлэх.
5. Улс төрийн намуудын зүгээс төрийн албаны чадавхид сөргөөр нөлөөлж буй улс төрийн томилгоог зогсоож төрийн захиргаа, тусгай, үйлчилгээний аль ч байгууллагын хүний нөөцийн чадавх, тэдгээрийн ур чадвар, эрх зүйн болоод улс төрийн боловсролын мэдлэгийг дээшлүүлэх, мэргэшсэн, чадварлаг хүний нөөцөд тулгуурласан томилгоо хийх.
6. Мэдээллийг ил тод нээлттэй болгож, иргэд, аж ахуй нэгж, хууль хяналтын байгууллагынхныг мэдээллээр тогтмол хангах, тухайн салбарын албан хаагчдын нийтийн албанд ажиллах ёс зүй, ёс суртахууныг дээшлүүлэх, энэ чиглэлээр шаталсан сургалтыг тогтмолжуулах.
7. Авлигын гэмт хэргийг илрүүлэхэд тусалсан иргэдийн мэдээллийг нууцалж,

хамгаалах арга хэмжээг тодорхой болгох.

8. Авлигын гэмт хэргийг илрүүлэхэд тусалсан иргэдийн шагналын хэмжээг нэмэгдүүлэх.
9. Авлигын гэмт хэргийн шүүх шийдвэрийг олон нийтэд нээлттэй хийж, харцуцлага шийтгэлийг олонд зарлаж мэдээлж байх.

Хавсралт. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн үнэлгээ

Үндсэн үзүүлэлтүүд	2018	2019	2020	2021	Өөрчлөлт
Шүүх, хууль хяналтын хүрээн дэх авлигын түгээмэл байдал	4.13	4.21	4.16	3.97	-0.19
Шүүх, хууль хяналтын салбарын хүрээн дэх авлигын түвшний өөрчлөлт	3.59	3.60	3.67	3.51	-0.16
Шүүх, хууль хяналтын байгууллагуудын хүрээн дэх авлигын тархалтын цар хүрээ	3.57	3.52	3.74	3.45	-0.29
Шүүх, хууль хяналтын байгууллагын тодорхой үйл ажиллагаан дахь авлигын түвшин	3.44	3.70	3.51	3.35	-0.16
Салбар болон үйл ажиллагаанд шүүх, хууль сахиулах байгууллагын авлигын чиглэгдсэн байдал	3.72	3.93	3.85	-	-
Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх хээл хахуулийн хэлбэр	3.57	3.80	3.61	3.63	0.02
Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх нөлөөллийн хэлбэр	3.68	3.86	3.74	3.77	0.03
Бүлэглэлийн хамаарал, нөлөөлөл	3.38	3.82	3.60	3.63	0.03
Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын хэлбэр	3.59	3.94	3.97	3.94	-0.03
Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх хээл хахууль өгөх, авах арга	3.38	3.68	3.58	3.64	0.06
Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигад нөлөөлсөн хүчин зүйлс	3.82	3.96	4.19	4.15	-0.04
Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшинд нөлөөлсөн дутагдал доголдол	3.94	4.09	4.15	4.22	0.07
Бүлэглэлүүдийн нөхцөл байдал	3.78	3.79	3.91	3.99	0.08
Шүүх, хууль сахиулах байгууллагын хүрээн дэх авлигын хор уршиг, үр дагавар	3.79	3.98	4.14	4.27	0.13
Авлигаар олсон хөрөнгийн зарцуулалт	3.52	3.81	3.55	3.70	0.15
Цар хүрээ	3.69	3.75	3.72	3.57	-0.15
Хэлбэр	3.52	3.83	3.71	3.73	0.02
Шалтгаан нөхцөл	3.84	3.98	4.11	4.14	0.03
Хор уршиг, үр дагавар	3.66	3.89	3.84	3.98	0.14
Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үнэлгээ	3.68	3.86	3.82	3.85	0.03



**ГАДААД УЛС ОРНУУДЫН АВЛИГЫН
ГЭМТ ХЭРЭГТ ОНОГДУУЛЖ БУЙ
ЯЛ ШИЙТГЭЛИЙН ТӨРӨЛ,
ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА-2021**

ГАДААД УЛС ОРНУУДЫН АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГТ
ОНОГДУУЛЖ БУЙ ЯЛ ШИЙТГЭЛИЙН ТӨРӨЛ, ХЭМЖЭЭНИЙ
ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

1. Оршил

Авлигын гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, нэгэнт гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, дахин хууль бус үйлдэл хийхээс хамгаалах нэг арга хэрэгсэл бол түүний гэмт санаа бодлоо хэрэгжүүлэн нийгэмд учруулсан хохиролтой нь дүйцсэн эрүүгийн ял шийтгэх явдал юм. Энэхүү “дүйцсэн” гэдэг шалгуур, түүнийг хангасан эсэхийг хэмжих үзүүлэлт тун ярвигтай, ээдрээтэй. Учир нь авлигын хор хөнөөл ихэвчлэн тухайн улсын төр, нийгмийн бүтэц, тогтолоо, институтын хүчин чадалд заналхийлж байдаг. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн хамтран амьдрах нөхцөл, боломж, ирээдүйг эргэлзээнд оруулдаг аюултай.

Авлигын гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээг тухайн улсын нийгэм-эдийн засгийн болон хүний хөгжил, соёлын онцлог, авлигатай тэмцэх институтийн хүчин чадал зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан тогтоох, өөрчлөх шаардлагатай байдаг. Ялын хэмжээ их бол хахуулийн хэмжээ ч ялгаагүй их байдаг байна. Иймээс ялын хэмжээ нэг ам.доллараар нэмэгдэхэд хахуулийн хэмжээ хоёр ам.доллараар нэмэгддэг талаар Роуз-Аккерман дурдсан байдаг (Rose-Ackerman S. , 1978, pp. 109-135)

. Нөгөөтгээгүүр, ялын хэмжээг хэтэрхий доогуур тогтоосноор нийгэмд авлигын гэмт хэрэг гаарч, авлигатай тэмцэх эрх бүхий байгууллага үр дүнтэй ажиллах боломжгүй болдог байна.

Монгол Улс дахь авлигын түвшин буурахгүй байгааг авлигын гэмт хэрэгт оногдуулж буй ял шийтгэлийн хэмжээ бага байгаатай холбон, олон тохиолдлыг жишээ татаж тайлбарлах явдал манай улсын иргэд, судлаачдын дунд түгээмэл байдаг. Хэдийгээр авлигын түвшин ганцхан хүчин зүйлээс хамаарахгүй нь тодорхой боловч авлигын гэмт хэрэгт оногдуулж буй ял шийтгэлийн төрөл, хэмжээ болон АТИ-ийн хооронд ямар нэгэн хамаарал бий эсэхийг илрүүлэх зорилгоор Монгол Улсыг оруулаад 34 улсын эрүүгийн хууль, авлигын эсрэг хууль болон холбогдох бусад хуулийг харьцуулан шинжилж, ажиглалт хийсэн юм.

Авлигын түвшинг бууруулах, авлигатай тэмцэхэд дотоодын эрүүгийн хууль тогтоомж нь дараах үүрэгтэй байдаг:

Нэгдүгээрт, авлигын гэмт хэргийг эрүүгийн хуульд хуульчилснаар авлигатай үр дүнтэй тэмцэх эрх зүйн механизм, боломжийг бүрдүүлэх,

Хоёрдугаарт, авлигаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгыг хангахуйц, тохиромжтой ялын бодлогыг хэрэгжүүлэх,

Гуравдугаарт, авлигатай тэмцэх эрх бүхий байгууллагаас авлигын гэмт хэргийг үр дүнтэй илрүүлэх зорилгоор хэргийн оролцогчдоос мэдээлэл авах, хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх,

Дөрөвдүгээрт, аж ахуйн нэгж, байгууллагууд ажилчдын авлигач үйлдэлд харцуулага хүлээх тогтолоог бий болгох,

Тавдугаарт, авлигын гэмт хэрэг нь ихэнх тохиолдолд зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн шинжтэй байдаг тул түүнтэй үр дүнтэй тэмцэх процессын ажиллагааны бололцоог эрх бүхий байгууллагад олгох зэрэг (Rose-Ackerman S. , 2002, pp. 1-2)

Авлигын гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээг тухайн гэмт хэргийн нийгмийн хор аюул, дам болон шууд учруулсан хохирлын хэмжээтэй дүйцүүлэн авч үзэхээс гадна нийгэм-эдийн засгийн болон хүний хөгжил, авлигатай тэмцэх институтийн хүчин чадал зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан тодорхойлох шаардлагатай байдаг. Зарим оронд, тухайлбал, Канад, Шинэ Зеланд зэрэг АТИ өндөр улс орнууд шүүх байгууллагын авлигажсан үйл ажиллагаанд хамгийн өндөр ял оноохоор хуульчилсан байгааг анзааралгүй орхиж болохгүй.

Улс орнууд албан тушаалтан хүлээн авах боломжтой бэлэг, дурсгалын зүйл, тусламж болон хахуулийн хооронд хуулийн хүрээнд зааг тогтоож өгдөг. Энэхүү заагийг өөрсдийн түүх соёл, нийгэм, эрх зүйн тогтолцоонд тулгуурлан боловсруулж авлигатай тэмцэх, урьдчилсан сэргийлэх үр дүнтэй бодлого боловсруулсны үндсэнд хуулиар зохицуулдаг. Авлигыг илрүүлэхэд ихэнх тохиолдолд гэмт хэргийн холбогдогчид өөрсдийн сайн дураар өгсөн мэдээллийг ашигладаг. Ингэхдээ авлигын гэмт хэргийг илрүүлэх, тохирох хариуцлага ногдуулж авлигын талаар мэдээлсэн этгээдийг урамшуулах бодлого баримталдаг байна. Ингэснээр гэмт хэрэгт холбогдогч аль нэг талыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлдөг. Энэ төрлийн зохицуулалтыг БНХАУ, Монгол зэрэг улс хуульчилсан байна.

Бид “Авлигын гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээ ба авлигын түвшин ямар хамааралтай вэ?” гэсэн асуултад хариулт хайх зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэсэн болно.

Судалгаанд авлигын гэмт хэргийн хамгийн түгээмэл хэлбэр болох хахууль авах, хахууль өгөх болон эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэргийг авч үзэв. Ингэхдээ улсуудыг АТИ-ийн оноогоор нь (10-19, 20-29, 30-39, 40-49, 50-59, 60-69, 70-79, 80-89) бүлэглэж, тэдгээрт харьцах ялын хэмжээний дундаж хандлагыг гаргасан.

2. Хахууль авах гэмт хэрэг

Судалгаанд хамрагдсан улсууд хахууль авах үйлдлийг гэмт хэрэгт тооцож, оногдуулах ялын хэмжээг дараах байдлаар зохицуулжээ(Хүснэгт №1).

Хүснэгт №1 Хахууль авах гэмт хэрэгт оногдуулах ялын төрөл, хэмжээ


№	Улс	АТИ / сүүлийн 9 жилийн дундаж/	Санки		
			Хорих	Торгох	Төрийн алба хаах эрх хасах
1	Дани	89	6 хүртэл жил	Авсан хахуулийн хэмжээгээр	
2	Шинэ Зеланд	89	14 хүртэл жил		
3	Финланд	88	4 хүртэл жил	120 хүртэлх хоногийн дундаж орлогын 16/1	
4	Швед	87	6 хүртэл жил		
5	Сингапур	85	5 хүртэл жил	100 мянган ам.доллар хүртэл буюу 215 сая хүртэл төгрөгөөр	
6	Канад	81	14 хүртэл жил		

7	Австрали	79	10 хүртэл жил	100 мянган нэгж хүртэл /1 нэгж=A\$222/ буюу 4960 сая хүртэл төгрөгөөр	
8	Хонконг	76	3-7 жил	100 мянгаас 500 мянган доллар буюу 36 саяас 183 сая төгрөгөөр	
9	Австри	74	6 сар - 10 жил		
10	БНСУ	61	10 хүртэл жил	20 сая вон буюу 51 сая хүртэл төгрөгөөр	10 хүртэл жил
11	Польш	56	12 хүртэл жил		
12	Малайз	50	20 хүртэл жил	Хахуулийн хэмжээг 10 дахин нэмэгдүүлж	
13	Итали	47	12 хүртэл жил	600 нэгж хүртэл /1 нэгж 1549 евро/ буюу 3200 сая хүртэл төгрөгөөр	
14	Өмнөд Африк	44	Бүх насаар нь хүртэл	Хахуулийн хэмжээг 5 дахин нэмэгдүүлж	
15	Турк	43	16 хүртэл жил		
16	Беларусь	40	15 хүртэл жил		
17	БНХАУ	39	1 сар - бүх насаар нь	Эд хөрөнгө хураах	
18	Монгол	37	12 хүртэл жил	40 сая хүртэл төгрөгөөр	8 хүртэл жил
19	Аргентин	37	1-12 жил	-	Төстэй албан тушаал хаших эрх хасах
20	Индонез	36	- Бүх насаар нь	50 мянгаас 1 тэрбум рупи буюу 10 саяас 200 сая төгрөгөөр	Ялтай байх хугацаа
21	Филиппин	35	2 жил 4 сар - 12 жил	Хахуулийн хэмжээг 1-3 дахин нэмэгдүүлж	
22	Ботсвана	35	3 хүртэл жил		1-5 жил
23	Вьетнам	33	20 жил - бүх насаар нь	Хахуулийн хэмжээг 1-5 дахин нэмэгдүүлж	
24	Египет	33	7 хүртэл жил		Бүх насаар нь
25	Казахстан	30	15 хүртэл жил	Хахуулийн хэмжээг 80 дахин нэмэгдүүлж, хөрөнгө хураах	
26	Гүрж	30	6 - 15 жил		3 хүртэл жил
27	Азербайжан	29	12 хүртэл жил		3 хүртэл жил
28	Украйн	29	12 хүртэл жил	ХХДХ-г 750-1500 дахин нэмэгдүүлж	15 жил
29	ОХУ	28	15 хүртэл жил	Хахуулийн хэмжээг 70 дахин нэмэгдүүлж	
30	Уганда	27	10 хүртэл жил	240 нэгж хүртэл /1 нэгж нь 20 мянган шиллинг/ буюу 3.8 сая төгрөгөөр	
31	Мадагаскар	27	10 хүртэл жил	15 мянгаас 750 мянган евро буюу 52 саяас 2600 сая хүртэл төгрөгөөр	
32	Мьянмар	25			Тодорхой эрх хасах
33	Узбекистан	21	15 хүртэл жил	ХХДХ-г 100 дахин нэмэгдүүлж	
34	Ливи	17	5 хүртэл жил		

Дээрх улс орнууд авлигын гэмт хэрэгт хорих, торгох болон төрийн алба хаах эрхийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх төрлийн ялыг голчлон хэрэглэж байна. Ингэхдээ торгуулийн хэмжээг хахууль болон хохирлын хэмжээнээс шалтгаалж оногдуулахаар, мөн хахууль авсан этгээдийг төрийн албанд дахин ажиллах эрхийг тогтсон хугацаагаар хасах шийтгэл оногдуулахаар хуульчилсан байна.

Судалгаанд хамрагдсан улсуудын хахууль авах гэмт хэрэгт оногдуулж буй хорих ялын хугацаа(хугацааны дээд хязгаараар тооцсон)-ны дунджийг Авлигын төсөөллийн индекс /АТИ/ (сүүлийн 9 жилийн дундаж)-тэй харьцуулан харуулав(График №1):

График №1 Хахууль авах гэмт хэрэгт оногдуулах хорих ялын хугацаа ба АТИ-ийн хамаарал



Графикаас харахад АТИ 50 оноонд хүртэл хорих ялын хэмжээ өсч байгаад индекс 50-иас дээш болмогц эргээд буурч байгаа нь ажиглагдаж байна¹. Энэ нь авлигын түвшин ба эдийн засаг, нийгэм, соёлын олон хүчин зүйлээс хамаарч байгаа нь тодорхой юм.

Дээрх улсуудын дийлэнх нь торгох ялыг үндсэн, цөөн хэдэн улсын хувьд нэмэгдэл ял байхаар хуульчилсан байна. Судалгаанд хамрагдсан улсуудын 9 нь буюу 26.5 хувь нь л хахууль авах гэмт хэрэгт оногдуулах торгох ялын хэмжээг тодорхой заасан бол үлдсэн 73,5 хувь нь авсан хахуулийн хэмжээ болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан хуульчилсан байна. Зарим улсад, тухайлбал, Казахстан улс хахуулийн хэмжээг 80 дахин нэмэгдүүлж торгох, мөн нэмээд эд хөрөнгө хураахаар, ОХУ хахуулийн хэмжээг 70 дахин нэмэгдүүлж торгохоор хуульчилсан байна. Судалгаанаас харахад хахууль авах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах торгох ялын хэмжээ тодорхой тогтсон байх нь олон улсын жишигтэй нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл, авсан хахууль, нийгэмд учруулсан хохирлын хэмжээтэй нь дүйцүүлж ял оноох нь илүү шударга болох нь харагдаж байна.

¹ Энд бүх насаар нь хорих ялыг 25 жилээр орлуулан тооцсон болно. Өмнөд Африк, БНХАУ, Индонез, Вьетнам улсуудын хувьд хорих ялын дээд хэмжээг бүх насаар нь хорихоор хуульчилсан байна.

3. Хахууль өгөх гэмт хэрэг

Судалгаанд хамрагдсан улс орнуудын ихэнх нь хахууль өгөх үйлдлийг гэмт хэрэгт тооцож, оногдуулах ялын хэмжээг хахууль авах гэмт хэрэгтэй ойролцоо байдлаар зохицуулжээ(Хүснэгт №2).

Хүснэгт №2 Хахууль өгөх гэмт хэрэгт оногдуулах ялын төрөл, хэмжээ

№	Улс	АТИ /сүүлийн 9 жилийн дундаж/	Санки		
			Хорих	Торгох	Төрийн алба хаах эрх хасах
1	Дани	89	3 хүртэл жил	1-60 өдрийн дундаж орлогоор	
2	Шинэ Зеланд	89	14 хүртэл жил		
3	Финланд	88	4 хүртэл жил	120 хүртэлх хоногийн дундаж орлогын 16/1	
4	Швед	87	6 хүртэл жил		
5	Сингапур	85	7 хүртэл жил	100 мянган доллар хүртэл буюу 215 сая хүртэл төгрөгөөр	
6	Канад	81	14 хүртэл жил		
7	Австрали	79	10 хүртэл жил	10 мянган нэгж хүртэл /1 нэгж A\$222/ буюу 4960 сая хүртэл төгрөгөөр	
8	Хонконг	76	3-7 жил	100 мянгаас 500 мянган доллар буюу 36 саяас 183 сая хүртэл төгрөгөөр	
9	Австри	74	10 хүртэл жил		
10	БНСУ	61	5 хүртэл жил	20 сая вон хүртэл буюу 51 сая хүртэл төгрөгөөр	10 хүртэл жил
11	Польш	56	6 сараас 12 жил		
12	Малайз	50	20 хүртэл жил	Хахуулийн хэмжээг 5 дахин нэмэгдүүлж	
13	Итали	47	12 хүртэл жил	600 нэгж хүртэл /1 нэгж 1549 евро/ буюу 3200 сая хүртэл төгрөгөөр	
14	Өмнөд Африк	44	- Бүх насаар нь	Хахуулийн хэмжээг 5 дахин нэмэгдүүлж	
15	Турк	43	2-12 жил		
16	Беларусь	40	10 хүртэл жил		
17	БНХАУ	39	1 жилээс бүх насаар нь	Эд хөрөнгийг хураах	
18	Монгол	37	5 хүртэл жил	400 сая хүртэл төгрөгөөр	5 хүртэл жил
19	Аргентин	37	1-6 жил		1-6 жил
20	Индонез	36	1-15 жил	50 мянгаас 1 тэрбум рупи буюу 0.01 саяас 200 сая төгрөгөөр	
21	Филиппин	35	2 жил 4 сар - 12 жил	Хахуулийн хэмжээг 1-3 дахин нэмэгдүүлж	
22	Ботсвана	35	-	-	-
23	Вьетнам	33	1 жилээс бүх насаар нь	Хахуулийн хэмжээг 1-5 дахин нэмэгдүүлж	
24	Египет	33	-	-	-
25	Казахстан	30	15 хүртэл жил	Хахуулийн хэмжээг 20-60 дахин нэмэгдүүлж, хөрөнгө хураах	Бүх насаар нь
26	Гүрж	30	8 хүртэл жил		
27	Азербайжан	29	2-8 жил	500-5000 манат буюу 0,8 саяас 8 сая төгрөгөөр	
28	Украйн	29	3-8 жил	ХХДХ-г 200-500 дахин нэмэгдүүлж, Эд хөрөнгө хураах	

29	ОХУ	28	5 хүртэл жил	Хахуулийн хэмжээг 5-40 дахин нэмэгдүүлж	3 хүртэл жил
30	Уганда	27	10 хүртэл жил	240 нэгж хүртэл /1 нэгж нь 20 мянган шиллинг/ буюу 3.8 сая төгрөгөөр	
31	Мадагаскар	27	-	-	-
32	Мьянмар	25	15 хүртэл жил	Хохирлоос шалтгаална	
33	Узбекистан	21	10 хүртэл жил		
34	Ливи	17	5 хүртэл жил		

Судалгаанд хамрагдсан улсууд хахууль өгөх гэмт хэрэгт оногдуулж буй хорих ялын хугацаа(хугацааны дээд хязгаараар тооцсон) ба АТИ(сүүлийн 9 жилийн дундаж)-ийн хамаарлыг График №2-т үзүүлэв.

График №2 Хахууль өгөх гэмт хэрэгт оногдуулах хорих ялын хугацаа ба АТИ-ийн хамаарал



График 1-тэй төстэй, АТИ 50 оноонд хүртэл хорих ялын хэмжээ өсч байгаад индекс 50-иас дээш болмогч эргээд буурч байгаа боловч индексийн оноо 80 орчим болоход хорих ялын хугацаа эргээд бага зэрэг нэмэгдэж байна.

Хахууль авах гэмт хэргийн нэгэн адил хахууль өгөх гэмт хэрэгт оногдуулах торгох ялын хэмжээг зөвхөн 9 улс тодорхой тогтоон хуульчилсан тул хамаарал тогтоох шинжилгээ хийгээгүй болно. Манай улсын хувьд ч мөн хахууль өгөх гэмт хэрэгт оногдуулах тогтох ялын хэмжээг өгсөн хахууль, нийгэмд учруулсан хохирлын хэмжээтэй нь дүйцүүлэн оногдуулах шаардлагатай байна. Малайз, Өмнөд Африк, Филиппин, Вьетнам, Казахстан зэрэг улсуудын хувьд хахуулийн хэмжээг 1-60 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөөр торгох шийтгэл оногдуулахаар хуульчилжээ.

Судалгаанд хамрагдсан 5 улс уг төрлийн гэмт хэрэгт төрийн албанд ажиллах эрх хасах ялыг нэмэгдэл ял байхаар зохицуулсан байна.

4. Эрх мэдлээ урвуулан ашиглах гэмт хэрэг

Судалгаанд хамрагдсан улс орнуудын 30 нь эрх мэдлээ урвуулан ашиглах үйлдлийг гэмт хэрэгт тооцож, оногдуулах ялын хэмжээг хуульчлан тогтоосон байна (Хүснэгт №3).


Хүснэгт №3 Эрх мэдлээ урвуулан ашиглах гэмт хэрэгт оногдуулах ялын төрөл, хэмжээ

№	Улс	АТИ /сүүлийн 9 жилийн дундаж/	Санки		
			Хорих	Торгох	Төрийн алба хаах эрх хасах
1	Дани	89	6 хүртэл жил	60 хүртэлх өдрийн дундаж иалин	
2	Шинэ Зеланд	89	-	-	-
3	Финланд	88	4 хүртэл жил	Хохирлоос шалтгаална	
4	Швед	87	2 хүртэл жил		
5	Сингапур	85	3 хүртэл жил		
6	Канад	81	-	-	-
7	Австрали	79	5 хүртэл жил		
8	Хонконг	76	-	-	-
9	Австри	74	10 хүртэл жил		
10	БНСУ	61	5 жил хүртэл	10 сая вон хүртэл буюу 25.5 сая хүртэл төгрөгөөр	10 жил хүртэл
11	Польш	56	10 жил хүртэлх		
12	Малайз	50	20 хүртэл жил	Хохирлын хэмжээг 5 дахин нэмэгдүүлж	
13	Итали	47	2 хүртэл жил	600 нэгж хүртэл /1 нэгж 1549 евро/ буюу 3200 сая хүртэл төгрөгөөр	
14	Өмнөд Африк	44	Бүх насаар нь хүртэл	Хахуулийн хэмжээг 5 дахин нэмэгдүүлж	
15	Турк	43	2 хүртэл жил		
16	Беларусь	40	15 хүртэл жил		
17	БНХАУ	39	Бүх насаар нь хүртэл	Эд хөрөнгө хураах	
18	Монгол	37	8 хүртэл жил	40 сая хүртэл төгрөгөөр	8 хүртэл жил
19	Аргентин	37	1-4 жил		1-5 жил
20	Индонез	36	Бүх насаар нь хүртэл	200 саяас 1 тэрбум рупи буюу 40 саяас 200 сая хүртэл төгрөгөөр	
21	Филиппин	35	12 хүртэл жил		Ялтай байх хугацаанд
22	Ботсвана	35	3 хүртэл жил		
23	Вьетнам	33	20 хүртэл жил	10-50 сая донг буюу 1.2 саяас 6 сая төгрөгөөр	5 хүртэл жил
24	Египет	33	-	-	-
25	Казахстан	30	7 хүртэл жил	5000 нэгж хүртэл /1 нэгж= 2917 тэнгэ/ буюу 98 сая хүртэл төгрөгөөр	Бүх насаар нь
26	Гүрж	30	3 хүртэлх жил		3 хүртэлх жил
27	Азербайжан	29	3-8 жил хүртэл	1000-2000 манат буюу 1.7 саяас 3.4 сая төгрөгөөр	3 хүртэлх жил
28	Украйн	29	12 хүртэл жил		3 хүртэл жил
29	ОХУ	28	10 хүртэл жил	6 сарын иалинтай тэнцэх хүртэл	

30	Уганда	27	10 хүртэл жил	240 нэгж хүртэл /1 нэгж нь 20 мянган шиллинг/ буюу 3.8 сая төгрөгөөр	
31	Мадагаскар	27	10 хүртэл жил	15 мянгаас 750 мянган евро буюу 52 саяас 2600 сая хүртэл төгрөгөөр	-
32	Мьянмар	25	6 хүртэлх сар	Хохирлоос шалтгаална	
33	Узбекистан	21	5 хүртэл жил	ХХДХ-г 600 дахин нэмэгдүүлж	Тодорхой эрх хасах
34	Ливи	17	5 хүртэл жил		

Судалгаанд хамрагдсан улсууд эрх мэдлээ урвуулан ашиглах гэмт хэрэгт оногдуулж буй хорих ялын хугацаа(хугацааны дээд хязгаараар тооцсон) ба АТИ(сүүлийн 9 жилийн дундаж)-ийн хамаарлыг График №3-м үзүүлэв.

График №3 Эрх мэдлээ урвуулан ашиглах гэмт хэрэгт оногдуулах хорих ялын хугацаа ба АТИ-ийн хамаарал




Эрх мэдлээ урвуулан ашиглах гэмт хэрэгт оногдуулах торгох болон эрх хасах нэмэгдэл ялын хувьд тоон мэдээлэл хангалтгүй тул шинжилгээ хийх боломжгүй байгаа боловч, ялангуяа, торгох ялын хувьд иөөнгүй улс тухайн этгээдийн нийгэмд учруулсан хохирлын болон цалин хөлсний хэмжээтэй харьцуулан оногдуулахаар хуульчилсан байна.

5. Дүгнэлт

Хахууль авах, өгөх, эрх мэдлээ урвуулан ашиглах гэмт хэрэгт оногдуулж буй хорих ялын хэмжээг АТИ-тэй харьцуулсан графикуудыг нэгтгэн График №4-т үзүүлэв:

График №4 Хахууль авах, өгөх, эрх мэдлээ урвуулан ашиглах гэмт хэрэгт оногдуулж буй хорих ялын хугацаа ба АТИ-ийн хамаарал



Энэхүү судалгааны “Авлигын гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээ ба авлигын түвшин ямар хамааралтай вэ?” гэсэн асуултад дараах байдлаар харуулах боломжтой байна. Үүнд:

- “Транспэрэнси интернэшнл” олон улсын байгууллагаас Авлигын төсөөллийн индексийн 50 хүртэлх оноог авлигын түвшин өндөр, 30 хүртэлх оноог хүнд хэлбэрийн системийн авлигатай улс, орон хэмээн тодорхойлдог. АТИ-ээр 50-иас дээш оноо авахад нөлөөлөх нэг хүчин зүйл нь авлигын гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээг нэмэгдүүлэх явдал юм. Харин АТИ нэгэнт 50 онооноос дээш гарсан тохиолдолд ялын бодлогыг буцаан сулруулах боломжтой байна.
- Хахууль авах, хахууль өгөх, эрх мэдлээ урвуулан ашиглах гэмт хэргийн хорих ялын дээд хэмжээ дунджаар 15 жил байснаар АТИ-ийг 50 оноо хүртэл өсөх магадлалтай нь судалгаанаас харагдаж байна.
- Манай улсын Эрүүгийн хууль авлигатай тэмцэх шударга, хүчтэй хэрэгсэл байж чадахгүй байна. Судалгаанаас харахад авлигын гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах торгох ялын хэмжээг тодорхой тогтоож өгөх нь олон улсын жишигт түгээмэл биш байна. Өөрөөр хэлбэл, гэмт этгээдийн авсан, өгсөн хахууль, нийгэмд учруулсан хохирлын хэмжээтэй нь уялдуулж торгох ялын хэмжээг шийдвэрлэх нь илүү шударга болох нь харагдаж байна.



**ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ,
2021 ОНЫ СУДАЛГАА**

БҮЛЭГ 1. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хүүхдийн шударга байдлын судалгааг “Транспэрэнси Интернэшнл Солонгос” байгууллагаас боловсруулсан арга зүйн дагуу анх 2008 онд Энэтхэг, Солонгос, Бангладеш, Монгол зэрэг улсад зохион байгуулсан. Уг арга зүйн дагуу Хүүхдийн шударга байдлын судалгааг АТГ-аас зохион байгуулан явуулж байна. Өнгөрсөн хугацаанд судалгааны үр дүнг соён гэгээрүүлэх ажил, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахад ашиглаж ирлээ.

1. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШНИЙ ТООЦООЛОЛ

Хүүхдийн шударга байдлын түвшинг тогтоохдоо доорх 12 асуултад тухайн хүүхэд санал нийлж байгаа эсэхийг нь асууж, хариулт бүрийг 1-5 хүртэлх оноогоор үнэлж, үнэлгээний арифметик дунджаар гаргав. Хүүхдийн шударга байдлын түвшин нь хүүхдийн ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих, авлигыг үл тэвчих үзэл гэсэн дэд үзүүлэлтээс бүрддэг. Хүүхдийн шударга байдлын түвшин 1-д ойртох тусам шударга бус, харин 5-д ойртох тусам шударга гэж үзнэ.

Хүснэгт 1. Хүүхдийн шударга байдлыг үнэлэхэд ашигласан асуулт

Асуултын дугаар	Асуулт
1.	Дотнын найз минь шалгалт өгч байхдаа бусдаас хуулж байвал би “найз минь юм чинь за яахав дээ” гэж бодно.
2.	Том хүмүүсийн үйлдэл хууль бус байсан ч надад ашигтай байвал хүлээн зөвшөөрнө.
3.	Хүүхдүүд интернетэд байгаа бусдын бүтээлээс хуулбарлаж гэрийн даалгавараа хийхдээ эх сурвалжийг нь заавал дурдах албагүй.
4.	Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь байж болох зүйл.
5.	Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга юм.
6.	Баян байх нь шударга байхаас илүү чухал.
7.	Төрийн албан хаагч төрийн үйлчилгээ үзүүлснийхээ төлөө шан харамж авч болно.
8.	Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн нь миний сайн найз байсан ч би өөрийн итгэдэг багш, эцэг, эх, хэн нэгэнд мэдэгдэнэ.
9.	Кино үзэхийн тулд урт дараалалд зогссоноос урдуур нь дайрч хурдан кинонд оро.
10.	Замын цагдаа-зохицуулагч байхгүй бол би замын хөдөлгөөний дүрэм зөрчиж магадгүй.
11.	Гэмт хэрэг үйлдсэн, авлига, хээл хахууль авсан хэн нэгнийг би зохих байгууллагад нь мэдэгдэнэ.
12.	Манай гэр бүл баяжиж л байвал миний аав, ээж эрх мэдлээ ашиглах, хууль зөрчих нь надад хамаагүй.

Хүүхдийн шударга байдлын түвшний дэд үзүүлэлт болох ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих болон авлигыг үл тэвчих байдлын үзүүлэлтийг тооцохдоо дээр дурдсан асуултуудын дагуу дэд үзүүлэлтийн дунджийг тооцсон болно. Дэд үзүүлэлт тооцоход ашигласан асуултыг дараахь хүснэгтээс харна уу.

Хүснэгт 2. Хүүхдийн шударга байдлын дэд үзүүлэлтийг тооцсон асуулт, асуултын дугаараар

	Ёс зүй, ёс суртахуун	Зөв төлөвшилт	Хууль сахих	Авлигыг үл тэвчих
Танин мэдэхүйн	3	4	1	2
Нөлөөллийн	6	5	7	8
Зан үйлийн	9	11	10	12

2. СУДАЛГАА ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙДАЛ

Авлигатай тэмцэх газар нь Хүүхдийн шударга байдлын судалгааг цахим хэлбэрээр “SurveyMonkey” судалгааны программыг ашиглан 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 10-12 дугаар ангийн сурагчид болон эцэг, эхчүүд, багш нараас санамсаргүй байдлаар сонгон, бэлтгэгдсэн асуулгыг бөглүүлж, судалгааг зохион байгуулав.


Судалгааны мэдээллийг цахим хэлбэрээр цуглуулах ажлыг 21 аймаг, нийслэлийн сургуулийн багш нар болон нийгмийн ажилтантай хамтран 2021 оны 4 дүгээр сарын 11-ны өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хооронд зохион байгууллаа. Судалгаанд аймаг, нийслэлийн хэмжээнд нийт 8080 сурагч, 1169 багш албан хаагч, 1968 эцэг, эх хамрагдав.

Мөн энэ удаагийн судалгаанд аймаг, нийслэлээс сонгон авсан түүврийн дагуу сургуулийн багш, албан хаагчдийг хамруулсан нь онцлог байв.

3. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

“Хүүхдийн шударга байдал-2021” судалгааны дүнгээр нийт сурагчийн 34.2 хувь нь эрэгтэй, 65.8 хувь нь эмэгтэй байгаа бол 17 настай сурагчид хамгийн их буюу 31.7 хувь, 14 настай сурагчид хамгийн бага буюу 2.0 хувь байна. Байршлаар нь авч үзвэл 56.0 хувь нь аймгаас, 44.0 хувь нь нийслэлийн харьяа сургуулиудын сурагчид байна (Зураг 1).

Зураг 1 . Хүүхдийн нас, хүйс




Судалгаанд хамрагдсан багш, албан хаагчдын 1001 буюу 85.6 хувь нь эмэгтэй, 168 буюу 14.4 хувь нь эрэгтэйчүүд байна. Насны бүлгээр авч үзвэл судалгаанд оролцсон багш, албан хаагчдын 33.8 хувь нь 35-44 настай, 32.0 хувь нь 25-34 настай, 24.1 хувь нь 45-54 настай, 6.2 хувь нь 24 хүртэлх настай байгаа бол судалгаанд оролцогчдын 3.9 хувь нь 55 дээш насныхан байна (Зураг 2).

Зураг 2. Багш, албан хаагчдын насны бүлэг



Хүүхдийн шударга байдал 2021 оны судалгаанд 1968 эцэг эхчүүд хамрагдсанаас 1672 буюу 85 хувь нь эмэгтэйчүүд байгаа бол 296 буюу 15 хувь нь эрэгтэйчүүд байна. Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 55.9 хувь нь 35-44 настай, 25.8 хувь нь 45-54 настай, 12.9 хувь нь 25-34 настай, 4.1 хувь нь 55 дээш настай, 1.4 хувь нь 24 хүртэлх настай байна (Зураг 3).

Зураг 3. Эцэг эхчүүдийн насны бүлэг



Хүүхдийн шударга байдал 2021 он судалгаанд хамрагдсан багш албан хаагчид, эцэг эхчүүдийг байршлаар нь авч үзвэл багш, албан хаагчдын 67.3 хувь нь, эцэг эхчүүдийн 67.0 хувь нь аймгуудаас оролцсон бол багш албан хаагчдын 32.7 хувь, эцэг эхчүүдийн 33.0 хувь нь нийслэлээс байна.

БҮЛЭГ 2. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Хүүхдийн шударга байдлын түвшинг 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн бөгөөд уг үзүүлэлтийн утга 1-д ойртох тусам шударга бус, 5-д ойртох тусам шударга гэж ойлгоно.


Хүүхдийн шударга байдлын түвшин 2021 оны судалгаагаар 4.06 гэсэн дүнтэй гарсан нь өмнөх оноос 0.05 пунктээр нэмэгдсэн байна (Зураг 4).

Зураг 4. Хүүхдийн шударга байдлын түвшин, оноор



Шударга байдлын үзүүлэлтийн хамгийн их ба хамгийн бага утгын зөрүү нь 0.66 пункт байна (Зураг 5). Есөн аймгийн үзүүлэлт улсын дунджаас доогуур байгаа бол 12 аймаг, нийслэлийн үзүүлэлт улсын дунджаас өндөр байна.

Зураг 5. Хүүхдийн шударга байдал 2021 он судалгааны түвшин, аймаг, нийслэлээр



Хүүхдийн шударга байдлын түвшинг аймаг, нийслэлээр тооцдог ба 2021 оны судалгааны үр дүнгээр Баян-Өлгий, Дорноговь, Орхон, Өвөрхангай аймгийн хүүхдийн шударга байдлын түвшин бага зэрэг буурсан. Хөвсгөл аймгийн хүүхдийн шударга байдлын түвшин өнгөрсөн онтой харьцуулахад өөрчлөлтгүй гарсан. Харин бусад аймаг болон нийслэлийн хүүхдийн шударга байдлын түвшин эерэг өөрчлөлттэй гарчээ (Хүснэгт 3).

Хүснэгт 3 Аймгуудын шударга байдлын түвшин, оноор

д/д	Аймаг	Шударга байдлын түвшин							Зөрүү
		2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	
1	Архангай	4.01	3.89	3.95	3.79	3.88	3.99	4.05	0.06
2	Баян-Өлгий	4.18	3.74	3.98	3.72	3.61	3.80	3.51	-0.28
3	Баянхонгор	4.03	4.17	4.04	3.99	3.95	4.04	4.10	0.07
4	Булган	4.26	3.67	3.95	3.98	3.88	3.92	4.00	0.07
5	Говь-Алтай	3.36	4.03	4.03	4.39	4.04	3.89	4.08	0.19
6	Говьсүмбэр	3.71	3.92	4.09	3.90	3.88	4.04	4.09	0.05
7	Дархан-Уул	3.56	4.04	4.02	4.11	3.93	4.03	4.04	0.01
8	Дорноговь	3.99	4.22	3.70	4.14	3.95	4.08	4.03	-0.04
9	Дорнод	3.38	4.08	4.11	3.96	3.93	4.02	4.10	0.08
10	Дундговь	4.26	3.79	4.26	4.19	3.93	4.07	4.13	0.06
11	Завхан	3.96	4.03	4.04	4.21	3.97	3.97	4.09	0.12
12	Орхон	4.07	4.04	3.99	3.40	3.83	4.06	4.02	-0.04
13	Өвөрхангай	3.65	4.16	3.72	4.06	3.91	4.05	4.01	-0.04
14	Өмнөговь	3.66	4.21	3.97	3.39	4.03	4.03	4.17	0.14
15	Сүхбаатар	4.13	3.69	3.96	3.92	3.90	4.08	4.10	0.02
16	Сэлэнгэ	3.57	4.04	4.10	4.13	3.91	4.01	4.08	0.07
17	Төв	3.87	3.98	3.81	4.11	3.97	3.95	4.14	0.19
18	Увс	4.29	4.06	4.03	4.11	3.98	4.09	4.17	0.07
19	Ховд	4.08	4.10	4.00	3.97	3.94	3.98	4.03	0.05
20	Хөвсгөл	4.36	4.09	4.28	4.01	3.99	4.07	4.07	0.00
21	Хэнтий	4.00	4.17	4.24	3.89	3.94	3.95	4.05	0.10
22	Улаанбаатар	4.05	3.98	3.95	3.78	3.88	4.03	4.09	0.06

Хүүхдийн шударга байдлын түвшинг дүүргээр тооцоход хамгийн их ба хамгийн бага утгын зөрүү нь 0.21 пункт байна (Зураг 6).

Зураг 6. Хүүхдийн шударга байдал 2021 он судалгааны түвшин, дүүргээр




Хүүхдийн шударга байдлын түвшинг дүүргээр тооцоход Баянгол, Налайх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн хүүхдийн шударга байдлын түвшин 0.03-0.09 пунктээр буурсан ба бусад дүүргийнх эерэг өөрчлөлттэй гарчээ (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Хүүхдийн шударга байдал дүүргээр, 2017-2020 он

Дүүрэг	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	Зөрүү
Баянзүрх дүүрэг	3.77	4.04	3.88	4.01	4.11	0.11
Баянгол дүүрэг	3.84	3.96	3.83	4.12	4.09	-0.03
Багануур дүүрэг	4.04	3.88	3.82	4.08	4.11	0.04
Баганхангай дүүрэг	3.91	4.00	3.69	3.71	4.26	0.55
Налайх дүүрэг	4.03	3.04	3.86	4.12	4.06	-0.06
Сүхбаатар дүүрэг	4.09	3.60	4.08	4.13	4.06	-0.07
Хан-Уул дүүрэг	3.86	3.92	4.06	4.00	4.05	0.05
Чингэлтэй дүүрэг	4.09	3.67	3.85	4.13	4.05	-0.09
Сонгинохайрхан дүүрэг	3.93	3.87	3.83	3.97	4.06	0.09

Хүүхдийн шударга байдлын түвшин сүүлийн 4 жилд нэмэгдсэн боловч эмэгтэй хүүхдийн шударга байдлын түвшинг эрэгтэй хүүхдийн шударга байдлын түвшинтэй харьцуулахад 2021 оны байдлаар 0.16 пунктээр их байгаа ба энэ байдал нь сүүлийн жилүүдэд хадгалагдаж байна (Зураг 7).

Зураг 7. Хүүхдийн шударга байдал, хүйсээр




Хүүхдийн шударга байдлын түвшин 11 дүгээр ангийн сурагчдын хувьд 0.5 пунктээр буурсан бол 10, 12 дугаар ангийн сурагчдын хувьд 0.2-0.4 пунктээр нэмэгдсэн байна (Зураг 8).

Зураг 8. Хүүхдийн шударга байдал, суралцаж буй ангиар



Төрийн өмчийн сургуулийн хүүхдийн шударга байдлын түвшин хувийн өмчийн сургуулийн хүүхдийн шударга байдлын түвшинөөс 0.12 пунктээр их байна (Зураг 9).

Зураг 9. Хүүхдийн шударга байдал, сургуулийн өмчийн хэлбэрээр




1. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Зөв шударга хүн болж төлөвшихөд эцэг, эх, гэр бүлийн орчин чухал үүрэгтэй хэмээн судалгаанд хамрагдсан багш албан хаагчдын 99.7 хувь нь үзсэн бол эцэг эхчүүдийн 99.5 хувь нь санал нийлнэ гэжээ.


Шударга байх талаар гэрийнхэн нь ихэвчлэн ярилцдаг хүүхдийн шударга байдлын түвшин шударга байх талаар гэрийнхэн нь хэзээч ярилцаж байгаагүй хүүхдийн шударга байдлын түвшинөөс 0.36 пунктээр их байна. Шударга байх талаар гэрийнхэн нь хэзээ ч ярилцаж байгаагүй хүүхдийн шударга байдлын түвшин 2020 онтой харьцуулахад 0.05 пунктээр буурсан байна (Зураг 10).

Зураг 10. Шударга байх талаар гэрийнхэнтэйгээ ярилцдаг нь хүүхдийн шударга байдалд нөлөөлдөг эсэх




Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 37.2 хувь нь хүүхэдтэйгээ шударга байх талаар байнга ярилцдаг, 57.0 хувь нь хааяа ярилцдаг гэсэн бол 4.8 хувь нь огт ярилцаж үзээгүй гэсэн байна (Зураг 11).

Зураг 11. Эцэг эхчүүд хүүхэдтэйгээ шударга байх талаар ярилцдаг эсэх



Шударга хандсаныхаа төлөө ойр дотны хүмүүсээр магтуулдаг хүүхдийн шударга байдлын түвшин шударга хандсаныхаа төлөө магтуулж байгаагүй хүүхдийн шударга байдлын түвшинөөс 0.17 пунктээр их байна (Зураг 12).

Зураг 12. Хүүхдийг шударга хандсаных нь төлөө магтах явдал хүүхдийн шударга байдалд нөлөөлөх эсэх




Шударга зүйл хийсэн хүүхдээ хэрхэн урамшуулдаг талаар судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдээс тодруулахад эцэг эхчүүдийн 63.0 хувь нь сайшаан магтана, 31.8 хувь нь хийх ёстой зүйлээ хийсэн гэж үзнэ, 3.2 хувь нь бусад байдлаар хандана гэсэн бол 2.1 хувь нь хүссэн зүйлийн нь авч өгнө гэж хариулсан байна (Зураг 13).

Зураг 13. Эцэг эхчүүд хүүхдээ шударга зүйл хийвэл хэрхэн урамшуулдаг байдал




Гэрийнхэн нь хүүхдээ шударга бус зүйл хийснийг нь мэдвэл хэлж ойлгуулдаг хүүхдийн шударга байдлын түвшин мэдсэн ч ямар нэгэн арга хэмжээ авдаггүй хүүхдийн шударга байдлын түвшинөөс 0.34 пунктээр их байна. Хүүхдээ шударга бус зүйл хийснийг нь мэдвэл хэлж ойлгуулах явдал 2020 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад 0.02 пунктээр нэмэгдсэн байна (Зураг 14).

Зураг 14. Хүүхдүүд шударга бус зүйл хийхэд эцэг, эхийн гаргадаг үйлдэл




Эцэг эхчүүд хүүхдээ шударга бус зүйл хийвэл хэрхэн хүлээж авах талаар судалгаанд оролцогсдоос тодруулахад эцэг эхчүүдийн 90.5 хувь нь ярилцаж бурууг ойлгуулна, 7.9 хувь нь зэмлэнэ гэсэн бол 1.3 хувь нь үл тоох болон бусад үйлдлийг гаргана гэжээ (Зураг 15).

Зураг 15. Хүүхдээ шударга бус зүйл хийвэл эцэг эхчүүдийн хандах байдал




Хорин дөрөв хүртэлх настай эцэг эхчүүдийн 0.5-0.6 хувь нь зөв хүн байх, шударга байх талаар хүүхэдтэйгээ байнга, эсхүл хааяа ярилдаг байна. Энэ үзүүлэлт нэмэгдсээр 35-44 настай эцэг эхчүүдийн 19.9-32.9 хувьд хүрээд буурч эхэлдэг байна. 45-54 настай эцэг эхчүүдийн 10 гаруй хувь харин 55 дээш настай эцэг эхчүүдийн 3 хүрэхгүй хувь нь зөв хүн байх, шударга байх талаар хүүхэдтэйгээ ярилцдаг гэжээ (Зураг 16).

Зураг 16. Эцэг эхчүүд хүүхэдтэйгээ ярилцдаг байдал эцэг эхийн насны бүлгээр




Шударга бус үйлдэл хийхийг найз нөхөд нь ятгадаг хүүхдийн шударга байдлын түвшин найз нөхөд нь шударга бус үйлдэл хийхийг хэзээ ч санал болгож байгаагүй хүүхдийн шударга байдлын түвшинөөс 0.44 пунктээр бага байна (Зураг 17).

Зураг 17. Хүүхдийн шударга байдалд найз нөхөд нь нөлөөлөх эсэх




Шударга бус үйлдлийн талаар ангийнхан болон найзтайгаа ярилцдаг хүүхдийн шударга байдлын түвшин ангийнхан болон найзтайгаа ярилцдаггүй хүүхдийн шударга байдлын түвшинөөс 0.11 пунктээр их байна. Шударга бус үйлдлийн талаар ангийнхан, найз нартайгаа ярилцдаг хүүхдийн шударга байдлын түвшин энэ талаар ярилцдаггүй хүүхдийн шударга байдлын түвшинөөс өндөр байдаг чиг хандлага 2021 онд хэвээр хадгалагджээ (Зураг 18).

Зураг 18. Хүүхдүүд шударга бус үйлдлийн талаар ангийнхан, найз нартайгаа ярилцах нь хүүхдийн шударга байдалд нөлөөлөх эсэх




Шударга бус зүйл хийсэн дотныхоо хүнийг зэмлэж сануулна гэж үзэж буй хүүхдийн шударга байдлын түвшин надад ашигтай байвал дэмжинэ гэж үзэж буй хүүхдийн шударга байдлын түвшинөөс 0.66 пунктээр их, 2020 онтой харьцуулахад 0.02 пунктээр буурсан байна. Шударга бус зүйл хийсэн дотныхоо хүнийг зэмлэж сануулна гэж үзэж буй хүүхдийн шударга байдлын түвшин надад ашигтай байвал дэмжинэ гэж үзэж буй хүүхдийн шударга байдлын түвшинөөс өндөр байх чиг хандлага сүүлийн хоёр жил хадгалагдаж байна (Зураг 19).

Зураг 19. Шударга бус зүйл хийсэн дотныхоо хүнд хандах хандлага ба хүүхдийн шударга байдлын түвшин



Шударга ёсны тухай мэдээллийг гэр бүл, сургууль, сонин хэвлэл, интернетийн хүрээнд авдаг хүүхдийн шударга байдлын түвшин нь зурагт радио, найз, нөхдийн хүрээлэл зэрэг бусад хүрээнээс авдаг хүүхдийн шударга байдлын түвшинөөс өндөр байна (Зураг 20).

Зураг 20. Хүүхдийн шударга ёсны талаарх мэдээлэл авах суваг ба хүүхдийн шударга байдлын түвшин




Хүүхдүүд шударга бус үйлдэл гаргасан тухай эцэг, эх, найз нөхөддөө хандан ярилцаж асуудлаа шийдвэрлэдэг болох нь судалгааны дүнгээс харагдаж байна (Зураг 21).

Зураг 21. Та шударга бус үйлдэл гаргавал хэнд ханддаг вэ?



Шударга бус асуудал тохиолдвол эцэг, эх, багш зэрэг дотныхоо хүнд ханддаг хүүхдийн шударга байдлын түвшин шударга бус асуудал тохиолдвол ямар нэгэн үйлдэл хийдэггүй хүүхдийн шударга байдлын түвшинөөс 0.43 пунктээр их байгаа нь тухайн хүүхдийг ойлгодог, нээлттэй ярилцдаг хүний дэмжлэг хэрэгцээтэй байгааг харуулж байна (Зураг 22).

Зураг 22. Шударга бус асуудал тохиолдоход хүүхдийн үйлдэл



2. ШУДАРГА БАЙДЛЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ

Судалгаанд оролцсон эцэг эхчүүд, багш албан хаагчдаас шударга байх гэдгийг хэрхэн ойлгож байгааг нээлттэй асуултаар тодруулав. Судалгааны үр дүнгээс харахад эцэг эхчүүд төдийгүй багш албан хаагчид шударга байх, шударга ёсны зарчмуудыг тэр бүр сайн ойлгохгүй байна. Судалгаанд оролцогсдын өгсөн хариултыг багцлан авч үзвэл үнэн зөв байх, ялгаварлан гадуурхахгүй байх, худал ярихгүй байх зэргийг шударга байхад хамааруулжээ (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Эцэг эхчүүд, багш, албан хаагчид “шударга байх” гэдгийг хэрхэн ойлгож буй байдал

Ойлголт	Эцэг эхчүүд	Багш албан хаагчид
Үнэн зөв	656	401
Яс үндэс, нийгмийн давхаргаар ялгаварлахгүй байх	167	177
Худал ярихгүй	159	52
Нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг дагаж мөрдөх	45	57
Хуурамч зангүй	34	
Чин сэтгэлээсээ хандах	31	
Хариуцлагатай байх	19	19

Нөгөө талаар судалгаанд оролцогсдоос “шударга бус” гэдгийг хэрхэн ойлгож байгааг мөн тодруулав. Эцэг эхчүүд, багш албан хаагчдын ойлголтыг багцлан хүснэгт 6-д харуулав. Худал, хуурамч зүйл хийх, ялгаварлан гадуурхах, хууль бус зүйл хийхийг шударга бус гэж үзэж байна.

Хүснэгт 6. Эцэг эхчүүд, багш албан хаагчдын “шударга бус” гэдгийг хэрхэн ойлгож буй байдал

Ойлголт	Эцэг, эхчүүд	Багш, албан хаагчид
Худал хуурмаг зүйл хийх	459	276
Эрх тэгш бус байдал, ялгаж хандах	207	207
Хууль бус зүйл хийх	92	82
Ёс зүйгүй байх	27	16
Хэлсэндээ хүрэхгүй	21	
Хэн нэгнийг хохироох үйлдэлийг санаатай хийх	10	
Хариуцлаггүй	9	11

Дээрхээс үзэхэд хүүхэд, залуучуудад шударга ёс, шударга бус зүйл гэдэг ойлголтыг өгч байх ёстой эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчдийн ойлголт бүрхэг байна.

Шударга ёсны талаар хичээл ордог эсэхийг хүүхдүүдээс тодруулан шударга байдлын түвшинтэй нь харьцуулан үзэхэд шударга ёсны талаар хичээл заалгадаг хүүхдийн шударга байдлын түвшин хичээл заалгадаггүй хүүхдийн шударга байдлын түвшинөөс 0.1 пунктээр өндөр байна (Зураг 23).

Зураг 23. Шударга ёсны талаар хичээл орох нь шударга байдалд нөлөөлөх эсэх



Шударга бус үйлдлийн талаар олон нийтэд мэдээлэх нь зөв гэж үздэг хүүхдийн шударга байдлын түвшин олон нийтэд мэдээлэх нь буруу гэж үздэг хүүхдийн шударга байдлын түвшинээс 0.16 пунктээр их байна (Зураг 24).

Зураг 24. Шударга бус үйлдлийг олон нийтэд мэдээлэх нь зөв үү?



Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрүүд хүүхдийг зөв шударга хүн болж төлөвших дадлыг олгож байгаа эсэхийг тодруулахад судалгаанд оролцсон багш, албан хаагчдын 79.7 хувь нь тийм гэж үзсэн бол 20.3 хувь нь зөв шударга хүн болж төлөвших дадлыг олгож чадахгүй байна гэжээ.

Шударга ёсны боловсрол олгодог гэж хариулсан багш, албан хаагчдаас ямар хичээлийн хөтөлбөрт олгож буй талаар тодруулахад Иргэний ёс зүйн боловсрол хичээлийг хамгийн ихээр нэрлэсэн (Хүснэгт 7) байна.

Хүснэгт 7. Шударга ёсны боловсрол олгодог хичээлийн хөтөлбөр

Хичээл	Давтамж
Иргэний ёс зүйн боловсрол хичээл	161
Монгол хэл уран зохилын болон гадаад хэлний хичээлийн текст зохиолуудаар дамжуулж олгодог	58
Нийгмийн ухааны хичээл	45
Ер нь бүх хичээлүүд өгдөг гэж ойлгодог	44
Ёс зүйн боловсрол	8
Эрүүл мэндийн хичээл	7
Англи хэлний хичээл	3

Шударга ёсны боловсрол олгож чадахгүй байна гэж хариулсан багш, албан хаагчдаас шалтгааны талаар нээлттэй асуултаар тодруулсан ба хариултыг багцлан (Хүснэгт 8) харуулав.

Хүснэгт 8. Хүүхдүүдэд шударга ёсны дадлыг олгож чадахгүй байгаа шалтгаан

Шударга ёсны дадлыг олгож чадахгүй байгаа шалтгаан	Давтамж
Яг хөтөлбөрт байхгүй	55
Хэт онолын хичээл их, зөв хүн байх агуулга хомс, ном хэрэглэгдхүүнгүй	27
Эцэг эхээс хамаарна	24
Шударга хүн болж төлөвших дадлыг олгож бүрэн чадахгүй байна.	17
Энэ талын хичээл ховор	16
Багш нар мэдлэгтэй байх ёстой	14
Түүх, нийгэм, иргэний ёс зүй, монгол хэл, уран зохиолын хичээлээр илүү боломжтой	10
Сургуулийн орчинд шударга бус зүйл ажиглагддаг	7
Цаг бага	7
Хүүхдийн хүмүүжил төлөвшилд зориулсан хичээлийг мэргэжлийн багшаар тусгайлан оруулах шаардлагатай	6
Бүх хичээлээр олгох ёстой	3

ДҮГНЭЛТ

Хүүхдийн шударга байдал 2021 оны судалгааны үр дүнгээс дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургуулийн багш, албан хаагчдын 85 гаруй хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа ба нас ахих тутам эрэгтэй багш, албан хаагчдын тоо буурч байна (Зураг 2).
- Хүүхдийн шударга байдал 2021 оны судалгаанд хамрагдсан нийт багш, албан хаагчид, эцэг эхчүүдийн 67 гаруй хувь нь орон нутгаас хамрагдсан байна. Энэ нь нийслэлд ажил, амьдралын хэв маяг, ачаалал ихтэй байдаг байж болзошгүй юм. Иймд энэ нөхцөл байдлыг цаашид судлах хэрэгтэй гэж үзэж байна.
- Хүүхдийн шударга байдлын түвшин 2021 оны судалгаагаар 4.06 гэсэн дүнтэй гарсан нь өмнөх оноос 0.05 пунктээр нэмэгдсэн байна (Зураг 4). Энэ нь хүүхдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд хэрэгжүүлбэл зохих урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүртээмж, чанарт бараг өөрчлөлт гарахгүй байна гэж үзэж болохоор байна.
- Хүүхдийн шударга байдлын түвшинг аймаг, нийслэлээр авч үзэхэд энэ удаагийн судалгааны үр дүнгээр Баян-Өлгий, Дорноговь, Орхон, Өвөрхангай аймгийн хүүхдийн шударга байдлын түвшин бага зэрэг буурсан. Үүнээс тус үзүүлэлт Баян-Өлгий аймгийн хувьд 2020 онд 3.80 байсан нь 3.51 болж 0.28 пунктээр буурсан нь анхаарал татаж байна.
- Эмэгтэй хүүхдийн шударга байдлын түвшинг эрэгтэй хүүхдийн шударга байдлын түвшинтэй харьцуулахад 2021 оны байдлаар 0.16 пунктээр их байгаа ба энэ байдал нь сүүлийн жилүүдэд хадгалагдаж байна (Зураг 7). Мөн төрийн өмчийн сургуулийн хүүхдийн шударга байдлын түвшин хувийн өмчийн сургуулийн хүүхдийн шударга байдлын түвшнөөс өндөр байх явдал ажиглагдаж байна (Зураг 9).
- Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 37.2 хувь нь хүүхэдтэйгээ шударга байх талаар байнга ярилцдаг, 57.0 хувь нь хааяа ярилцдаг гэсэн бол 4.8 хувь нь огт ярилцаж үзээгүй гэсэн байна (Зураг 11). Гэтэл шударга байх талаар гэрийнхэн нь ихэвчлэн ярилцах (Зураг 10), шударга хандсаныхаа төлөө ойр дотны хүмүүсээр магтуулах (Зураг 12), хэлж ойлгуулах (Зураг 14) зэрэг нь хүүхдийн шударга байдлын түвшинд эерэг нөлөө үзүүлж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.
- Харин эцэг эхчүүдийн хүүхэддээ анхаарал, халамж тавих, хүүхэдтэйгээ ажиллах явдал эцэг эхчүүдийн нас ахих тутам буурч байгаа хандлага энэ удаагийн судалгаагаар мөн ажиглагдаж байна (Зураг 16).
- Хүүхдийн шударга байдлын түвшинд ангийнхан болон найз нөхөд нь нөлөөлдөг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Иймд шударга бус үйлдлийн талаар ангийнхан болон найзтайгаа ярилцах, шударга бус зүйл хийсэн дотныхоо хүнийг зэмлэж сануулах зэрэг нь хүүхдүүдэд эерэг нөлөөтэй байна (Зураг 19).
- Шударга бус асуудал тохиолдвол хүүхдүүд эцэг, эх, багш зэрэг дотныхоо хүнд хандан асуудлаа шийдвэрлэдэг байна (Зураг 21). Гэтэл эцэг эхчүүд болон багш албан хаагчдын шударга байх, шударга бусын талаарх ойлголт бүрхэг байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна (Хүснэгт 5-6).
- Шударга байх, шударга бус зүйл гэсэн ойлголтыг эцэг эхчүүд, багш албан хаагчдаас нээлттэй асуултаар тодруулахад худал хуурмаг зүйл хийхгүй байх, ялгаварлан гадуурхах, ялгаж хандахгүй байхыг шударга гэсэн ойлголтод авч үзэж байна (Хүснэгт 5-6).

- Шударга ёсны талаар хичээл заалгадаг хүүхдийн шударга байдлын түвшин энэ талаар хичээл залгадаггүй хүүхдийн шударга байдлын түвшинөөс өндөр байх чиг хандлага энэ удаагийн судалгаагаар мөн ажиглагдав (Зураг 23).
- Шударга бус үйлдлийн талаар олон нийтэд мэдээлэх нь зөв гэж үзэх хүүхдийн шударга байдлын түвшин өндөр байх чиг хандлага мөн энэ удаагийн судалгаагаар хадгалагджээ (Зураг 24).
- Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрүүд хүүхдийг зөв шударга хүн болж төлөвших дадлыг олгож байна хэмээн судалгаанд оролцсон багш, албан хаагчдын 79.7 хувь нь үзсэн ба үүнийг Иргэний ёс зүйн боловсрол хичээлээр олгож байна гэжээ.
- Харин зөв шударга хүн болж төлөвших дадлыг ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөр олгож чадахгүй байна гэж үзсэн багш албан хаагчид уг асуудал яг хөтөлбөрт байхгүй, хичээлийн хөтөлбөрүүд хэт онолын хичээл ихтэй, зөв хүн байх агуулга, хомс, ном хэрэглэгдэхүүнгүй гэжээ (Хүснэгт 8).

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬД:

- Шударга зан чанар, шударга байдал, шударга ёс гэдэг ойлголтуудыг тодорхойлж хүүхэд гэлтгүй насанд хүрэгчдэд хэрэглэж хэвшүүлэх талаар соён гэгээрүүлэх ажлыг тогтмол явуулах;
- Шударга зан чанар, шударга байдал, шударга ёс гэдэг ойлголтуудыг хүүхдүүдийн насны ангилал, боловсролын түвшин бүрт тохирсон соён гэгээрүүлэх ажлын бодлого боловсруулах, байдлаар зааж сургах;
- Багш нарыг ёс зүйн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалтад тасралтгүй хамруулах, сургууль дээр хэлэлцүүлэг, мэтгэлцээн зэргийг тогтмол зохион байгуулах;
- Хүүхдийн шударга байдлын түвшингөөр нь тухайн сургууль болон хичээл заасан багш нарыг нь шалгаруулан урамшуулах;
- Сургууль бүр хичээлийн жилдээ анги, сургуулийн хэмжээнд сар, улирал бүр шударга үйлдэл хийсэн хүүхдийг шалгаруулах зэрэг ёс зүйн болоод ёс суртахууны хүмүүжил олгох арга хэмжээг тогтмол зохион байгуулах;
- Сургууль, сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, эцэг эхчүүдэд зориулсан шударга байдлын талаар ойлголт өгөх, хэвшүүлэх загвар хичээл, хөтөлбөр, хэлэлцүүлэг, уралдаан тэмцээн, тоглоом зэргийг танилцуулсан гарын авлага, хэрэглэгдэхүүн бэлтгэх, түгээх;
- Шударга ёсны хүмүүжил олгох хэрэглэгдэхүүн, ном, гарын авлагаар багш, албан хаагчдыг хангах;

ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН УВЬД:

- Хүүхдэд шударга ёсны хүмүүжил олгох, зөв хүн болгон төлөвшүүлэхийн тулд эцэг, эхчүүд өөрсдөө үг хэл, үйл хөдлөл, биеэрээ зөв үлгэр дууриалал үзүүлж хэвших;
- Хүүхдээ шударга үйлдэл хийсэн бол магтаж, сайшааж байх, шударга бус үйлдэл хийсэн бол хор хөнөөлийг ухааруулан тайлбарлаж өгөх;
- Хүүхдийнхээ багш нартай байнга холбоотой байх, хүүхдээ олны дунд биеэ хэрхэн авч явж байх талаар зааж сургах;
- Хүүхэдтэйгээ илэн далангүй дотно ярилцаж хүсэл зоригийг нь олж мэдэх, тэдэнд нөхөрсөг зөвлөгөө өгөх, чиглүүлж байх;
- Хүүхдээ ямар хүүхэдтэй найзалж, нөхөрлөж байгааг нь үргэлж мэдэж байх;
- Хүүхэдтэйгээ шударга ёсны талаарх ойлголтоо нэгтгэх, цаг үргэлж дэмжих;

- Хүүхдүүд олон төрлийн олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашигладаг тул тэдний интернэт хэрэглээнд хяналт тавьж байх;
- Зөвхөн ээжүүд хүүхэдтэйгээ байнгын харилцаатай байхаас гадна аавууд ч гэсэн хүүхэдтэйгээ ойр дотно байж тэдэнд сайн сайхан байдлаар нөлөөлж байх;
- Эцэг, эхчүүд нас ахих тусам хүүхдэд тавих хараа хяналт, анхаарал халамжаа улам бүр нэмэгдүүлэх;

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬД:

- Телевизүүдээр хүүхдийн сэтгэл зүйд нөлөөлсөн үлгэр жишээ авахаар шударга ёсны талаарх сонирхолтой кино, хөтөлбөр, нэвтрүүлгийг тогтмол бэлтгэн гаргах;
- Хүүхдийг зөв хандлагатай зөв хүн болгон төлөвшүүлэхийн тулд холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах;
- Цахим орчинд гарч байгаа мэдээллийн урсгалд хяналт тавьж ажиллах



**"НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 12-Р
СУРГУУЛЬ"-ИЙН СУРАГЧИД, ЭЦЭГ,
ЭХЧҮҮДИЙН СУДАЛГАА**

I. СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Авлигатай тэмцэх газрын УССГХ-ээс хэрэгжүүлж буй Бангладеш Улсын эиэг, эхийн зөвлөлийн тэргүүн туршлагыг нэвтрүүлэх ажлын хүрээнд “Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 12-р сургууль”-ийн сурагчид, эиэг, эхчүүдийн шударга байдлыг үнэлэх судалгааны мэдээллийг “Survey monkey” цахим программ цуглуулан, үр дүнг нэгтгэлээ.

Хүүхдийн шударга байдлын судалгааг АТГ-аас уламжлал болгон зохион байгуулдаг “Хүүхдийн шударга байдлын судалгаа”-ны асуулгын дагуу явуулсан бол эиэг, эхчүүдийн шударга байдлын судалгааг тусгай асуулга боловсруулан мэдээллийг цуглуулсан.

Судалгаанд “Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 12-р сургууль”-ийн 6-12 дугаар ангийн нийт 1226 сурагч, 1-12 дугаар ангийн нийт 2261 эиэг, эх хамрагдсан.

Хүүхдийн шударга байдлын түвшинг тогтоохдоо доорх 12 асуултад тухайн хүүхэд санал нийлж байгаа эсэхийг нь асууж, харуулт бүрийг 1-5 хүртэлх оноогоор үнэлж, үнэлгээг арифметик дунджаар тооцов. Хүүхдийн шударга байдлын түвшин нь хүүхдийн ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих, авлигыг үл тэвчих үзэл гэсэн дэд үзүүлэлтээс бүрддэг. Хүүхдийн шударга байдлын түвшин 1-д ойртох тусам шударга бус, харин 5-д ойртох тусам шударга гэж үзнэ.


Хүүхдийн шударга байдлыг дараах асуултуудаар үнэлсэн. Үүнд:

Дугаар	Асуулт
1	Дотнын найз минь шалгалт өгч байхдаа бусдаас хуулж байвал би “найз минь юм чинь за яах вэ дээ” гэж бодно.
2	Том хүмүүсийн үйлдэл хууль бус байсан ч надад ашигтай байвал хүлээн зөвшөөрнө.
3	Хүүхдүүд интернетэд байгаа бусдын бүтээлээс хуулбарлаж гэрийн даалгавраа хийхдээ эх сурвалжийг нь заавал дурдах албагүй.
4	Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь байж болох зүйл.
5	Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга юм.
6	Баян байх нь шударга байхаас илүү чухал.
7	Төрийн албан хаагч төрийн үйлчилгээ үзүүлснийхээ төлөө шан харамж авч болно.
8	Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн нь миний сайн найз байсан ч би өөрийн итгэдэг багш, эиэг, эх, хэн нэгэнд мэдэгдэнэ.
9	Кино үзэхийн тулд урт дараалалд зогссоноос урдуур нь дайрч хурдан кинонд оорно.
10	Замын цагдаа-зохицуулагч байхгүй бол би замын хөдөлгөөний дүрэм зөрчиж магадгүй.
11	Гэмт хэрэг үйлдсэн, авлига, хээл хахууль авсан хэн нэгнийг би зохих байгууллагад нь мэдэгдэнэ.
12	Манай гэр бүл баяжиж л байвал миний аав, ээж эрх мэдлээ ашиглах, хууль зөрчих нь надад хамаагүй.

II. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 12-р сургуулийн 6-12 дугаар ангийн нийт 1416 сурагчийн 1226 буюу 86.6 хувь нь судалгаанд хамрагдсан байна. Үүнээс: 6 дугаар ангийн 289 сурагчийн 253 буюу 87.5 хувь нь, 7 дугаар ангийн 249 сурагчийн 234 буюу 94.0 хувь нь, 8 дугаар ангийн 253 сурагчийн 232 буюу 91.7 хувь нь, 9 дүгээр ангийн 195 сурагчийн 156 буюу 80.0 хувь нь, 10 дугаар ангийн 144 сурагчийн 131 буюу 91.0 хувь нь, 11 дүгээр ангийн 128 сурагчийн 105 буюу 82.0 хувь нь, 12 дугаар ангийн 158 сурагчийн 115 буюу 72.8 хувь нь тус тус судалгаанд хамрагдсан байна.

ЗУРАГ 1. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГААНД ХАМРАГДСАН СУРАГЧДЫН ТОО



Авлигатай тэмцэх газраас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Хүүхдийн шударга байдлын судалгаа”-ны 2020 оны дүнгээр хүүхдийн шударга байдлын түвшин 4.01 байгаа бол Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 12-р сургуулийн хүүхдийн шударга байдлын түвшин 3.62 байгаа нь улсын дүнгээс 0.39 пунктээр бага байна.




Хүүхдийн шударга байдлын түвшинг хүйсээр авч үзвэл 6 дугаар ангийн сурагчдын хувьд эрэгтэй сурагчдын шударга байдал 3.69, эмэгтэй сурагчдынх 3.65 байгаа нь 0.04 пунктээр зөрүүтэй байна. Харин 7-12 дугаар ангийн эрэгтэй сурагчдын шударга байдал эмэгтэй сурагчдынхаас 0.01-0.12 пунктээр бага байна

ХҮСНЭГТ 1. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН, анги, хүйсээр

Анги	Нийт сурагчид	Эрэгтэй сурагчид	Эмэгтэй сурагчид
6 дугаар анги	3.67	3.69	3.65
7 дугаар анги	3.65	3.60	3.68
8 дугаар анги	3.63	3.62	3.63
9 дүгээр анги	3.52	3.48	3.55
10 дугаар анги	3.67	3.63	3.70
11 дүгээр анги	3.48	3.46	3.49
12 дугаар анги	3.62	3.56	3.68


Судалгаанд хамрагдсан сурагчдын 18.3 хувь нь шударга байх талаар гэрийнхэнтэйгээ байнга ярилцаж байгаа гэж харуулсан бол 45.5 хувь нь заримдаа ярилцаж, 30.1 хувь нь хааяа ярилцаж, 6.1 хувь нь хэзээ ч ярилцажгүй гэж харуулсан байна.

ЗУРАГ 2. ШУДАРГА БАЙХ ТАЛААР ГЭРИЙНХЭНТЭЙГЭЭ ЯРИЛЦДАГ ЭСЭХ, хувиар




Шударга байх талаар гэрийнхэнтэйгээ байнга ярилцаж хүүхдийн шударга байдлын түвшин 3.72 байгаа бол хэзээ ч ярилцаж байгаагүй хүүхдийн шударга байдлын түвшин 3.52 байна. Энэ нь гэр бүлийн харилцаа, хандлага хүүхдийн шударга байдалд чухал нөлөөтэй болохыг илэрхийлж байна. Мөн шударга байх талаар гэр бүлийнхэнтэйгээ ярилцаж эсэхийг улсын дүнтэй харьцуулан үзэхэд тус сургуулийн хүүхдийн шударга байдлын түвшин 0.31-0.45 пунктээр доогуур байна.

ЗУРАГ 3. ШУДАРГА БАЙХ ТАЛААР ГЭРИЙНХЭНТЭЙГЭЭ ЯРИЛЦДАГ НЬ ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛД НӨЛӨӨЛДӨГ ЭСЭХ




Судалгаанд хамрагдсан сурагчдын 1.7 хувь нь найз, нөхөд нь шударга бус үйлдэл хийхийг байнга хүсдэг гэж харуулсан бол 10.9 хувь нь заримдаа хүсдэг, 20.3 хувь нь хааяа хүсдэг, 67.0 хувь нь хэзээ ч хүсэж байгаагүй гэж харуулсан байна. Хүүхдүүд найз нөхдөө уруу татан шударга бус үйлдэл хийх нь бага байгааг эндээс харж болох юм.

ЗУРАГ 4. ШУДАРГА БУС ҮЙЛДЭЛ ХИЙХИЙГ НАЙЗУУДЫН ЗҮГЭЭС ХҮСДЭГ ЭСЭХ, хувиар




Шударга хандсаныхаа төлөө магтуулдаг хүүхдийн шударга байдлын түвшин 3.65 байгаа бол хэзээ ч магтуулж байгаагүй хүүхдийн шударга байдлын түвшин 3.57 байна. Энэ нь хүүхдэд тухайн цаг хугацаанд урмын үгс хэлэх нь цаашид тухайн хүүхдийг шударга иргэн болон төлөвшихөд эерэг нөлөөтэй байна. Мөн хүүхдийг шударга хандсаных нь төлөө магтах нь шударга байдалд нөлөөлж буй эсэхийг улсын дүнтэй харьцуулан үзэхэд тус сургуулийн хүүхдийн шударга түвшин 0.36-0.43 пунктээр доогуур байна.

ЗУРАГ 5. ХҮҮХДИЙГ ШУДАРГА ХАНДСАНЫХ НЬ ТӨЛӨӨ МАГТАХ ЯВДАЛ ШУДАРГА БАЙДАЛД НӨЛӨӨЛДӨГ ЭСЭХ




Судалгаанд хамрагдсан сурагчдын 1.7 хувь нь шударга бус зүйл хийхэд гэрийнхэн яадаг ч үгүй зүгээр өнгөрүүлдэг гэж харцуулсан бол 17.3 хувь нь зэмлэж ойлгуулдаг, 4.8 хувь нь тэд сонирхдоггүй, 76.2 хувь нь хэлж ойлгуулдаг гэж харцуулсан байна.

ЗУРАГ 6. ХҮҮХДҮҮД ШУДАРГА БУС ЗҮЙЛ ХИЙХЭД ГЭРИЙНХНИЙ ХАНДАХ ХАНДЛАГА, хувиар




Гэрийнхэн нь хүүхдээ шударга бус зүйл хийснийг нь мэдвэл хэлж ойлгуулдаг хүүхдийн шударга байдлын түвшин 3.63 байгаа бол ямар нэгэн арга хэмжээ авдаггүй хүүхдийн шударга байдлын түвшин 3.42 байна. Энэ нь тухайн хүүхдэд шударга бус зүйлийн үр дагаврыг хэлж ойлгуулснаараа сайн хүн болон төлөвших нөхцөлийг бүрдүүлж өгч байна. Мөн хүүхдээ шударга бус зүйл хийснийг нь мэдвэл хэрхэн хандаж байгаа нь хүүхдийн шударга байдалд нөлөөлж буй эсэхийг улсын дүнтэй харьцуулан үзэхэд тус сургуулийн хүүхдийн шударга түвшин 0.22-0.44 пунктээр доогуур байна.

ЗУРАГ 7. ХҮҮХДҮҮД ШУДАРГА БУС ЗҮЙЛ ХИЙХЭД ГЭРИЙНХЭН НЬ ХЭРХЭН ХАНДАГ НЬ ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛД НӨЛӨӨЛДӨГ ЭСЭХ




Судалгаанд хамрагдсан сурагчдын 68.5 хувь нь шударга бус зүйл хийсэн дотныхоо хүнд зэмлэж сануулдаг гэж харуулсан бол 12.4 хувь нь надад хамаагүй бол би ямар ч үйлдэл хийхгүй, 1.7 хувь нь надад ашигтай байвал дэмжинэ, 17.4 хувь нь бусад гэж харуулсан байна.

ЗУРАГ 8. ХҮҮХДҮҮД ШУДАРГА БУС ЗҮЙЛ ХИЙСЭН ДОТНЫХОО ХҮНД ХАНДАХ ХАНДЛАГА, хувиар



Шударга бус зүйл хийсэн дотныхоо хүнийг зэмлэж сануулдаг хүүхдийн шударга байдлын түвшин 3.64, өөрт нь хамаагүй бол би ямар ч үйлдэл хийхгүй байх хүүхдийн шударга байдлын түвшин 3.52, өөрт нь ашигтай байвал дэмжих хүүхдийн шударга байдлын түвшин 3.54 байна. Хүүхдүүд шударга бус зүйл хийсэн дотныхоо хүнд хэрхэн ханддаг нь хүүхдийн шударга байдалд нөлөөлдөг эсэхийг улсын дүнтэй харьцуулан үзэхэд тус сургуулийн хүүхдийн шударга түвшин 0.06-0.52 пунктээр доогуур байна.

ЗУРАГ 9. ХҮҮХДҮҮД ШУДАРГА БУС ЗҮЙЛ ХИЙСЭН ДОТНЫХОО ХҮНД ХЭРХЭН ХАНДАГ НЬ ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛД НӨЛӨӨЛДӨГ ЭСЭХ




Судалгаанд хамрагдсан нийт сурагчдын 834 буюу 68.0 хувь нь эцэг, эх, багш зэрэг дотныхоо хүнд хэлдэг, 276 буюу 22.5 хувь нь шударга бус асуудлыг арилгахын тулд ямар нэгэн зүйл хийдэг, 39 буюу 3.2 хувь нь юу ч хийхгүй гэсэн бол 77 буюу 6.3 хувь нь бусад гэж хариулсан байна. Анги дэвших тусам хүүхдүүдийн бие даах, шийдвэр гаргах чадвар нэмэгдэж, асуудлыг шийдвэрлэхийн тулд өөрсдөө ямар нэгэн зүйл хийж, эцэг, эх, багш зэрэг дотныхоо хүндээ хандах нь багасаж байгааг дараах хүснэгтээс харж болохоор байна.

ХҮСНЭГТ 2. ШУДАРГА БУС АСУУДАЛ ТОХИОЛДВОЛ ХҮҮХДҮҮДИЙН ХАНДАХ ХАНДЛАГА, ангуар

Анги	Арилгахын тулд ямар нэг зүйл хийнэ	Эцэг, эх, багш зэрэг дотныхоо хүндээ хэлнэ	Юу ч хийхгүй	Бусад	Нийт
6 дугаар анги	16	220	12	5	253
7 дугаар анги	28	192	4	10	234
8 дугаар анги	43	164	10	15	232
9 дүгээр анги	43	96	4	13	156
10 дугаар анги	43	69	5	14	131
11 дүгээр анги	57	38	3	7	105
12 дугаар анги	46	55	1	13	115
Бүгд	276	834	39	77	1226

Судалгаанд хамрагдсан нийт сурагчдын 35.2 хувь нь гэр бүлийнхнээсээ шударга ёсны талаар мэдээлэл авдаг бол 29.9 хувь нь интернетээс, 18.1 хувь нь сургуулийн орчноос, 8.6 хувь нь телевиз, радиогоор, 2.7 хувь нь найз нөхдөөсөө, 1.1 хувь нь сонин хэвлэлээс, 4.4 хувь нь бусад эх үүсвэрээс мэдээллийг авдаг гэж харцуулсан байна.

ЗУРАГ 10. ШУДАРГА ЁСНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ АВДАГ ЭХ ҮҮСВЭР, хувиар



Судалгаанд хамрагдсан нийт сурагчдын 684 буюу 55.8 хувь нь шударга бус асуудал тохиолдвол эцэг, эхдээ ханддаг байна. Ангуар нь авч үзвэл эцэг эхдээ ханддаг хүүхдүүдийн тоо анги дэвших тусам буурсан байна. Харин найз нөхдөө 316 буюу 25.8 хувь нь ханддаг бол ангийн багшдаа 75 буюу 6.1 хувь нь ханддаг байна.


ХҮСНЭГТ 3. ШУДАРГА БУС АСУУДАЛ ТОХИОЛДВОЛ ХЭНД ХАНДАХ ТАЛААР, ангуар

Анги	Эцэг, эх	Найз, нөхөд	Ангийн багш	Хүүхдийн тусламжийн утас 108	Хүүхдийн эрхийн байгууллагад	Сургуулийн захиралд	Бусад	Бүгд
6 дугаар анги	189	35	15	7	3	1	3	253
7 дугаар анги	165	32	15	4	6	1	11	234
8 дугаар анги	124	66	17	4	5	-	16	232
9 дүгээр анги	70	50	12	4	3	1	16	156
10 дугаар анги	46	63	4	-	1	1	16	131
11 дүгээр анги	46	35	5	1	2	-	16	105
12 дугаар анги	44	35	7	5	1	1	22	115
Бүгд	684	316	75	25	21	5	100	1226

III. ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 12-р сургуулийн 1-12 дугаар ангийн нийт 2261 эцэг, эх судалгаанд хамрагдсан бөгөөд 1730 буюу 76.5 хувь нь эмэгтэй, 531 буюу 23.5 хувь нь эрэгтэй хүмүүс байна. Судалгаанд хамрагдсан нийт эцэг, эхчүүдийн 50.2 хувь нь 35-44 насныхан байгаа бөгөөд тэдгээрээс 866 буюу 76.3 хувь нь эмэгтэй, 269 буюу 23.7 хувь нь эрэгтэйчүүд байна.

ЗУРАГ 11. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР




Судалгаанд хамрагдсан нийт эцэг, эхчүүдийг тус сургуульд суралцагч хүүхдийн тоогоор нь авч үзвэл, 1 хүүхэд нь суралцагч эцэг, эх 1197 буюу 52.9 хувийг, 2 хүүхэд нь суралцагч эцэг, эх 851 буюу 37.6 хувийг, 3 хүүхэд нь суралцагч эцэг, эх 188 буюу 8.3 хувийг, 4 ба түүнээс дээш хүүхэд суралцагч эцэг, эх 25 буюу 1.1 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 4. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН ТОО, ХҮҮХДИЙН ТООГООР

Хүүхдийн тоо	Тус сургуульд танай хэдэн хүүхэд суралцагч вэ?				Бүгд
	1 хүүхэд	2 хүүхэд	3 хүүхэд	4 ба түүнээс дээш хүүхэд	
1 хүүхэдтэй	244	-	-	-	244
2 хүүхэдтэй	534	281	-	-	815
3 хүүхэдтэй	287	385	84	-	756
4 ба түүнээс дээш хүүхэдтэй	132	185	104	25	446
Бүгд	1 197	851	188	25	2 261


Судалгаанд хамрагдсан нийт эцэг, эхчүүдийн 88.6 хувь нь хүүхдээ шударга бус зүйл хийвэл ярилцаж ойлгуулна гэж харуулсан бол 10.6 хувь нь зэмлэнэ, 0.1 хувь нь үл тооно, 0.7 хувь нь бусад гэж харуулсан байна.

ЗУРАГ 12. ХҮҮХДЭЭ ШУДАРГА БУС ЗҮЙЛ ХИЙВЭЛ ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН ХАНДАХ ХАНДЛАГА, ХУВИАР



Хүүхдээ шударга зүйл хийвэл эцэг, эхчүүдийн хандах хандлага ижил буюу дийлэнх хувь нь сайшаан магтдаг байна. Судалгааны үр дүнгээс харахад эмэгтэйчүүдийн 68.7 хувь нь хүүхдээ шударга зүйл хийвэл сайшаан магтдаг бол 28.1 хувь нь хийх ёстой зүйлээ хийсэн гэж үзнэ, 1.2 хувь нь хүссэн зүйлийг нь авч өгдөг байна.

ЗУРАГ 13. ХҮҮХДЭЭ ШУДАРГА ЗҮЙЛ ХИЙВЭЛ ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН ХАНДАХ ХАНДЛАГА, хүйс, хувиар




Судалгаанд хамрагдсан нийт эцэг, эхчүүдийн 2163 буюу 95.7 хувь нь хүүхдээ сургуульд оруулахын тулд хэн нэгэнд бэлэг, эд зүйл, мөнгө өгөх, эсвэл үнэгүй үйлчилгээ үзүүлж байгаагүй гэж хариулсан бол 98 буюу 4.3 хувь нь тийм гэж хариулсан байна. Тийм гэж хариулсан эцэг, эхчүүдийн 33.7 хувь нь хувийн байгууллагад ажилладаг, 27.6 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 24.5 хувь нь төрийн байгууллагад ажилладаг бол 11.2 хувь нь тодорхой ажил эрхэлдэггүй хүмүүс байна.

ХҮСНЭГТ 5. ХҮҮХДЭЭ СУРГУУЛЬД ОРУУЛАХЫН ТУЛД ХЭН НЭГЭНД БЭЛЭГ, ЭД ЗҮЙЛ, МӨНГӨ ӨГӨХ, ЭСВЭЛ ҮНЭГҮЙ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ БАЙСАН ЭСЭХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДЛААР

Хөдөлмөр эрхлэлтийн байдал	Хүүхдээ сургуульд оруулахын тулд хэн нэгэнд бэлэг, эд зүйл, мөнгө өгөх, эсвэл үнэгүй үйлчилгээ үзүүлж байсан эсэх		
	Тийм	Үгүй	Нийт
Хувийн байгууллага	33	848	881
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	27	465	492
Төрийн байгууллага	24	437	461
Тэтгэвэрт	2	58	60
Олон улсын байгууллага	1	21	22
Ажилгүй	11	334	345
Нийт	98	2 163	2 261


Эцэг, эхчүүдийн 93.5 хувь нь хүүхдээ шалгалт өгч байхдаа бусдаас хуулсныг мэдвэл болохгүй гэдгийг хэлж ойлгуулдаг бол 1.4 хувь нь дуугүй өнгөрч, 0.8 хувь нь шийтгэдэг гэж хариулсан байна.

ЗУРАГ 14. ХҮҮХДЭЭ ШАЛГАЛТ ӨГЧ БАЙХДАА БУСДААС ХУУЛСНЫГ МЭДВЭЛ ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН ХАНДАХ ХАНДЛАГА, хувиар




Эцэг, эхчүүдийн 89.8 хувь нь хүүхдээ бусдын эд зүйлийг зөвшөөрөлгүй авсныг мэдвэл буруу зүйл гэдгийг хэлж ойлгуулдаг бол 8.8 хувь нь зэмлэнэ, 1.3 хувь нь бусад гэж хариулсан байна.

ЗУРАГ 15. ХҮҮХДЭЭ БУСДЫН ЭД ЗҮЙЛИЙГ ЗӨВШӨӨРӨЛГҮЙ АВСНЫГ МЭДВЭЛ ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН ХАНДАХ ХАНДЛАГА, хувиар



Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 30.9 хувь нь зөв хүн байх, шударга байх талаар хүүхэдтэйгээ байнга ярилцдаг, 61.4 хувь нь хааяа ярилцдаг, 7.2 хувь нь ярилцаж үзээгүй гэж хариулсан байна. Харин эмэгтэйчүүдийн 37.4 хувь нь байнга ярилцдаг, 59.2 хувь нь хааяа ярилцдаг, 2.9 хувь нь ярилцаж үзээгүй гэж хариулсан байна.

ЗУРАГ 16. ЗӨВ ХҮН БАЙХ, ШУДАРГА БАЙХ ТАЛААР ХҮҮХЭДТЭЙГЭЭ ЯРИЛЦДАГ ЭСЭХ, хүйсээр



Эцэг, эхчүүдийн 2113 буюу 93.5 хувь нь хүүхдийнхээ дэргэд шударга бус зүйл ярих, хийхээс зайлсхийж чаддаг гэсэн бол 148 буюу 6.5 хувь нь чаддаггүй гэж

хариулсан байна. Харин эцэг эхчүүдийн үг үйлдэл бүр нь хүүхдэд үлгэр дуурайлал болно гэж 2214 буюу 97.9 хувь нь үзсэн бол үлгэр дуурайлал болохгүй гэж 2.1 хувь нь хариулжээ.

ХҮСНЭГТ 6. ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТАЛААРХ ҮЛГЭР ДУУРАЙЛАЛ

Үзүүлэлт	Хүүхдийнхээ дэргэд шударга бус зүйл ярих, хийхээс зайлсхийж чаддаг эсэх	Таны үг, үйлдэл бүр таны хүүхдэд үлгэр дуурайлал болно гэдэгтэй санал нийлдэг эсэх
Тийм	2 113	2 214
Үгүй	148	47
Нийт	2 261	2 261

ДҮГНЭЛТ

Авлигатай тэмцэх газрын УССГХ-ээс хэрэгжүүлж буй Бангладеш Улсын эцэг, эхийн зөвлөлийн тэргүүн туршлагыг нэвтрүүлэх ажлын хүрээнд “Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 12-р сургууль”-ийн сурагчид, эцэг, эхчүүдийн шударга байдлыг үнэлэх судалгааг “Survey monkey” цахим программ ашиглан зохион байгууллаа.

- Судалгаанд “Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 12-р сургууль”-ийн 6-12 дугаар ангийн нийт 1226 сурагч хамрагдсанаас 700 буюу 57.1 хувь нь эмэгтэй, 526 буюу 42.9 хувь нь эрэгтэй сурагчид байна. Харин 1-12 дугаар ангийн нийт 2261 эцэг, эх хамрагдсанаас 1730 буюу 76.5 хувь нь эмэгтэй, 531 буюу 23.5 хувь нь эрэгтэй хүмүүс байна.
- Авлигатай тэмцэх газраас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Хүүхдийн шударга байдлын судалгаа”-ны 2020 оны дүнгээр хүүхдийн шударга байдлын түвшин 4.01 байгаа бол Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 12-р сургуулийн хүүхдийн шударга байдлын түвшин 3.62 байгаа нь улсын дүнгээс 0.39 пунктээр бага байна. Энэ нь тус сургуулийн сурагчдын шударга байдлын түвшин нь улсын дүнгээс доогуур байгааг илтгэж байгаа бөгөөд цаашид хүүхдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүртээмжийг нэмэгдүүлэх нь зүйтэй юм.
- Судалгааны үр дүнгээс харахад хүүхдүүд болон эцэг, эхийн хариултаас харахад хүүхэдтэйгээ зөв хүн байх, шударга ёсны талаар дийлэнх хувь нь хааяа ярилцдаг гэж хариулсан байна. Шударга ёсны талаар байнга ярилцдаг эцэг, эхчүүд хүүхдээ аливаа асуудалд шударга хандсаных нь төлөө магтан сайшааж харин буруу зүйл, шударга бус үйлдэл хийснийг мэдвэл тухайн зүйлээс гарах үр дүнг тайлбарлан өгдөг хүүхдүүдийн шударга байдлын түвшин нь бусад хүүхдийнхээс өндөр байна.
- Хүүхдүүд шударга бус үйлдэл тохиолдвол эцэг, эх, найз нөхдөдөө хандан ярилцаж асуудлаа шийдвэрлэдэг болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байгаа бөгөөд анги дэвших тусам эцэг, эхээс илүүтэй найз нөхөдтэйгээ ярилцах хандлага нэмэгдэж байна.
- Хүүхдээ сургуульд оруулахын тулд хэн нэгэнд бэлэг, эд зүйл, мөнгө өгөх, эсвэл үнэгүй үйлчилгээ үзүүлэх нь хэдийгээр бага байгаа хэдий ч ийм асуудал гаргаж байсан гэж хариулсан эцэг, эхчүүдийн дийлэнх хувь нь хувийн байгууллагад ажилладаг болон хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүс байна.